

ӨМНӨТГӨЛ

Манай улс өнөөг хүртэл нийт 188 олон улсын олон талт гэрээнд нэгдэн орсон бөгөөд тэдгээрийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн тусгай дугаар болгон хэвлэн нийтлэх ажлыг 2004 онд Улсын Их Хурлын Тамгын газар, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс хамтран эхлүүлсэн билээ. Олон улсын аливаа гэрээний орчуулга “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэгдэж байж албан ёсны болох бөгөөд холбогдох хуулийн заалтын дагуу Гадаад хэргийн яам уг орчуулгыг хариуцан гүйцэтгэж байна.

Эл ажлын хүрээнд хүний эрх болон НҮБ-ын дүрэм, дипломат, консулын харилцаа, олон улсын шүүх, олон улсын эрүүгийн шүүх, маргааныг арбитраар шийдвэрлэх зэрэг олон улсын эрх зүйн салбарын манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээг эхний 2 боть болгон хэвлүүлж та бүхэнд толилуулсан билээ.

Одоо хэвлэгдэн гарч буй “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн тусгай дугаарын 3 дугаар ботид оюуны өмчийн эрх зүйн салбарын манай улсын нэгдэн орсон олон талт 14 гэрээг хэвлүүлж байна. “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн тусгай дугаарын 4 дүгээр ботид терроризм, бусад гэмт хэргийн эсрэг 18 конвенцийг хэвлүүлэхээр бэлтгэж байна.

Ийнхүү эхний 4 ботийг бэлтгэж гаргасанаар Монгол Улсын нэгдэн орсон 188 олон талт гэрээнээс 89 нь албан ёсны орчуулгатайгаар “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэгдэж байна. Энэ нь нэн ялангуяа, шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл зэрэг манай хууль, хяналтын байгууллагад ажиллагсадын өдөр тутмын ажилд эрх зүйн үнэтэй эх сурвалж болно гэж найдаж байна.

ГАДААД ХЭРГИЙН
САЙД



Ц. МӨНХ-ОРГИЛ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2005 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

ТУСГАЙ ДУГААРЫН III БОТЬ

Гарчиг

58. Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц.....	605
59. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц.....	620
60. Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц.....	648
61. Барааны тэмдгийн улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр.....	684
62. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол	700
63. Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр	717
64. Барааны тэмдгийг бүртгэх бараа үйлчилгээний олон улсын ангиллын тухай Ниццийн хэлэлцээр	730
65. Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээр	742
66. Патентийн хамтын ажиллагааны гэрээ	751
67. Патентын олон улсын ангиллын тухай Страсбургийн хэлэлцээр	795
68. Олимпын бэлгэ тэмдгийг хамгаалах тухай Найробын гэрээ	808
69. Зохиогчийн эрхийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ	812
70. Тоглолт болон дуу авианы бичлэгийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ	820
71. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр	830

**58. ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГА
БАЙГУУЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ***

*1967 оны 7 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурж
1979 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар*

Хэлэлцэн тохирогч талууд,

тусгаар тогтнол, эрх тэгш байдлыг хүндэтгэх үндсэн дээр харилцан ашигтай байхын тулд улс хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулахыг эрмэлзэж;

бүтээлч үйл ажиллагааг дэмжих зорилгоор дэлхий дахинд оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг дээшлүүлэхийг эрмэлзэж,

холбооны гишүүн улс тус бүрийн бие даасан байдлыг хүндэтгэн үзэхийн ялдамд аж үйлдвэрийн өмчийн болон утга зохиол урлагийн бүтээлийг хамгаалах салбарт байгуулагдсан холбоодын үйл ажиллагааг илүү үр ашигтай болгох, орчин үед нийцүүлэхийг эрмэлзэж;

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Байгууллага байгуулах

Дэлхийн оюуны өмчийн байгууллагыг үүгээр үүсгэн байгуулав.

2 дугаар зүйл

Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү конвенцийн зорилгоор:

- (i) “байгууллага” гэж Дэлхийн оюуны өмчийн байгууллагыг (ДООБ);
- (ii) “олон улсын товчоо” гэж оюуны өмчийн олон улсын товчоог;
- (iii) “Парисын конвенц” гэж 1883 оны 3 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурсан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай конвенц болон түүнийг хянан өөрчилсөн баримт бичгүүдийг;
- (iv) “Бернийн конвенц” гэж 1886 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр гарын үсэг зурсан Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай конвенц болон түүнийг хянан өөрчилсөн баримт бичгүүдийг;

* Монгол Улс 1978 оны 10 дугаар сарын 10-ны өдөр соёрхон баталсан.

- (v) “Парисын холбоо” гэж Парисын конвенцоор байгуулсан олон улсын холбоог;
- (vi) “Бернийн холбоо” гэж Бернийн конвенцоор байгуулсан олон улсын холбоог;
- (vii) “холбоод” гэж Парисын холбоо болон түүнтэй холбогдуулан байгуулсан тусгай холбоод болон хэлэлцээр, Бернийн холбоо болон 4 дүгээр зүйлийн (iii)-д заасны дагуу байгууллагын удирдаж байгаа оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг дээшлүүлэхэд чиглэсэн бусад олон улсын хэлэлцээрийг;
- (viii) “ оюуны өмч” гэж:
 - утга зохиол, урлаг, шинжлэх ухааны бүтээл,
 - тоглогчдын тоглолт, дуу авианы бичлэг болон радио телевизийн нэвтрүүлэг,
 - хүний бүтээн туурвисан бүх шинэ бүтээл,
 - шинжлэх ухааны нээлт,
 - бүтээгдэхүүний загвар,
 - бараа болон үйлчилгээний тэмдэг, хуулийн этгээдийн нэр болон илэрхийлэл,
 - шударга бус өрсөлдөөний эсрэг хамгаалалт

болон аж үйлдвэр, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн салбарт гарч буй оюуны бүтээлээс үүдэн гарах бусад бүх эрхийг хэлнэ.

3 дугаар зүйл

Байгууллагын зорилго

Байгууллагын зорилго нь:

- (i) улс хоорондын хамтын ажиллагаа болон шаардлагатай үед бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллах замаар дэлхий дахинаа оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудлыг хөхиүлэн дэмжих,
- (ii) холбоод хоорондын захиргааны хамтын ажиллагааг хангахад оршино.

4 дүгээр зүйл

Чиг үүрэг

3 дугаар зүйлд заасан зорилгод хүрэхийн тулд байгууллага нь өөрийн холбогдох байгууллагаар дамжуулан холбоо тус бүрийн эрхлэх асуудлын хүрээнд:

- (i) оюуны өмчийн эрхийг дэлхий дахинаа үр ашигтай хамгаалах асуудлыг хялбарчлах болон энэ салбарт үндэсний хууль тогтоомжийг уялдуулахад чиглэсэн арга хэмжээг дээшлүүлэх;
- (ii) Парисын холбоо, түүнтэй холбогдуулан байгуулсан тусгай холбоод болон Бернийн холбооны үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- (iii) оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг дээшлүүлэхэд чиглэсэн бусад олон улсын хэлэлцээрийг байгуулах, удирдах, оролцох;
- (iv) оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг дээшлүүлэхэд чиглэсэн бусад олон улсын хэлэлцээрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- (v) оюуны өмчийн эрхийг хамгаалах салбарт эрх зүйн техникийн туслалцаа хүссэн улстай хамтран ажиллах;
- (vi) оюуны өмчийн эрхийн хамгаалалтын асуудлаарх мэдээллийг цуглуулах, түүнийг түгээх, энэ салбарт судалгаа явуулах, судалгааны дүнг хэвлэх;
- (vii) оюуны өмчийн эрхийн олон улсын хамгаалалтыг хялбарчлахад чиглэсэн үйлчилгээ явуулах, шаардлагатай үед энэ салбарт бүртгэл хөтлөх, бүртгэлтэй холбоотой мэдээллийг хэвлэн нийтлэх;
- (viii) бусад шаардлагатай бүх арга хэмжээг авна.

5 дугаар зүйл

Гишүүнчлэл

(1) 2 дугаар зүйлийн (vii)-д заасан холбоодын гишүүн аливаа улс байгууллагын гишүүн болоход нээлттэй байна.

(2) Холбоодын гишүүн бус боловч,

- (i) Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагын эсхүл Олон улсын цөмийн эрчим хүчний байгууллагын гишүүн улс эсхүл Олон улсын шүүхийн дүрэмд оролцогч улс,
- (ii) энэхүү конвенцид оролцогч тал болохыг Ерөнхий Ассамблейгаас урьсан тохиолдолд аливаа улс уг байгууллагын гишүүн болоход мөн нээлттэй байна.

6 дугаар зүйл

Ерөнхий Ассамблей

(1) (a) Аль нэг холбооны гишүүн бөгөөд энэхүү конвенцид оролцогч улсуудаас бүрдсэн Ерөнхий Ассамблейтай байна.

(b) Улс бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөгч, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) a) Ерөнхий Ассамблей нь:

- (i) зохицуулах хорооноос нэр дэвшүүлсний үндсэн дээр ерөнхий захирлыг томилно;
- (ii) байгууллагын талаарх ерөнхий захирлын тайланг хянаж батлах бөгөөд түүнд шаардлагатай бүх зааварчилгаа өгнө;
- (iii) зохицуулах хорооны тайлан, үйл ажиллагааг хянаж батлах бөгөөд тус хороонд зааварчилгаа өгнө;
- (iv) холбоодод хамаарах нийтийн зардлын хоёр жилийн төсвийг батална;
- (v) 4 дүгээр зүйлийн (iii)-т заасан олон улсын хэлэлцээрийг эрхлэх асуудлаар ерөнхий захирлын санал болгосон арга хэмжээг батална;
- (vi) байгууллагын санхүүгийн журмыг батална;
- (vii) Нэгдсэн Үндэсний Байгууллагын жишгийг харгалзан нарийн бичгийн дарга нарын газрын ажлын хэлийг тодорхойлно;
- (viii) 5 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (ii)-т заасан улсуудыг энэхүү конвенцид оролцогч тал болохыг урина;
- (ix) байгууллагын гишүүн бус ямар улсууд, засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагууд байгууллагын хуралдаанд ажиглагчаар оролцох эрхтэйг тодорхойлно;
- (x) энэхүү конвенцид заасан бусад холбогдох чиг үүргийг гүйцэтгэнэ.

(3) a) Аливаа гишүүн улс нэг болон хэд хэдэн холбооны гишүүн байхаас үл хамаарч Ерөнхий Ассамблейд нэг санал өгөх эрхтэй.

(b) Ерөнхий Ассамблейн гишүүн улсын тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

с) (b) дэд хэсгийн заалтыг үл харгалзан хэрэв ямар нэг чуулганд оролцох улсуудын тоо тэн хагасаас бага байх боловч Ерөнхий Ассамблейн гишүүн улсуудын гуравны нэгтэй тэнцүү буюу илүү байвал Ерөнхий Ассамблей шийдвэр гаргах эрхтэй боловч Ерөнхий Ассамблейн өөрийн үйл ажиллагаанд хамаарах шийдвэрээс бусад шийдвэр нь дараахь нөхцөл бүрдсэн үед хүчин төгөлдөр болно. Эдгээр шийдвэрийг олон улсын товчоо нь Ерөнхий Ассамблейн чуулганд оролцоогүй улсуудад хүргүүлэх бөгөөд уг шийдвэрийг батлах, түдгэлзэх талаарх саналаа шийдвэрийг хүргүүлснээс хойш 3 сарын дотор бичгээр ирүүлэхийг мэдэгдэнэ. Хэрэв энэ хугацаа дуусах үед шийдвэрийг баталсан буюу түдгэлзсэн улсын тоо Ерөнхий Ассамблейн чуулганыг хүчинтэйд тооцоход дутаж байсан улсын тоонд хүрсэн тохиолдолд, мөн шийдвэр хүчинтэйд тооцогдоход шаардлагатай олонхын хувьд хүрсэн тохиолдолд уг шийдвэр хүчин төгөлдөр болно.

(d) Ерөнхий Ассамблей нь (e) ба (f) дэд хэсэгт зааснаас бусад тохиолдолд гуравны хоёрын олонхын саналаар шийдвэр гаргана.

(e) 4 дүгээр зүйлийн (iii)-т заасан олон улсын хэлэлцээрийг эрхлэх асуудалтай холбогдох арга хэмжээг батлахад шаардлагатай олонхын хувь нь дөрөвний гурав байна.

(f) Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 57 ба 63 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагатай байгуулах гэрээг батлахад аравны есийн хувь шаардлагатай .

(g) Ерөнхий захирлыг томилоход ((2) дахь хэсгийн (i)), олон улсын хэлэлцээрийг эрхлэх асуудлаар ерөнхий захирлын санал болгосон арга хэмжээг батлахад ((2) дахь хэсгийн (v)), ба төв байрыг шилжүүлэх (10 дугаар зүйл) асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн Ерөнхий Ассамблейд олонхын санал шаардагдахаас гадна мөн Парисын холбоо, Бернийн холбооны чуулганд олонхын саналаар шийдвэрлэсэн байх шаардлагатай.

(h) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(i) Нэг төлөөлөгч нэг улсыг төлөөлж, зөвхөн тухайн улсын нэрийн өмнөөс санал өгөх эрхтэй.

(4) а) Ерөнхий захирал хоёр жил тутамд нэг удаа Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганыг зарлан хуралдуулна.

(b) Зохицуулах хороо эсхүл Ерөнхий Ассамблейн гишүүн улсын дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу ерөнхий захирал Ерөнхий Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.

(c) Чуулган байгууллагын төв байранд хуралдана.

(5) Энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн бус улсууд Ерөнхий Ассамблейн чуулганы хуралдаанд ажиглагчаар оролцох эрхтэй.

(6) Ерөнхий Ассамблей нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг боловсруулан батална.

7 дугаар зүйл

Бага хурал

(1) а) Аль нэг холбооны гишүүн мөн эсэхээс үл хамааран энэхүү конвенцид оролцогч улсууд бага хурал зохион байгуулна.

(b) Улс бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөгч, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) Бага хурал нь:

(i) оюуны өмчийн эрхийг хамгаалах салбарын нийтлэг сонирхлын асуудлуудыг хэлэлцэх бөгөөд холбоодын эрх хэмжээ болон тусгаар байдлыг харгалзаж энэ асуудлаар зөвлөмж гаргах эрхтэй;

(ii) бага хурлын хоёр жилийн төсвийг батална;

(iii) бага хурлын төсвийн хүрээнд эрх зүй техникийн туслалцааны хоёр жилийн хөтөлбөрийг боловсруулж батална;

(iv) 17 дугаар зүйлд заасны дагуу энэхүү конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулна;

(v) байгууллагын гишүүн бус ямар улсууд, засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагууд хуралдаанд ажиглагчаар оролцох эрхтэйг тодорхойлно;

(vi) энэхүү конвенцид заасан бусад чиг үүргийг гүйцэтгэнэ.

(3) (a) Гишүүн улс бүр бага хуралд нэг санал өгөх эрхтэй.

(b) Гишүүн улсын гуравны нэг кворум бүрдүүлнэ.

(c) 17 дугаар зүйлд заасныг харгалзан бага хурал гуравны хоёрын олонхын саналаар шийдвэр гаргана.

(d) Энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн бус улсуудын төлөх татварын хувь хэмжээг тогтооход зөвхөн эдгээр улсын төлөөлөгчид санал өгөх эрхтэй байна.

(e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(f) Нэг төлөөлөгч нэг улсыг төлөөлж, зөвхөн тухайн улсын нэрийн өмнөөс санал өгөх эрхтэй.

(4) (a) Ерөнхий захирал бага хурлын ээлжит чуулганыг Ерөнхий Ассамблей чуулдаг газарт болон хугацаанд зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал гишүүн улсуудын олонхын хүсэлтийн дагуу бага хурлын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.

(5) Бага хурал нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг боловсруулан батална.

8 дугаар зүйл

Зохицуулах хороо

(1) (a) Зохицуулах хороо нь энэхүү конвенцид оролцогч тал бөгөөд Парисын холбооны, эсхүл Бернийн холбооны, эсхүл хоёулангийнх нь гүйцэтгэх хорооны гишүүн улсуудаас бүрдэнэ. Ингэхдээ эдгээр гүйцэтгэх хороод нь тэдгээрийг томилсон Ассамблейн гишүүн улсуудын дөрөвний нэгээс илүү тоотой бүрдсэн тохиолдолд тэрхүү гүйцэтгэх хороо нь өөрийн гишүүн улсуудаас зохицуулах хороонд орох улсуудыг томилно. Ийнхүү томилохдоо дээр дурдсан дөрөвний нэгээс хэтрүүлэхгүй байна. Харин байгууллагын төв байр нь байрладаг улсыг дээрх дөрөвний нэгийг тооцоход хамааруулахгүй.

(b) Зохицуулах хорооны гишүүн улс бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөгч, шинжээчтэй байж болно.

(c) Бага хурлын хөтөлбөр, төсөв, хэлэлцэх асуудалтай холбоотой эсхүл энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбоодын гишүүн бус улсуудын эрх, үүргийг хөндөж болох нэмэлт, өөрчлөлтийг конвенцид оруулах асуудлыг зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцэхэд дээрх улсуудын дөрөвний нэг нь тэрхүү хорооны гишүүдийн нэгэн адил эрхтэйгээр оролцоно. Бага хурал өөрийн ээлжит хуралдаан бүрээр дээрх улсуудыг томилно.

(d) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) Хэрэв байгууллагын удирддаг холбоод нь зохицуулах хороонд төлөөлөлтэй байхыг хүсвэл өөрийн төлөөлөгчдийг зохицуулах хорооны гишүүн улсуудаас томилно.

(3) Зохицуулах хороо нь:

(i) холбоодын удирдлагууд, Ерөнхий Ассамблей, бага хурал, ерөнхий захиралд захиргааны, санхүүгийн холбогдолтой асуудлаар хоёр ба түүнээс дээш холбоодын, эсхүл нэг ба түүнээс дээш холбоод болон байгууллагын нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, нэн ялангуяа холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгнө;

(ii) Ерөнхий Ассамблейн хэлэлцэх асуудлын дэгийн төслийг бэлтгэнэ;

(iii) бага хурлын хэлэлцэх асуудал, хөтөлбөрийн төсөл болон төсвийг бэлтгэнэ;

- (iv) [хасагдсан];
- (v) ерөнхий захирлын бүрэн эрхийн хугацаа дуусах үед, эсхүл ерөнхий захирлын албан тушаал чөлөөтэй байх үед Ерөнхий Ассамблейд уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигчийг томилохгүй бол зохицуулах хороо өөр хүний нэрийг дахин дэвшүүлнэ; ерөнхий захирал томилогдох хүртэл зохицуулах хороо нэр дэвшүүлэх эрхтэй;
- (vi) ерөнхий захирлын албан тушаал Ерөнхий Ассамблейн хоёр чуулганы хооронд чөлөөлөгдвөл шинэ ерөнхий захирал ажлаа хүлээн авах хүртэл ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилно;
- (vii) энэхүү конвенцоор олгогдсон бусад чиг үүргийг гүйцэтгэнэ.

(4) (a) Ерөнхий захирал зохицуулах хорооны ээлжит хуралдааныг жил бүр нэг удаа зарлан хуралдуулна. Хуралдааныг байгууллагын төв байранд хийнэ.

(b) Ерөнхий захирал өөрийн санаачилгаар эсхүл хорооны даргын эсхүл гишүүдийн дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу зохицуулах хорооны ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

(5) (a) Улс бүр (1) дэх хэсгийн (a) дэд хэсэгт заасан нэг буюу хоёр гүйцэтгэх хорооны гишүүн эсэхээс үл хамаарч зохицуулах хороонд нэг санал өгөх эрхтэй.

(b) Зохицуулах хорооны гишүүдийн тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(c) Нэг төлөөлөгч нэг улсыг төлөөлж, зөвхөн тухайн улсын нэрийн өмнөөс санал өгөх эрхтэй.

(6) (a) Зохицуулах хороо нь нийт саналын энгийн олонхоор өөрийн саналаа илэрхийлэх ба шийдвэр гаргана. Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(b) Энгийн олонхын санал авсан ч зохицуулах хорооны аливаа гишүүн санал хураалт дууссан даруй саналыг дараахь байдлаар нарийвчлан тоолох хүсэлт гаргах эрхтэй. Үүнд: хоёр тусгай жагсаалт бэлтгэх ба нэг нь Парисын холбооны гүйцэтгэх хорооны гишүүн улсын нэрийг жагсаасан, нөгөөх нь Бернийн холбооны гүйцэтгэх хорооны гишүүн улсын нэрийг жагсаасан байх бөгөөд улс бүрийн нэрийн ард өгсөн саналыг бичнэ. Хэрэв энэ тооллогоор ердийн олонход хүрэхгүй тохиолдолд саналыг хүчингүйд тооцно.

(7) Байгууллагын гишүүн боловч зохицуулах хорооны гишүүн бус аливаа улс хорооны хуралдаанд санал өгөх эрхгүйгээр, харин хэлэлцүүлэгт оролцох эрхтэй ажиглагчаар оролцож болно.

(8) Зохицуулах хороо өөрийн үйл ажиллагааны журмыг тогтооно.

9 дүгээр зүйл

Олон улсын товчоо

(1) Олон улсын товчоо нь байгууллагын нарийн бичгийн дарга нарын газар байна.

(2) Олон улсын товчоог ерөнхий захирал тэргүүлэх ба тэрээр хоёр ба түүнээс дээш орлогчтой байна.

(3) Ерөнхий захирлыг тогтсон хугацаагаар томилох ба тэр нь зургаан жилээс багагүй байна. Ерөнхий захирлыг тогтсон хугацаагаар улираан томилж болно. Бүрэн эрхийн эхний хугацаа, дараагийн хугацаа болон томилолтын бусад нөхцөлийг Ерөнхий Ассамблей тогтооно.

(4) (a) Ерөнхий захирал байгууллагын удирдах албан тушаалтан байна.

(b) Байгууллагыг ерөнхий захирал төлөөлнө.

(c) Ерөнхий захирал байгууллагын дотоод, гадаад хэргийн асуудлаар Ерөнхий Ассамблейн дүрэмд захирагдаж Ерөнхий Ассамблейд тайлагнана.

(5) Ерөнхий захирал нь хөтөлбөрийн төсөл, төсөв болон үйл ажиллагааны тайланг бэлтгэнэ. Тэдгээрийг сонирхогч улсын засгийн газарт, холбоодын болон байгууллагын эрх бүхий байгууллагад дамжуулна.

(6) Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа ажилтан Ерөнхий Ассамблей, бага хурал, зохицуулах хорооны болон бусад ажлын хэсэг, хороодын хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий захирал эсхүл түүний томилсон ажилтан дээрх газруудын нарийн бичгийн дарга байна.

(7) Ерөнхий захирал олон улсын товчооны үүрэг даалгаврыг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай боловсон хүчнийг томилно. Тэрээр өөрийн орлогчийг зохицуулах хороогоор батлуулсны дараа томилно. Хөдөлмөр эрхлэх нөхцөлийн тухай журмыг ерөнхий захирлын санал болгосноор зохицуулах хороогоор батална. Албан хаагчийн хөдөлмөр эрхлэх нөхцөлийг тодорхойлох болон ажилтныг ажилд авахад түүний ажлын өндөр үр дүн, ур чадвар, үнэнч шударга байдлыг үндэс болгон тогтооно. Түүнчлэн ажилтан авахад газар зүйн аль болох өргөн хүрээг хамруулахад зохих анхаарал хандуулна.

(8) Ерөнхий захирлын болон ажилтны хариуцлагын чанар нь гагцхүү олон улсын шинжтэй байна. Тэд албан үүргээ гүйцэтгэхдээ аливаа засгийн газар болон байгууллагад хамааралгүй аливаа газраас зааварчилгаа хүсэх, авах эрхгүй. Тэд олон улсын ажилтны албан тушаалд хор учруулж болохуйц аливаа үйлдлээс зайлсхийнэ. Аливаа гишүүн улс ерөнхий захирал болон ажилтнуудын хариуцлагын олон улсын шинж чанарыг хүндэтгэн, албан үүргээ гүйцэтгэхэд нь нөлөө үзүүлэхээс зайлсхийнэ.

10 дугаар зүйл

Төв байр

(1) Байгууллагын төв байр нь Женевт байрлана.

(2) Түүнийг шилжүүлэх асуудлыг 6 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн (d) ба (g) дэд хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл

Санхүү

(1) Байгууллага нь холбоодод хамаарах нийтийн зардлын төсөв, бага хурлын төсөв гэсэн хоёр тусдаа төсөвтэй байна.

(2) (a) Холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт хэд хэдэн холбоодын сонирхлын зардлын талаарх заалтыг тусгана.

(b) Төсвийг дараахь эх сурвалжаас бүрдүүлнэ:

- (i) холбоодын татвар (холбооны татварын хэмжээг тус холбоо нь холбоодод хамаарах нийтийн зардалд оруулах сонирхолтой байгаа эсэхийг харгалзан үзэж, түүнийг тухайн холбооны Ассамблей тогтооно);
- (ii) аль нэг холбооноос шууд хамааралгүйгээр олон улсын товчооноос гүйцэтгэсэн, мөн эрх зүй, техникийн туслалцаа үзүүлэх хүрээнээс бусад салбарт олон улсын товчооноос гүйцэтгэсэн үйлчилгээний хураамж;
- (iii) аль нэг холбооноос шууд хамааралгүйгээр олон улсын товчооноос гаргасан хэвлэлийн худалдаанаас, хэвлэх эрх шилжүүлснээс олсон орлого;
- (iv) (3) дахь хэсгийн (b) дэд хэсгийн 4-т зааснаас бусад, байгууллагад өгсөн бэлэг дурсгал, өв, хандив;
- (v) түрээс, хүү, байгууллагын бусад орлого.

(3) (a) Бага хурлын төсөвт бага хурлын хуралдаануудыг зохион байгуулах болон эрх зүй, техникийн туслалцааны дараахь зардлыг багтаана.

(b) Төсвийг дараахь эх сурвалжаас бүрдүүлнэ:

- (i) энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн бус улсын татвар;
- (ii) холбоодоос энэ төсөвт оруулсан мөнгө (түүний хэмжээг тухайн холбооны Ассамблей тогтоох бөгөөд аливаа холбоо нь дээрх төсөвт хандивлахаас татгалзаж болно);

- (iii) олон улсын товчооноос эрх зүй, техникийн туслалцааны хүрээнд үзүүлсэн үйлчилгээний хураамж;
- (iv) (a) дэд хэсэгт заасан зорилгоор байгууллагад өгсөн бэлэг дурсгал, өв, хандив.

(4) а) Бага хурлын төсөвт төлөх татварын хэмжээг тогтоох зорилгоор энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн бус улс бүр тодорхой ангилалд хамаарах бөгөөд дараахь байдлаар тогтоосон нэгжийн дагуу жилийн татварыг төлнө:

А Анги.	10
В Анги.	3
С Анги.	1

(b) Улс бүр 14 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан үйл ажиллагааг явуулахдаа аль ангилалд хамаарах хүсэлтэйгээ илэрхийлж болно. Эдгээр улс өөрийн ангиллыг солих эрхтэй. Хэрэв тухайн орон доогуур ангиллыг сонговол бага хурлын ээлжит хуралдааны үеэр мэдэгдэх шаардлагатай. Эдгээр өөрчлөлт нь уг хуралдааны дараагийн жилийн эхэнд хүчин төгөлдөр болно.

(c) Улс бүрийн жилийн татвар нь түүний нэгжийн тоог татвар төлж байгаа бүх улсын нэгжийн нийлбэрт харьцуулах хэлбэрээр тогтоосон, бага хурлын төсөвт төлөх нийт татварт эзлэх хувьтай тэнцүү байна.

(d) Татварыг жил бүрийн нэгдүгээр сарын нэгнээс эхэлж төлнө.

(e) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнөх жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Энэ зүйлийн дагуу энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн бус санхүүгийн татварыг хожигдуулж буй аливаа улс, мөн санхүүгийн татвараа хоёр жилээр хоцроож буй, энэхүү конвенцид оролцогч тал бөгөөд аль нэг холбооны гишүүн аливаа улс гишүүн байгууллагынхаа аливаа асуудалд санал өгөх эрхгүй болно. Гэхдээ эдгээр байгууллага төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд тухайн улсад эдгээр байгууллагад санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

(6) Ерөнхий захирал олон улсын товчооноос эрх зүй, техникийн туслалцааны хүрээнд үзүүлэх үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоож зохицуулах хороонд тайлагнана.

(7) Байгууллага нь зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу улсуудын засгийн газар, олон нийтийн болон хувийн байгууллага, хувь хүнээс бэлэг, өв, хандив авахыг зөвшөөрнө.

(8) (a) Байгууллага нь эргэлтийн хөрөнгийн сантай байх бөгөөд тэр нь холбоодоос болон энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн

бус улсаас төлсөн нэг удаагийн төлбөрөөс бүрдэнэ. Хэрэв сангийн хэмжээ хүрэлцэхгүй бол байгууллага түүнийг нэмэгдүүлнэ.

(b) Холбоо бүрийн төлөх нэг удаагийн төлбөр ба сангийн хэмжээг нэмэгдүүлэхэд холбоодын оруулах хувь хэмжээг тухайн холбооны Ассамблей тогтооно.

(c) Энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн бус улсаас төлөх нэг удаагийн төлбөрийн хэмжээ буюу санг нэмэгдүүлэхэд төлөх төлбөрийн хэмжээ нь энэ санг байгуулсан жил, эсхүл түүнийг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан жилд тухайн улсаас төлөх татварын хувьтай адил байна. Адилтгасан хэмжээ буюу төлбөр хийх нөхцөлийг ерөнхий захирлын санал болгосноор зохицуулах хорооны зөвлөмжийн үндсэн дээр бага хурал тогтооно.

(9) (a) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг улстай байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн улс урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг тусдаа байгууллага, тухайн улс хоорондын хэлэлцээрээр зохицуулна. Тэр орон урьдчилгаа өгөх үүрэг өөртөө хүлээж байгаа хугацаандаа зохицуулах хороонд суудалтай байна.

(b) (a) дэд хэсэгт дурдсан улс ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(10) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу холбооны нэг буюу хэд хэдэн гишүүн улс эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ерөнхий Ассамблей томилно.

12 дугаар зүйл

Эрх зүйн чадвар; эрх ямба ба дархан эрх

(1) Байгууллага нь гишүүн улс бүрийн нутаг дэвсгэр дээр тухайн улсын хуулийн дагуу өөрийн зорилт, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн чадвараар хангагдсан байна.

(2) Байгууллага нь төв байрны тухай хэлэлцээрийг Швейцарийн Холбооны Улстай байгуулах ба цаашид төв байр байрлаж болох аливаа улстай байгуулж болно.

(3) Байгууллага нь бусад гишүүн улстай байгууллага, түүний ажилтнууд, бүх гишүүн улсын төлөөлөгчид байгууллагын зорилт, үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх ямба болон дархан эрх эдлэх зорилгоор хоёр болон олон талт гэрээ байгуулж болно.

(4) Ерөнхий захирал байгууллагын өмнөөс (2) ба (3) дахь хэсэгт заасан хэлэлцээрийн төслийн талаар хэлэлцээ хийх, зохицуулах хороо төслийг зөвшөөрсний дараа тэдгээрийг байгуулж, гарын үсэг зурж болно.

13 дугаар зүйл

Бусад байгууллагатай харьцах

(1) Байгууллага нь шаардлагатай үед бусад засгийн газар хоорондын байгууллагатай ажлын харилцаа тогтоож хамтран ажиллаж болно. Дээрх асуудлаарх аливаа ерөнхий хэлэлцээрийг зохицуулах хорооноос зөвшөөрөл авсны дараа ерөнхий захирал байгуулна.

(2) Байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд олон улсын төрийн бус байгууллагатай болон холбогдох засгийн газрын зөвшөөрснөөр үндэсний, засгийн газрын болон төрийн бус байгууллагатай зөвлөх, хамтран ажиллах арга хэмжээг авч болно. Дээрх арга хэмжээг зохицуулах хороогоор батлуулсны дараа ерөнхий захирал хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл

Конвенцид оролцогч тал болох

(1) 5 дугаар зүйлд заасан улсууд дараахь замаар энэхүү конвенцид оролцогч тал болох бөгөөд байгууллагын гишүүн болж болно:

- (i) соёрхон батлах шаардлагагүйгээр гарын үсэг зурах, эсхүл
- (ii) гарын үсэг зурсны дараагаар соёрхон баталж, батламж жуух бичгээ хадгалуулах, эсхүл
- (iii) нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулах.

(2) Энэхүү конвенцийн бусад заалтыг үл харгалзан, Парисын конвенц болон Бернийн конвенц эсхүл энэ хоёр конвенцид оролцогч улс дараахь актад нэгэн зэрэг нэгдэн орох буюу соёрхон батлах замаар эсхүл эдгээр тэдгээрт нэгдэн орсон эсхүл соёрхон баталсан тохиолдолд энэхүү конвенцид оролцогч тал болж болно:

Парисын конвенцийн Стокгольмын актыг бүхэлд нь эсхүл түүний 20 дугаар зүйлийн (1) дахь хэсгийн (b) дэд хэсгийн (i)-д заасан хязгаарлалттайгаар,
эсхүл Бернийн конвенцийн Стокгольмын актыг бүхэлд нь эсхүл түүний 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсгийн (i)-д заасан хязгаарлалттайгаар.

(3) Батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулна.

15 дугаар зүйл

Конвенц хүчин төгөлдөр болох

(1) Энэхүү конвенц нь Парисын холбооны арван гишүүн улс болон Бернийн холбооны долоон гишүүн улс 14 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан арга хэмжээ авснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хэрэв тухайн улс хоёр холбооны гишүүн бол хоёуланд нь харьяалагдана гэж ойлгоно. Энэ хугацаанд, энэ

конвенц хоёр холбооны гишүүн бус улсуудын хувьд 14 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан арга хэмжээг энэ хугацаанаас гурван сарын өмнө буюу түүнээс илүү хугацаанаас өмнө авсан бол хүчин төгөлдөр болно.

(2) Бусад аль ч улсын хувьд энэхүү конвенц тухайн улс 14 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан арга хэмжээг авсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

16 дугаар зүйл

Тайлбар

Энэхүү конвенцид тайлбар хийхийг хориглоно.

17 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт

(1) Энэхүү конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг аливаа гишүүн улс, зохицуулах хороо, эсхүл ерөнхий захирал санаачилж болно. Ерөнхий захирал тийм саналыг бага хурлаар хэлэлцүүлэхээс зургаан сарын өмнө гишүүн улсуудад хүргүүлнэ.

(2) Нэмэлт, өөрчлөлтийг бага хурлаар батална. Хэрэв нэмэлт, өөрчлөлт нь энэхүү конвенцид оролцогч тал боловч аль нэг холбооны гишүүн бус улсын эрх үүргийг хөндөхөөр байвал тухайн улсууд санал өгөх эрхтэй. Санал болгосон бусад нэмэлт, өөрчлөлтийн хувьд энэхүү конвенцид оролцогч тал бөгөөд холбооны гишүүн улс санал өгөх эрхтэй. Өөрчлөлтийг нийт саналын ердийн олонхоор шийдэх бөгөөд бага хурлаар зөвхөн Парисын холбоо болон Бернийн холбооны чуулганаар холбогдох конвенцийн хувьд зохих журмын дагуу өмнө хэлэлцэж баталсан нэмэлт, өөрчлөлтийн талаар санал өгнө.

(3) Аливаа нэмэлт, өөрчлөлтийг зохих журмын дагуу хүлээн авсан тухай мэдэгдлийг бага хурал нэмэлт, өөрчлөлтийг баталж байгаа үед (2) дахь хэсгийн дагуу санал өгөх эрх бүхий байгууллагын гишүүдийн дөрөвний гурваас ерөнхий захирал бичгээр хүлээн авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох үед байгууллагын гишүүн байсан эсхүл тэр үед гишүүн болсон аливаа улс дээрх нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба харин санхүүгийн үүрэгтэй холбоотой өөрчлөлтийг зөвхөн тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн авсан тухайгаа мэдэгдсэн улсууд л хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл

Цуцлах

(1) Аливаа улс ерөнхий захиралд мэдэгдэл өгөх замаар энэхүү конвенцийг цуцалж болно.

(2) Ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл

Мэдэгдэл хийх

Ерөнхий захирал бүх гишүүн улсын засгийн газарт:

- (i) энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдөр;
- (ii) гарын үсэг зурсан, соёрхон баталсан батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичиг хадгалуулахаар өгсөн тухай;
- (iii) энэхүү конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлт, тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдөр;
- (iv) энэхүү конвенцийг цуцалсан тухай тус тус мэдэгдэнэ.

20 дугаар зүйл

Төгсгөлийн заалтууд

(1) (a) Энэхүү конвенцийн англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн нэг эх хувьд гарын үсэг зурах бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Эх бичвэрүүдийг Швед Улсын засгийн газарт хадгалуулна.

(b) Энэхүү конвенц нь 1968 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл Стокгольм хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна.

(2) Дэлхийн оюуны өмчийн байгууллагын ерөнхий захирал сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү конвенцийн албан ёсны эх бичвэрийг герман, итали, португали хэлээр болон бага хурлаас тогтоосон бусад хэлээр гаргана.

(3) Ерөнхий захирал энэхүү конвенцийн баталгаажуулсан хоёр хуулбар болон бага хурлаар баталсан нэмэлт, өөрчлөлтийг Парисын ба Бернийн холбооны гишүүн улсуудын засгийн газар, энэхүү конвенцид нэгдэн орж байгаа бусад улсын засгийн газар болон хүсэлт гаргасан бусад улсын засгийн газарт дамжуулна. Ийнхүү дамжуулсан конвенцийн эх бичвэрийн гарын үсэг бүхий хуулбарыг Шведийн Засгийн газар баталгаажуулна.

(4) Ерөнхий захирал энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

21 дүгээр зүйл

Шилжилтийн заалтууд

(1) Анхны ерөнхий захирал бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүртэл энэхүү конвенцид заасан олон улсын товчоо, эсхүл ерөнхий захирал гэдэгт аж үйлдвэрийн болон утга

зохиол, урлагийн өмчийг хамгаалах олон улсын нэгдсэн товчоо /мөн “Оюуны өмчийг хамгаалах олон улсын нэгдсэн товчоо” гэнэ/ болон түүний ерөнхий захирлыг ойлгоно.

(2) (a) Аль нэг холбооны гишүүн боловч энэхүү конвенцид оролцогч бус улсууд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойшхи таван жилийн хугацаанд хэрэв өөрсдөө хүсвэл конвенцид оролцогч талын нэгэн адил эрх эдэлж болно. Тийм эрх эдлэх хүсэлтэй аливаа улс энэ тухайгаа ерөнхий захиралд бичгээр мэдэгдэнэ. Энэ нь мэдэгдэл түүнийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Ийм улс дээрх хугацаа дуустал Ерөнхий Ассамблей ба бага хурлын гишүүн байна.

(b) Дээрх таван жилийн хугацаа дуусахад тэдгээр улс Ерөнхий Ассамблей ба бага хуралд, зохицуулах хороонд санал өгөх эрхгүй болно.

(c) Энэхүү конвенцид оролцогч тал болсноор тэдгээр улс санал өгөх эрхээ сэргээнэ.

(3) (a) Парисын болон Бернийн холбооны гишүүн боловч конвенцид оролцогч бус улсын хувьд олон улсын товчоо ба ерөнхий захирал нь аж үйлдвэрийн болон утга зохиол урлагийн өмчийн хамгаалах олон улсын нэгдсэн товчоо, түүний ерөнхий захирал хэвээр байна.

(b) Энэхүү конвенц хүчин төгөлдөр болох үед дээрх товчоонд ажиллаж байсан ажилтан (a) дэд хэсэгт заасан шилжилтийн хугацаанд олон улсын товчоонд ажилладаг гэж тооцогдоно.

(4) (a) Парисын холбооны бүх гишүүн улс байгууллагын гишүүн болсон тохиолдолд тэрхүү холбооны товчооны эрх, үүрэг, өмч нь байгууллагын олон улсын товчоонд шилжинэ.

(b) Бернийн холбооны бүх гишүүн улс байгууллагын гишүүн болсон тохиолдолд тэрхүү холбооны товчооны эрх, үүрэг, өмч нь байгууллагын олон улсын товчоонд шилжинэ.

59. АЖ ҮЙЛДВЭРИЙН ӨМЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ПАРИСЫН КОНВЕНЦ*

*1970 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр буюу 1970 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хүчин
төгөлдөр болсон*

*(1883 оны 3 дугаар сарын 20)
1900 оны 12 дугаар сарын 14-нд Брюссельд,
1911 оны 6 дугаар сарын 2-нд Вашингтонд,
1925 оны 11 дүгээр сарын 6-нд Гаагад,
1934 оны 6 дугаар сарын 2-нд Лондонд,
1958 оны 10 дугаар сарын 31-нд Лиссабонд,
1967 оны 7 дугаар сарын 14-нд Стокгольмд тус тус хянан өөрчилж,
1979 оны 9 дүгээр сарын 28-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар*

* Монгол Улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан

1 дүгээр зүйл

Холбоо байгуулах; аж үйлдвэрийн өмчийн хүрээ

(1) Энэхүү конвенцийг хэрэглэж байгаа орнууд аж үйлдвэрийн өмчийг хамгаалах холбоо байгуулна.

(2) Аж үйлдвэрийн эрхийн хамгаалалтын объектод патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр, эх үүсвэр буюу нэрийн гарлын заалт, шударга бус өрсөлдөөнийг таслан зогсоох үйлдэл багтана.

(3) Аж үйлдвэрийн өмчийг хамгийн өргөн утгаар ойлгож, зөвхөн үйлдвэр болон худалдаанд бус, түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, уул уурхайн олборлох үйлдвэр, дарс, буудай, тамхины навч, жимс, мал, ашигт малтмал, цэвэр ус, шар айраг, цэцэг, гурил гэх мэт байгалийн буюу боловсруулалтын аргаар гарган авдаг бүх төрлийн бүтээгдэхүүнд адил хамаарна.

(4) Шинэ бүтээлийн патентад холбооны гишүүн орны хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлийн бүх төрлийн патент болох импортын патент, сайжруулсан бүтээлийн патент, нэмэгдэл патент ба гэрчилгээ хамаарна.

2 дугаар зүйл

Холбооны гишүүн орны харьяатад зориулсан үндэсний горим

(1) Холбооны аливаа гишүүн орны харьяат аж үйлдвэрийн өмчийн эрхийн хувьд энэхүү конвенцоор тусгайлан олгосон эрхийг хөндөхгүйгээр холбооны бусад бүх орны хуулиар өөрийн харьяатад олгодог, эсхүл цаашид олгох давуу эрхийг эдэлнэ. Иймд тэд тухайн орнууд өөрийн харьяатад тавих албан ёсны шаардлага, нөхцөлийг мөрдөж байвал тэдгээрийн адил эрхийн хамгаалалт болон эрхийг зөрчих тохиолдолд тэдний аливаа эрх зүйн адил хамгаалалттай байна.

(2) Гэхдээ эрхийн хамгаалалт хүсэж байгаа оронд байнга оршин суудаг байх, эсхүл тухайн оронд худалдааны эсхүл үйлдвэрийн газартай байх нөхцөлийг холбооны гишүүн орны харьяатад аж үйлдвэрийн өмчийн аливаа эрхийг эдлэхэд урьдчилсан нөхцөл болгон шаардахгүй.

(3) Шүүхийн болон захиргааны горим болон хуулийн харьяалалд хамаарах, түүнчлэн үйл ажиллагаа явуулах хаяг тодорхойлох, эсхүл итгэмжлэгч томилох зэрэг холбооны гишүүн орон бүрийн аж ахуйн өмчийн тухай хуулийн заалтын шаардлага хадгалагдана.

3 дугаар зүйл

Зарим этгээдийг холбооны гишүүн орны харьяаттай адилтган авч үзэх

Холбооны гишүүн орны харьяат биш боловч холбооны орнуудын аль нэгэнд байнга оршин суудаг, эсхүл тэр оронд үйлдвэрийн буюу худалдааны газар эзэмшдэг этгээдийг холбооны орны харьяаттай адилтган авч үзнэ.

4 дүгээр зүйл

**А-І. Патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, зохиогчийн гэрчилгээ: давамгайлах эрх
G. Патент: мэдүүлгийг салгах**

А.

(1) Холбооны гишүүн аль нэг оронд патент хүсэх тухай мэдүүлэг буюу ашигтай загвар, эсхүл бүтээгдэхүүний загвар, эсхүл барааны тэмдгийг бүртгүүлэх тухай мэдүүлгийг зохих журмаар нь гаргасан аливаа этгээд, эсхүл түүний өв залгамжлагч бусад оронд мэдүүлэг гаргах зорилгоор дор дурдсан хугацаанд давамгайлах эрх эдэлнэ.

(2) Холбооны гишүүн аливаа орны дотоодын хууль тогтоомж буюу холбооны гишүүн орнууд хоорондын хоёр ба олон талт гэрээний дагуу мэдүүлэг гаргах нь ердийн үндэсний мэдүүлэг гаргахтай адил бөгөөд давамгайлах эрх үүсэх үндэслэл гэж хүлээн зөвшөөрнө.

(3) Ердийн үндэсний мэдүүлэг гаргах гэдэгт түүнийг цаашид хэрхэхээс үл шалтгаалан холбогдох оронд мэдүүлэг гаргасан өдрийг тогтоох зорилгоор мэдүүлэг гаргахыг ойлгоно.

В.

Иймд дээр дурдсан хугацаа дуусахаас өмнө холбооны гишүүн бусад оронд цаашид мэдүүлэг гаргасныг энэ хугацааны гүйцэтгэсэн үйлдлийн үндсэн дээр буюу тэдгээр үйлдэл нь гуравдагч этгээдийн аливаа эрх үүсэх болон хувьдаа ашиглах аливаа эрх үүсэх үндэслэл болохгүй байвал, тухайлбал өөр газарт мэдүүлэг гаргасан, шинэ бүтээл хэвлэн нийтлэгдсэн, түүнийг ашигласан, бүтээгдэхүүний зарим хэсгийг худалдаанд гаргасан, тэмдгийг ашигласан гэсэн үндэслэлээр түүнийг хүчин төгөлдөр бус гэж хүлээн зөвшөөрөхгүй. Давамгайлах эрхийн үндэслэл болж чадах анхны мэдүүлэг гаргахаас өмнө гуравдагч этгээдийн олж авсан эрх нь холбооны гишүүн орон бүрийн дотоодын хууль, тогтоомжийн дагуу хадгалагдана.

С.

(1) Давамгайлах эрхийн дээр дурдсан хугацаа нь шинэ патент, ашигтай загварт арван хоёр сар, аж үйлдвэрийн загвар болон барааны тэмдэгт зургаан сар байна.

(2) Эдгээр хугацааг анхны мэдүүлэг өгсөн өдрөөс эхлэн тооцно. Мэдүүлэг гаргасан өдрийг хугацаанд оруулахгүй.

(3) Хэрэв энэ хугацааны эцсийн өдөр хууль ёсны амралтын өдөр, эсхүл эрхийн хамгаалалт хүсэж байгаа орны байгууллага мэдүүлэг хүлээж авдаггүй амралтын өдөр байвал хугацааг дараагийн анхны ажлын өдрийг хүртэл сунгана.

(4) Хэрэв дараагийн мэдүүлэг гаргасан өдөр анхны мэдүүлгийг буцааж авсан, хөдөлгөөнгүй орхисон, хойшлуулсан, нийтэд танилцуулахад хангалтгүй, түүнчлэн аливаа эрхийг хэрэгжүүлэхээр түүнийг үргэлжлүүлээгүй болон тэр нь давамгайлах эрхэд татгалзах үндэслэл гаргаагүй тохиолдолд холбооны гишүүн тэр улсад гаргасан, (2) дахь хэсэгт дурдсан агуулгаар гаргасан анхны урьдах мэдүүлэгт тодорхойлсон шинэ бүтээлд давамгайлах хугацаа дуусах өдөрт гаргасан дараагийн мэдүүлгийг анхны мэдүүлгээр тооцох ёстой. Анхны өмнөх мэдүүлэг, давамгайлах эрхийг татгалзах үндэслэл болохгүй.

D.

(1). Анхны өмнөх мэдүүлгийн үндсэн дээр давамгайлах давуу байдал ашиглахыг хүсэж байгаа аливаа этгээдээс мэдүүлэг гаргасан өдөр болон орныг заасан мэдүүлэг өгөхийг шаардана. Орон бүр ийм мэдүүлгийг гаргах сүүлчийн хугацааг тогтооно.

(2) Эдгээр заалтыг эрх бүхий байгууллагаас хэвлэн гаргадаг нийтлэлд, түүнчлэн патент болон түүнд хамаарах шинэ бүтээлийн тодорхойлолтод дурдсан байх ёстой.

(3) Холбооны гишүүн орнууд давамгайлах эрхийн тухай мэдэгдэл гаргасан этгээдээс түүний урьд нь гаргасан мэдэгдлийн хуулбарыг (тодорхойлолт, зураглал г.м) ирүүлэхийг шаардаж болно. Энэ мэдэгдлийг хүлээн авсан байгууллага хуулбар үнэн зөв гэж баталгаажуулсан хуулбарт хуулийн ямар нэгэн баталгаажилт шаардахгүй бөгөөд ямар ч тохиолдолд түүнийг дараачийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш гурван сарын дотор ямар нэгэн хураамжгүйгээр ирүүлж болно. Харин мэдүүлэг анх гаргасан өдрийн тухай уг байгууллагаас авсан магадалгаа болон орчуулгыг хавсаргаж ирүүлэхийг шаардах эрхтэй байна.

(4) Мэдэгдэл гаргах үед нь давамгайллын тухай мэдэгдэлд зориулсан өөр ямар нэгэн албан ёсны шаардлага тавьж болохгүй. Холбооны гишүүн орон бүр давамгайлах эрхийг алдахаас илүү, энэхүү зүйлд дурдсан албан ёсны шаардлагыг мөрдөхгүйгээс үүсгэх үр дагаврыг тодорхойлно.

(5) Цаашдаа өөр нотолгоо шаардагдаж болно.

Анхны өмнөх мэдүүлгийн үндсэн дээр давамгайлал хүсэж байгаа этгээд уг мэдүүлгийн дугаарыг заах ёстой. Энэ дугаар (2) дахь хэсэгт дурдсан журмаар хэвлэн нийтлэгдэнэ.

E

(1) Ашигтай загварт гаргасан мэдүүлэгт үндэслэсэн давамгайлах эрхийг хэрэглэж байгаа оронд бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргаж байвал давамгайлах хугацааг бүтээгдэхүүний загварт тогтоосон хугацаагаар авна.

(2) Үүнээс гадна, аливаа оронд патентад гаргасан мэдүүлэгт үндэслэсэн давамгайлах эрхийг хэрэглэж байгаа тохиолдолд ашигтай загварын мэдүүлэг гаргах, эсхүл эсрэг байхыг зөвшөөрнө.

F.

Холбооны гишүүн аль ч орон мэдүүлэг гаргагч хэд хэдэн оронд тогтоосон олон давамгайлал хүсэж байгаа, эсхүл нэг буюу хэд хэдэн давамгайлал хүсэж байгаа мэдүүлэг нэг буюу хэд хэдэн хэсгээс бүрдэж, тэдгээр нь давамгайлал хүсэж байгаа мэдүүлэгт ороогүй гэдэг үндэслэлээр хэрэв, зөвхөн энэ хоёр тохиолдолд тухайн улсын хуулиар шинэ бүтээлийн нэгдмэл байдал хангасан байвал дээрх патентын мэдүүлгийг бүртгэхээс татгалзах, давамгайлах эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх эрх эдлэхгүй.

Нэг буюу олон мэдүүлэгт орсон хэсгүүдийн хувьд давамгайлал хүсэж байвал дараачийн мэдүүлгийг гаргах нь хэвийн нөхцөлд давамгайлах эрх үүсгэнэ.

G.

(1) Хэрэв магадлан дүгнэлтийн явцад мэдүүлсэн шинэ бүтээл олон бүтээлд хамаарч байвал, мэдүүлэг гаргагч, давамгайлах эрхийн давуу байдлын зохих тохиолдолд анхны мэдүүлэг гаргасан өдрийн мэдүүлэг бүрд хэвээр хадгалахаар мэдүүлгийг хэд хэдэн мэдүүлэг болгон салгаж болно.

(2) Мэдүүлэг гаргагч өөрийн санаачилгаар, давамгайлах эрхийн давуу байдлын зохих тохиолдолд анхны мэдүүлэг гаргасан өдрийг мэдүүлэг бүрд хэвээр хадгалахаар мэдүүлгийг хэд хэдэн мэдүүлэг болгон салгаж болно. Холбооны гишүүн орон бүр мэдүүлгийг салгахыг зөвшөөрөх нөхцөлийг тодорхойлох эрх эдэлнэ.

H.

Давамгайлал хүсэж байгаа шинэ бүтээлийн хэсгүүд мэдүүлгийн багц баримт бичигт илэрсэн тохиолдолд шинэ бүтээлийн зарим хэсгүүд гарлын оронд гаргасан мэдүүлэгт тодорхойлогдоогүй гэдэг шалтгаанаар давамгайлал эдлүүлэхээс татгалзахгүй.

I.

(1) Шинэ бүтээлийн патент эсхүл зохиогчийн гэрчилгээг өөрийн сонголтоор хүсэх эрх эдэлдэг оронд шинэ бүтээлийн мэдүүлэг нь патентын мэдүүлгийг авахад мөрддөгтэй адил нөхцөлд, энэхүү зүйлийн заалтын дагуу давамгайллын эрхийг хүсэх үндэслэл болно.

(2) Шинэ бүтээлийн патент эсхүл зохиогчийн гэрчилгээг өөрийн сонголтоор хүсэх эрх эдэлдэг оронд амьдарч байгаа шинэ бүтээлийн зохиогчийн гэрчилгээ авах мэдүүлэг гаргагч нь патент, ашигтай загвар буюу шинэ бүтээлийн зохиогчийн гэрчилгээ хүссэн мэдүүлэгт үндэслэгдсэн давамгайлах эрхийг патентын мэдүүлэгт хамаарах энэхүү зүйлийн заалтын дагуу эдэлнэ.

4 bis зүйл

Патент: өөр өөр оронд ижил төрлийн шинэ бүтээлд олгогдсон патентын үл хамаарал

(1) Холбооны гишүүн орны харьяатаас холбооны гишүүн өөр өөр оронд гаргасан мэдүүлгийн патент нь холбооны гишүүн эсхүл гишүүн бус бусад аль ч оронд авсан адил шинэ бүтээлийн патентаас үл хамаарна.

(2) Энэхүү заалтыг ямар нэгэн хязгаарлалтгүй авч үзэх бөгөөд, тухайлбал давамгайлах хугацаанд мэдүүлэг гаргасан патент нь патентыг хүчингүй болгох, эрхийн үйлчлэлийг зогсоох түүнчлэн ердийн хүчинтэй байх хугацааг тогтоох үүднээс ч гэсэн үл хамааралтай гэсэн утгаар авч үзнэ.

(3) Энэхүү заалт нь түүнийг хүчин төгөлдөр болох үед хэрэгжиж байгаа бүх патентад хамаарна.

(4) Энэхүү заалтыг шинээр орнууд нэгдэн орох тохиолдолд тухайн нэгдэн орох мөчид аль ч талаасаа хэрэгжиж байгаа патентын хувьд мөн адил хэрэглэнэ.

(5) Давамгайллаас үүсэх давуу байдлаар авсан патент нь холбооны гишүүн бүх оронд патентыг авахдаа давамгайллаас үүсэх давуу байдлаар бус мэдүүлэг гаргасан, эсхүл ийм байдлаар олгогдсон патентын адил үйлчлэх хугацаатай байна.

4 ter зүйл

Патент, патентад зохиогчийг заах

Зохиогч патентад өөрийн нэрийг заалгах эрх эдэлнэ.

4 quater зүйл

Патент: Хуулийн дагуу худалдааг хязгаарлах тохиолдолд патентлаг чадвар хадгалагдах

Патентлагдсан аргаар үйлдвэрлэгдсэн эсхүл патентлагдсан бүтээгдэхүүний худалдааг үндэсний хууль тогтоомжийн үндсэн дээр хязгаарласан буюу багасгасан гэдэг үндэслэлээр патент олгохыг татгалзах буюу патентыг хүчингүйд тооцож болохгүй.

5 дугаар зүйл

А. Патент: Бүтээлийг импортлох, ашиглахгүй байх болон хангалтгүй ашиглах, албадан лиценз

В. Бүтээгдэхүүний загвар: ашиглахгүй байх, барааг импортлох

С. Барааны тэмдэг: ашиглахгүй байх, хэлбэрийн ялгаа, хамтран эзэмшигчийн ашиглалт

Д. Патент, ашигтай загвар, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар: тэмдэг хэрэглэх

А.

(1) Холбооны гишүүн аль нэг оронд үйлдвэрлэсэн барааг, патент олгосон оронд патент эзэмшигч оруулбал түүнд үндэслэсэн эзэмшигчийн эрхэд хохирол үүсэхгүй.

(2) Холбооны гишүүн орон бүр ашиглагдаагүй шинэ бүтээлийн хувьд патентаар олгогдсон онцгой эрхийг хэрэгжүүлэх явцад гарч болох зүй бусын ашиглалтыг таслан зогсоох зорилгоор албадан лиценз өгөх тухай хууль ёсны арга хэмжээ авах эрх эдэлнэ.

(3) Албадан лиценз өгөх нь зүй бус ашиглалтыг таслан зогсооход хангалтгүй гэж үзвэл патентын эрхийг хасаж болно. Патентыг хүчингүй болгох, патентын эрхийг

хасах аль ч үйлдлийг анхны албадан лиценз өгснөөс хойш хоёр жилийн хугацаа дуусахаас өмнө хийж болохгүй.

(4) Патентын мэдүүлэг гаргаснаас хойш дөрвөн жил өнгөрөөгүй буюу патент олгосноос хойш гурван жил өнгөрөөгүй болон аль хугацаа нь сүүлд дуусахаас өмнө ашиглаагүй буюу хангалтгүй ашигласан гэдэг шалтгаанаар албадан лиценз өгөхийг шаардаж болохгүй; хэрэв патент эзэмшигч түүнийг ашиглаагүй байсан тухай үйлдлээ нотолж байвал албадан лиценз өгөхөөс татгалзана. Тийм лиценз нь онцгой бус байх ба мөн энэ лицензийг хэрэглэж байгаа үйлдвэрийн газрын хэсэгт нь өгөх давхар хараат лиценз өгөх зөвшөөрөлтэй байна.

(5) Дээр дурдсан заалтыг шаардлагатай засвар, найруулгатайгаар ашигтай загварт хэрэглэж болно.

В.

Бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалтыг, түүнийг ашиглаагүй эсхүл эрхийн хамгаалалттай бүтээгдэхүүнтэй адил төстэй, ижил гарлын бараа импортолсон гэдэг шалтгаанаар ямар ч нөхцөлд зогсоож болохгүй.

С.

(1) Хэрэв бүртгэгдсэн тэмдгийг аль нэг оронд заавал ашиглах ёстой нөхцөлд ашиглагдаагүйг нь үнэмшилтэй шалтгаанаар сонирхогч этгээдийн зүгээс нотлоогүй тохиолдолд, мөн боломжит хугацаа дууссан тохиолдолд л түүний бүртгэлийг хүчингүй болгож болно.

(2) Холбооны гишүүн аль нэг оронд бүртгэгдсэн тэмдгийн ялгагдах үндсэн шинжийг өөрчлөөгүй бөгөөд зөвхөн зарим нэг өөр бүрдэлтэй хэлбэрээр тэмдгийг эзэмшигч нь ашигласан нь тэмдэгт олгосон эрхийн хамгаалалтыг хязгаарлахгүй бөгөөд бүртгэлийг хүчингүй болгохгүй.

(3) Эрхийн хамгаалалт хүсэж байгаа тухайн орны дотоодын хуулийн дагуу тэмдгийн хам эзэмшигчид болох үйлдвэрлэл, худалдааны байгууллагууд адил төрлийн буюу ижил үүслийн бүтээгдэхүүний тэмдгийг зэрэг ашиглах нь хэрэв тэмдгийн тийм ашиглалт нь олон нийтэд буруу ойлголт өгөхгүй, олон нийтийн сонирхолтой зөрчилдөхгүй байвал эрхийн хамгаалалт хүсэж байгаа холбооны гишүүн аль нэг орны тэмдгийн бүртгэлд саад болохгүй бөгөөд ямар нэгэн байдлаар эрхийн хамгаалалтыг хязгаарлахгүй.

Д.

Эрхийг хүлээн зөвшөөрөхдөө бүтээгдэхүүнд тавьсан ямар нэгэн тэмдэглэл буюу патент, ашигтай загвар, барааны тэмдгийн бүртгэл болон бүтээгдэхүүний загварын хадгалалтын талаар ямар нэгэн заалт хийсэн байхыг шаардахгүй.

5 bis зүйл

Аж үйлдвэрийн өмчийн эрхийн бүх төрөл: эрхийг хадгалах хураамжийн төлбөрийн хөнгөлөлтийн хугацаа: Патент сэргээх

(1) Аж үйлдвэрийн өмчийн эрхийг хадгалахад төлөх хураамжид олгох хөнгөлөлтийн хугацаа нь үндэсний хуулиар тогтоосон хураамж байвал, түүнд оногдох нэмэгдэл хураамжийн хамт зургаан сараас багагүй байхаар тогтооно.

(2) Холбооны гишүүн орон хураамж төлөгдөөгүйгээс болоод хүчингүй болсон шинэ бүтээлийн патентыг сэргээх эрх эдэлнэ.

5 ter зүйл

Патент: Тээврийн хэрэгслийн хэсэг болох патентлагдсан бүтээлийг чөлөөтэй ашиглах

Холбооны гишүүн орон бүр дараахь үйлдлийг патент эзэмшигчийн эрхийг зөрчсөнд тооцохгүй:

- (i) холбооны гишүүн орны нутагт усан замаар тохиолдлоор буюу түр нэвтэрч орсон бусад орны хөлөг онгоцны гадар бие, хөдөлгүүр, татуургын сүлжил, механизм болон бусад тоног төхөөрөмжид патентлагдсан хэрэгслийг онцгой шаардлагаар ашигласан бол;
- (ii) холбооны гишүүн орны нутагт агаарын болон газрын замаар тохиолдлоор буюу түр нэвтэрч орсон бусад орны агаарын болон газрын хөдлөх бүрэлдэхүүний угсралт, ашиглалт болон тэдгээрийн туслах тоноглолд патентлагдсан хэрэгслийг ашигласан бол.

5 quater зүйл

Патент: Импортлож буй улсад патентлагдсан аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг импортлох

Патентлагдсан аргаар үйлдвэрлэсэн барааг эрхийн хамгаалалт хийсэн холбооны гишүүн оронд импортлоход патент эзэмшигч тухайн оронд патентлагдсан аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувьд импортлож байгаа орны үндэсний хуулиар түүнд олгогдсон бүх эрхийг эдэлнэ.

5 quinquies зүйл

Бүтээгдэхүүний загвар

Холбооны гишүүн бүх улсад бүтээгдэхүүний загвар хамгаалагдана.

6 дугаар зүйл

Тэмдэг: Бүртгэх нөхцөл; өөр өөр оронд нэг тэмдгийн хамгааллын үл хамаарал

(1) Барааны тэмдгийг бүртгэх ба мэдүүлэг гаргах нөхцөлийг холбооны гишүүн орон бүр өөрийн үндэсний хууль тогтоомжоор тодорхойлно.

(2) Гэхдээ холбооны гишүүн орны харьяатаас холбооны гишүүн аливаа бусад оронд мэдүүлсэн барааны тэмдгийг гарлын оронд мэдүүлэг өгөөгүй, бүртгүүлээгүй, хугацаа сунгаагүй гэдэг шалтгаанаар бүртгэхээс татгалзах эсхүл хүчин төгөлдөр бус гэж үзэхгүй.

(3) Холбооны гишүүн аль нэг оронд зохих журмаар бүртгүүлсэн барааны тэмдгийг нь гарлын орон болон холбооны гишүүн бусад оронд бүртгүүлсэн тэмдгээс үл хамааралтай гэж тооцно.

6 bis зүйл

Тэмдэг: Нийтээр мэдэх барааны тэмдэг

(1) Холбооны гишүүн орон, тэмдгийг хэрэглэж байгаа буюу тэмдгийг бүртгэсэн орны эрх бүхий байгууллагын тодорхойлсноор конвенцийн давуу эрхийг эдлэгч этгээдийн өөрийн буюу адил төрлийн бүтээгдэхүүнд хэрэглэдэг тэмдэг тухайн улсад нийтээр мэддэг болсон тэмдэгтэй төөрөгдөл үүсгэж болохуйц ба тэмдгийг дуурайлган үйлдсэн, хуулбарласан, орчуулсан барааны тэмдгийг сонирхогч этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу эсхүл тухайн орны хууль тогтоомжоор зөвшөөрч байвал хэрэглэхийг хориглох, бүртгэлийг хүчингүй болгох, бүртгэхээс татгалзах үүрэг хүлээнэ. Энэ заалт, тэмдгийн зонхилох бүрдэл хэсэг нь нийтэд илэрхий болсон тэмдгийн хуулбар буюу түүнийг дуурайлгасан, түүнтэй төөрөгдөл үүсгэж болохуйц байгаа тохиолдолд бүрэн хамаарна.

(2) Тийм тэмдгийг хүчингүй болгох тухай шаардлага гаргахын тулд тэмдгийн бүртгэлийн өдрөөс эхлэн таван жилээс багагүй хугацаанд мэдэгдэнэ. Холбооны гишүүн орон, тэмдгийн ашиглалтыг хориглох шаардлага гаргаж болох хугацааг ч тогтоох эрх эдэлнэ.

(3) Шударга бусаар ашиглаж байгаа болон бүртгэгдсэн тэмдгийг ашиглахыг хориглох буюу хүчингүй болгох тухай шаардлага гаргахад хугацаа тогтоохгүй.

6 ter зүйл

Тэмдэг: Улсын сүлд, хяналтын тусгай тэмдэглэгээ болон засгийн газар хоорондын байгууллагын бэлгэ тэмдэгтэй холбоотой тэмдгийг хориглох

(1) (a) Холбооны гишүүн бусад орны төрийн бэлгэ тэмдэг, далбаа, сүлд, тэдгээр улсын баталгаажуулалт, хяналтын тэмдэглэл, тусгай тэмдэг, түүнчлэн сүлдний үүсэл, дүрслэлийн талаас авч үзэхэд дууриалгасан тэмдгийг барааны тэмдгээр буюу түүний ямар нэгэн бүрдэл хэсгээр эрх бүхий засаглалын зөвшөөрөлгүй ашиглаж байгааг зохих арга хэмжээ авах замаар хориглох, бүртгэлийг хүчингүй болгох, бүртгэхээс татгалзах талаар холбооны гишүүн орнууд харилцан тохиролцоно.

(b) (a) дэд хэсэгт дурдсан заалт нь эрхийн хамгаалалтыг хангахад чиглэгдсэн хүчин төгөлдөр олон улсын хэлэлцээрээр тодорхойлсон сүлд, далбаа, бусад бэлгэ тэмдэг, хураангуйлсан болон бүтэн нэрээс бусад сүлд, далбаа, бусад бэлгэ тэмдэг, холбооны нэг буюу хэд хэдэн орон гишүүн нь байдаг засгийн газар хоорондын байгууллагын хураангуйлсан болон бүтэн нэрэнд адил хэмжээгээр хамаарна.

(c) Холбооны гишүүн аль ч орон (b) дэд хэсэгт дурдсан заалтыг энэхүү конвенц тухайн оронд хүчин төгөлдөр болохоос өмнө шударгаар олж авсан эрх эзэмшигчид хохирол учруулах байдлаар хэрэглэх ёсгүй. Хэрэв (a) дэд хэсэгт дурдсан бүртгэл, ашиглалт нь тухайн байгууллага, сүлд, далбаа, бэлгэ тэмдэг, хураангуйлсан

болон бүтэн нэртэй холбоотой байна гэсэн сэтгэгдэл нийтэд үүсгэхгүй, эсхүл энэ бүртгэл, ашиглалт байгууллага, ашиглагчийн хоорондох харилцаанд нийтэд төөрөгдөл үүсгэхээр илэрхий чиглэгдээгүй байвал холбооны гишүүн орон дурдсан заалтыг хэрэглэх үүрэггүй.

(2) Баталгаажуулалт, хяналтын тэмдэглэгээ, тусгай тэмдгийг хэрэглэхийг хориглох үйлдэл нь тэмдэг, эсхүл түүнийг бүрдэлдээ багтаасан тэмдгийг тэр төрлийн буюу адил бараанд ашиглахаар зориулагдсан байх тохиолдолд хүчинтэй байна.

(3) (а) Эдгээр заалтыг хэрэглэх зорилгоор холбооны гишүүн орнууд, олон улсын товчоогоор зуучлуулан улсын бэлгэ тэмдэг, баталгаажуулалт, хяналтын тэмдэглэл, тусгай тэмдэг зэрэг цаашдаа энэхүү зүйлийн хамгаалалтад бүрэн хэмжээгээр эсхүл зарим хязгаартай оруулахыг хүсэж байгаа тэмдгийн жагсаалтыг харилцан мэдээлэх, түүнчлэн энэхүү жагсаалтад цаашид орох өөрчлөлтийн талаар харилцан мэдээлж байхаар тохиролцов. Холбооны гишүүн орон мэдээлсэн тэмдгийн жагсаалтыг нийтэд танил болгох зорилгоор цаг алдалгүй хэвлэн нийтэлнэ. Гэхдээ улсын далбааны хувьд тийм мэдээлэл хийх үүрэггүй.

(b) Энэхүү зүйлийн (1) дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурьдсан заалт, зөвхөн олон улсын товчоогоор зуучлуулж холбооны гишүүн орнууд мэдээлэгдсэн сүлд, далбаа, бусад бэлгэ тэмдэг, олон улсын засгийн газар хоорондын байгууллагын хураангуйлсан болон бүтэн нэрэнд хэрэглэгдэнэ.

(4) Холбооны гишүүн орон бүр өөрийн боломжийн хэрээр татгалзсан байдлаа, олон улсын товчоогоор зуучлуулан сонирхогч орон болон олон улсын засгийн газар хоорондын байгууллагад, мэдээллийг хүлээж авснаас хойш арван хоёр сарын дотор мэдэгдэнэ.

(5) Улсын далбааны хувьд (1) дэх хэсэгт дурдсан арга хэмжээг 1925 оны 11 дүгээр сарын 6-ны өдрөөс хойш бүртгэгдсэн тэмдэгт хэрэглэнэ.

(6) Далбаанаас бусад төрийн бэлгэ тэмдгийн хувьд болон холбооны гишүүн орны тэмдэглэл, тусгай тэмдэг, сүлд, далбаа, бусад бэлгэ тэмдэг, олон улсын засгийн газар хоорондын байгууллагын хураангуйлсан болон бүтэн нэрийн хувьд энэ заалт, зөвхөн дээрх (3) дахь хэсэгт дурдсан мэдээллийг хүлээж авснаас хойш хоёр сар өнгөрсний дараа бүртгэгдсэн тэмдэгт хэрэглэгдэнэ.

(7) Шударга бус үйлдлийн тохиолдолд улсууд, 1925 оны 11 дүгээр сарын 6-аас өмнө бүртгэгдсэн төрийн бэлгэ тэмдэг, тэмдэглэл, тусгай тэмдгийг агуулсан тэмдгийг хүчингүй болгох эрх эдэлнэ.

(8) Өөрийн улсын төрийн бэлгэ тэмдэг, тэмдэглэл, тусгай тэмдэг хэрэглэх зөвшөөрөлтэй харьяатууд эдгээр тэмдгийг бусад оронд адил төстэй тэмдэг байгаа тохиолдолд ч хэрэглэж болно.

(9) Хэрэв тухайн ашиглалт нь барааны гарлын хувьд төөрөгдөл үүсгэж болохоор байвал, холбооны гишүүн бусад орны сүлдийг зөвшөөрөлгүйгээр худалдаанд хэрэглэхийг хориглох үүрэгтэй.

(10) Дээр дурдсан заалтууд нь 6 quinquies зүйлийн В бүлгийн (3) дахь хэсэгт дурдсан холбооны гишүүн орны гаргасан тэмдэглэл, тусгай тэмдэг, сүлд, далбаа, төрийн бусад бэлгэ тэмдгийг болон (1) дэх хэсэгт жагсаасан олон улсын засгийн газар хоорондын байгууллагын ялгах тэмдгийг зөвшөөрөлгүй агуулсан тэмдгийг хүчингүй болгох, бүртгэлээс татгалзах эрхийг орнууд хэрэгжүүлэхэд саад учруулахгүй.

6 quater зүйл

Тэмдэг: тэмдэг шилжүүлэх

(1) Тухайн тэмдгийг ашиглаж байгаа үйлдвэрлэл, худалдааны байгууллагатай нь хамт шилжүүлж байвал ийм шилжүүлэлтийг хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд үйлдвэрлэл, худалдааны байгууллагын хагас нь тухайн оронд байрлаж, шилжүүлсэн тэмдгийг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээгдэхүүнийг борлуулах онцгой эрхийг хамтад нь шилжүүлж авсан тохиолдолд л холбооны гишүүн орны хууль тогтоомжийн дагуу тэмдгийн шилжүүлэлт хүчин төгөлдөр гэж үзнэ.

(2) Энэхүү заалт нь холбооны гишүүн оронд, тухайн тэмдгийн шилжүүлэлт хүчин төгөлдөр байх, эрх шилжүүлж авсан этгээдийн ашиглалт уг тэмдгийг ашиглаж байгаа бүтээгдэхүүний чанар, шинж байдал, гарал үүслийн хувьд нийтэд төөрөгдөл үүсгэж болох байдлыг авч үзэх үүрэг ноогдуулахгүй.

6 quinquies зүйл

Тэмдэг: Холбооны гишүүн нэг оронд бүртгэгдсэн тэмдгийг холбооны гишүүн бусад оронд хамгаалах

А.

(1) Гарлын орондоо зохих журмын дагуу бүртгэгдсэн барааны тэмдэг бүрийг холбооны гишүүн бусад оронд бүртгүүлэхээр мэдүүлж болох бөгөөд энэ зүйлд заасан тайлбараар ямар байгаагаар нь хамгаална. Эдгээр орон бүртгэлийг бүрэн албан ёсны болтол гарлын оронд нь эрх бүхий байгууллагад бүртгэсэн тухай гэрчилгээ ирүүлэхийг шаардаж болно. Тийм гэрчилгээнд ямар нэг баталгаа шаардахгүй.

(2) Холбооны гишүүн оронд мэдүүлэг гаргагч нь бодит болон үр ашиг бүхий үйлдвэрлэлийн буюу худалдааны байгууллагатай байх, хэрэв тэрээр холбооны хэмжээнд тийм байгууллагагүй боловч холбооны гишүүн оронд байнга оршин суудаг байх, эсхүл холбооны хэмжээнд байнга оршин суудаг орон байхгүй боловч холбооны гишүүн орны харьяат байх тохиолдлын аль нэгийг хангаж байвал тухайн орныг гарлын орон гэж үзнэ.

В.

Энэхүү зүйлд хамаарах барааны тэмдгийг зөвхөн дараахь тохиолдолд хүчин төгөлдөр бус гэж үзэх буюу бүртгэхээс татгалзаж болно:

1. Хэрэв тэмдэг нь эрхийн хамгаалалт хүсэж байгаа оронд гуравдагч этгээдийн олж авсан эрхийг хөндөж байвал;

2. Хэрэв тэмдэг нь ямар нэг ялгагдах шинж тэмдэггүй эсхүл тухайн тэмдэг нь бүтээгдэхүүний гарлын байршил, үнэ, зориулалт, тоо, чанар, төрлийн тэмдэглэл, үйлдвэрлэсэн хугацаа эсхүл эрхийн хамгаалалт хүсэж байгаа орны худалдааны тогтсон

заншил, хэвшсэн хэлбэрт нийтлэг болсон зэрэг худалдаанд хэрэглэж болох заалтыг шууд тусгасан бүрдэлтэй байвал;

3. Хэрэв тэмдэг нь нийтэд төөрөгдөл үүсгэж болох эсхүл нийгмийн хэв журам, ёс суртахуунд харшилж байвал; Чингэхдээ нийгмийн хэв журамд шууд хамаарах хууль тогтоомжийн заалтаас өөр тэмдгийн тухай хууль тогтоомжийн ямар нэгэн заалтад тохирохгүй гэсэн ганцхан шалтгаанаар нийгмийн хэв журамд харшилж байна гэж үзэхгүй. Гэхдээ энэхүү заалтад 10 bis зүйлийн заалтыг ашиглана.

C.

(1) Тэмдгийг эрхийг хамгаалалтад авах эсэхийг тодорхойлохын тулд бүхий л бодит нөхцөл, тухайлбал тэмдгийн ашиглагдсан хугацааг авч үзнэ.

(2) Гарлын оронд бүртгэгдсэн тэмдгийн ялгагдах шинжийг өөрчлөөгүй бөгөөд тэмдгийн зөвхөн бүрдэл нь өөрчлөгдсөнөөр гарлын оронд хамгаалагдсан тэмдгээс ялгагдаж байна гэдэг ганцхан үндэслэлээр барааны тэмдгийг холбооны гишүүн бусад оронд бүртгэхээс татгалзаж болохгүй.

D.

Хэрэв гарлын оронд бүртгэгдээгүй тэмдэгт эрхийн хамгаалалт хүсэх тохиолдолд энэхүү зүйлийн заалтыг хэн ч ашиглаж болохгүй.

E.

Гэхдээ гарлын оронд хийсэн тэмдгийн бүртгэлийн шинэчлэл ямар ч тохиолдолд, уг тэмдэг бүртгэгдсэн холбооны гишүүн өөр оронд бүртгэлийг шинэчлэх үүрэг үүсгэхгүй.

F.

Гарлын оронд хийгдсэн бүртгэл 4 дүгээр зүйлд заасан хугацаанаас хожуу хийгдсэн ч, уг хугацаанд багтаж тэмдэг бүртгүүлэхээр өгсөн мэдүүлэгт давамгайлах эрхийн давуу тал хадгалагдсан байна.

6 sexies зүйл

Тэмдэг: Үйлчилгээний тэмдэг

Холбооны гишүүн орон үйлчилгээний тэмдгийг хамгаалах үүрэг хүлээнэ. Гэхдээ тэд эдгээр тэмдгийг бүртгэх үүрэг хүлээхгүй.

6 septies зүйл

Тэмдэг: Эзэмшигчийн зөвшөөрөлгүй түүний төлөөлөгч, итгэмжлэгчээр бүртгэл хийлгэх

(1) Холбооны гишүүн аль нэг орны тэмдэг эзэмшигчийн төлөөлөгч эсхүл итгэмжлэгч эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр нэг буюу хэд хэдэн гишүүн оронд тэр тэмдгийг бүртгүүлэхээр өөрийн санаачилгаар мэдүүлэг өгсөн бөгөөд, хэрэв төлөөлөгч буюу итгэмжлэгч энэ үйлдлээ үнэмшүүлсэн нотолгоо гаргаагүй, тухайн улсын хууль үүнийг зөвшөөрч байвал эзэмшигч бүртгэлийг хийлгэхгүй эсэргүүцэх, түүнийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл өөрийн ашигт зориулж бүртгэлийг дахин бүртгүүлэх эрх эдэлнэ.

(2) хэрэв эзэмшигч төлөөлөгч буюу итгэмжлэгчдээ тэмдэг ашиглах зөвшөөрөл өгөөгүй бол (1) дэх хэсэгт заасан нөхцөлийг дагуу эзэмшигч тэмдгийн ашиглалтыг эсэргүүцэх эрх эдэлнэ.

(3) Үндэсний хууль тогтоомжоор энэхүү зүйлд заасан эрхийг эзэмшигч ашиглах боломжит хугацааг тогтоож болно.

7 дугаар зүйл

Тэмдэг: Тэмдэг хэрэглэж байгаа бүтээгдэхүүний шинж

Барааны тэмдэг хэрэглэгдэж байгаа бүтээгдэхүүний шинж байдал ямар ч тохиолдолд тэмдгийн бүртгэлийг саатуулах зүйл болохгүй.

7 bis зүйл

Тэмдэг: Хамтын тэмдэг

(1) Холбооны гишүүн орнууд гарлын орны хуультай зөрчилдөөгүй тохиолдолд үйлдвэрлэл, худалдааны байгууллага биш холбоодын хамтын тэмдгийг хамгаалах, бүртгүүлэх мэдүүлгийг хүлээн авах үүрэг хүлээнэ.

(2) Орон бүр хамтын тэмдгийг хамгаалах онцгой нөхцөлийг өөрөө тодорхойлох бөгөөд хэрэв энэ тэмдэг нийтийн сонирхолд харшилж байвал түүний эрхийн хамгаалалтыг татгалзаж болно.

(3) Гэхдээ хоршоо оршин тогтнох нь гарлын орны хууль тогтоомжтой харшлаагүй тохиолдолд уг хоршоод нь эрхийн хамгаалалт хүсэж байгаа оронд оршдоггүй эсхүл тэр орны хуультай зохицоогүй байгуулагдсан гэдэг үндэслэлээр хамтын тэмдгийн эрхийн хамгаалалтыг татгалзаж болохгүй.

8 дугаар зүйл

Аж ахуйн нэгжийн нэр

Холбооны гишүүн бүх оронд аж ахуйн нэгжийн нэрийг барааны тэмдгийн бүрдэлд орсон эсэхээс үл хамааран түүнийг мэдүүлэг гаргахыг шаардахгүйгээр эсхүл бүртгэлгүйгээр хамгаална.

9 дүгээр зүйл

Тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр: Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласан барааг импортлоход хураах

(1) Холбооны гишүүн оронд хууль ёсны хамгаалалтын эрхтэй тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар хэрэглэж байгаа бүтээгдэхүүнийг гаднаас импортлоход хураана.

(2) Хууль бус тэмдэг хэрэглэж байгаа оронд эсхүл тийм барааг импортолж буй оронд ч барааг мөн хураана.

(3) Прокурор болон бусад эрх бүхий байгууллага, сонирхогч этгээд, хувь хүн, хуулийн этгээдийн шаардлагаар орон бүрийн дотоодын хуулийн дагуу барааг хураана.

(4) Эрх бүхий байгууллагууд бараа дамжин өнгөрөх тохиолдолд хураах үүрэг хүлээхгүй.

(5) Хэрэв тухайн орны хуулиар барааг импортлох үед хураах тухай заагаагүй бол импортлохыг хориглох буюу импортолсны дараа хураах үйлдлээр барааг хураах үйлдлийг сольж болно.

(6) Хэрэв тухайн орны хуулиар барааг импортлоход хураах, импортлохыг хориглох, импортолсны дараа нь хураах тухай заагаагүй бол тухайн хуульд тохирох өөрчлөлт оруулах хүртэл эдгээр арга хэмжээг тухайн орон өөрийн харьяатад ийм тохиолдолд авах арга хэмжээтэй адил нөхцөлөөр хуулийн үйлдэл, хэрэгслээр оруулна.

10 дугаар зүйл

Худал заалт: Бүтээгдэхүүний гарал үүсэл болон үйлдвэрлэгчийн хэн болох тухай худал заалттай барааг оруулахад хураах гэх мэт

(1) Өмнөх зүйлийн заалтыг бүтээгдэхүүний гарал үүслийн тухай болон үйлдвэрлэгч, боловсруулагч, худалдаалагч хэн болох талаарх худал заалтыг шууд ба шууд бусаар ашиглах тохиолдолд хэрэглэнэ.

(2) Хувь хүн эсхүл хуулийн этгээдийн алин болохоос үл хамааран ийм барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл худалдаанд оролцсон, эсхүл барааны гарлын газар, эсхүл тийм газар байрлаж буй бүс нутагт, эсхүл худал заасан тэр оронд, эсхүл тийм худал заалтыг ашигласан газар байрлаж буй этгээдийг ямар ч тохиолдолд сонирхогч тал гэж үзнэ.

10 bis зүйл

Шударга бус өрсөлдөөн

(1) Холбооны гишүүн орнууд холбоонд оролцогч орны харьяатыг шударга бус өрсөлдөөний эсрэг үр нөлөөтэй хамгаалалтаар хангана.

(2) Үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаанд үнэнч заншилд харш өрсөлдөөний аливаа үйлдлийг шударга бус өрсөлдөөнд тооцно.

(3) Түүний дотор дараахь зүйлийг хориглоно:

- (i) өрсөлдөгчийн үйлдвэр, бараа, эсхүл өрсөлдөгчийн үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагааны хувьд ямар нэгэн аргаар андуурал үүсгэх аливаа үйлдэл;
- (ii) худалдааны үйл ажиллагааны явцад өрсөлдөгчийн үйлдвэр, бараа, эсхүл түүний үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагааны нэр хүндийг унагах худал мэдээлэл хийх;

- (iii) худалдааны явцад барааны мөн чанар, боловсруулалтын үйл ажиллагаа, үзүүлэлт, зориулалтаар ашиглахад тохирох байдал, тооны хувьд олон нийтийг төөрөгдөлд оруулах худал мэдээлэл ашиглах.

10 ter зүйл

Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр, худал заалт, шударга бус өрсөлдөөн: эрх зүйн хамгаалалт, шүүхэд хандах эрх

(1) Холбооны гишүүн орнууд холбооны гишүүн бусад орны харьяатыг 9, 10 дугаар зүйл болон 10 bis зүйлд заасан бүх үйлдлийг үр нөлөөтэй таслан зогсоох эрх зүйн хамгаалалтаар хангах үүрэгтэй.

(2) Үүнээс гадна холбооны гишүүн орнууд өөрсдийн хуулиар ийм холбоо, нэгдлүүдийг хориглоогүй тохиолдолд 9, 10 дугаар зүйл болон 10 bis зүйлд заасан үйлдлийг таслан зогсоох зорилгоор сонирхогч үйлдвэрлэгч, боловсруулагч, худалдаачны төлөөлж буй холбоо, нэгдлүүдэд эрх зүйн хамгаалалт хүсэж байгаа орны хуулиар хуулиар зөвшөөрч байгаа хэмжээнд шүүх болон захиргааны байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

11 дүгээр зүйл

Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг: Зарим олон улсын үзэсгэлэнд түр хамгаалалт олгох

(1) Холбооны гишүүн орнууд өөрийн хууль тогтоомжийн дагуу түүний нутаг дэвсгэр дээр зохион байгуулах албан ёсны болон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын үзэсгэлэнд тавигдсан барааны хувьд патентын чадвартай шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон барааны тэмдэгт хамгаалалт олгоно.

(2) Ийм түр хамгаалалт нь 4 дүгээр зүйлд заасан хугацаанаас хэтэрч болохгүй. Хэрэв уг хугацаанаас хожуу давамгайлах эрх шаардах тохиолдолд аливаа орны эрх бүхий байгууллага барааг үзэсгэлэнд тавьж сурталчилсан өдрөөс эхлэн энэ хугацааг тооцож болно.

(3) Орон бүр үзэсгэлэнд тавьсан барааны бодит нотолгоо буюу сурталчилсан хугацаа, мөн шаардлагатай бол бусад нотлох баримт бичгийг шаардаж болно.

12 дугаар зүйл

Аж үйлдвэрийн өмчийн асуудал эрхлэх үндэсний тусгай алба

(1) Холбооны гишүүн орон бүр аж үйлдвэрийн өмчийн хэрэг эрхлэх тусгай алба болон олон нийтийг патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон барааны тэмдгийн патенттай танилцуулах төвлөрсөн байгууллага байгуулах үүрэг хүлээнэ.

(2) Энэ алба нь албан ёсны тогтмол хэвлэлтэй байж, дараахь зүйлийг нийтэлнэ:

(a) патент олгосон эзэмшигчийн нэрсийг патентлагдсан бүтээлийн товч тодорхойлолтын хамт;

(b) бүртгэгдсэн тэмдгийн дардас.

13 дугаар зүйл

Холбооны Ассамблей

(1) (a) Холбоо нь 13-17 дугаар зүйлийг дагаж мөрдөх холбооны гишүүн орнуудаас бүрдсэн Ассамблейтай байна.

(b) Орон бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөгч, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(a) Ассамблей нь:

(i) холбоог удирдах, хөгжүүлэх болон энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх асуудлыг эрхэлнэ;

(ii) Дэлхийн оюуны өмчийн байгууллага (цаашид “байгууллага” гэнэ) байгуулах тухай конвенцид заасан оюуны өмчийн олон улсын товчоонд (цаашид “олон улсын товчоо” гэнэ) хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлын талаар чиглэл өгөх бөгөөд ингэхдээ 13-17 дугаар зүйлийг заавал дагаж мөрдөхгүй холбооны гишүүн орнуудын саналд зохих анхаарал тавина;

(iii) байгууллагын ерөнхий захирлаас холбооны талаар явуулсан үйл ажиллагааны тайланг хянаж батлах, холбооны эрх мэдэлд багтах бүх асуудлаар шаардлагатай бүх зааврыг түүнд өгнө;

(iv) Ассамблейн гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгоно;

(v) гүйцэтгэх хорооны тайлан болон үйл ажиллагааг хянаж баталж, түүнд чиглэл өгнө;

(vi) холбооны хөтөлбөрийг тодорхойлж, хоёр жилийн төсөв болон түүний санхүүгийн тайланг батална;

(vii) холбооны санхүүгийн журмыг батална;

- (viii) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзэх шинжээчдийн хороо, ажлын хэсэг байгуулна;
 - (ix) холбооны гишүүн бус ямар орон, түүнчлэн ямар засгийн газар хоорондын болон олон улсын засгийн газрын бус байгууллагыг түүний чуулганд ажиглагчаар оролцуулж болохыг тодорхойлно;
 - (x) 13-17 дугаар зүйлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батална;
 - (xi) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа шаардлагатай бусад арга хэмжээ авна;
 - (xii) энэхүү конвенцийн дагуух бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ;
 - (xiii) Ассамблей өөрөө зөвшөөрсөн нөхцөлд байгууллага байгуулах тухай конвенцоор тогтоосон эрхийг хэрэгжүүлнэ.
- (b) Байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын сонирхсон асуудлын хувьд Ассамблей зохицуулах хорооны зөвлөмжийг сонссоны дараа шийдвэр гаргана.
- (3) (a) (b) дэд хэсгийг мөрдөх нөхцөлд төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж болно.
- (b) Тусгай хэлэлцээрийн дагуу 12 дугаар зүйлд заасан аж үйлдвэрийн өмчийн үндэсний тусгай албаны үүргийг гүйцэтгэх дундын ерөнхий байгууллага бүхий холбооны гишүүн орнуудыг тэдгээрийн аль нэг нь төлөөлж болно.
- (4) (a) Ассамблейн гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.
- (b) Ассамблейн гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.
- (c) (b) дэд хэсгийг үл харгалзан аль нэг чуулганд Ассамблейн нийт гишүүн орны тэн хагасаас бага боловч гуравны нэг буюу түүнээс илүү гишүүн орон төлөөлөгчдөө ирүүлсэн бол Ассамблей өөрийн ажиллагааны журамд хамаарахаас бусад бүх шийдвэр гаргаж болно. Ийм шийдвэрийг гагцхүү дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо нь чуулганд оролцоогүй Ассамблейн гишүүн орнуудад дээр дурдсан шийдвэрийг илгээж, уг шийдвэрийг илгээснээс хойш гурван сарын дотор эдгээр шийдвэрт санал өгч, түдгэлзсэн эсэх тухай саналаа бичгээр ирүүлэхийг хүснэ. Тогтоосон хугацаа өнгөрөх үед энэ журмаар саналаа өгсөн буюу түдгэлзсэнээ мэдэгдсэн орны тоо чуулганд хүчинтэй болоход дутуу байсан тоонд хүрч байвал зохих олонхи байна гэж үзэж шийдвэр хүчин төгөлдөр болно.

(d) 17 дугаар зүйлийн (2) дахь хэсгийг хэрэглэх тохиолдолд Ассамблей нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрээ гаргана.

(e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(5) (a) (b) дэд хэсэгт заасан тохиолдлоос гадна төлөөлөгч зөвхөн нэг улсыг төлөөлж саналаа өгнө.

(b) (3) дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан холбооны гишүүн орнууд ерөнхий дүрмийн дагуу Ассамблейн чуулганд өөрийн орны төлөөлөгчдийг оролцуулахыг эрмэлзэнэ. Хэрэв ямар нэгэн онцгой нөхцөлд эдгээр аливаа орон өөрийн төлөөлөгчдийг оролцуулах боломжгүй бол өөр ийм орныг өөрийнх нь нэрийн өмнөөс төлөөлж санал өгөхөд итгэмжилж болно. Тэгэхдээ нэг төлөөлөгч зөвхөн нэг орны нэрийн өмнөөс санал өгч болно. Ийм санал өгөх итгэмжлэлийг төрийн тэргүүний буюу эрх бүхий сайдын гарын үсэгтэй баримтаар олгоно.

(6) Ассамблейн гишүүн бус холбооны гишүүн орнуудыг Ассамблейн чуулгаанд ажиглагчаар оролцуулна.

(7) (a) Онцгой тохиолдлоос бусад тохиолдолд ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулдаг газарт болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны буюу Ассамблейн гишүүн орны дөрөвний нэгийн хусэлтийн дагуу онцгой чуулганыг зарлан хуралдуулна.

(8) Ассамблей өөрийн ажиллагааны журмыг батална.

14 дүгээр зүйл

Гүйцэтгэх хороо

(1) Ассамблей гүйцэтгэх хороотой байна.

(2) (a) Гүйцэтгэх хороо нь Ассамблей Ассамблейн гишүүн орнуудаас сонгосон орнуудаас бүрдэнэ. Байгууллагын төв байр нутаг дэвсгэр дээр нь байрладаг орон 16 дугаар зүйлийн (7) дахь хэсгийн (b) дэд хэсгийн дагуу гүйцэтгэх хороонд нэг суудалтай байна.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүн орны засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(3) Гүйцэтгэх хорооны гишүүн орны тоо нь Ассамблейн гишүүн нийт орны дөрөвний нэгтэй тэнцүү байна. Эзэлбэл зохих суудлын тоог тодорхойлохдоо дөрөвт хуваасны дараахь үлдэгдлийг тооцоонд авахгүй.

(4) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгохдоо Ассамблей газар зүйн шударга хуваарилалт болон холбоотой байгуулсан тусгай хэлэлцээрт оролцогч орнууд гүйцэтгэх хороог бүрдүүлж буй орнуудын тоонд багтах шаардлагад зохих анхаарлыг хандуулна.

(5) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн бүр түүнийг сонгосон Ассамблейн чуулган хааснаас хойш Ассамблейн дараагийн ээлжит чуулган хаах хүртэл үүргээ хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүд дахин сонгогдож болох бөгөөд гэхдээ тоо нь уг бүрэлдэхүүний гуравны хоёроос хэтэрч болохгүй.

(c) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгох, дахин сонгох тухай тодорхой дүрмийг Ассамблей тогтооно.

(6) (a) Гүйцэтгэх хороо:

- (i) Ассамблейн хэлэлцэх асуудлын дэгийн төслийг бэлтгэнэ;
- (ii) ерөнхий захирлын бэлтгэсэн холбооны хоёр жилийн төсөв, хөтөлбөрийн төслийн талаарх саналыг Ассамблейд оруулна;
- (iii) /хасагдсан/;
- (iv) ерөнхий захирлын ээлжит тайлан, санхүүгийн аудитын жилийн тайланг зохих саналын хамт Ассамблейд оруулна;
- (v) Ассамблейн шийдвэрийн дагуу болон Ассамблейн ээлжит хоёр чуулганы хооронд буй болсон нөхцөл байдлыг харгалзан ерөнхий захирлаас холбооны хөтөлбөрийг биелүүлэх явдлыг хангахад шаардагдах бүх арга хэмжээ авна;
- (vi) энэхүү конвенцийн дагуу түүнд оноосон бусад бүх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хороо нь захиргааны үүргийг нь байгууллага хэрэгжүүлдэг бусад холбооны сонирхолд хамаарах асуудлаар байгууллагын зохицуулах хорооны саналыг сонссоны дараа шийдвэр гаргана.

(7) (a) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны ээлжит хуралдааныг аль болохоор байгууллагын зохицуулах хорооны хуралдаг газарт болон хугацаагаар жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал өөрийн санаачилгаар эсхүл хорооны даргын эсхүл гүйцэтгэх хорооны гишүүдийн дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу гүйцэтгэх хорооны онцгой хуралдааныг зарлан хуралдуулна.

(8) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(с) Санал хураалтад оролцогсдын энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.

(d) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(е) Төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.

(9) Гүйцэтгэх хорооны гишүүн бус холбооны гишүүн орнуудыг хуралдаанд ажиглагчаар оролцуулна.

(10) Гүйцэтгэх хороо өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална.

15 дугаар зүйл

Олон улсын товчоо

(1) (а) Холбооны захиргааны зорилтыг Уран зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай олон улсын конвенцоор байгуулагдсан холбооны товчоотой нэгдсэн холбооны товчоог залгамжилсан олон улсын товчоо хэрэгжүүлнэ.

(b) Түүнчлэн олон улсын товчоо холбооны төрөл бүрийн байгууллагын нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

(с) Байгууллагын ерөнхий захирал холбооны гүйцэтгэх тэргүүн болох бөгөөд холбоог төлөөлнө.

(2) Олон улсын товчоо аж үйлдвэрийн өмчийг хамгаалахтай холбоотой мэдээллийг цуглуулж хэвлэн нийтэлнэ. Холбооны гишүүн орон бүр аж үйлдвэрийн өмчийг хамгаалахтай холбоотой өөрийн шинэ хууль, албан ёсны баримт бичгийг олон улсын товчоонд цаг алдалгүй өгнө. Холбооны гишүүн орон олон улсын товчоо шаардлагатай гэж үзсэн аж үйлдвэрийн өмчийн хамгаалалтад шууд хамааралтай аж үйлдвэрийн өмчийн бүх төрлийн хэвлэлийг мөн хүргүүлнэ.

(3) Олон улсын товчоо сар бүрийн хэвлэл гаргана.

(4) Олон улсын товчоо аж үйлдвэрийн өмчийг хамгаалах талаар холбооны гишүүн аль нэг орны хүсэлтээр мэдээллээр хангана.

(5) Олон улсын товчоо аж үйлдвэрийн өмчийг хамгаалах талаар судалгаа явуулж, аж үйлдвэрийн өмчийг хамгаалах асуудлыг дэмжихийг чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.

(6) Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа этгээд Ассамблей, гүйцэтгэх хорооны болон аливаа бусад шинжээчдийн хороо, ажлын хэсгийн бүх хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа этгээд өөрийн албан тушаалын дагуу эдгээр байгууллагын нарийн бичгийн дарга байна.

(7) (a) Олон улсын товчоо Ассамблейгаас өгсөн чиглэлийн дагуу болон гүйцэтгэх хороотой хамтран конвенцийн 13-17 дугаар зүйлээс бусад заалтыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг хангана.

(b) Олон улсын товчоо хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажилтай холбогдуулан олон улсын засгийн газар хоорондын болон олон улсын засгийн газрын бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал болон түүний томилсон этгээд тэдгээр бага хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

(8) Олон улсын товчоо түүнд оногдуулсан бусад бүх даалгаврыг гүйцэтгэнэ.

16 дугаар зүйл

Санхүү

(1) (a) Холбоо төсөвтэй байна.

(b) Холбооны төсөв нь холбооны орлого, зарлага, холбооны зардлаас холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт орох хандив, тэрчлэн байгууллагын бага хурлын төсөвт орох зардал зэргээс бүрдэнэ.

(c) Холбоонд бус харин байгууллагын удирдлаган дор ажилладаг нэг буюу хэд хэдэн бусад холбоодод хамаарах зардлыг холбоодод хамаарах нийтийн зардал гэж үзнэ. Энэхүү нийтийн зардлаас холбоонд оногдох хувь нь тэдгээр холбоод дахь холбооны сонирхлын эзлэх хэмжээтэй адил байна.

(2) Холбооны төсвийг байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) Холбооны төсөв дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

- (i) холбооны гишүүн орнуудын татвар;
- (ii) холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамж;
- (iii) холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтын үнэ, түүнийг ашиглуулсны хураамж;
- (iv) бэлэг, гэрээслэлээр шилжүүлсэн зүйл, татаас;
- (v) түрээс, хувь болон бусад орлого.

(4) (a) Төсөвт төлөх татварын хэмжээг тогтоох зорилгоор холбооны гишүүн орон бүр тодорхой ангилалд хамаарах бөгөөд өөрийн жилийн татварыг дараахь байдлаар тогтоосон нэгжийн дагуу төлнө:

ангилал I	25
ангилал II	20
ангилал III	15
ангилал IV	10
ангилал V	5
ангилал VI	3
ангилал VII	1

(b) Аль ангилалд орохоо урьдчилан тогтоогүй бол орон бүр батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөхийн хамт хамаарахыг байхыг хүсэж байгаа ангиллыг заана. Аливаа орон бүр өөрийн ангиллыг сольж болно. Хэрэв тухайн орон доогуур ангиллыг сонговол, энэ өөрчлөлтийн тухайгаа Ассамблейд ээлжит чуулганы үеэр мэдэгдэнэ. Уг өөрчлөлт нь тэр тухай мэдэгдсэн чуулганы дараачийн хуанлийн жилийн эхнээс хүчин төгөлдөр болно.

(c) Орон бүрийн жилийн татвар нь түүний нэгжийн тоог татвар төлж байгаа бүх орны нэгжийн нийлбэрт харьцуулах хэлбэрээр тогтоосон, холбооны төсөвт төлөх нийт татварт эзлэх хувьтай тэнцүү байна.

(d) Татварыг жил бүрийн нэгдүгээр сарын нэгнээс эхэлж төлнө.

(e) Өмнөх хоёр бүтэн жилд өгөх ёстой татварын хэмжээтэй тэнцүү буюу түүнээс дээш өртэй орон холбооны аливаа байгууллагад санал өгөх эрхгүй. Гэхдээ төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд холбооны аль нэг байгууллага тухайн оронд санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

(f) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнөх жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Холбооны нэрийн өмнөөс олон улсын товчооны үзүүлсэн үйлчилгээний төлбөрт авах төлбөр, хураамжийн хэмжээг ерөнхий захирал тогтоож, Ассамблей болон гүйцэтгэх хороонд тайлагнана.

(6) (a) Холбоо нь холбооны гишүүн орон бүрээс өгөх нэг удаагийн төлбөрөөс бүрдэх эргэлтийн хөрөнгийн сантай байна. Хэрэв эргэлтийн хөрөнгийн сан хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(b) Дурдсан санд орон бүрийн төлөх анхны татварын хэмжээ буюу энэ санг нэмэгдүүлэхэд төлөх орон бүрийн хувь хэмжээ нь санг байгуулсан жил, эсхүл түүнийг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан жилд тухайн орноос төлөх татварын хувьтай адил байна.

(c) Энэ харьцаа, төлбөрийн нөхцөлийг ерөнхий захирлын саналын үндсэн дээр болон байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг авсны дараа Ассамблей тогтооно.

(7) (a) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг оронтой байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн орон урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ

болон урьдчилгаа олгох нөхцөлийг тусдаа байгууллага, тухайн орон хоорондын хэлэлцээрээр зохицуулна. Тэр орон урьдчилгаа өгөх үүрэг өөртөө хүлээж байгаа хугацаандаа гүйцэтгэх хороонд суудалтай байна.

(b) (a) дэд хэсэгт дурдсан орон ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(8) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу холбооны нэг буюу хэд хэдэн орон эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ассамблей томилно.

17 дугаар зүйл

13-17 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах

(1) 13, 14, 15, 16 дугаар зүйл болон энэхүү зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ассамблейн гишүүн аль ч орон, гүйцэтгэх хороо эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Ерөнхий захирал ийм саналыг Ассамблейн чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө Ассамблейн гишүүн орон бүрт илгээнэ.

(2) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей дөрөвний гурвын олонхын саналаар батална. Гэхдээ 13 дугаар зүйл болон энэхүү хэсэгт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтын тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед Ассамблейн гишүүн байсан орны дөрөвний гурав нь өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр гаргасан мэдэгдлийг ерөнхий захирал хүлээж авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүчин төгөлдөр болох хугацаанд Ассамблейн гишүүн байсан орнууд буюу түүнээс хойш Ассамблейн гишүүн болсон бүх орон заавал дагаж мөрдөнө. Гэхдээ холбооны гишүүн орны санхүүгийн хүлээх үүргийг өндөржүүлэх талаар аливаа нэмэлт, өөрчлөлтийг тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргасан орон л дагаж мөрдөнө.

18 дугаар зүйл

1-12 дугаар зүйл болон 18-30 дугаар зүйлийг хянан өөрчлөх

(1) Холбооны тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор энэхүү конвенцийг хянан өөрчилж болно.

(2) Энэ зорилгоор холбооны гишүүн орон бүрт ээлж дараалан холбооны гишүүн орнуудын төлөөлөгчдийг оролцуулсан бага хурлыг зохион байгуулна.

(3) 13-17 дугаар зүйлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг 17 дугаар зүйлийн заалтын дагуу зохицуулна.

19 дүгээр зүйл

Тусгай хэлэлцээр

Энэхүү конвенцийн заалттай зөрчилдөхгүй тохиолдолд холбооны гишүүн орнууд аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай өөр хоорондоо тусгай хэлэлцээр байгуулах эрхийг хадгална.

20 дугаар зүйл

**Холбооны гишүүн орон соёрхон батлах буюу нэгдэн орох,
хүчин төгөлдөр болох**

(1) (a) Энэхүү актад гарын үсэг зурсан холбооны гишүүн аливаа орон түүнийг соёрхон баталж болох ба хэрэв түүнд гарын үсэг зураагүй бол түүнд нэгдэн орж болно. Батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(b) Холбооны гишүүн орон бүр батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичигтээ соёрхон батлах буюу нэгдэн орох нь дараахь зүйлүүдэд хамаарахгүй гэдгийг мэдэгдэж болно:

(i) 1-12 дугаар зүйл, эсхүл

(ii) 13-17 дугаар зүйл.

(c) Соёрхон батлах буюу нэгдэн орохдоо (b) дэд хэсэгт дурдсан хоёр бүлэг зүйлийн нэгийг хамаарахгүй гэж мэдэгдсэн холбооны гишүүн аливаа орон хожим нь соёрхон батлах болон нэгдэн орох үйлдэл нь эдгээр бүлэг зүйлд хамаарна гэж мэдэгдэж болно. Ийм мэдэгдлийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(2) (a) 1-12 дугаар зүйл нь батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгээ өгөхдөө (1) дэх хэсгийн (b) дэд хэсгийн (i)-т заасан мэдэгдлийг хийгээгүй холбооны гишүүн эхний арван орны хувьд арав дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

(b) 13-17-дугаар зүйл нь батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгээ өгөхдөө (1) дэх хэсгийн (b) дэд хэсгийн (ii)-т заасан мэдэгдлийг хийгээгүй холбооны гишүүн эхний арван орны хувьд арав дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

(c) 1-17 дугаар зүйл нь (1) дэх хэсгийн (b) дэд хэсгийн (i) буюу (ii)-т дурдсан хоёр бүлэг нь (a) буюу (b) дэд хэсгийн дагуу эхэлж хүчин төгөлдөр болох нөхцөлд эсхүл (1) дэх хэсгийг (b) дэд хэсгийг мөрдөх нөхцөлд, (a) буюу (b) дэд хэсэгт дурдсан орноос бусад батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн холбооны гишүүн аливаа орны хувьд эсхүл (1) дэх хэсгийн (c) дэд хэсгийн дагуу мэдэгдэл хийсэн холбооны гишүүн аливаа орны хувьд хэрэв өргөн барьсан жуух, баримт бичиг буюу мэдэгдэлд илүү хожуу хугацаа заагаагүй бол тийм

баримт бичгийг хадгалуулахаар ерөнхий захиралд өргөн барьсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан тохиолдолд энэхүү баримт бичиг тухайн орны хувьд тэрхүү заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

(3) Батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичиг хадгалуулахаар өгөх холбооны гишүүн аливаа орны хувьд 18-30 дугаар зүйл нь (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан бүлгийн аль нэгийн хугацаанаас илүү эрт хүчин төгөлдөр болох өдөр эсхүл (2) дахь хэсгийн (a), (b) буюу (c) дэд хэсгийн дагуу энэ орны хувьд хүчин төгөлдөр болно.

21 дүгээр зүйл

Холбооны гишүүн бус орон нэгдэн орох, хүчин төгөлдөр болох

(1) Холбооны гишүүн бус аливаа орон энэхүү актад нэгдэн орж холбооны гишүүн болж болно. Нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(2) (a) Энэхүү актын аливаа заалт хүчин төгөлдөр болохоос нэг сар буюу түүнээс дээш хугацаанаас өмнө нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн холбооны гишүүн бус аливаа орны хувьд нэгдэн орсон тухай баримт бичигт илүү хожуу хугацаа заагаагүй бол заалтууд 20 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) буюу (b) дэд хэсгийн дагуу эхэлж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэхдээ:

- (i) хэрэв 1-12 дугаар зүйл энэ өдөр хүчин төгөлдөр болоогүй бол тухайн орон эдгээр заалт хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд эдгээр зүйлийн хувьд Лиссабоны актын 1-12 дугаар зүйлийг дагаж мөрдөнө;
- (ii) хэрэв 13-17 дугаар зүйл энэ өдөр хүчин төгөлдөр болоогүй бол тухайн орон эдгээр заалт хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд эдгээр зүйлийн хувьд Лиссабоны актын 13 дугаар зүйл болон 14 дүгээр зүйлийн (3), (4) буюу (5) дахь хэсгийг дагаж мөрдөнө.

Хэрэв нэгдэн орсон тухай баримт бичигтээ аливаа орон илүү хожуу хугацааг заасан бол энэхүү акт тухайн орны хувьд уг заасан өдөрт хүчин төгөлдөр болно.

(b) Энэхүү баримт бичгийн аль нэг бүлэг заалт хүчин төгөлдөр болсон өдрөөс нэг сараас богино хугацааны өмнө нэгдэн орсон тухай өөрийн баримт бичгээ хадгалуулахаар өгсөн холбооны гишүүн бус аливаа орны хувьд энэхүү баримт бичиг (a) дэд хэсгийн дагуу, хэрэв нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй бол нэгдэн орсон тухай ерөнхий захирал мэдэгдэл хийсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хэрэв нэгдэн орсон тухай баримт бичигтээ аливаа орон илүү хожуу хугацааг заасан бол энэхүү акт тухайн орны хувьд уг заасан өдөрт хүчин төгөлдөр болно.

(3) Энэхүү баримт бичиг бүрэн хэмжээнд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш юмуу тэр өдөр хүртэл нэг сараас бага хугацаанд нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар өргөн барьсан холбооны гишүүн бус аливаа улсын хувьд энэхүү баримт

бичиг, хэрэв нэгдэн орох тухай баримт бичигтээ хожуу өдрийг заагаагүй бол түүний нэгдэн орсон тухай ерөнхий захирал мэдэгдэл хийснээс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Нэгдэн орсон тухай баримт бичигтээ хугацаа заасан тохиолдолд энэхүү баримт бичиг тухайн орны хувьд заасан өдөр хүчин төгөлдөр болно.

22 дугаар зүйл

Соёрхон батлах болон нэгдэн орохын үр дагавар

20 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт болон 28 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт дурдсан нөхцөлөөс бусад тохиолдолд соёрхон батлах болон нэгдэн орсноор энэхүү актын бүх заалтуудыг хүлээн зөвшөөрөх болон түүгээр олгох бүх давуу талыг эдэлнэ.

23 дугаар зүйл

Өмнөх актуудад нэгдэн орох

Энэхүү акт бүрэн хэмжээнд хүчин төгөлдөр болсны дараа аливаа орон энэхүү конвенцийн өмнөх актуудад нэгдэн орж болохгүй.

24 дүгээр зүйл

Нутаг дэвсгэр

(1) Аливаа орон батламж жуух бичиг буюу нэгдэн орох тухай баримт бичигтээ эсхүл түүнээс хойш ямар ч хугацаанд ерөнхий захиралд бичгээр өгсөн мэдэгдэлд энэхүү конвенцийг бүх нутаг дэвсгэртээ эсхүл зөвхөн мэдэгдэлд заасан олон улсын харилцааны хувьд хариуцлага хүлээдэг зарим нутаг дэвсгэрт хэрэглэх тухай мэдэгдэж болно.

(2) Тийм мэдүүлэг гаргасан эсхүл тийм мэдэгдэл илгээсэн аливаа орон ямар ч үед энэхүү конвенцийг бүх нутаг дэвсгэрт эсхүл тухайн нутаг дэвсгэрийн зарим хэсэгт хэрэглэхгүй тухайгаа ерөнхий захиралд мэдэгдэж болно.

(3) (a) (1) дэх хэсгийн дагуу үйлдсэн аливаа мэдэгдэл нь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай бичигт заасан өдрөөс хүчин төгөлдөр болох ба дурдсан хэсгийн дагуу илгээсэн аливаа мэдэгдэл нь ерөнхий захирал энэ тухай нотолсноос хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

(b) (2) дахь хэсгийн дагуу илгээсэн аливаа мэдэгдэл нь ерөнхий захирал хүлээн авснаас хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

25 дугаар зүйл

Конвенцийг үндэсний хүрээнд хэрэглэх

(1) Энэхүү конвенцид оролцогч орон бүр орон бүр өөрийн үндсэн хуулийн дагуу энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

(2) Орон бүр батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үед дотоодын хууль тогтоомжийн дагуу энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлэх боломжтой болсон байх ёстой.

26 дугаар зүйл

Цуцлах

(1) Энэхүү конвенц нь цаг хугацааны хязгааргүй хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

(2) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдэл илгээснээр энэхүү актыг цуцалж болно. Тийм цуцлалтад нь өмнөх бүх акт багтах бөгөөд энэ нь зөвхөн мэдэгдэл хийсэн оронд хамаарна. Энэ тохиолдолд холбооны бусад орны хувьд конвенц хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.

(3) Цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэхүү зүйлд заасан цуцлах эрх аль ч оронд түүний холбооны гишүүн болсон өдрөөс хойш таван жилийн хугацаа дуусахаас өмнө үүсэхгүй.

27 дугаар зүйл

Өмнөх актыг хэрэглэх

(1) Энэхүү акт нь түүнийг мөрдөж буй орнуудын хоорондын харилцааны хувьд болон конвенцийг хэрэглэх хэмжээнд ч 1883 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Парисын конвенцийг болон түүнийг хянан өөрчилсөн актуудыг орлоно.

(2) (a) Харин энэхүү актыг мөрддөггүй буюу бүрэн бус хэмжээнд мөрддөг бөгөөд 1958 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Лиссабоны актыг мөн мөрддөг орны хувьд Лиссабоны акт нь бүрэн хэмжээнд эсхүл (1) дэх хэсгийн заалтын дагуу энэхүү актыг орлохгүй хэмжээнд хүчин төгөлдөр байна.

(b) Энэхүү баримт бичгийг бүхэлд нь буюу түүний аль ч хэсгийг, мөн Лиссабоны баримт бичгийг огт мөрддөггүй орны хувьд 1934 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Лондонгийн акт нь бүрэн хэмжээнд эсхүл (1) дэх хэсгийн заалтын дагуу энэхүү актыг орлохгүй хэмжээнд хүчин төгөлдөр байна.

(c) Энэхүү баримт бичгийг бүхэлд нь буюу түүний аль ч хэсгийг, мөн Лиссабоны болон Лондонгийн актыг огт мөрддөггүй орны хувьд 1925 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн Гаагын акт нь бүрэн хэмжээнд эсхүл (1) дэх хэсгийн заалтын дагуу энэхүү актыг орлохгүй хэмжээнд хүчин төгөлдөр байна.

(3) Холбооны гишүүн бус энэхүү баримт бичигт нэгдэн орж байгаа орнууд энэхүү актад оролцогч тал биш холбооны гишүүн аливаа орны эсхүл 20 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсгийн (i)-ийн дагуу мэдэгдэл хийсэн энэхүү актад оролцогч тал болох аль ч орны харилцаанд энэхүү баримт бичгийг хэрэглэнэ.

28 дугаар зүйл

Маргааныг шийдвэрлэх

(1) Энэхүү конвенцийг хэрэглэх болон тайлбарлахтай холбоотой холбооны гишүүн хоёр буюу хэд хэдэн орны хооронд гаргасан аливаа маргааныг хэлэлцээрийн замаар шийдэж чадахгүй, хэрэв маргаанд оролцогч дурдсан орнууд маргааныг зохицуулах өөр аргын талаар харилцан тохиролцохгүй бол дурдсан орны аль нэг нь шүүхийн журмын дагуу мэдүүлэг гаргах хэлбэрээр олон улсын шүүхэд шилжүүлж болно. Олон улсын шүүхэд мэдүүлэг гаргаж байгаа орон шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн маргааны тухай олон улсын товчоонд мэдэгдэх бөгөөд олон улсын товчоо энэ тухай холбооны гишүүн бусад оронд мэдээлэх үүрэгтэй.

(2) Энэхүү баримт бичигт гарын үсэг зурах эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичиг хадгалуулах үед аливаа орон өөрийгөө (1) дэх хэсгийн заалтыг мөрдөхгүй гэж мэдэгдэж болно. Харин тухайн орон болон холбооны гишүүн бусад орны хоорондын маргааны хувьд (1) дэх хэсгийн заалт хамаарахгүй.

(3) (2) дахь хэсгийн дагуу мэдүүлэг гаргасан аливаа орон ямар ч үед ерөнхий захиралд мэдэгдэл илгээх замаар түүнийгээ татан авч болно.

29 дүгээр зүйл

Гарын үсэг, хэл, хадгалах

(1) (a) Энэхүү баримт бичгийг нэг хувь франц хэлээр үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд Швед Улсын Засгийн газарт хадгалуулав.

(b) Сонирхсон засгийн газартай зөвлөлдсөний дараа ерөнхий захирал албан ёсны эх бичвэрийг англи, испани, итали, герман, португали, орос болон чуулганаас тогтоосон бусад хэлээр боловсруулж гаргана.

(c) Өөр өөр бичвэрийн талаарх ялгаатай ойлголт гарах тохиолдолд франц хэлээрх бичвэрийг баримтална.

(2) Энэхүү акт 1968 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл Стокгольм хотод гарын үсэг зурахад нээлттэй байна.

(3) Энэхүү актын Швед Улсын Засгийн газраас баталгаажуулсан, гарын үсэг зурсан хоёр хувийг ерөнхий захирал холбооны гишүүн бүх орны засгийн газарт болон хүсэлт гаргасан бусад орны засгийн газарт илгээнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү актыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал гарын үсэг зурсан болон батламж жуух бичиг, нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн, мөн эдгээр баримтыг бичигт дурдсан мэдэгдэл эсхүл 20 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (c) дэд хэсгийн дагуу хийсэн мэдэгдэл, энэхүү актын аливаа заалт хүчин төгөлдөр болох, цуцлах тухай

мэдэгдэл, 24 дүгээр зүйлийн дагуу илгээсэн мэдэгдлийн тухай холбооны гишүүн орны засгийн газарт мэдэгдэнэ.

30 дугаар зүйл

Шилжилтийн заалт

(1) Анхны ерөнхий захирал албан тушаалдаа орох хүртэл энэхүү актад дурдсан байгууллагын олон улсын товчооны, эсхүл ерөнхий захирлын талаарх тайлбарыг холбооны товчооны эсхүл түүний захирлын талаарх тайлбар гэж үзнэ.

(2) 13-17 дугаар зүйлээр үүрэг хүлээгээгүй холбооны гишүүн орнууд Байгууллага байгуулах тухай конвенц хүчин төгөлдөр болсны дараа таван жилийн хугацаанд, хэрэв хүсвэл энэ актын 13-17 дугаар зүйлээр олгосон эрхийг хэрэгжүүлж болно.

Тийм эрхийг эдлэхийг хүсэж байгаа аливаа орон ерөнхий захиралд бичгээр мэдэгдэл илгээж, тэр нь хүлээж авсан өдрөөсөө үйлчилнэ. Тэдгээр орныг заасан хугацаа дуустал чуулганы гишүүн гэж үзнэ.

(3) Холбооны гишүүн бүх орон байгууллагын гишүүн болох хүртэл байгууллагын олон улсын товчоо холбооны товчооны хэлбэрээр үүрэг гүйцэтгэж, харин ерөнхий захирал мөн энэ товчооны захирлын хэлбэрээр ажиллана.

(4) Гагцхүү холбооны гишүүн бүх орон байгууллагын гишүүн болсны дараа холбооны товчооны хөрөнгө, эрх, үүрэг байгууллагын олон улсын товчоонд шилжинэ.

60. УТГА ЗОХИОЛ, УРЛАГИЙН БҮТЭЭЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ БЕРНИЙН КОНВЕНЦ*

(1886 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн)

*1896 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Парист эцэслэж,
1908 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Берлинд хянан өөрчилж,
1914 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Бернд эцэслэж,
1928 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Ромд,
1948 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Брюссельд,
1967 оны 7 дугаар сарын 14-ний өдөр Стокгольмд,
1971 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Парист хянан өөрчилж,*

1979 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар

Тус холбооны гишүүн орнууд,

* Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр соёрхон баталсан

Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг бололцооны хирээр үр ашигтай, нэгдмэл хэлбэрээр хамгаалах талаар адил байгаад урамшин,

Стокгольм хотноо 1967 онд хуралдсан хянан өөрчлөх бага хурлын ажлын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

Стокгольмын бага хурлаас баталсан актын 1-20 дугаар болон 22- 26 дугаар зүйлийг өөрчлөлгүйгээр тус актыг хянан өөрчлөхөөр шийдвэрлэж,

Үүнтэй холбогдуулан өөрсдийн бүрэн эрхийг зохих журмаар илэрхийлж бүрэн эрхт төлөөлөгчид дор гарын үсэг зуран,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Холбоо байгуулах

Энэхүү конвенцийг хэрэглэж буй орнууд утга зохиол болон урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалахад холбоо байгуулна.

2 дугаар зүйл

- 1. "Утга зохиол ба урлагийн бүтээл"; 2. Хамгаалалтад авахгүй байхаар тогтоож болох нөхцөл; 3. Үүсмэл бүтээл; 4. Албан ёсны эх бичвэр; 5. Эмхтгэл; 6. Хамгаалах үүрэг, хамгаалалтын үр ашиг хүртэгчид; 7. Хавсарга урлагийн бүтээл, бүтээгдэхүүний загвар; 8. Шинэ мэдээ.**

(1) "Утга зохиол ба урлагийн бүтээл" гэсэн нэр томъёонд бүтээсэн арга, хэлбэрийг үл харгалзан утга зохиол, шинжлэх ухаан, урлагийн бүх бүтээл, тухайлбал ном товхимол болон бусад бичмэл зохиол; лекц, хэлсэн үг, номлол болон ийм төрлийн бусад бүтээл; жүжгийн ба хөгжимт-жүжгийн зохиол; жүжгийн бүтээл болон үггүй жүжиг; үгтэй ба үггүй хөгжмийн бүтээл; кино зураг болон түүнтэй ижил аргаар бүтээсэн бүтээл; зураг, уран зургийн, уран барилгын, уран баримлын зураасан зургийн болон барын бүтээл; гэрэл зургийн ба түүнтэй ижил аргаар бүтээсэн бүтээл; хавсарга урлагийн бүтээл; номын зураг, газрын зураг, төлөвлөгөө; үлгэрчилсэн зураг; газар зүй, байр зүй, уран барилгын болон шинжлэх ухаанд холбогдох гурван хэмжээст бүтээл хамаарна.

(2) Гэхдээ бодит хэлбэрээр илэрхийлээгүй аливаа нэгэн утга зохиол, урлагийн бүтээл буюу түүний ямар нэгэн тодорхой хэсгийг хамгаалалтад авахгүй байхаар холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тогтоох эрхээ хадгална.

(3) Утга зохиолын ба урлагийн бүтээлийн орчуулга, найруулга, мөн хөгжмийн зохиолын тохируулсан найруулга болон бусад өөрчлөлт нь эх бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүйгээр хамгаалагдана.

(4) Хууль тогтоох, захиргааны болон шүүхийн хууль зүйн шинжтэй албан ёсны бичиг баримт, мөн тэдгээрийн албан ёсны орчуулгыг хамгаалах асуудлыг холбооны гишүүн орон нь хууль тогтоомжоороо тодорхойлох эрхээ хадгална.

(5) Материалыг сонгосон, байрлуулснаараа оюуны бүтээлийн үр дүн болохуйц нэвтэрхий толь, цоморлиг зэрэг утга зохиол болон урлагийн бүтээлийн эмхтгэл тэдгээр эмхтгэлийг бүрдүүлж буй бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүйгээр хамгаалагдана.

(6) Энэ зүйлд дурдсан бүтээл нь холбооны гишүүн бүх оронд энэ хамгаалалт зохиогч болон түүний эрх залгамжлагчдад ашигтайгаар хамгаалагдана.

(7) Холбооны гишүүн орон энэхүү конвенцийн 7 дугаар зүйлийн (4) дэх хэсэгт заасныг харгалзан хавсарга урлагийн бүтээл, бүтээгдэхүүний загвар ба зургийг хамгаалах хэмжээ хүрээ, нөхцөлийг өөрийн хууль тогтоомждоо заах эрхтэй. Гарлын оронд гагцхүү загвар, зургийн хувиар хамгаалагддаг бүтээлийн талаар холбооны гишүүн бусад оронд загвар, зурагт олгох тусгай хамгаалалтыг шаардаж болох бөгөөд тухайн оронд ийм тусгай хамгаалалт олгодоггүй бол дээрх бүтээлийг урлагийн бүтээлд хамааруулан хамгаална.

(8) Өдрийн шинэ мэдээ буюу сонин хэвлэлийн энгийн сонордуулгын чанартай үйл явдлын мэдээлэл энэхүү конвенцоор хамгаалагдахгүй.

2 bis зүйл

Тодорхой бүтээлийн хамгаалалтыг хязгаарлаж болох тухай:

1.Хэлсэн үг; 2.Лекц, уриалгыг тодорхой байдлаар ашиглах;

3.Ийм бүтээлийн эмхтгэл бэлтгэх эрх

(1) Холбооны гишүүн орон нь төрийн асуудлаар хэлсэн үг, шүүх хурал дээр хэлсэн үгийг 1 дүгээр зүйлд дурдсан хамгаалалтад бүрэн буюу хэсэгчлэн хууль тогтоомжоороо хамааруулахгүй байх эрхийг хадгална.

(2) Түүнчлэн холбооны гишүүн орон нь лекц, уриалга болон олны өмнө хэлсэн иймэрхүү төрлийн бүтээлийг мэдээллийн зориулалтаар сонин хэвлэлд нийтлэх, телевиз, радиогоор нэвтрүүлэх, утсан холбоогоор дамжуулах ба энэхүү конвенцийн 11 bis дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт зааснаар нийтэд сонордуулах нөхцөлийг хууль тогтоомжоор тодорхойлох эрхээ хадгална.

(3) Харин зохиогч нь өмнөх хэсэгт дурдсан өөрийн бүтээлийн эмхтгэлийг бэлтгэж гаргах онцгой эрх эдэлнэ.

3 дугаар зүйл

Хамгаалалт олгох хэмжүүр: 1.Зохиогчийн иргэний харьяалал; бүтээлийг туурвисан газар; 2.Зохиогчийн оршин суугаа газар; 3."Нийтийн хүртээл болсон" бүтээл; 4."Нийтийн хүртээл нэгэн зэрэг болгосон бүтээл

(1) Энэхүү конвенцид заасан хамгаалалтыг:

(a) зохиогч нь холбооны гишүүн аль нэг орны харьяат бол түүний туурвисан бүтээл нийтийн хүртээл болсон эсэхээс үл хамаарч;

(b) зохиогч нь холбооны гишүүн орны харьяат биш боловч түүний бүтээлийг холбооны гишүүн аль нэгэн оронд анх удаа буюу холбооны гишүүн болон холбооны гишүүн бус оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болгосон тохиолдолд тус тус олгоно.

(2) холбооны гишүүн аль нэг орны харьяат биш боловч дээрх орны аль нэгэнд байнга оршин суудаг тохиолдолд энэхүү конвенцийн дагуу тухайн орны харьяатын нэгэн адил эрх эдэлнэ.

(3) "Нийтэлсэн бүтээл" гэж зохиогчийн зөвшөөрлөөр, бүтээлийн шинж байдлыг харгалзан нийтийн боломжийн хэрэгцээг хангаж чадахуйц хувиар хувилагдсан бүтээл ямар ч аргаар хувилснаас хамаарахгүй нийтэлсэн бүтээлийг хэлнэ. Жүжгийн, хөгжмийн, хөгжимт-жүжгийн буюу киноны бүтээлийг тоглож үзүүлэх, утга зохиолын бүтээлийг нийтийн өмнө унших, утга зохиол болон урлагийн бүтээлийг утсан холбоогоор дамжуулах буюу телевиз, радиогоор нэвтрүүлэх, урлагийн бүтээлийг үзүүлэх, уран барилга барих зэргийг нийтийн хүртээл болгосонд үл тооцно.

(4) Бүтээлийг анх туурвиж гаргаснаас хойш гуч хоногийн дотор хоёр буюу түүнээс илүү оронд нийтийн хүртээл болгосон бол уг бүтээлийг хэд хэдэн оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болгосонд тооцно.

4 дүгээр зүйл

Кино бүтээл, уран барилгын бүтээл болон уран сайхны тодорхой бүтээлийг хамгаалалтад авах хэмжүүр

3 дугаар зүйлд тусгасан нөхцөлд тохирсон эсэхийг үл харгалзан энэхүү конвенцид тусгасан хамгаалалтыг хэрэгжүүлнэ:

(a) ажлын байр буюу байнга оршин суудаг газар нь холбооны гишүүн орны аль нэгэнд байдаг кино бүтээл туурвигчид;

(b) уран барилгын бүтээл нь холбооны гишүүн аль нэг оронд барьж байгуулагдсан буюу байшин, бусад барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг нь болсон урлагийн өөр бүтээл холбооны гишүүн аль нэг оронд байгаа зохиогчид хамаарна.

5 дугаар зүйл

Эрхийн баталгаа:

- 1. болон 2. Гарлын орны хилийн гадна;**
- 3. Гарлын оронд; 4. "Гарлын орон"**

(1) Энэхүү конвенцийн дагуу бүтээл нь хамгаалагдаж буй зохиогчид бүтээлийн гарлын орноос гадна холбооны гишүүн орны хууль тогтоомжийн дагуу өөрсдийн

харьяатад одоо буюу цаашид эдлүүлэх эрх, түүнчлэн энэхүү конвенцид заасан онцгой эрхийг эдэлнэ.

(2) Ийм эрх эдлэх, хэрэгжүүлэхэд ямар нэгэн албан ёсны үйлдэл хийхийг шаардах ёсгүй бөгөөд бүтээлийн гарлын оронд хамгаалалт байдаг эсэхийг үл харгалзана. Иймд зохиогчийн эрхээ хамгаалах арга хэрэгсэл, хэмжээ хүрээг энэхүү конвенцид тусгасан заалтаас гадна гагцхүү хамгаалалт хүссэн орны хууль тогтоомжоор зохицуулна.

(3) Уг хамгаалалтыг гарлын оронд тухайн орны хууль тогтоомжоор зохицуулна. Энэхүү конвенцийн заалтын дагуу бүтээл нь хамгаалагдаж буй зохиогч уг бүтээлийн гарлын орны харьяат биш байвч тэр орны харьяат зохиогчдын нэгэн адил эрх эдэлнэ.

(4) Бүтээлийн гарлын орон гэдэг нь:

(a) холбооны гишүүн аль нэг оронд анх нийтийн хүртээл болсон тохиолдолд - тухайн орон; хамгаалалтын хугацааг янз бүрээр тогтоосон холбооны хэд хэдэн оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болгосон бүтээлийн хувьд хууль тогтоомжид хамгаалалтын нь хамгийн богино хугацаа тогтоосон тэр орон;

(b) холбооны гишүүн бус орон болон холбооны гишүүн аль нэг оронд болон холбооны гишүүн бус оронд нэгэн зэрэг нийтийн хүртээл болсон тохиолдолд;

(c) нийтийн хүртээл болгоогүй бүтээл, түүнчлэн холбооны гишүүн бус оронд анх удаа нийтийн хүртээл болгосон бүтээлийг холбооны гишүүн аль нэг оронд нэгэн зэрэг гаргаагүй бол зохиогчийг харьяалах тэр орон:

- (i) кино бүтээл туурвигчийн ажлын байр буюу оршин суугаа газар нь холбооны гишүүн аль нэг оронд байвал уг бүтээлийн гарлын орон нь тухайн орон байна;
- (ii) зохиогчийн уран барилгын бүтээлийг холбооны гишүүн аль нэг оронд барьсан буюу байшин, бусад барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг болсон урлагийн өөр бүтээл нь холбооны гишүүн аль нэг оронд байгаа бол уг бүтээлийн гарлын орон тухайн орон байна.

6 дугаар зүйл

Холбооны гишүүн зарим орны харьяатын тодорхой бүтээлийн хамгаалалтыг хязгаарлаж болох тухай: 1. Анх удаа нийтийн хүртээл болгосон орон болон бусад орон, 2. Буцаан хэрэглэж үл болох, 3. Мэдэгдэл

(1) Хэрэв холбооны гишүүн бус ямар нэгэн оронд холбооны гишүүн аль нэг орны харьяат зохиогчийн бүтээлийн хамгаалалт хангалтгүй бол холбооны гишүүн тухайн орон нь бүтээлийг анх нийтийн хүртээл болгох үедээ холбооны гишүүн аль нэг оронд байнга байнга оршин суудаггүй өөр орны харьяат зохиогчийн бүтээлд хийх хамгаалалтыг хязгаарлаж болно. Хэрэв бүтээлийг анх нийтийн хүртээл болгосон орон

энэ эрхээ хэрэгжүүлсэн бол холбооны гишүүн бусад орон ийм онцгой дэглэм тогтоогдсон бүтээлийн хувьд дээрх орноос илүү хамгаалалт хангах үүрэггүй.

(2) Дээрх хэсэгт дурдсан аль ч хязгаарлалт нь ийм хязгаарлалт тавихаас өмнө холбооны гишүүн аль нэг оронд нийтийн хүртээл болгосон бүтээлийн зохиогчийн эрхийг үл хөндөнө.

(3) Энэ зүйлийн дагуу зохиогчийн эрхийг хязгаарлаж, холбооны гишүүн орон Дэлхийн оюуны өмчийн байгууллагын ерөнхий захиралд (цаашид "ерөнхий захирал" гэнэ) энэ тухайгаа бичгээр мэдэгдэж, хязгаарлалтад хамаарагдах орон, түүнчлэн тухайн орны харьяат зохиогчийн бүтээлд тавих хязгаарлалтыг тодорхойлон дурдана. Ерөнхий захирал энэ мэдэгдлийг холбооны гишүүн бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

6 bis зүйл

Эд хөрөнгийн бус амины эрх: 1.Зохиогч мөн болохыг хүлээн зөвшөөрөхийг шаардах; Бүтээлийг өөрчилсөн буюу эрх зөрчсөн бусад үйлдлийг эсэргүүцэх; 2.Зохиогч нас барсны дараа, 3.Хамгаалах арга

(1) Зохиогч нь зохиогчийн эд хөрөнгийн эрхээс үл шалтгаалан, тэр ч атугай энэхүү эрхээ шилжүүлсэн тохиолдолд ч гэсэн тэрээр бүтээлийнхээ зохиогч мөн болохыг хүлээн зөвшөөрөхийг шаардах эрхтэйгээс гадна уг бүтээлийг гуйвуулах, гажуудуулах буюу өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулхуйц бусад аливаа халдлагыг эсэргүүцэх эрхтэй.

(2) Зохиогчийг нас барсны дараа наад зах нь түүний эд хөрөнгийн эрх дуусгавар болох хүртэл дээрх хэсэгт заасан эрх хүчин төгөлдөр байх бөгөөд хамгаалалт тогтоосон орны хууль тогтоомжоор эрх мэдэл олгогдсон этгээд буюу албан байгууллага уг эрхийг хэрэгжүүлнэ. Гэхдээ энэхүү конвенцийг соёрхон батлах буюу нэгдэн орох үед аль нэг орны хууль тогтоомжид зохиогчийг нас барсны дараа дээрх хэсэгт заасан бүх эрхийг хамгаалахаар заагаагүй бол тэдгээр эрхийн аль нэг нь хамгаалагдахгүй байхаар тогтоож болно.

(3) Энэхүү зүйлд дурдсан эрх хамгаалах аргыг хамгаалалт хүссэн орны хууль тогтоомжоор зохицуулна.

7 дугаар зүйл

Хамгаалах хугацаа: 1.Нийтлэг зүйл; 2.Кино бүтээлийн хувьд; 3.Нэргүйгээр буюу зохиомол нэрээр гаргасан бүтээл; 4.Гэрэл зургийн болон хавсарга урлагийн бүтээл; 5.Хугацаа тооцож эхлэх огноо; 6. Урт хугацаа; 7. Богино хугацаа; 8. Хэрэглэх хууль тогтоомж, хугацаа "харьцуулах"

(1) Зохиогч энэхүү конвенцоор насан турш хамгаалалтад байх бөгөөд түүнийг нас барснаас хойш тавин жил үйлчилнэ.

(2) Харин зохиогчийн зөвшөөрөлтэйгөөр кино бүтээлийг нийтийн хүртээл болгосноос хойш тавин жилийн дараа, хэрэв нийтийн хүртээл болгоогүй бол уг бүтээлийн туурвиснаас хойш тавин жилийн дараа түүнийг хамгаалах хугацаа дуусахаар холбооны гишүүн орон тогтоох эрхтэй.

(3) Нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийг энэхүү конвенцид зааснаар хамгаалах хугацаа уг бүтээлийг эрх зүйн дагуу нийтийн хүртээл болгосноос хойш тавин жилийн дараа дуусгавар болно. Гэвч зохиомол нэр нь тухайн зохиогчийн болох нь эргэлзээгүй бол (1) дэх хэсэгт заасан хугацаагаар хамгаална. Хэрэв нэргүйгээр буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийг зохиогч дээр дурдсан хугацаанд жинхэнэ нэрээ тайлбал мөн (1) дэх хэсэгт заасан хугацааг хэрэглэнэ. Нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийг зохиогч нас барснаас хойш тавин жил өнгөрсөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй бол холбооны гишүүн орон уг бүтээлийг хамгаалах үүрэггүй.

(4) Урлагийн бүтээлд тооцогдох гэрэл зургийн болон хавсарга урлагийн бүтээл хамгаалах хугацааг холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тогтоох эрхтэй; гэхдээ энэ хугацаа ийм бүтээл туурвиснаас хойш хорин таван жилээс богино байж үл болно.

(5) Зохиогчийг нас барсны дараа бүтээлийг нь хамгаалах хугацаа, түүнчлэн (2), (3), (4) дэх хэсэгт заасан хугацааг зохиогчийн нас барсан буюу дээрх хэсэгт заасан үйл явдал болсны дараахь жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцно.

(6) Холбооны гишүүн орон хамгаалалтын хугацааг дээрх хэсэгт дурдсанаас илүүгээр тогтоох эрхтэй.

(7) Энэхүү конвенцийн Ромын актыг хүлээн зөвшөөрсөн, холбооны гишүүн орны үндэсний хууль тогтоомжид дээрх дэд зүйлд дурдсанаас богино хугацаа заасан бол энэхүү конвенцийг гарын үсэг зурах буюу түүнийг соёрхон батлахдаа дээрх хугацааг хэвээр үлдээх эрхтэй.

(8) Аль ч тохиолдолд дээрх хугацааг хамгаалалт тогтоосон орны хуулиар тодорхойлно. Гэхдээ тухайн орны хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол энэ хугацаа нь уг бүтээлийн гарлын оронд тогтоосноос илүү байж үл болно.

7 bis зүйл

Хамтын бүтээлийг хамгаалах журам

Зохиогчийг нас барснаас хойш тоолох хугацааг хамтран зохиогчдоос амьд үлдсэн сүүлчийн хүн нас барснаас эхлэн тооцсон тохиолдолд өмнөх зүйлийн заалтыг уг хамтын бүтээлийн хувьд хэрэглэнэ.

8 дугаар зүйл

Орчуулах эрх

Энэхүү конвенцоор хамгаалагдсан утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь жинхэнэ эх бүтээлийн хувьд өөрийн эрх эдлэх бүх хугацааны туршид түүнийг өөрөө орчуулах, орчуулахыг зөвшөөрөх онцгой эрхтэй.

9 дүгээр зүйл

**Хуулбарлах эрх: 1.Нийтлэг үндэслэл; 2. Гарч болох онцгой тохиолдол;
3. Дууны болон дүрс бичлэг**

(1) Энэхүү конвенцоор хамгаалагдах утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь уг бүтээлийг аливаа хэлбэрээр хуулбарлахыг зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ.

(2) Ийм бүтээлийг хэвийн ашиглахад хохиролгүйгээр, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хохироохгүйгээр зарим онцгой тохиолдолд хуулбарлахыг зөвшөөрсөн заалт хууль тогтоомжоороо тогтоох эрхтэй.

(3) Энэхүү конвенцийн агуулгын үүднээс аливаа дууны ба дүрс бичлэг нь бүтээлийг хуулбарласанд тооцно.

10 дугаар зүйл

Бүтээлийг чөлөөтэй ашиглах тодорхой тохиолдол;

1.Ишлэл; 2.Сургалтад ашиглах тайлбар зураг, эх сурвалж, зохиогчийн нэрийг заах

(1) Хэвлэлийн тоймд сонин, сэтгүүлийн нийтлэлээс хэсэгчлэн ашиглах зэргээр зорилгодоо тохирсон хэмжээгээр уламжлалт заншлыг баримтлан хууль ёсоор нийтийн хүртээл болгосон бүтээлээс ишлэл хийж болно.

(2) Шударга ёсыг баримтлан утга зохиол, урлагийн бүтээлийг зорилгодоо тохирсон хэмжээгээр ном хэвлэл, радио-телевизийн нэвтрүүлэг, дууны бичлэг буюу сургалтын чанартай үзүүлэнд ашиглахыг холбооны гишүүн орны хууль тогтоомж болон тэдний хооронд байгуулсан эсхүл байгуулах тусгай хэлэлцээрээр зөвшөөрч болно.

(3) Өмнөх хэсэгт дурдсанаар бүтээл ашиглахдаа эх сурвалж болон зохиогчийн нэрийг дурдана.

10 bis зүйл

Бүтээлийг чөлөөтэй ашиглаж болох бусад тохиолдол.

1. Эфирт дамжуулсан тодорхой нийтлэл, бүтээл; 2. Цаг үеийн үйл явцад үзүүлсэн буюу сонордуулсан бүтээл

(1) Эдийн засаг, улс төр болон шашны тулгамдсан асуудлаар сонин, сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл, түүнчлэн эфирт дамжуулсан ийм төрлийн бүтээлийн зохиогчийн эрхийг онцлон заагаагүй бол түүнийг сонин хэвлэлд дахин хэвлэх, эфирт буюу утсан холбоогоор дамжуулах зэргээр хуулбарлан ашиглаж нийтийн хүртээл болгохыг холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тодорхойлох эрхээ хадгална. Гэхдээ эх сурвалжийг заавал тодорхой дурьдах бөгөөд энэ үүргийг зөрчсөний эрх зүйн үр дагаврыг хамгаалалт тогтоосон орны хууль тогтоомжоор тодорхойлно.

(2) Түүнчлэн цаг үеийн үйл явдлын явцад үзүүлсэн буюу сонордуулгын чанар агуулсан утга зохиол, урлагийн бүтээлийг мэдээллийн зорилгод тохирох хэмжээгээр гэрэл зураг, дүрс бичлэг үзүүлэх, эфирт буюу утсан холбоогоор дамжуулах зэргээр

дахин ашиглаж нийтэд мэдээлэх нөхцөлийг холбооны гишүүн орон хууль тогтоомжоороо тодорхойлох эрхээ хадгална.

11 дүгээр зүйл

Жүжгийн болон хөгжмийн бүтээлийг ашиглах тодорхой эрх:

1.Нийтийн өмнө тоглох, тоглуулахаар өгөх эрх; 2.Орчуулгын талаар

(1) Жүжгийн, хөгжимт-жүжгийн ба хөгжмийн бүтээлийн зохиогч нь

- (i) аливаа арга хэрэгслээр өөрийн бүтээлийг нийтийн өмнө тоглох;
- (ii) өөрийн бүтээлийг аливаа арга хэрэгслээр дамжуулан нэвтрүүлж нийтийн хүртээл болгох зөвшөөрөл олгох онцгой эрхийг эдэлнэ.

(2) Жүжгийн буюу хөгжимт-жүжгийн бүтээлийн зохиогч нь түүнийг бусад хэл рүү орчуулах талаар жинхэнэ эх зохиолын хувьд эдлэх эрхийн хугацаа дуустал мөн ийм эрх эдэлнэ.

11 bis зүйл

Эфирт дамжуулах ба үүнтэй холбогдсон эрх;

- 1.Эфирт дамжуулах болон утасгүй холбооны бусад арга хэрэгслээр дамжуулах, эфирт дамжуулсан бүтээлийг утсан холбоогоор дамжуулах буюу эфирт дахин дамжуулах замаар нийтийн хүртээл болгох, эфирт дамжуулсан бүтээлийг чанга яригч болон ийм төрлийн бусад хэрэгслээр нийтийн хүртээл болгох**
- 2.Албадан олгох лиценз; 3. Бичлэг: богино хугацаанд ашиглах бичлэг**

(1) Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид нь дараахь зүйлийг зөвшөөрөх онцгой эрхийг эдэлнэ:

- (i) өөрийн бүтээлийг эфирт дамжуулах, буюу тэмдэг, авиа, дүрсийг утасгүй холбоогоор дамжуулах аливаа бусад арга хэрэгслээр нийтийн хүртээл болгох;
- (ii) анхны байгууллагаас өөр байгууллага урьд эфирт цацсан бүтээлийг утсан буюу утасгүй холбооны аливаа хэрэгслээр давтан дамжуулж олонд хүртээх;
- (iii) эфирт дамжуулсан бүтээлийг чанга яригч болон тэмдэг, авиа буюу дүрс дамжуулах аливаа бусад хэрэгслийн тусламжтайгаар нийтэд хүртээх.

(2) Дээрх хэсэгт дурьдсан эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг холбооны гишүүн орны хууль тогтоомжоор тодорхойлж болох бөгөөд энэхүү нөхцөл, шаардлага нь гагцхүү тухайн орны хувьд үйлчилнэ. Аль ч тохиолдолд энэхүү нөхцөл нь зохиогчийн эд хөрөнгийн бус амины эрх, түүнчлэн хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд бол зохих эрх бүхий байгууллагаас тогтоосон шударга шагнал авах эрхийг хохироож үл болно.

(3) (1) дэх хэсэгт заасан зөвшөөрөл нь хэрэв өөрөөр тогтоогоогүй бол эфирт дамжуулсан бүтээлийг дууны болон дүрс бичлэгийн хэрэгсэлд буулгаж авах зөвшөөрөл болохгүй. Гэхдээ радиогийн өргөн нэвтрүүлгийн байгууллага өөрийн хэрэгслээр өөрийн нэвтрүүлэгт зориулан богино хугацаанд ашиглах бичлэг хийх журмыг холбооны гишүүн орны хууль тогтоомжоор ийм бичлэгийг гагцхүү баримтат шинжтэйн хувьд албан ёсны архивт хадгалахыг зөвшөөрч болно.

11 ter зүйл

Утга зохиолын бүтээлийн хувьд эдлэх тодорхой эрх:

- 1. Нийтийн өмнө унших ба холбооны хэрэгслээр дамжуулан нийтэд хүртээх;**
- 2. Орчуулах**

(1) Утга зохиолын бүтээлийг зохиогчид нь:

- (i) аливаа арга хэрэгслээр өөрсдийн бүтээлийг нийтийн өмнө унших;
- (ii) өөрийн бүтээлийг уншсан нэвтрүүлгийг аливаа арга хэрэгслээр дамжуулж нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрхтэй.

(2) Утга зохиолын бүтээлийг зохиогч нь түүнийг орчуулах талаар жинхэнэ эх зохиолын хувьд эдлэх эрхийн үйлчлэх хугацаа дуусах хүртэл мөн ийм эрх эдэлнэ.

12 дугаар зүйл

**Нэг төрөл зүйлээс нөгөөд шилжүүлэх, зохиомжлох болон
бусад нэмэлт, өөрчлөлт оруулах эрх**

Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь өөрийн бүтээлд засвар оруулах, тохируулан найруулах болон бусад өөрчлөлт хийхийг зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ.

13 дугаар зүйл

**Хөгжмийн бүтээл, түүнд хамаарах эх бичвэрийн бичлэг хийх эрхийг хязгаарлах
боломжийн тухай: 1. Албадан олгох лиценз, 2. Завсрын арга хэмжээ; 3. Зохиогчийн
зөвшөөрөлгүйгээр гадаадаас оруулсан хувийг хураах**

(1) Холбооны гишүүн орон бүр хөгжмийн бүтээлийн зохиогч, түүнтэй хамт бичлэг хийхийг зөвшөөрсөн аливаа эх бичвэрийн зохиогчдод олгох онцгой эрхийн талаар зохих тайлбар, нөхцөл өөрөө тогтоох, хэрэв байгаа бол ийм эх бичвэрээр хөгжмийн зохиолын бичлэг хийхийг зөвшөөрч болно; гэхдээ ийм тайлбар, нөхцөлийг гагцхүү түүнийг тогтоосон оронд сахин баримтлах бөгөөд хэлэлцээр байгуулаагүй үед зохих эрх бүхий байгууллагаас тогтоосон шагнал авах дээрх зохиогчдын эрхийг зөрчиж хэрхэвч үл болно.

(2) Ром хотноо 1928 оны 6 дугаар сарын 2-ны өдөр, мөн Брюссельд 1948 оны 6 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан конвенцийн 13 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн дагуу холбооны гишүүн аль нэг оронд бүтээсэн хөгжмийн бүтээлийн бичлэгийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жилийн хугацаа

өнгөрсний дараа тухайн оронд хөгжмийн зохиолчийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлаж болно.

(3) Энэ зүйлийн (1), (2) дахь хэсэгт заасны дагуу хийсэн бөгөөд түүнийг хууль бус гэж үздэг оронд сонирхогч талын зөвшөөрөлгүйгээр оруулсан бичлэгийг хураан авбал зохино.

14 дүгээр зүйл

Кино найруулга ба түүнд хамаарах эрх: 1.Кино зохиол болгон найруулах ба сэргээн найруулах; тараах; ийнхүү найруулсан буюу хуулбарласан бүтээлийг олны өмнө үзүүлэх ба утсан холбоогоор дамжуулан нийтэд хүртээх; 2.Кино зохиолын найруулгад засвар оруулах; 3.Албадан олгосон лицензийг үл хэрэглэх

(1) Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч нь:

- (i) өөрсдийн бүтээлийг кино болгон найруулах, хуулбарлах, ийнхүү өөрчлөн найруулсан буюу хуулбарласан бүтээлээ тараах;
- (ii) өөрчлөн найруулсан буюу хуулбарласан бүтээлээ олны өмнө тоглож үзүүлэх болон утсан холбоогоор дамжуулан нийтийн хүртээл болгохыг тус тус зөвшөөрөх онцгой эрх эдэлнэ.

(2) Кино болгон найруулсан утга зохиол, урлагийн бүтээлийг урлагийн бусад аливаа хэлбэрээр өөрчлөн найруулахад кино найруулагчаас гадна жинхэнэ эх бүтээлийн зохиогчийн зөвшөөрөл шаардагдана.

(3) Энэ тохиолдолд 13 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн заалтыг үл хэрэглэнэ.

14 bis зүйл

Кино зургийн бүтээлийн талаарх тусгай заалт: 1.Жинхэнэ эх бүтээлтэй адилтгах; 2.Эрх эзэмшигчид: бүтээл туурвихад хувь нэмэр оруулсан тодорхой хүмүүсийн зарим эрхийг хязгаарлах; 3. Бусад хувь нэмэр оруулагчид

(1) Өөрчлөн найруулах буюу хуулбарлаж болох аливаа бүтээлийн зохиогчийн эрхийг үл хөндөн кино зургийн бүтээлийг жинхэнэ эх бүтээлийн нэгэн адил хамгаалбал зохино. Кино зургийн бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигч нь өмнөх зүйлд заасан эрхийг оролцуулан жинхэнэ эх бүтээлийн зохиогчийн нэгэн адил эрх эдэлнэ.

(2) (a) Кино зургийн бүтээл, зохиогчийн эрх эзэмшигч этгээдийг хамгаалалт тогтоосон тэр орны хууль тогтоомжоор тодорхойлно.

(b) Харин кино зургийн бүтээлийг туурвихад оролцсон зохиогчдыг уг бүтээлийг зохиогчийн эрх эзэмшигчдийн тоонд оролцуулахаар хууль тогтоомждоо заасан холбооны гишүүн оронд уг бүтээлийг хуулбарлах, тараах, нийтийн өмнө тоглож үзүүлэх, утсан холбоогоор дамжуулж нийтэд хүртээх, эфирт цацах буюу бусад аргаар

нийтэд таниулах, түүнчлэн түүний эх бичвэрийг дэлгэцнээ буюу хөрвүүлэх аргаар эсрэг буюу онцгой нөхцөл тогтоосноос бусад тохиолдолд татгалзах эрхгүй.

(с) Дээрх зүйлсийг хэрэглэхдээ түүнд дурьдсан үүргийг хэлэлцээр буюу түүнтэй адил бичмэл акт байгуулах эсэх тухай асуудлыг кино зургийн бүтээл туурвигчийн ажлын байр буюу байнга оршин суух газар байгаа орны хууль тогтоомжоор зохицуулна. Гэхдээ хамгаалалт тогтоосон холбооны гишүүн орон энэхүү үүргийг хэлэлцээр буюу дүйцэхүйц бичмэл актаар тодорхойлон хууль тогтоомжоор заах эрхээ хадгална. Энэ эрхийг хэрэгжүүлсэн орон энэ тухайгаа ерөнхий захиралд бичгээр мэдэгдэж, тэрээр түүнийг холбооны бусад бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

(d) "Эсрэг буюу онцгой нөхцөл" гэдэг ойлголтод дээр дурсан үүрэгт хамаарах хязгаарлалтын бүх нөхцөл багтана.

(3) Хэрэв үндэсний хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол кино зохиол туурвигч, киноны хөгжмийг зохиогч, эх бичвэрийг зохиогч, найруулагч нарын хувьд дээрх (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт үл хэрэглэнэ. Хэдийгээр дээр дурдсан (2) дахь хэсгийн (b) дэд хэсгийг киноны найруулагчид хэрэглэхээр хууль тогтоомждоо заагаагүй бол холбооны гишүүн орон энэ тухайгаа ерөнхий захиралд бичгээр мэдэгдэж, тэрээр түүнийг холбооны гишүүн бусад бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

14 ter зүйл

Урлагийн бүтээл, жинхэнэ эх бүтээлийг борлуулахад "хувь тогтоож оролцох эрх":

1.Худалдаж борлуулсны орлогоос хувь хүртэх эрх;

2.Хэрэглэх хууль тогтоомж. 3.Журам

(1) Урлагийн жинхэнэ эх бүтээл болон зохиогч, хөгжмийн зохиолчдын гар бичмэлийн жинхэнэ эхийн хувьд зохиогч өөрөө, түүний нас барсны дараа үндэсний хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд буюу байгууллага уг бүтээлийг зохиогч өөрөө шилжүүлэн өгснөөс хойш худалдан борлуулах бүрт хувь хүртэх салшгүй эрх эдэлнэ.

(2) Хэрэв зохиогчийн харьяалах орны хууль тогтоомжоор зөвшөөрсөн бол дээрх хэсэгт заасан хамгаалалтыг холбооны гишүүн аливаа оронд хэрэглэж болох бөгөөд түүний хүрээ хязгаарыг хамгаалалт тогтоосон орны хууль тогтоомжоор зохицуулна.

(3) Хураамж авах журам болон мөнгөний хэмжээг үндэсний хууль тогтоомжоор тодорхойлно.

15 дугаар зүйл

Хамгаалах эрхийг дагаж мөрдөхөд хангах эрх:

1.Зохиогчийн нэрийг бичих буюу зохиомол нэр нь эргэлзээ үл төрүүлэх;

2.Кино бүтээлийн хувьд;

3.Нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээлийн хувьд;

4.Зохиогч нь үл мэдэгдэх хэвлэгдээгүй бүтээлийн тодорхой тохиолдолд

(1) Тухайн этгээд энэхүү конвенцоор хамгаалагдсан утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч мөн эсэхийг тогтоож, үүний үндсэн дээр зохиогчийн эрхийн аливаа зөрчлийг холбооны гишүүн оронд шүүхээр хэлэлцэн шийдвэрлэхийн тулд уг

зохиогчийн нэрийг тухайн бүтээл дээр ердийн журмаар бичиж хэвлэсэн байвал хангалттай. Зохиогчийн сонгосон зохиомол нэр нь түүний талаар ямар ч эргэлзээ төрүүлэхгүй тохиолдолд энэхүү хэсгийн заалтыг хэрэглэж болно.

(2) Үүний эсрэг нотолгоо байхгүй бол кино зохиол дээр ердийн байдлаар нэр нь бичиж тэмдэглэгдсэн хувь хүн, хуулийн этгээдийг уг бүтээл туурвигчид тооцно.

(3) Дээрх (1) дэх хэсэгт зааснаас бусад нэргүй буюу зохиомол нэрээр гаргасан бүтээл дээр заасан хэвлэн нийтлэгч, хэрэв өөр эсрэг нотолгоо байхгүй бол, зохиогчийн эрхийг хамгаалж, түүний хэрэгжилтийг хангах бүрэн эрхтэй. Зохиогч жинхэнэ нэрээ илчилж уг бүтээлийн зохиогчийн эрхээ мэдэгдсэн үед тухайн хэсгийн заалт дуусгавар болно.

(4) (a) Хэвлэгдэж гараагүй бүтээлийн зохиогч нь үл мэдэгдэх боловч тэрээр холбооны гишүүн аль нэг оронд харьяат гэж үзэх бүрэн үндэслэлтэй бол энэхүү орны хууль тогтоомжоор уг зохиогчийг төлөөлөн түүний эрхийг хамгаалж, холбооны гишүүн оронд эрхийн хэрэгжилтийг хангах эрх мэдэл бүхий байгууллагыг тохоон томилж болно.

(b) Энэ заалтын дагуу ийм байгууллага тохоон томилсон холбооны гишүүн орон нь энэ тухайгаа ерөнхий захиралд бичгээр мэдэгдэж, уг байгууллагын тухай бүрэн тодорхой танилцуулна. ерөнхий захирал үүнийг холбоонд орсон бусад бүх оронд нэн даруй мэдэгдэнэ.

16 дугаар зүйл

Хууль бусаар хуулбарлаж тараасан бүтээл:

- 1.Хураах;**
- 2.Хилээр оруулахад хураах;**
- 3.Хэрэглэх хууль тогтоомж**

(1) Бүтээлийг эрх зүйн хамгаалалтад авсан холбооны гишүүн аль ч оронд хууль бусаар хуулбарлан тараасан уг бүтээлийн хувийг хураан авбал зохино.

(2) Түүнчлэн өмнөх хэсгийн заалт нь аливаа бүтээлийг хамгаалалтад аваагүй буюу хамгаалалтын хугацаа дууссан оронд хуулбарласан хувиудад нэгэн адил хамаарна.

(3) Хураах ажиллагааг орон бүрийн хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл

Бүтээлийг тараах, тоглох, үзүүлэхэд хяналт тавих боломж

Энэхүү конвенцийн дагуу эрх бүхий байгууллага уг эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бол аливаа бүтээлийг тараах, тоглох, үзүүлэхэд хууль тогтоомжоор буюу журмаар хяналт тавих, эсхүл хориглоход холбооны гишүүн аль ч орны засгийн газрын эрхийг ямар нэгэн байдлаар хөндөхгүй.

18 дугаар зүйл

Конвенцийг хүчин төгөлдөр болох үед түүнд хамаарах бүтээл:

- 1. Гарлын оронд хамгаалах хугацаа дуусаагүй бүтээлийг хамгаалах;**
- 2. Хамгаалалт тогтоосон орны хамгаалах хугацаа дууссан бүтээлийг хамгаалахгүй байх;**
- 3. Эдгээр зарчмыг хэрэглэх;**
- 4. Тусгай тохиолдол**

(1) Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болох үед гарлын орны хамгаалалтын хугацаа дуусаагүйн улмаас нийтийн хүртээл болоогүй байсан бүх бүтээлийн талаар энэхүү конвенцийн заалтыг хэрэглэнэ.

(2) Хэрэв ямар нэгэн бүтээлийн өмнөх хамгаалалтын хугацаа дуусаж хамгаалалт тогтоосон оронд нийтийн хүртээл болсон бол түүнийг тухайн оронд дахин хамгаалалтад авахгүй.

(3) Дээр дурдсан зарчмыг холбооны гишүүн орны хооронд энэ зорилгоор байгуулсан буюу байгуулах хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлнэ. Ийм хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд зохих орон бүр уг зарчмыг хэрэглэх нөхцөлийг тус тусдаа тогтооно.

(4) Холбооны гишүүн аль нэг орон шинээр элссэн, түүнчлэн 7 дугаар зүйлд заасны дагуу хамгаалалтын хүрээ өргөжсөн болон тайлбараасаа татгалзсан тохиолдолд дээрх заалтыг нэгэн адил хэрэглэнэ.

19 дүгээр зүйл

Конвенцид зааснаас илүү өргөн хамгаалалт

Холбооны гишүүн аль нэг орон илүү өргөн хүрээтэй хамгаалалтыг хууль тогтоомжоороо тогтооход энэхүү конвенцийн заалт саад болохгүй.

20 дугаар зүйл

Холбооны гишүүн орны хооронд байгуулах тусгай хэлэлцээр

Холбооны гишүүн орны засгийн газар энэхүү конвенцид тусгаснаас илүү өргөн хүрээтэй эрх зохиогчдод олгох буюу энэхүү конвенцид үл харшлах бусад заалт агуулсан тусгай хэлэлцээр хоорондоо байгуулах эрхээ хадгалан үлдэнэ. Эдгээр шаардлагыг хангаж байгуулсан хүчин төгөлдөр хэлэлцээрийн заалтыг биелүүлбэл зохино.

21 дүгээр зүйл

Хөгжиж буй оронд хамаарах тусгай заалт:

- 1. Нэмэлт бүлгийг иш татах;**
- 2. Нэмэлт бүлэг энэхүү конвенцийн нэгэн хэсэг**

(1) Хөгжиж буй оронд хамаарах тусгай заалтыг нэмэлт бүлэгт тусгасан болно.

(2) Энэхүү конвенцийн 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт зааснаар нэмэлт нь энэхүү конвенцийн салшгүй хэсэг болно.

22 дугаар зүйл

Ассамблей:

- 1. Ассамблейг байгуулах, түүний бүрэлдэхүүн; 2.Зорилт;
3.Кворум, санал хураалт, ажиглагчид;
4.Зарлан хуралдуулах; 5.Ажиллагааны журам**

(1) (ай) Холбоо нь 22-26 дугаар зүйлийг дагаж мөрдөх холбооны гишүүн орнуудаас бүрдсэн Ассамблейтай байна.

(b) Орон бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөгч, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) (a) Ассамблей нь:

- (i) холбоог удирдах, хөгжүүлэх болон энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх асуудлыг эрхэлнэ;
- (ii) Дэлхийн оюуны өмчийн байгууллага (цаашид “байгууллага” гэнэ) байгуулах тухай конвенцид заасан Оюуны өмчийн олон улсын товчоонд (цаашид “олон улсын товчоо” гэнэ) хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлын талаар чиглэл өгөх бөгөөд ингэхдээ 22-26 дугаар зүйлийг заавал дагаж мөрдөхгүй холбооны гишүүн орнуудын саналд зохих анхаарал тавина;
- (iii) байгууллагын ерөнхий захирлаас холбооны талаар явуулсан үйл ажиллагааны тайланг хянаж батлах, холбооны эрх мэдэлд багтах бүх асуудлаар шаардлагатай бүх зааврыг түүнд өгнө;
- (iv) Ассамблейн гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгоно;
- (v) гүйцэтгэх хорооны тайлан болон үйл ажиллагааг хянаж баталж, түүнд чиглэл өгнө;
- (vi) холбооны хөтөлбөрийг тодорхойлж, хоёр жилийн төсөв болон түүний санхүүгийн тайланг батална;
- (vii) холбооны санхүүгийн дотоод журмыг батална;
- (viii) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзэх шинжээчдийн хороо, ажлын хэсэг байгуулна;

- (ix) холбооны гишүүн бус ямар орон, түүнчлэн ямар засгийн газар хоорондын болон олон улсын засгийн газрын бус байгууллагыг түүний чуулганд ажиглагчаар оролцуулж болохыг тодорхойлно;
 - (x) 22-26 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлтийг батална;
 - (xi) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа шаардлагатай бусад арга хэмжээ авна;
 - (xii) энэхүү конвенцийн дагуух бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ;
 - (xiii) Ассамблей өөрөө зөвшөөрсөн нөхцөлд байгууллага байгуулах тухай конвенцоор тогтоосон эрхийг хэрэгжүүлнэ.
- (b) Түүнчлэн Ассамблей нь байгууллагын зохицуулах хорооны саналыг сонсоод байгууллага захиргааны үүргийг гүйцэтгэдэг бусад холбооны сонирхсон асуудлаар шийдвэр гаргана;
- (3) (a) Ассамблейн гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.
- (b) Ассамблейн гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.
- (c) (b) дэд хэсгийг үл харгалзан аль нэг чуулганд Ассамблейн нийт гишүүн орны тэн хагасаас бага боловч гуравны нэг буюу түүнээс илүү гишүүн орон төлөөлөгчдөө ирүүлсэн бол Ассамблей өөрийн ажиллагааны журамд хамаарахаас бусад бүх шийдвэр гаргаж болно. Ийм шийдвэрийг гагцхүү дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо нь чуулганд оролцоогүй Ассамблейн гишүүн орнуудад дээр дурдсан шийдвэрийг илгээж, уг шийдвэрийг илгээснээс хойш гурван сарын дотор эдгээр шийдвэрт санал өгч, түдгэлзсэн эсэх тухай саналаа бичгээр ирүүлэхийг хүснэ. Тогтоосон хугацаа өнгөрөх үед энэ журмаар саналаа өгсөн буюу түдгэлзсэнээ мэдэгдсэн орны тоо чуулганд хүчинтэй болоход дутуу байсан тоонд хүрч байвал зохих олонхи байна гэж үзэж шийдвэр хүчин төгөлдөр болно.
- (d) 26 дугаар зүйлийн (2) дахь хэсгийг хэрэглэх тохиолдолд Ассамблей нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрээ гаргана.
- (e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.
- (f) Төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.
- (g) Ассамблейн гишүүн бус холбооны гишүүн орны төлөөлөгчдийг түүний чуулганд ажиглагчаар оролцуулна;
- (4) (a) Онцгой тохиолдлоос бусад тохиолдолд ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулдаг газарт болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны буюу Ассамблейн гишүүн орны дөрөвний нэгийн хусэлтийн дагуу онцгой чуулганыг зарлан хуралдуулна.

(5) Ассамблей өөрийн ажиллагааны журмыг батална.

23 дугаар зүйл

Гүйцэтгэх хороо:

- 1. Байгуулах; 2. Бүрэлдэхүүн;
3. Гишүүдийн тоо; 4. Газар зүйн байршил; тусгай хэлэлцээр;
5. Улиран сонгох хугацаа, хязгаар, сонгуулийн дүрэм;
6. Зорилт, 7. Зарлан хуралдуулах;
8. Кворум, санал хураах;
9. Ажиглагчид; 10. Ажиллагааны журам**

(1) Ассамблей гүйцэтгэх хороотой байна.

(2) (a) Гүйцэтгэх хороо нь Ассамблей Ассамблейн гишүүн орнуудаас сонгосон орнуудаас бүрдэнэ. Байгууллагын төв байр нутаг дэвсгэр дээр нь байрладаг орон 25 дугаар зүйлийн (7) дахь хэсгийн (b) дэд хэсгийн дагуу гүйцэтгэх хороонд нэг суудалтай байна.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүн орны засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(3) Гүйцэтгэх хорооны гишүүн орны тоо нь Ассамблейн гишүүн нийт орны дөрөвний нэгтэй тэнцүү байна. Эзэлбэл зохих суудлын тоог тодорхойлохдоо дөрөвт хуваасны дараахь үлдэгдлийг тооцоонд авахгүй.

(4) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгохдоо Ассамблей газар зүйн шударга хуваарилалт болон холбоотой байгуулсан тусгай хэлэлцээрт оролцогч орнууд гүйцэтгэх хороог бүрдүүлж буй орнуудын тоонд багтах шаардлагад зохих анхаарлыг хандуулна.

(5) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн бүр түүнийг сонгосон Ассамблейн чуулган хааснаас хойш Ассамблейн дараагийн ээлжит чуулган хаах хүртэл үүргээ хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүд дахин сонгогдож болох бөгөөд гэхдээ тоо нь уг бүрэлдэхүүний гуравны хоёроос хэтэрч болохгүй.

(c) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгох, дахин сонгох тухай тодорхой дүрмийг Ассамблей тогтооно.

(6) (a) Гүйцэтгэх хороо:

- (i) Ассамблейн хэлэлцэх асуудлын дэгийн төслийг бэлтгэнэ;
(ii) ерөнхий захирлын бэлтгэсэн холбооны хоёр жилийн төсөв, хөтөлбөрийн төслийн талаарх саналыг Ассамблейд оруулна;

- (iii) /хасагдсан/;
- (iv) ерөнхий захирлын ээлжит тайлан, санхүүгийн аудитын жилийн тайланг зохих саналын хамт Ассамблейд оруулна;
- (v) Ассамблейн шийдвэрийн дагуу болон Ассамблейн ээлжит хоёр чуулганы хооронд буй болсон нөхцөл байдлыг харгалзан ерөнхий захирлаас холбооны хөтөлбөрийг биелүүлэх явдлыг хангахад шаардагдах бүх арга хэмжээ авна;
- (vi) энэхүү конвенцийн дагуу түүнд оноосон бусад бүх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хороо нь захиргааны үүргийг нь байгууллага хэрэгжүүлдэг бусад холбооны сонирхолд хамаарах асуудлаар байгууллагын зохицуулах хорооны саналыг сонссоны дараа шийдвэр гаргана.

(7) (a) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны ээлжит хуралдааныг аль болохоор байгууллагын зохицуулах хорооны хуралддаг газарт болон хугацаагаар жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал өөрийн санаачилгаар эсхүл хорооны даргын эсхүл гүйцэтгэх хорооны гишүүдийн дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу гүйцэтгэх хорооны онцгой хуралдааныг зарлан хуралдуулна.

(8) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(c) Санал хураалтад оролцогсдын энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.

(d) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(e) Төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.

(9) Гүйцэтгэх хорооны гишүүн бус холбооны гишүүн орнуудыг хуралдаанд ажиглагчаар оролцуулна.

(10) Гүйцэтгэх хороо өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална.

24 дугаар зүйл

Олон улсын товчоо:

- 1.Нийтлэг зорилт, ерөнхий захирал; 2.Ерөнхий мэдээлэл; 3.Сэтгүүл;**
- 4.Бусад оронд мэдээлэх; 5.Судалгаа, үйлчилгээ; 6.Хуралдаанд оролцох;**
- 7.Хянан өөрчлөх бага хурал; 8. Бусад зорилт**

(1) (a) Холбооны захиргааны зорилтыг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай олон улсын конвенцоор байгуулагдсан холбооны товчоотой нэгдсэн холбооны товчоог залгамжилсан олон улсын товчоо хэрэгжүүлнэ.

(b) Түүнчлэн олон улсын товчоо холбооны төрөл бүрийн байгууллагын нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

(c) Байгууллагын ерөнхий захирал холбооны гүйцэтгэх тэргүүн болох бөгөөд холбоог төлөөлнө.

(2) Олон улсын товчоо зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотой мэдээллийг цуглуулж хэвлэн нийтэлнэ. Холбооны гишүүн орон бүр зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотой өөрийн шинэ хууль, албан ёсны баримт бичгийг олон улсын товчоонд цаг алдалгүй өгнө.

(3) Олон улсын товчоо сар бүрийн хэвлэл гаргана.

(4) Олон улсын товчоо зохиогчийн эрхийг хамгаалах талаар холбооны гишүүн аль нэг орны хүсэлтээр мэдээллээр хангана.

(5) Олон улсын товчоо зохиогчийн эрхийг хамгаалах талаар судалгаа явуулж, зохиогчийн эрхийг хамгаалах асуудлыг дэмжихийг чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.

(6) Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа этгээд Ассамблей, гүйцэтгэх хорооны болон аливаа бусад шинжээчдийн хороо, ажлын хэсгийн бүх хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа этгээд өөрийн албан тушаалын дагуу эдгээр байгууллагын нарийн бичгийн дарга байна.

(7) (a) Олон улсын товчоо Ассамблейгаас өгсөн чиглэлийн дагуу болон гүйцэтгэх хороотой хамтран конвенцийн 22-26 дугаар зүйлээс бусад заалтыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг хангана.

(b) Олон улсын товчоо хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажилтай холбогдуулан олон улсын засгийн газар хоорондын болон олон улсын засгийн газрын бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал болон түүний томилсон этгээд тэдгээр бага хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

(8) Олон улсын товчоо түүнд оногдуулсан бусад бүх даалгаврыг гүйцэтгэнэ.
25 дугаар зүйл

Санхүү:

- 1.Төсөв; 2. Бусад холбоотой ажиллах;
3.Эх сурвалж; 4.Татвар: Өмнөх төсвийн хэмжээг үргэлжлүүлэх;
5.Хураамж ба төлбөр; 6.Эргэлтийн хөрөнгийн сан; 7. Зохицуулагч орны засгийн газраас олгох урьдчилгаа; 8.Аудитын шалгалт**

(1) (a) Холбоо төсөвтэй байна.

(b) Холбооны төсөв нь холбооны орлого, зарлага, холбооны зардлаас холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт орох хандив, тэрчлэн байгууллагын бага хурлын төсөвт орох зардал зэргээс бүрдэнэ.

(c) Холбоонд бус харин байгууллагын удирдлаган дор ажилладаг нэг буюу хэд хэдэн бусад холбоодод хамаарах зардлыг холбоодод хамаарах нийтийн зардал гэж үзнэ. Энэхүү нийтийн зардлаас холбоонд оногдох хувь нь тэдгээр холбоод дахь холбооны сонирхлын эзлэх хэмжээтэй адил байна.

(2) Холбооны төсвийг байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) Холбооны төсөв дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

- (i) холбооны гишүүдийн татвар;
- (ii) холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамж;
- (iii) холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтын үнэ, түүнийг ашиглуулсны хураамж;
- (iv) бэлэг, гэрээслэлээр шилжүүлсэн зүйл, татаас;
- (v) түрээс, хувь болон бусад орлого.

(4) (a) Төсөвт төлөх татварын хэмжээг тогтоох зорилгоор холбооны гишүүн орон бүр тодорхой ангилалд хамаарах бөгөөд өөрийн жилийн татварыг дараахь байдлаар тогтоосон нэгжийн дагуу төлнө:

ангилал I	25
ангилал II	20
ангилал III	15
ангилал IV	10
ангилал V	5
ангилал VI	3
ангилал VII	1

(b) Аль ангилалд орохоо урьдчилан тогтоогүй бол орон бүр батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөхийн хамт хамаарахыг байхыг хүсэж байгаа ангиллыг заана. Аливаа орон бүр өөрийн ангиллыг сольж болно. Хэрэв тухайн орон доогуур ангиллыг сонговол, энэ өөрчлөлтийн тухайгаа Ассамблейд ээлжит чуулганы үеэр мэдэгдэнэ. Уг өөрчлөлт нь тэр тухай мэдэгдсэн чуулганы дараачийн хуанлийн жилийн эхнээс хүчин төгөлдөр болно.

(c) Орон бүрийн жилийн татвар нь түүний нэгжийн тоог татвар төлж байгаа бүх орны нэгжийн нийлбэрт харьцуулах хэлбэрээр тогтоосон, холбооны төсөвт төлөх нийт татварт эзлэх хувьтай тэнцүү байна.

(d) Татварыг жил бүрийн нэгдүгээр сарын нэгнээс эхэлж төлнө.

(e) Өмнөх хоёр бүтэн жилд өгөх ёстой татварын хэмжээтэй тэнцүү буюу түүнээс дээш өртэй орон холбооны аливаа байгууллагад санал өгөх эрхгүй. Гэхдээ төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд холбооны аль нэг байгууллага тухайн оронд санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

(f) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнө жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Холбооны нэрийн өмнөөс олон улсын товчооны үзүүлсэн үйлчилгээний төлбөрт авах төлбөр, хураамжийн хэмжээг ерөнхий захирал тогтоож, Ассамблей болон гүйцэтгэх хороонд тайлагнана.

(6) (a) Холбоо нь холбооны гишүүн орон бүрээс өгөх нэг удаагийн төлбөрөөс бүрдэх эргэлтийн хөрөнгийн сантай байна. Хэрэв эргэлтийн хөрөнгийн сан хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(b) Дурдсан санд орон бүрийн төлөх анхны татварын хэмжээ буюу энэ санг нэмэгдүүлэхэд төлөх орон бүрийн хувь хэмжээ нь санг байгуулсан жил, эсхүл түүнийг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан жилд тухайн орноос төлөх татварын хувьтай адил байна.

(c) Энэ харьцаа, төлбөрийн нөхцөлийг ерөнхий захирлын саналын үндсэн дээр болон байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг авсны дараа Ассамблей тогтооно.

(7) (a) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг оронтой байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн орон урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг тусдаа байгууллага, тухайн орон хоорондын хэлэлцээрээр зохицуулна. Тэр орон урьдчилгаа өгөх үүрэг өөртөө хүлээж байгаа хугацаандаа гүйцэтгэх хороонд суудалтай байна.

(b) (a) дэд хэсэгт дурдсан орон ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(8) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу холбооны нэг буюу хэд хэдэн орон эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ассамблей томилно.

26 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт:

1. Ассамблей нэмэлт, өөрчлөлт оруулж болох заалт, санал; 2. Батлах; 3. Хүчинтэй болгох

(1) 22, 23, 24, 25 дугаар зүйл болон энэхүү зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ассамблейн гишүүн аль ч орон, гүйцэтгэх хороо эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Ерөнхий захирал ийм саналыг Ассамблейн чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө Ассамблейн гишүүн орон бүрт илгээнэ.

(2) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей дөрөвний гуравын олонхын саналаар батална. Гэхдээ 13 дугаар зүйл болон энэхүү хэсэгт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтын тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед Ассамблейн гишүүн байсан орны дөрөвний гурав нь өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр гаргасан мэдэгдлийг ерөнхий захирал хүлээж авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүчин төгөлдөр болох хугацаанд Ассамблейн гишүүн байсан орнууд буюу түүнээс хойш Ассамблейн гишүүн болсон бүх орон заавал дагаж мөрдөнө. Гэхдээ холбооны гишүүн орны санхүүгийн хүлээх үүргийг өндөржүүлэх талаар аливаа нэмэлт, өөрчлөлтийг тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргасан орон л дагаж мөрдөнө.

27 дугаар зүйл

Хянан өөрчлөх:

1.Зорилго; 2. Бага хурал; 3. Батлах;

(1) Холбооны тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор энэхүү конвенцийг хянан өөрчилж болно.

(2) Энэ зорилгоор холбооны гишүүн орон бүрт ээлж дараалан холбооны гишүүн орнуудын төлөөлөгчдийг оролцуулсан бага хурлыг зохион байгуулна.

(3) 22-26 дугаар зүйлд оруулах нэмэлттэй өөрчлөлттэй холбоотой 26 дугаар зүйлийн заалтыг харгалзан энэхүү акт болон түүний нэмэлт бүлгийг хянан өөрчлөхөд санал нэгтэй шийдвэр шаардагдана.

28 дугаар зүйл

Энэхүү актыг хүлээн зөвшөөрөх бөгөөд акт холбооны гишүүн орны хувьд хүчин төгөлдөр болох:

1.Соёрхон батлах, нэгдэн орох; зарим заалтыг хасах, заалтыг буцаан хэрэглэх;

2. 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болох;

3. 22-38 дугаар зүйл хүчин төгөлдөр болох;

(1) (а) Энэхүү актад гарын үсэг зурсан холбооны гишүүн аливаа орон түүнийг соёрхон баталж болох ба хэрэв түүнд гарын үсэг зураагүй бол түүнд нэгдэн орж болно. Батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(b) Холбооны гишүүн аливаа орон нэгдэн орсон тухай баримт бичиг эсхүл батламж жуух бичигтээ ийнхүү соёрхон батлах буюу нэгдэн орох нь 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэгт хамаарахгүй гэдгийг мэдэгдэж болно, гэхдээ тухайн орон урьд нь нэмэлт бүлгийн VI зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсэн бол дээр дурдсан баримт бичигт тухайн орны соёрхон батлах буюу нэгдэн орох нь зөвхөн 1-20 дүгээр зүйлд хамаарахгүй гэж мэдэгдэж болно.

(c) (b) дэд хэсэгт заасны дагуу соёрхон батлах буюу нэгдэн орох нь дээр дурдсан заалтуудад хамаарахгүйг мэдэгдсэн холбооны гишүүн аливаа орон соёрхон баталсан буюу нэгдэн орсныгоо тэдгээр зүйлд хамааруулах болсноо хожим ямар ч үед мэдэгдэж болно. Энэ мэдэгдлийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(2) (a) Дор дурдсан хоёр нөхцөл бүрдсэнээс хойш гурван сарын дараа 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болно. Үүнд:

- (i) доод тал нь холбооны гишүүн таван орон 1 дүгээр зүйлийн (b) дэд хэсгийн заалтын дагуу мэдэгдэл хийхгүйгээр энэхүү актыг соёрхон батлах буюу нэгдэн орох;
- (ii) Франц, Испани, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Америкийн Нэгдсэн Улс 1971 онд 7 дугаар сарын 24-ний өдөр Парис хотноо хянан өөрчилсөн Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцид нэгдэн орох.

(b) (a) дэд хэсэгт зааснаар хүчин төгөлдөр болох нь (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан мэдэгдлийг хийхгүйгээр батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ дээр дурдсанаар хүчин төгөлдөр болохоос гурван сараас доошгүй хугацааны өмнө хадгалуулахаар өгсөн холбооны гишүүн орнуудад хамаарна.

(c) 1-21 дүгээр зүйл, нэмэлт бүлэг нь (b) дэд хэсэгт үл хамаарах бөгөөд (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан мэдэгдлийг хийхгүйгээр энэхүү актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон холбооны гишүүн аливаа орны хувьд батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй тохиолдолд эдгээр баримтыг бичгийг хадгалуулахаар өгснийг ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа энэхүү конвенцийн хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан орны хувьд 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг нь тухайн заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

(d) Энэ зүйлийн (a) дэд хэсгээс (c) дэд хэсэг хүртэл заалт нь нэмэлт бүлгийн VI зүйлийг хэрэглэхэд нөлөөлөхгүй.

(3) 22-38 дугаар зүйл нь (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан мэдэгдэл хийж буюу хийлгүйгээр энэхүү актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон холбооны гишүүн аливаа орны хувьд батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй бол эдгээр баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан орны хувьд 22-38 дугаар зүйл болон нэмэлт бүлэг нь тухайн заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

**Холбооны гишүүн бус орон хүлээн зөвшөөрөх, тэдний хувьд хүчин төгөлдөр болох;
1.Хүлээн зөвшөөрөх; 2.Хүчин төгөлдөр болох;**

(1) Холбооны гишүүн бус аливаа орон энэхүү актад нэгдсэн, конвенцид оролцогч тал болон холбооны гишүүн орон болж болно. Нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулна.

(2) (а) Энэхүү конвенц нь (b) дэд хэсэгт заасныг харгалзан холбооны гишүүн бус орны хувьд нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй тохиолдолд түүний нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн тухай ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан орны хувьд энэхүү конвенц нь тухайн заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

(b) 28 дугаар зүйлийг (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасны дагуу 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг нь (а) дэд хэсэгт зааснаас өмнө байвал тухайн орон энэ хооронд 1-21 дүгээр зүйл, нэмэлт бүлгийн оронд энэхүү конвенцийн Брюсселийн актын 1-20 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

29 bis зүйл

ДООБ байгуулах тухай конвенцийн 14 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн зорилгоор энэхүү актыг хүлээн зөвшөөрсний үр дагавар

Энэхүү конвенцийн Стокгольмын актын 22-38 дугаар зүйлийг дагаж мөрддөггүй аливаа орон энэхүү актыг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэн орсныг Байгууллага байгуулах тухай конвенцийн 14 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн зорилгоор Стокгольмын актын 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсгийн (i)-д заасан хязгаарлалттай уг актад нэгдэн орсон буюу соёрхон баталсанд тооцно.

30 дугаар зүйл

Тайлбар:

1.Тайлбар хийхийг боломжийг хязгаарлах; 2.Өмнө нь хийсэн тайлбар; орчуулгын эрхийн талаарх тайлбар; тайлбарыг хасах

(1) Энэ зүйлийн (2) дахь хэсэг, 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэг, 33 дугаар зүйлийн (2) дахь хэсэг болон нэмэлт бүлгийн дагуу зөвшөөрөгдсөн тохиолдлоос бусад тохиолдолд конвенцийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон орон энэхүү конвенцийн бүх заалтыг хүлээн зөвшөөрсөнд тооцогдож, уг конвенцоор олгосон бүх давуу эрхийг эдэлнэ.

(2) (а) Энэхүү актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон холбооны гишүүн аливаа орон нэмэлт бүлгийн V зүйлийн (2) дахь хэсгийг харгалзан батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай бичгээ хадгалуулахаар өгөх үед өмнө нь хийсэн тайлбараа хэвээр үлдээх тухай мэдэгдэх тохиолдолд уг тайлбараа хадгалж болно.

(b) Холбооны гишүүн бус аливаа орон энэхүү конвенцид нэгдэн орохдоо болон нэмэлт бүлгийн V зүйлийн (2) дахь хэсгийг харгалзан орчуулгын талаарх энэхүү актын 8 дугаар зүйлийн оронд 1896 онд Парист эцэслэсэн 1886 оны холбооны тухай конвенцийн 5 дугаар зүйлийн заалтыг ядаж түр хугацаанд хэрэглэх саналтай байгаагаа мэдэгдэж болох бөгөөд эдгээр заалт нь гагцхүү тухайн оронд нийтлэг хэрэглэдэг хэлнээ орчуулахад хамаарна гэдгийг ойлгон зөвшөөрсөн байвал зохино. Нэмэлт бүлгийн I зүйлийн (6) дахь хэсгийн (b) дэд хэсгийг харгалзан холбооны гишүүн аливаа орон гарлын орон нь ийм тайлбар хийсэн орон байх бүтээлийн орчуулгын бүтээлийн хувьд гарлын орон болох тухайн орны олгож буй хамгаалалттай эн тэнцүү хамгаалалтыг эдлэх эрхтэй.

(c) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдсэнээр ийм нэмэлт тайлбараа ямар ч үед буцааж болно.

31 дүгээр зүйл

Зарим нутаг дэвсгэрт хэрэглэх:

- 1.Мэдэгдэл; 2.Мэдэгдлээ буцаах; 3.Хүчинтэй хугацаа;
4. Бодит байдлыг хүлээн зөвшөөрсөнд үл тооцох;**

(1) Аливаа орон батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ, эсхүл үүнээс хойш ямар ч үед ерөнхий захиралд мэдэгдэх бичиг илгээх замаар энэхүү конвенцийг мэдэгдэлд дурдсан түүний олон улсын харилцаанд хариуцлагын хүрээнд хариуцдаг нутаг дэвсгэрийн бүхэлд нь эсхүл хэсэгт нь хэрэглэх тухайгаа мэдэгдэж болно.

(2) Ийнхүү мэдэгдсэн аливаа орон энэхүү конвенцийг дээр дурдсан нутаг дэвсгэрийн бүхэлд нь эсхүл хэсэгт нь хэрэглэхээ болих тухайгаа ерөнхий захиралд ямар ч үед мэдэгдэж болно.

(3) (a) (1) дэх хэсгийн дагуу хийсэн аливаа мэдэгдэл нь соёрхон баталсан буюу нэгдэх орсон нь хүчин төгөлдөр болох өдөр хүчинтэй болох бөгөөд мөн хэсгийн дагуу илгээсэн мэдэгдэх бичгийг илгээсэн тухай ерөнхий захирал мэдэгдсэнээс хойш гурван сарын дараа хүчинтэй болно.

(b) (2) дахь хэсэгт заасны дагуу илгээсэн аливаа мэдэгдэх бичиг нь уг бичгийг ерөнхий захирал хүлээн авснаас хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэхүү зүйлийг холбооны гишүүн орон (1) дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсний нь дагуу бусад холбооны гишүүн орон энэхүү конвенцийг хэрэглэх нутаг дэвсгэрийн талаарх бодит байдлыг аяндаа хүлээн зөвшөөрсөн буюу зөвшөөрсөнд тооцно гэж үзэхгүй.

32 дугаар зүйл

Энэхүү акт болон өмнөх актыг хэрэглэх:

- 1.Холбооны гишүүн болсон орнуудын хооронд; 2.Холбоонд элсэж байгаа аливаа орнууд болон холбооны гишүүн орнуудын хооронд; 3.Зарим харилцаанд нэмэлт бүлгийг хэрэглэх**

(1) Энэхүү акт холбооны гишүүн орнууд хоорондын харилцааны хувьд болон уг актыг хэрэглэх хүрээнд 1886 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Бернийн конвенц болон түүнийг хянан өөрчилсөн дараагийн актыг орлоно. Энэхүү актыг соёрхон батлаагүй, эсхүл түүнд нэгдэн ороогүй холбооны орнуудын хувьд өмнөх актууд бүхэлд нь, эсхүл дээр дурдсан өгүүлбэрийн дагуу орлогдохгүй хэсгийг үргэлжлүүлэн дагаж мөрдөнө.

(2) Энэхүү актад оролцогч тал болсон холбооны гишүүн бус орон (3) дахь хэсгийг харгалзан энэхүү актыг дагаж мөрддөггүй буюу дагаж мөрддөг хэдий ч 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсэн холбооны гишүүн аливаа орны хувьд энэхүү актыг хэрэглэнэ. Тухайн орон дээр дурдсан холбооны орон тухайн орны хувьд

- (i) өөрийн дагаж мөрддөг хамгийн сүүлийн актын заалтыг хэрэглэж болно;
- (ii) нэмэлт бүлгийн 1 дүгээр зүйлийн (6) дахь хэсгийг харгалзан хамгаалалтынхаа хэмжээг энэхүү актад заасан түвшинд нийцүүлэх эрхтэйг хүлээн зөвшөөрнө.

(3) Нэмэлт бүлэгт заасан аливаа эрх буюу боломжийг хэрэглэсэн орон бүр уг эрх буюу боломжид хамаарах нэмэлт бүлэгт тусгасан заалтыг энэхүү актад нэгдэн ороогүй холбооны аль ч орны хувь тухайн орон дээрх заалтыг хэрэглэхийг зөвшөөрсөн нөхцөлд хэрэглэж болно.

33 дугаар зүйл

Маргаан:

- 1.Олон улсын шүүхийн эрх мэдэл; 2.Энэ эрх мэдлийн талаарх тайлбар;**
- 3.Тайлбарыг хасах**

(1) Энэхүү конвенцийг хэрэглэх буюу тайлбарлах талаар холбооны хоёр буюу түүнээс илүү гишүүн орны хооронд гарсан аливаа маргааныг хэлэлцээрийн замаар шийдвэрлэж чадаагүй бөгөөд дээрх орон маргаанаа өөр аргаар зохицуулах талаар харилцан тохиролцоогүй бол холбогдох орны аль нэг нь Олон улсын шүүхийн дүрмийн дагуу мэдүүлэг гаргах замаар уг маргааныг Олон улсын шүүхэд шилжүүлж болно. Мэдүүлэг гаргасан орон энэ тухайгаа олон улсын товчоонд мэдэгдэж, тэрээр энэ тухай холбооны бусад оронд сонордуулна.

(2) Аливаа орон энэхүү актад гарын үсэг зурах, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үед (1) дэх хэсгийн заалтыг дагаж мөрдөхгүйгээ мэдэгдэж болно. Ийм орон болон холбооны гишүүн бусад аливаа орон хоорондын маргаанд (1) дэх хэсгийн заалт хамаарахгүй.

(3) Энэ зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэл гаргасан аливаа орон ерөнхий захиралд мэдэгдсэнээр ямар ч үед уг мэдэгдлээсээ татгалзаж болно.

34 дүгээр зүйл

Өмнө нь гарсан зарим актын талаар тавих хориг:

1.Өмнөх актын талаар; 2.Стокгольмын актын протокол

(1) 29 bis зүйлийг харгалзан аль ч орон 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болсноос хойш энэхүү конвенцийн өмнөх актыг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орж үл болно.

(2) 1-21 дүгээр зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болсноос хойш аль ч орон Стокгольмын актын нэмэлт протоколын хөгжиж буй оронд хамаарах 5 дугаар зүйлд заасан мэдэгдэл хийж үл болно.

35 дугаар зүйл

Конвенцийн үйлчлэх хугацаа:

**1.Хязгааргүй хугацаа; 2.Цуцлах боломж;
3.Цуцлалт хүчин төгөлдөр болох хугацаа; 4.Цуцлахыг хойшлуулах**

(1) Энэхүү конвенцийн хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацааг хязгаарлахгүй.

(2) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдэх замаар энэхүү актыг цуцалж болно. Ийм цуцлалт нь өмнөх бүх актад хамаарахаас гадна зөвхөн мэдэгдэл гаргасан орны хувьд хүчинтэй бөгөөд холбооны бусад орны хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

(3) Энэ цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэ зүйлд заасан цуцлах эрхийг аль ч орон холбооны гишүүн болсон өдрөөсөө хойш таван жилийн хугацаанд эдлэхгүй.

36 дугаар зүйл

Конвенцийг хэрэглэх: 1.Шаардлагатай арга хэмжээ авах үүрэг. 2.Үүрэг үүсэх үе

(1) Энэхүү конвенцид оролцогч орон бүр өөрийн Үндсэн хуулийн дагуу энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

(2) Энэхүү конвенцид нэгдэн орж буй орон бүр тухайн үед өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлж чадахуйц байвал зохино.

37 дугаар зүйл

Төгсгөлийн заалт

1.Актын хэл; 2.Гарын үсэг; 3. Баталгаажуулсан хувь; 4. Бүртгэл; 5.Мэдэгдэл

(1) (а) Энэхүү актыг англи, франц хэлээр нэг хувь үйлдэж үзэглэх бөгөөд (2) дахь хэсгийг харгалзан ерөнхий захиралд хадгалуулна.

(b) Албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний дараа араб, испани, итали, герман, португали хэл болон Ассамблейн тодорхойлох бусад хэлээр үйлдэнэ.

(c) Аливаа эх бичвэрийг тайлбарлахад санал зөрөлдвөл франц хэлээрх эх бичвэрийг баримтална.

(2) Энэхүү акт 1972 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэ өдрийг хүртэл 1 дүгээр зүйлийн (a) дэд хэсэгт заасан хувийг Франц Улсын Засгийн газарт хадгалуулна.

(3) Ерөнхий захирал нь энэхүү актыг үзэглэсэн хоёр хувийг холбооны бүх орны засгийн газарт, түүнчлэн өөрсдийн хүссэнээр бусад аливаа орны засгийн газарт илгээнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү актыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал нь гарын үсэг зурсан, нэгдэн орсон тухай баримт бичиг буюу батламж жуух бичгээ хадгалуулахаар ирүүлсэн эдгээр баримт бичигт дурдсан буюу 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэг, 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) болон (b) дэд хэсэг, мөн 33 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу гаргасан мэдэгдлийн тухай, энэхүү актын аливаа зүйл хүчин төгөлдөр болсон тухай, цуцалсан тухай мэдэгдэх бичиг болон 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (c) дэд хэсэг, 31 дүгээр зүйлийн (1), (2) дахь хэсэг, 33 дугаар зүйлийн (3) болон 38 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу илгээсэн мэдэгдэл, түүнчлэн нэмэлт бүлэгт дурдсан мэдэгдлийн тухай холбооны гишүүг бүх оронд сонордуулна.

38 дугаар зүйл

Шилжилтийн заалт:

**1."Таван жилийн" онцгой эрх эдлэх; 2.Холбооны товчоо;
3.Холбооны товчоог залгамжлах**

(1) Энэхүү актыг соёрхон батлаагүй буюу түүнд нэгдэн ороогүй бөгөөд энэхүү конвенцийн Стокгольмын актын 22-26 дугаар зүйлийг дагаж мөрддөггүй холбооны гишүүн орон, хэрэв хүсвэл, эдгээр зүйлээр олгосон эрхийг 1975 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл дээрх зүйлийг дагаж мөрддөгийн адил эдэлж болно. Ийм эрх эдлэхийг хүссэн аливаа орон энэ тухай ерөнхий захиралд бичгээр мэдэгдэх бөгөөд ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн мэдэгдэл хүчин төгөлдөр болно. Эдгээр орон дээрх хугацаа хүртэл Ассамблейн гишүүнд тооцогдоно.

(2) Холбооны гишүүн бүх орон байгууллагын гишүүн болох хүртэл байгууллагын олон улсын товчоо нь холбооны товчооны үүргийг, ерөнхий захирал нь дурдсан товчооны захирлын үүргийг тус тус гүйцэтгэнэ.

(3) Холбооны гишүүн бүх оронд байгууллагын гишүүн болмогц холбооны товчооны эрх, үүрэг, эд хөрөнгө нь байгууллагын олон улсын товчоонд шилжинэ.

**НЭМЭЛТ БҮЛЭГ
ХӨГЖИЖ БҮЙ ОРОНД ХАМААРАХ ЗААЛТ**

1 зүйл

Хөгжиж буй оронд үзүүлэх хөнгөлөлт:

- 1. Үзүүлэх хөнгөлөлт, мэдэгдэл; 2. Мэдэгдлийн хүчинтэй байх хугацаа; 3. Хөгжиж буй орны статусыг зогсоох; 4. Нөөц хувь; 5. Тодорхой нутаг дэвсгэрийн талаарх мэдэгдэл; 6. Харилцан үйлчлэх хязгаар**

(1) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд тогтсон практикийн дагуу хөгжиж байгаад тооцогддог аливаа орон энэхүү нэмэлт бүлгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь болсон энэхүү конвенцийг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохдоо өөрийн эдийн засгийн байдал болон нийгэм, соёлын хэрэгцээг цэгнэж энэхүү актад тусгасан бүх эрхийг хамгаалах заалтыг нэн даруй хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл II зүйлд заасан хөнгөлөлт буюу III зүйлд заасан хөнгөлөлт эсхүл энэ хоёр хөнгөлөлтийн аль алийг нь ашиглах тухайгаа нэгдэн орсон тухай барим бичиг буюу батламж жуух бичгээ ерөнхий захиралд хадгалуулахдаа мэдэгдэх, эсхүл V дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан хожим дуртай цагтаа сонордуулах замаар мэдэгдэж болно. Тухайн орон II зүйлд заасан хөнгөлөлтийг ашиглахын оронд V дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (a) дэд хэсгийн дагуу мэдэгдэл гаргаж болно.

(2) (a) 1-21 дүгээр зүйл, энэхүү заалт нь 28 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор энэ зүйлийн (1) дэх хэсэгт зааснаар гаргасан аливаа мэдэгдэл нь уг хугацаа дуустал хүчин төгөлдөр байна. Ийм мэдэгдлийг дараагийн 10 жил бүтнээр буюу хэсэгчлэн сэргээж болох бөгөөд гагцхүү тухайн 10 жилийн хугацаа дуусахаас 15-аас илүүгүй, 3-аас доошгүй сарын өмнө мэдэгдэх бичгээ ерөнхий захиралд хадгалуулахаар ирүүлсэн байвал зохино.

(b) 10 жилийн хугацаа дууссанаас хойш энэ зүйлийн (1) дэх хэсгийн дагуу гаргасан аливаа мэдэгдэл нь 1-21 зүйл болон нэмэлт бүлэг хүчин төгөлдөр болсны дараа 28 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт зааснаар тухайн 10 жилийн хугацаа дуусах хүртэл хүчинтэй байна. Аливаа ийм мэдэгдлийг (a) дэд хэсгийн 2 дахь өгүүлбэрт зааснаар сэргээж болно.

(3) Энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу хөгжиж буй оронд тооцогдож байснаа больсон холбооны гишүүн аливаа орон (2) дахь хэсэгт заасны дагуу мэдэгдлээ сэргээж болохгүйгээс гадна өөрийн мэдэгдлийг албан ёсоор буцааж авах эсэхээс үл хамааран тухайн 10 жилийн хугацаа буюу хөгжиж байгаа орон гэж тооцогдохоо больсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрснөөс хойш хэдийгээр тухайн 10 жилийн хугацаа дуусаагүй байсан ч (1) дахь хэсэгт дурдсан хөнгөлөлтийг ашиглах эрхгүй.

(4) Энэ зүйлийн (1), (2) дахь хэсгийн дагуу гаргасан мэдэгдэл хүчингүй болох үеэр энэхүү нэмэлт бүлгийн дагуу олгосон лицензээр хэвлэсэн бүтээлийн нөөц хувь өөр газар байгаа бол түүнийг тарааж дуусгана.

(5) Энэхүү актын заалтыг хүлээн зөвшөөрч үүрэг хүлээсэн аливаа орон (1) дэх хэсэгт дурдсан оронтой адилтгаж үзэх нөхцөлтэй аль нэг нутаг дэвсгэрт хамааруулан хэрэглэх тухай 31 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн дагуу мэдэгдэл буюу мэдэгдэх бичиг хадгалуулахаар өгсөн бол дээрх нутаг дэвсгэрийн талаар (1) дэх хэсэгт дурдсан

мэдэгдэл гаргах болон (2) дахь хэсэгт дурдсанаар мэдэгдлээ шинэчлэх тухай мэдэгдэх бичиг ирүүлж болно. Ийм мэдэгдэл буюу мэдэгдэх бичиг хүчин төгөлдөр байх хугацаанд дээр дурдсан нутаг дэвсгэрийн хувьд энэхүү нэмэлт бүлгийн заалтыг хэрэглэнэ.

(б) (а) аливаа орон (1) дэх хэсэгт заасан хөнгөлөлтийг ашиглах нь тус оронд анх туурвисан бүтээлийн хувьд өөр аливаа орон 1-20 дугаар зүйлийн дагуу олгох үүрэгтэй хамгаалалтаас бага хэмжээтэй хамгаалалт хийх шалтгаан болох учиргүй.

(б) V зүйлийн (1) дэх хэсгийн (а) дэд хэсгийн мэдэгдэл гаргасан орон гарлын орон болох бүтээлийн хувьд 1 зүйлийн (1) дэх хэсгийн (3)-т зааснаар хэрэглэх хугацаа дуусах өдрөөс өмнө 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (б) дэд хэсгийн 2 дахь өгүүлбэрт дурдсан эн тэнцүү хамгаалалт хэрэглэх эрхийг ашиглаж үл болно.

II зүйл

Орчуулгын эрхийг хязгаарлах:

1.Эрх бүхий байгууллагаас олгох лиценз; 2-4. Лиценз олгох нөхцөл; 5.Лиценз олгох зорилго; 6.Лиценз хүчингүй болох; 7.Тайлбар зургаас бүрдсэн бүтээл; 8.Ашиглалтаас хассан бүтээл; 9.Эфирт нэвтрүүлэг хийдэг байгууллагад олгох лиценз

(1) Энэ зүйлд дурдсан хөнгөлөлтийг ашиглах тухайгаа мэдэгдсэн аливаа орон хэвлэсэн буюу өөр иймэрхүү хэлбэрээр хуулбарласан бүтээлийн хувьд 8 дугаар зүйлд заасан орчуулгын онцгой эрхээ IV зүйлийг харгалзан дор дурдсан нөхцөлтэйгөөр зохих эрх бүхий байгууллагаас олгох онцгой бус, бусдад үл шилжүүлэх лицензийн тогтолцоогоор сольж болно.

(2) (а) Энэ зүйлийн (3) дахь хэсэгт заасныг харгалзан хэрэв бүтээлийг анх хэвлэн гаргаснаас хойш 3 жил буюу үндэсний хууль тогтоомжоор илүү урт хугацаа дуусах хүртэл уг бүтээлийг тухайн оронд нийтлэг хэлээр орчуулан гаргаагүй бол орчуулах эрх бүхий этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр тухайн орны аливаа харьяат дээр дурдсан бүтээлийг нийтлэг хэлээр орчуулж хэвлэх буюу ижил төстэйгөөр хуулбарлан гаргах лиценз авч болно.

(б) Түүнчлэн тухайн хэл рүү орчуулсан бүх номыг борлуулж тарааж дууссан бол энэ зүйлд заасан нөхцөлөөр лиценз олгож болно.

(3) (а) Холбооны гишүүн нэг буюу хэд хэдэн хөгжингүй оронд нийтлэг бус хэлээр орчуулга хийх тохиолдолд 2 дахь хэсгийн (а)-д заасан 3 жилийн оронд нэг жилийн хугацааг хэрэглэнэ.

(б) Энэ зүйлийн (1)-д дурдсан аливаа орон нийтлэг хэл бүхий холбооны гишүүн хөгжингүй оронтой санал нэгтэй харилцан тохиролцсоноор тухайн хэл дээр хийсэн орчуулгын хувьд (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасан 3 жилийг нэг жилээс доошгүй богино хугацаагаар сольж болно. Харин энэ нь англи, франц, испани хэлэнд үл хамаарна. Ийнхүү харилцан зөвшилдсөн засгийн газар аливаа ийм тохиролцооны тухай ерөнхий захиралд мэдэгдэнэ.

(4) (а) Энэхүү зүйлийн заалтын дагуу гурван жилийн дараа авах лицензийг дор дурдсан өдрөөс хойш 6 сар өнгөртөл, нэг жилийн дараа авах лицензийг мөн дор дурдсан өдрөөс хойш 9 сар өнгөртөл тус тус олгож үл болно. Үүнд:

- (i) лиценз авахыг хүсэгч этгээд IV дүгээр зүйлийн (1) зүйлд дурдсан шаардлагыг биелүүлсэн өдөр;
- (ii) хэрэв орчуулах эрх эзэмшигч этгээдийн нэр буюу хаяг мэдэгдэхгүй байвал лиценз авахыг хүсэгч этгээд лиценз олгох эрх мэдэл бүхий байгууллагад өгсөн мэдүүлгийнхээ хуулбарыг IV зүйлийн (2) дахь хэсэгт зааснаар явуулсан өдөр болно.

(б) Мэдүүлэгт дурдсан хэлээр хийсэн орчуулгыг орчуулах эрхтэй этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр дээрх 6 буюу 9 сарын хугацаанд хэвлэж гаргасан бол энэ зүйлд заасан лиценз олгохгүй.

(5) Энэ зүйлд заасны дагуу аливаа лицензийг гагцхүү сургалт буюу эрдэм шинжилгээний зорилгоор олгоно.

(6) Орчуулах эрхтэй этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр аль нэг бүтээлийн орчуулгыг хэвлэн гаргаж тухайн оронд иймэрхүү төрлийн бүтээгдэхүүнд тогтоосон ердийн үнээр борлуулж байгаа бол хэл агуулгаараа ойролцоо орчуулгын талаар энэхүү зүйлд заасны дагуу олгосон лиценз хүчингүй болох бөгөөд лиценз хүчингүй болохоос өмнө хэвлэн гаргасан бүх номыг тарааж борлуулж дуусгана.

(7) Гол төлөв тайлбар зургаас бүтсэн бүтээлийн хувьд гагцхүү III зүйлд заасан нөхцөлийг нэгэн адил биелүүлэх тохиолдолд эх бичвэрийг орчуулж хэвлэн гаргах, зургийг хэвлэх гаргах лиценз олгоно.

(8) Зохиогч өөрийн бүтээлийн бүх хувийг борлуулж тараахаа больж татан авсан бол энэ зүйлд зааснаар лиценз олгож үл болно.

(9) (а) Хэвлэлийн буюу дахин хуулбарлах өөр иймэрхүү хэлбэрээр гаргасан бүтээлийг орчуулах лицензийг (1) дэх хэсэгт заасан оронд ажлын төв байр бүхий радио нэвтрүүлгийн байгууллагад Энэхүү байгууллагаас дээр дурдсан орны эрх мэдэл бүхий байгууллагад гаргасан мэдүүлгийн үндсэн дээр олгож болох бөгөөд гагцхүү доорхи дурдсан нөхцөлийг биелүүлсэн байвал зохино. Үүнд:

- (i) тухайн орны хууль тогтоомжийн дагуу хэвлэсэн болон олж авсан хувиас орчуулга хийх;
- (ii) гагцхүү сургалт, боловсролын зорилготой эсхүл тусгай техникийн буюу эрдэм шинжилгээний судалгааны үр дүнг тодорхой мэргэжлийн мэргэжилтэн нарт түгээн хүргэх зориулалт бүхий радио нэвтрүүлэгт тухайн орчуулгыг ашиглах;
- (iii) орчуулгыг гагцхүү (ii)-т заасан зорилго бүхий тухайн орны сонсогчдод зориулан хууль зүйн дагуу явуулах нэвтрүүлэгт түүнчлэн зөвхөн ийм нэвтрүүлэгт хэрэглэхийн тулд хийсэн дуун

буюу дүрс бичлэгийн тусламжтайгаар явуулах нэвтрүүлэгт хэрэглэх;

(iv) аливаа орчуулгыг арилжааны зорилгоор үл ашиглах.

(b) Энэ хэсгийн дагуу олгосон лицензийн үндсэн дээр радио нэвтрүүлгийн байгууллагаас хийсэн орчуулгын дуун буюу дүрс бичлэгийг хэрэв тухайн байгууллага зөвшөөрсөн бол (a) дэд хэсэгт дурдсан зорилго нөхцөлийг баримтлан эрх мэдэл бүхий байгууллага нь лиценз олгосон оронд ажлын түр байр нь оршдог аливаа бусад радио нэвтрүүлгийн байгууллага ашиглаж болно.

(c) Түүнчлэн энэ зүйлийн (a) хэсэгт дурдсан бүх шаардлага нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд зөвхөн системтэй сургалтад хэрэглэхээр үйлдэж гаргасан дуун ба дүрс бичлэгт орсон аливаа эх бичвэрийг орчуулах лицензийг радио нэвтрүүлгийн байгууллагад олгож болно.

(d) Энэ зүйлийн (a)-(c) дэд хэсэгт дурдсаныг харгалзан өмнөх зүйлүүдийн заалтыг тус хэсгийн дагуу лиценз олгох, хэрэгжүүлэхэд хэрэглэнэ.

III зүйл

Хуулбарлан нийтлэх эрхийг хязгаарлах:

- 1. Эрх мэдэл бүхий байгууллагаас олгосон лиценз; 2-5. Уг лицензийг олгох нөхцөл;
6. Лиценз хүчингүй болгох; 7. Энэ зүйлд хамаарах**

(1) Энэ зүйлд дурдсан хөнгөлөлтийг ашиглах тухайгаа мэдэгдсэн аливаа орон 9 дүгээр зүйлд заасан хуулбарлан нийтлэх дархан эрхээ IV зүйлийг харгалзан дор дурдсан нөхцөлтэйгөөр зохих эрх бүхий байгууллагаас олгох онцгой бус, бусдад үл шилжүүлэх лицензийн тогтолцоогоор сольж болно.

(2) (a) Хэрэв (7) дахь хэсэгт зааснаар энэ зүйлийг хамааруулан хэрэглэх бүтээлийн хувьд:

(i) тухайн хэвлэлийг анх нийтлэн гаргасан өдрөөс эхлэн тооцох 3 дугаар зүйлд заасан хугацаа;

(ii) Мөн өдрөөс эхлэн тооцох (1) дэх хэсэгт дурдсан орны үндэсний хууль тогтоомжоор тодорхойлсон аливаа өөр урт хугацаа тус тус дууссаны дараа ийм хэвлэлийн хувийг зургаан сарын дотор тухайн оронд нийтэд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр тухайн оронд ийм төрлийн бүтээлийн хувьд тогтоосон нийтэд буюу тогтмол сургалтад зориулан ийм төрлийн хэвлэлийн тогтоосон үнээр худалдаж борлуулаагүй бол түүнээс хямд үнээр хэвлэн тарааж болно.

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу тараасан хэвлэлийн хэвлэлийн хугацаа дууссанаас хойш зөвшөөрөгдсөн хувийг 6 сарын дотор тухайн оронд нийтэд буюу сургалтад зориулан ийм төрлийн хэвлэлийн тогтоосон үнээр худалдаж борлуулаагүй бол уг хэвлэлийг хуулбарлаж нийтлэн гаргах лицензийг энэхүү зүйлд заасны нөхцөлийн дагуу олгож болно.

3) Дор дурдсанаас бусад тохиолдолд (2) дахь хэсгийн (а) дэд хэсгийн (i)-т заасан хугацаа таван жил байна. Үүнд:

- (i) математик, техникийг оролцуулан байгалийн ба нарийн шинжлэх ухааны бүтээлүүдийн хувьд энэ хугацаа 3 жил байна, эсхүл
- (ii) урлагийн, яруу найргийн, жүжгийн ба хөгжмийн бүтээл, түүнчлэн урлагийн номын хувьд энэ хугацаа 7 жил байна.

(4) (а) Энэ зүйлийн дагуу 3 жилийн дараа олгож болох ямар ч лицензийг:

- (i) IV зүйлийн (1) дэх хэсэгт заасан шаардлагыг биелүүлсэн өдрөөс;
- (ii) хэрэв дахин нийтлэх эрхтэй этгээдийн овог нэр буюу хаяг мэдэгдэхгүй байвал IV зүйлийн (2) дахь хэсэгт заасанчлан өөр этгээд лиценз олгох эрх мэдэл бүхий байгууллагад гаргасан мэдүүлгийнхээ хуулбарыг илгээсэн өдрөөс хойш 6 сар өнгөртөл олгохгүй.

(b) Хэрэв өөр урт хугацааны дараа олгох лицензийн хувьд IV зүйлийн (2) дахь хэсгийг хэрэглэж болохоор байвал мэдүүлэг, мэдэгдлийн хуулбарыг илгээсэн өдрөөс хойш 3 сар өнгөртөл ямар ч лицензийг олгож үл болно.

(c) Дээр дурдсан зургаа, гурван сарын хугацаанд тухайн хэвлэлийг (2) (а)-д зааснаар тарааж борлуулсан бол ямар ч лиценз олгохгүй.

d) Хэрэв өөр этгээд дахин хэвлэж гаргах лиценз авахыг хүссэн аливаа бүтээлийн бүх хувийг зохиогч нь өөрөө борлуулж тараахаа больж татан авсан бол ямар ч лиценз олгохгүй.

(5) Дор дурдсан тохиолдолд аливаа бүтээлийн орчуулгыг дахин хэвлэж гаргах лицензийг энэ зүйлд зааснаар олгохгүй. Үүнд:

- (i) орчуулгыг орчуулга хийх эрхтэй этгээд өөрөө буюу түүний зөвшөөрөлтэйгөөр гаргаагүй;
- (ii) лиценз авах хүсэлт гаргасан оронд нийтлэг бус хэлээр орчуулга хийсэн тус тус болно.

(6) Дахин хэвлэх эрхтэй этгээд буюу түүний зөвшөөрөлтэйгөөр өөр этгээд (1) дэх хэсэгт заасан оронд ийм хувийг нийтэд буюу тогтмол сургалтад зориулан тухайн оронд гол төлөв хэрэглэдэг үнээр борлуулан тараах тохиолдолд хэрэв ийм бүтээлийг лицензээр гаргасан хэвлэлийн адил хэл дээр, агуулга ойролцоогоор гаргасан бол, энэхүү зүйлийн дагуу олгосон лиценз хүчингүй болно. Лиценз хүчингүй болохоос өмнө хэвлэн гаргасан бүх хувийг борлуулан тарааж дуусгана.

(7) (а) Энэ зүйлийн (b) дэд хэсэгт заасныг харгалзан энэ зүйлийн заалтыг зөвхөн хэвлэлийн буюу хуулбарлан гаргах иймэрхүү өөр хэлбэрээр нийтэлсэн бүтээлд хамааруулан хэрэглэнэ.

(b) Түүнчлэн энэхүү зүйл зөвхөн тогтмол сургалтад зориулан үйлдэж хууль зүйн дагуу гаргасан дууны ба дүрс бичлэг, түүнд орсон зохиогчийн эрхээр хамгаалагдах аливаа бүтээл, түүнчлэн уг бичлэгт орсон аливаа эх бичвэрийн лиценз авахыг хүссэн оронд нийтлэг хэлнээ хөрвүүлсэн орчуулга тус тус хамаарна.

IV зүйл

II, III дугаар зүйлийн дагуу олгох лицензүүдэд хамаарах нийтлэг заалт:

1-2.Лиценз олгох журам; 3.Зохиогч бүтээлийн нэрийг заах;

4. Бүтээлийн хувийг гадаадад гаргах; 5.Мэдэгдэх бичиг; 6.Нөхөн төлбөр

(1) Лиценз авахыг хүссэн этгээд орчуулга хийж хэвлүүлэх буюу ном хэвлэл хуулбарлан нийтэлж гаргах эрх бүхий этгээдэд зөвшөөрөл авахаар хандаж татгалзсан хариу авсан эсхүл зохих ёсоор хүчин чармайлт гаргасан боловч ийм эрх эдлэх этгээдийг тогтоож чадаагүйгээ тухайн оронд тогтоосон журмаар нотолж чадсан гагцхүү энэ тохиолдолд II, III зүйлийн дагуу лиценз олгоно. Хүсэлт гаргагч лиценз авахаар хандахдаа (d) дэд хэсэгт дурдсан үндэсний буюу олон улсын аль нэг мэдээллийн төвд сонордуулна.

(2) Эрх эзэмшигч этгээдийг тогтоох бололцоогүй бол лиценз авахыг хүсэгч нь лиценз олгох эрх мэдэл бүхий байгууллагад гаргасан мэдүүлгийнхээ хувийг тухайн бүтээл дээр овог нэр нь бичигдсэн хэвлэгч, түүнчлэн харилцан мэдээлэх тусгай журамд дурдсан аливаа үндэсний буюу олон улсын төвд баталгаатай агаарын шуудангаар илгээхээс гадна нийтлэгчээс мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн хэсгийн явуулдаг Засгийн газарт уламжлуулахаар ерөнхий захиралд явуулна.

(3) II буюу III дугаар зүйлийн дагуу олгосон лицензээр хэвлэн гаргасан буюу орчуулж нийтэлсэн ном, хэвлэлийн бүх хувь дээр бүтээлийн гарчиг, зохиогчийн овог нэрийг заасан байвал зохино. Орчуулж нийтлэх аль ч тохиолдолд жинхэнэ гарчгийг бүх хувь дээр хэвлэсэн байвал зохино.

(4) (a) II буюу III дугаар зүйлийн дагуу олгосон аливаа лиценз нь бүтээлийг гадаадад гаргахад үл хамаарах бөгөөд гагцхүү лиценз авсан оронд орчуулж буюу хуулбарлаж хэвлэн гаргахад хүчин төгөлдөр байна.

(b) (a) дэд хэсгийн зорилгоор гадаадад гаргах гэдгийг бүтээлийн хувийг аливаа дэвсгэр нутгаас түүний талаар I зүйлийн (5) дахь хэсгийн дагуу мэдэгдэл хийсэн оронд илгээх гэж ойлговол зохино.

(c) Англи, испани францаас бусад аливаа хэлнээ орчуулга хийх лицензийг II зүйлийн дагуу олгосон орны засгийн газрын буюу өөр байгууллага ийм лицензээр хэвлэсэн орчуулгын хувийг өөр оронд илгээхдээ дор дурдсан 4 нөхцөлийг биелүүлсэн бол (a) дэд хэсэгт заасан утгаар гадаадад гаргасан гэж үзэхгүй. Үүнд:

- (i) хүлээн авагч нь лиценз олгосон оронд, эсхүл ийм харьяатуудыг нэгтгэсэн байгууллага байх;
- (ii) орчуулгын хувийг гагцхүү дунд, их сургуульд буюу судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах;

- (iii) арилжааны зорилгоор бус дээрх хувийг илгээн хүлээн авагчид тараах;
- (iv) эдгээр хувийг хүлээн авч буй орон нь лиценз олгосон оронтой тохиролцож түүнийг хүлээн авч тараахдаа зөвшөөрсөн бөгөөд лиценз олгосон орны засгийн газар нь ийм хэлэлцээрийн тухай ерөнхий захиралд мэдэгдсэн байх.

(5) II буюу III зүйлд заасан журмаар олгосон лицензээр хэвлэн гаргасан бүх хувь нь гагцхүү уг лицензийн хамаарах орон буюу дэвсгэр нутагт тараах ёстойг зохих хэлээр дурдаж тэмдэглэсэн мэдэгдэх бичигтэй байна.

(6) (a) Тухайн орны хэмжээнд дор дурдсан болзлыг хангах шаардлагатай арга хэмжээ авна. Үүнд:

- (i) зохих хоёр орны этгээд чөлөөтэй хэлэлцээр хийхдээ гол төлөв хэрэглэдэг шан харамжийн хэмжээнд тохирох шударга нөхөн төлбөр орчуулгын эрх буюу дахин хэвлэх эрх эзэмшигч этгээдэд өгөхөөр лицензэд заасан байх;
- (ii) нөхөн төлбөрийг олгох ба гуйвуулах;

Хэрэв үндэсний тусгай валютын журам байдаг бол тухайн орны эрх бүхий байгууллага олон улсын механизмын тусламжтайгаар уг нөхөн төлбөрийг чөлөөтэй хөрвөх валютаар буюу түүний эквивалентаар гуйвуулах талаар бүх хүчин чармайлтаа дайчилна.

b) Тодорхой ном хэвлэлийг зөв орчуулах буюу хуулбарлан дахин хэвлэх талаар үндэсний хууль тогтоомжоор шаардлагатай арга хэмжээ авна.

V зүйл

Орчуулгын эрхийг хязгаарлах талаар шилж сонгох боломж:

1. Үүний тулд 1886 оны актуудад заасан дотоод журам; 2. II зүйлийн дагуу дотоод журмыг өөрчилж үл болох; 3. Шилж сонгох хугацаа

(1) (a) II зүйлд заасан хөнгөлөлтийг ашиглахаар мэдэгдэх эрх бүхий аливаа орон үүний оронд энэхүү актыг соёрхон батлах буюу шууд нэгдэн орох:

- (i) хэрэв энэхүү конвенцийн 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) дэд хэсэгт тухайн оронд хамаарах бол энэ зүйлд заасан журмаар орчуулах эрхийнхээ талаар мэдэгдэл хийж болно;
- (ii) хэрэв тухайн орны хувьд 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) дэд хэсэгт хамаарахгүй тэр ч бүү хэл холбооны гишүүн бус бол 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсгийн эхний ангид заасны дагуу мэдэгдэл хийж болно.

б) Энэхүү нэмэлт бүлгийн I зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу тухайн орон хөгжиж буй оронд тооцогдохоо больсон бол энэ хэсгийн дагуу гаргасан мэдэгдэл нь I дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт заасны дагуу хэрэглэх хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр байна.

(с) Энэ хэсгийн дагуу мэдэгдэл гаргасан аливаа орон уг мэдэгдлийг буцааж авсан тохиолдолд ч гэсэн II дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг цаашид ашиглах эрхгүй болно.

(2) Энэ зүйлийн (3) дахь хэсгийг харгалзан II дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг ашигласан аливаа орон (1) дэх хэсгийн дагуу цаашид мэдэгдэл гаргаж үл болно.

(3) I дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт зааснаар хөгжиж буй оронд тооцохоо больсон аливаа орон I дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт зааснаар хэрэглэх хугацаа дуусахаас 2 жилийн өмнө тухайн орон холбооны гишүүн бус байлаа ч гэсэн 30 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсгийн эхний ангид заасан зорилгоор мэдэгдэл гаргаж болно.

VI зүйл

Нэмэлт бүлгийн зарим заалтыг тухайн орон түүнд нэгдэн орохоос өмнө хэрэглэж болох боломж:

1.Мэдэгдэл; 2.Мэдэгдлийг хадгалуулахаар өгөх ба хүчин төгөлдөр болох хугацаа

(1) Холбооны гишүүн аливаа орон энэхүү актын батлагдсан өдрөөс эхлэн 1-21 дүгээр зүйл болон энэхүү нэмэлт бүлгийн дагуу үүрэг хүлээх хүртэл дараахь мэдэгдлийг гаргаж болно. Үүнд:

- (i) хэрэв тухайн орон 1-21 дүгээр зүйл болон энэхүү нэмэлт бүлгээр холбоотой нь хувьд I дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт дурдсан хөнгөлөлтийг ашиглах эрхтэй бол дараахь хэсгийн дагуу II буюу III дугаар зүйлийг хэрэглэхээр ямар нэг бүтээлийн гарлын орон доорх (ii)-т заасны дагуу зөвшөөрсөн тохиолдолд II буюу III зүйлийг хэрэглэхээ мэдэгдэж болно. Ийм мэдэгдэлд II зүйлийн оронд V зүйлийг иш татаж болно;
- (ii) түүнчлэн энэхүү нэмэлт бүлгийг тухайн орон гарлын орон нь болох бүтээлийн хувьд дээрх хэсэгт зааснаар мэдэгдэх бичиг илгээсэн улсуудаас хэрэглэхийг зөвшөөрч байгаагаа мэдэгдэж болно.

(2) дээрх (i)-т заасны дагуу, эсхүл (1) дэх хэсгийн дагуу гаргасан аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэж ерөнхий захиралд хадгалуулна. Уг мэдэгдэл нь түүнийг хадгалуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

**61. БАРААНЫ ТЭМДГИЙН ОЛОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ
МАДРИДЫН ХЭЛЭЛЦЭЭР***

1891 оны 4 дүгээр сарын 14-нд гарын үсэг зурж, 1900 оны 12 дугаар сарын 14-нд Брюссельд, 1911 оны 6 дугаар сарын 2-нд Вашингтонд, 1925 оны 11 дүгээр сарын 6-нд Гаагад, 1934 оны 6 дугаар сарын 2-нд Лондонд, 1957 оны 6 дугаар сарын 15-нд Ниццид, 1967 оны 7 дугаар сарын 14-нд Стокгольмд хянан өөрчилсөн бөгөөд 1979 оны 9 дүгээр сарын 28-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар

1 дүгээр зүйл

**Тусгай холбоо байгуулах, олон улсын товчоонд
барааны тэмдгийг бүртгэх, гарлын орныг тодорхойлох**

(1) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх орнууд барааны тэмдгийн олон улсын бүртгэл эрхэлсэн тусгай холбоог байгуулна.

(2) Хэлэлцэн тохирогч орнуудын харьяатууд гарлын орны холбогдох байгууллагаар дамжуулан гарлын оронд бүртгүүлсэн бараа, үйлчилгээний тэмдгийн талаар Дэлхийн оюуны өмчийн байгууллага (цаашид “байгууллага” гэнэ) байгуулах тухай конвенцид дурдсан Оюуны өмчийн олон улсын товчоо (цаашид “олон улсын товчоо” гэнэ) –нд мэдүүлэг өгөх замаар дээрх барааны буюу үйлчилгээний тэмдгийг энэхүү хэлэлцээрт оролцогч бусад бүх оронд хамгаалуулж болно.

(3) Мэдүүлэг гаргагчийн бодит болон үр ашиг бүхий үйлдвэрийн буюу худалдааны байгууллага нь оршиж байгаа тусгай холбооны гишүүн орныг гарлын оронд тооцно; хэрэв тэрээр тусгай холбооны гишүүн оронд тийм байгууллагагүй бол байнга оршин суудаг тусгай холбооны гишүүн орныг гарлын оронд тооцно; хэрэв мэдүүлэг гаргагч тусгай холбооны гишүүн оронд байнга оршин суудаггүй боловч тэр орны харьяат мөн бол харьяалагдаж байгаа орныг нь гарлын оронд тооцно.

2 дугаар зүйл

**Парисын конвенцийн 3 дугаар зүйлд хамаарах
зарим этгээдийг холбооны орны харьяаттай адилтгаж үзэх**

Энэхүү хэлэлцээрт нэгдэн ороогүй орнуудын харьяат энэхүү хэлэлцээрээр байгуулагдсан тусгай холбооны нутаг дэвсгэрийн хүрээнд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 3 дугаар зүйлээр тогтоосон нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд тэднийг хэлэлцэн тохирогч орнуудын харьяаттай адилтгаж үзнэ.

3 дугаар зүйл

Олон улсын бүртгэлийн мэдүүлгийн бүрдэл

(1) Олон улсын бүртгэлд мэдүүлгийг журмаар тогтоосон маягтаар гаргана. Барааны тэмдгийн гарлын орны байгууллага нь энэ мэдүүлэгт дурдсан өгөгдлүүд үндэсний бүртгэлийн мэдээлэлтэй тохирч байгааг гэрчлэх ба барааны тэмдгийн мэдүүлгийг гарлын орны бүртгэлд оруулсан анхдагч огноо, бүртгэлийн дугаарыг мөн олон улсын бүртгэлийн мэдүүлгийн огноог заасан байна.

* Монгол Улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан

(2) Мэдүүлэг гаргагч барааны тэмдгийг хамгаалуулах гэсэн бараа буюу үйлчилгээг заана, түүнчлэн бололцоотой бол Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох тухай Ниццийн хэлэлцээрээр тогтоосон олон улсын ангиллын зохих ангилал буюу ангиллуудыг заана. Хэрэв мэдүүлэг гаргагч ангилал заагаагүй бол олон улсын товчоо өөрөө бараа буюу үйлчилгээг дээрх ангиллын дагуу холбогдох ангилалд оруулна. Мэдүүлэг гаргагчийн заасан бараа буюу үйлчилгээний ангилалд олон улсын товчоо үндэсний байгууллагатай хамтран хяналт тавина. Хэрэв үндэсний байгууллага болон олон улсын товчооны санал зөрөлдвөл олон улсын товчооны шийдвэрийг баримтална.

(3) Хэрэв мэдүүлэг гаргагч өөрийн барааны тэмдгийн ялгаатай шинжийг өнгөөр хамгаалуулахыг хүсэж байвал тэрээр:

1. энэ тухай мэдүүлэг гарган хамгаалуулахаар хүсэж байгаа өнгө буюу өнгөний хослолуудыг мэдүүлэгтээ заана;
2. мэдүүлгийн хамт уг барааны тэмдгийн өнгөт хуулбарыг хавсарган ирүүлнэ. Тэдгээрийг олон улсын товчооноос олгох тодорхойлолтод хавсаргана. Өнгөт хуулбарын тоог журмаар тогтооно.

(4) Олон улсын товчоо 1 дүгээр зүйлийн дагуу гаргасан мэдүүлгийн барааны тэмдгийг хойшлуулалгүй бүртгэнэ. Тэгэхдээ гарлын оронд мэдүүлэг гаргасан өдрөөс хойш хоёр сарын дотор олон улсын товчоо уг мэдүүлгийг хүлээн авсан бол гарлын оронд мэдүүлгийг хүлээн авсан өдрөөр нь олон улсын бүртгэлд бүртгэн авснаар тооцно. Хэрэв энэ хугацаанд мэдүүлэг хүлээн аваагүй бол олон улсын товчоо мэдүүлэг хүлээн авсан өдрөөр бүртгэлд оруулна. Олон улсын товчоо ийнхүү бүртгэсэн тухай сонирхогч байгууллагуудад цаг алдалгүй мэдэгдэнэ. Бүртгүүлэхээр гаргасан мэдүүлэгт дурдсан мэдээллийг үндэслэн бүртгэлд авсан барааны тэмдгийг олон улсын товчооноос тогтмол гаргадаг сэтгүүлд нийтэлнэ. Хэрэв барааны тэмдгүүд нь дүрслэх элементүүд агуулсан онцгой дүрслэлийн шинж агуулж байвал, эсхүл зураглалын тусгай бичлэгтэй бол тэдгээрийн хэвлэлийн барыг мэдүүлэг гаргагч ирүүлэх үүрэгтэй эсэхийг журмаар тогтооно.

(5) Бүртгэгдсэн барааны тэмдгийг хэвлэн нийтлэх зорилгоор хэлэлцэн тохирогч орнуудын байгууллага бүр олон улсын товчооноос дээр дурдсан нийтлэлээс тодорхой тооны хувийг үнэгүй, тодорхой тооны хувийг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (а) дэд хэсэгт заасан нэгжийн тооны дагуу хямдруулсан үнээр, мөн журмаар тогтоосон нөхцөлөөр авна. Энэхүү нийтлэл бүх хэлэлцэн тохирогч орнуудад хангалттай байх ёстой бөгөөд үүнээс өөр ямар ч зүйлийг мэдүүлэг гаргагчаас шаардах ёсгүй.

3 bis зүйл

Нутаг дэвсгэрийн хязгаарлалт

(1) Олон улсын бүртгэлд авагдсан хамгаалалт зөвхөн тухайн орны нутаг дэвсгэр дээр үйлчлэх тухай барааны тэмдгийн эзэмшигчийн хүсэлтийг аливаа хэлэлцэн тохирогч орон байгууллагын ерөнхий захирал (цаашид “ерөнхий захирал” гэнэ) — д ямар ч үед бичгээр мэдэгдэж болно.

(2) Энэхүү мэдэгдэл нь түүнийг ерөнхий захирал хэлэлцэн тохирогч бусад оронд явуулсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

3 ter зүйл

Нутаг дэвсгэрийг өргөтгөх тухай хүсэлт

(1) Олон улсын бүртгэлд авагдсан, 3 bis зүйлээр олгосон эрхийн дагуу зөвхөн тухайн оронд үйлчлэх хамгаалалтыг өргөтгөх тухай хүсэлтийг 3 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасан мэдүүлгээр тусгайлан үйлдэнэ.

(2) Олон улсын бүртгэлд авагдсан барааны тэмдгийг хамгаалуулах нутаг дэвсгэрийн хүрээг өргөтгөх тухай хүсэлтийг гарлын орны байгууллагаар дамжуулан зохих журмаар тогтоосон маягтаар гаргана. Олон улсын товчоо түүнийг тэр даруй бүртгэж, цаг алдалгүй сонирхогч байгууллагуудад мэдэгдэн олон улсын товчооноос эрхлэн тогтмол гаргадаг хэвлэлд нийтэлнэ. Барааны тэмдгийг хамгаалуулах нутаг дэвсгэрийн хүрээг өргөтгөх тухай шийдвэр олон улсын бүртгэлд орсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн үйлчлэх хугацаа дуусмагц уг шийдвэр хүчингүй болно.

4 дүгээр зүйл

Олон улсын бүртгэлийн үйлчлэл

(1) Барааны тэмдэг нь 3 дугаар зүйл болон 3 ter зүйлийн дагуу олон улсын товчоонд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хэлэлцэн тохирогч орнуудад тухайн орны бүртгүүлэхээр мэдүүлсэн барааны тэмдгийн нэгэн адил хамгаалагдана. 3 дугаар зүйлд дурдсан бараа буюу үйлчилгээний ангиллыг заах нь барааны тэмдгийг хамгаалах хүрээг тодорхойлоход хэлэлцэн тохирогч орнуудад хязгаарлалт болно гэж үзэхгүй.

(2) Олон улсын бүртгэлд авах аливаа барааны тэмдэг нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 4 дүгээр зүйлээр тогтоосон давамгайлах эрхийг уг зүйлийн D хэсэгт заасан хэлбэрийн хувьд тавигдах шаардлагагүйгээр эдэлнэ.

4 bis зүйл

Үндэсний бүртгэлийг олон улсын бүртгэлээр орлуулах

(1) Хэрэв нэг буюу хэд хэдэн оронд бүртгүүлсэн барааны тэмдгийг олон улсын товчоонд хожим нь уг барааны эзэмшигч буюу түүнийг залгамжлах эрх бүхий хүний нэрээр бүртгүүлбэл олон улсын бүртгэл нь түрүүчийн бүртгэлээр олгосон эрхийг хөндөхгүйгээр үндэсний бүртгэлийг сольсон гэж үзнэ.

(2) Үндэсний байгууллага нь олон улсын бүртгэлд авсан тухай өөрийн бүртгэлд тэмдэглэл хийнэ.

5 дугаар зүйл

Үндэсний байгууллагуудын татгалзал

(1) Барааны тэмдгийг бүртгэсэн тухай болон 3 *ter* зүйлийн дагуу хамгаалуулах нутаг дэвсгэрийн хүрээг нь өргөтгөх тухай хүсэлтийг бүртгэн авсан тухай олон улсын товчооноос мэдэгдэл авсан байгууллагууд өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан уг тэмдгийг өөрийн нутаг дэвсгэр дээр хамгаалахгүй тухай мэдэгдэх эрхтэй. Чингэхдээ Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн дагуу үндэсний бүртгэлд бүртгүүлэх барааны тэмдэгт хэрэглэх зөвхөн тэр нөхцөлийг үндэслэн ийнхүү татгалзаж болно. Харин бараа буюу үйлчилгээний хязгаарлагдмал тоо буюу ангиллын хязгаарлагдмал тооноос бусад тэмдгийг үндэсний хууль тогтоомжоор бүртгэхийг зөвшөөрөхгүй гэдэг үндэслэлээр бүрэн буюу хэсэгчилсэн байдлаар хамгаалалтаас татгалзаж болгохгүй.

(2) Энэхүү эрхийг эдлэхийг хүсэж буй байгууллагууд өөрийнхөө татгалзаж байгаа бүхий л шалтгааныг дурдан үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанд олон улсын товчоонд мэдэгдэх ёстой. Гэхдээ барааны тэмдгийг 3 *ter* зүйлд заасны дагуу олон улсын бүртгэлд бүртгэсэн, эсхүл эрхийн хамгаалалтыг өргөтгөх тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилээс хэтэрч болохгүй.

(3) Олон улсын товчоо гарлын орны байгууллага, барааны тэмдгийн эзэмшигч, эсхүл гарлын орны байгууллага олон улсын товчоонд түүнийг итгэмжлэгчийг мэдэгдсэн тохиолдолд тэрхүү итгэмжлэгчид татгалзсан тухай мэдэгдлийн хувийг тэр даруйд нь хүргүүлнэ. Сонирхогч этгээд эрхийн хамгаалалтаас татгалзсан оронд барааны тэмдгээ өөрөө шууд бүртгүүлсэн бол хамгаалалтын адил эрх эдэлнэ.

(4) Олон улсын товчоо барааны тэмдгийг хамгаалахаас татгалзаж байгаа шалтгааныг аливаа сонирхож буй этгээдэд даруй мэдэгдэх ёстой.

(5) Барааны тэмдгийн бүртгэл буюу эрхийн хамгаалалтыг өргөтгөх тухай хүсэлтийн тухайд хэсэгчлэн буюу бүрмөсөн татгалзаж буй тухай аливаа шийдвэрийг дээр дурдсан нэг жилийн хугацаанд олон улсын товчоонд өгөөгүй байгууллагууд энэхүү зүйлийн (1) дэх хэсэгт заасан эрхийг уг барааны тэмдгийн хувьд эдлэх эрхгүй болно.

(6) Барааны тэмдгийг эзэмшигчид зохих хугацаанд нь өөрийнхөө эрхийг хамгаалах боломж олгохгүйгээр эрх бүхий байгууллагууд олон улсын барааны тэмдгийг хүчингүй болгох шийдвэр гаргах ёсгүй. Олон улсын барааны тэмдгийг хүчингүй болгосон тухай шийдвэрийг олон улсын товчоонд мэдэгдэнэ.

5 bis зүйл

Барааны тэмдгийн бүрдэл хэсгийн хууль ёсны ашиглалтыг нотлох баримт

Хэлэлцэн тохирогч орнуудын байгууллагаас шаардаж болох тэмдгийн сүлд, зураг, ялгах тэмдэг, цол, аж ахуйн нэгжийн нэр, мэдүүлэг гаргагчийнхаас өөр нэр, бусад бичвэр зэргийг агуулсан зарим бүрдлийг хэрэглэх хууль ёсны бичиг баримтыг гарлын орны байгууллагын гэрчилгээнээс өөр гэрчилгээгээр батлахгүй.

5 ter зүйл

Олон улсын бүртгэлд хийсэн тэмдэглэлийн хуулбар,

Шинэ байдалд хайлт хийх, олон улсын бүртгэлийн хуулга

(1) Олон улсын товчоо сонирхогчийн хүсэлтээр тодорхой барааны тэмдгийн бүртгэлд хийсэн тэмдэглэлийн хуулбарыг журмаар тогтоосон хураамж авсны үндсэн дээр гаргаж өгнө.

(2) Олон улсын товчоо олон улсын барааны тэмдгийн санд мөн төлбөртэйгөөр хайлт хийж болно.

(3) Хэлэлцэн тохирогч аль нэг оронд үйлдвэрлэх зорилгоор олон улсын бүртгэлээс хэсэгчлэн авсан хэсгүүд заавал баталгаажсан байхыг шаардахгүй.

6 дугаар зүйл

**Олон улсын бүртгэлийн хүчинтэй хугацаа,
олон улсын бүртгэлийн хараат бус байдал, гарлын оронд эрхийн хамгаалалт дуусгавар
болох**

(1) Барааны тэмдгийг 7 дугаар зүйлд дурдсан нөхцөлөөр сунгах боломжтойгоор олон улсын товчоонд хорин жилийн хугацаатайгаар бүртгэнэ.

(2) Олон улсын бүртгэлийн огнооноос эхлэн таван жилийн хугацаа өнгөрөхөд энэ бүртгэл гарлын оронд урьдчилан бүртгэгдсэн үндэсний барааны тэмдгээс хараат бус байдалтай болох бөгөөд дараахь нөхцөлүүдийг харгалзана.

(3) Өмнө нь 1 дүгээр зүйлийн дагуу гарлын оронд бүртгэгдсэн үндэсний барааны тэмдэг хэрэв олон улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш таван жилийн хугацаанд гарлын орондоо бүрэн буюу хагас эрхийн хамгаалалт эдлээгүй бол, шилжүүлэгдсэн эсэхээс үл хамааран олон улсын бүртгэлээс үүдэн гарах бүрэн буюу хагас эрхийн хамгаалалтыг цаашид эдлэхгүй. Энэ журмыг таван жилийн хугацаа өнгөрөөгүй байхад шүүхээр хэрэг үүсгэсний улмаас хамгаалуулах эрхээ алдсан тохиолдолд хэрэглэж болно.

(4) Сайн дураар буюу цуцлах тохиолдолд гарлын орны байгууллага барааны тэмдгийг олон улсын бүртгэлээс хасахыг олон улсын товчооноос хүсэх ба товчоо нь түүнийг цуцална. Хэрэв шүүхээр авч хэлэлцэх хэрэг үүсвэл байгууллага нэхэмжлэл гаргагчийн хүсэлтээр буюу мэдүүлгийн хуулбар болон хэрэг үүссэн тухай бусад баримтын нотолгоо болон шүүхийн эцсийн шийдвэрийг олон улсын товчоонд хүргүүлнэ. Товчоо энэ тухай олон улсын бүртгэлд тэмдэглэнэ.

7 дугаар зүйл

Олон улсын бүртгэлийн хугацааг сунгах

(1) Өмнөх хугацаа дууссан үеэс эхлэн бүртгэлийн үндсэн хураамжийг ердийн журмаар төлөх, шаардлагатай бол 8 дугаар зүйлийн (2) дахь хэсгээр тогтоосон нэмэлт болон тусгай хураамжийг төлөх замаар аливаа бүртгэлийг хорин жилийн хугацаагаар сунгаж болно.

(2) Хугацааг сунгахдаа өмнөх бүртгэлийн сүүлчийн хэлбэрт холбогдох аливаа өөрчлөлтийг оруулахгүй.

(3) 1957 оны 6 дугаар сарын 15 - ны өдрийн Ниццийн хэлэлцээр буюу энэхүү баримт бичгийн дагуу хийх анхны сунгалт нь бүртгэлд хамаарах олон улсын ангиллыг бүрэн тусгасан байх ёстой.

(4) Хамгаалалтын хугацаа дуусахаас зургаан сарын өмнө олон улсын товчоо албан бус мэдэгдэл явуулах замаар барааны тэмдгийн эзэмшигч ба түүний итгэмжлэгчид заасан хугацаа дуусах тодорхой он сар өдрийг сануулна.

(5) Журмаар тогтоосон нэмэгдэл хураамжийг төлсөн нөхцөлд олон улсын бүртгэлийг сунгах зургаан сарын хөнгөлөлттэй хугацаа өгнө.

8 дугаар зүйл

Үндэсний хураамж, олон улсын хураамж, хураамжийн илүүдэл үлдэгдлийг хуваарилах, нэмэлт хураамж болон тусгай хураамж

(1) Гарлын орны байгууллага олон улсын бүртгэлд барааны тэмдгээ бүртгүүлэх буюу бүртгэлийн хугацаагаа сунгуулах барааны тэмдгийн эзэмшигчээс өөрийн орлого болгон хураан авах үндэсний хураамжийн хэмжээг өөрийн үзэмжээр тогтооно.

(2) Олон улсын хураамжийг урьдчилан төлсөн нөхцөлд олон улсын товчоонд барааны тэмдгийг бүртгэн авна. Уг хураамжид доорх зүйлийг багтаана. Үүнд:

(a) үндсэн хураамж;

(b) тэмдэг хэрэглэх бараа буюу үйлчилгээний олон улсын ангиллын гурваас илүү ангилал бүрээс авах нэмэлт хураамж;

(c) 3 төр зүйлийн дагуу эрхийн хамгаалалтыг өргөтгөх тухай хүсэлт гаргасны тусгай хураамж.

(3) Хэрэв бараа буюу үйлчилгээний ангиллын тоог олон улсын товчоо тогтоосон бол (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан нэмэлт хураамжийг бүртгэлийн он сар өдрийг харгалзахгүйгээр журмаар тогтоосон хугацаанд төлж болно. Хэрэв тогтоосон хугацаа дууссан байхад нэмэлт хураамж төлөөгүй бөгөөд бараа буюу үйлчилгээний тоог мэдүүлэг гаргагч шаардагдах хэмжээгээр хорогдуулаагүй бол олон улсын бүртгэлд цаашид бүртгэх ажлыг зогсоосонд тооцно.

(4) (2) дахь хэсгийн (b) ба (c) дэд хэсэгт дурдсан орлогоос бусад олон улсын бүртгэлээс орсон төрөл бүрийн орлогын жилийн дүнг олон улсын товчоо энэхүү актад оролцогч орнуудад адил хэмжээтэйгээр хуваарилна. Тэгэхдээ дурдсан актыг биелүүлэхтэй холбогдсон зардлыг хасна. Хэрэв энэхүү актыг хүчин төгөлдөр болох үед аль нэг орон энэ актыг соёрхон батлаагүй буюу түүнд нэгдэн ороогүй байсан бол актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон өдөр хүртэлх өмнөх актын үндсэн дээр хуваарилагдсан орлогын илүүдэл хувийг тухайн орон авах эрхтэй.

(5) 2 дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан хураамжаас бий болсон хөрөнгийг жил бүрийн эцэст энэхүү акт эсхүл 1967 оны 6 дугаар сарын 15- ны өдрийн Ниццийн актад оролцогч орнуудад орон бүрийн өнгөрөгч жилд хамгаалуулахаар өгсөн барааны тэмдгийн тоонд тэгшитгэн хуваарилна. Харин урьдчилсан магадлан шүүлт хийлгэж байгаа орны хувьд бол энэ тоог журмаар тогтоосон коэффициентыг харгалзан бодож тооцно. Хэрэв энэхүү актыг хүчин төгөлдөр болох үед аль нэг орон энэ актыг соёрхон батлаагүй буюу нэгдэн ороогүй байсан бол актыг соёрхон батлах буюу нэгдэн орох хүртэлх Ниццийн актын үндсэн дээр хуваарилагдсан мөнгөний орлогоос тухайн орон хувь хүртэх эрхтэй.

(6) (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан тусгай хураамжаас бий болсон хөрөнгийг 3 bis зүйлд дурдсан эрхийг эдэлж буй орнуудад (5) дахь хэсгийн заалтын дагуу хуваарилна. Хэрэв энэхүү актыг хүчин төгөлдөр болох үед уг орон энэ актыг соёрхон батлаагүй буюу түүнд нэгдэн ороогүй байсан бол актыг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орох хүртэлх Ниццийн актын үндсэн дээр хуваарилагдсан мөнгөний орлогоос тухайн орон хувь хүртэх эрхтэй.

8 bis зүйл

Нэг буюу түүнээс дээш оронд эрхийн хамгаалалт хийхээс татгалзах

Олон улсын бүртгэлд бүртгүүлсэн эзэмшигч хэлэлцэн тохирогч нэг болон түүнээс дээш оронд барааны тэмдгээ хамгаалуулахаас татгалзах тухайгаа өөрийн орны байгууллагад мэдүүлэг гаргах замаар олон улсын товчоонд мэдэгдэнэ. Олон улсын товчоо холбогдох орнуудад ийнхүү татгалзсаныг мэдэгдэнэ. Татгалзах тохиолдолд хураамж төлөхгүй.

9 дүгээр зүйл

**Олон улсын бүртгэлийг хөндөх үндэсний бүртгэлд өөрчлөлт оруулах,
Олон улсын бүртгэлд дурдсан бараа, үйлчилгээний жагсаалтыг багасгах, түүнд нэмэлт
оруулах болон солих**

(1) Олон улсын бүртгэлд бүртгүүлсэн эзэмшигчийн харьяалах орны байгууллага нь бүртгэлээс хассан, хамгаалуулахаас татгалзсан, эзэмшигч нь эрхээ шилжүүлсэн зэрэг барааны тэмдгийн талаар үндэсний бүртгэлд өөрчлөлт оруулсан тухай, хэрэв эдгээр өөрчлөлт нь олон улсын бүртгэлийг хөндөж байгаа бол олон улсын товчоонд мэдэгдэнэ.

(2) Товчоо эдгээр өөрчлөлтийг олон улсын бүртгэлд оруулаад хэлэлцэн тохирогч орнуудын байгууллагуудад мэдэгдэх бөгөөд өөрийн хэвлэлд нийтэлнэ.

(3) Олон улсын бүртгэлд бүртгүүлсэн эзэмшигч барааны тэмдэгт хамаарах бараа буюу үйлчилгээний жагсаалтыг хорогдуулах тухай хүсэлт гаргавал гаргавал дээрх журмаар гүйцэтгэнэ.

(4) Ийм хэлцэл хийхэд журмаар тогтоосон хураамж төлнө.

(5) Бараа буюу үйлчилгээний жагсаалтад цаашид нэмэлт оруулбал 3 дугаар зүйлийн заалтын дагуу мэдүүлгээ шинээр гаргана.

(6) Нэг бараа буюу үйлчилгээг нөгөөгөөр солихыг нэмэлт оруулахтай адилаар зохицуулна.

9 bis зүйл

Тэмдэг эзэмшигчийн орныг өөрчлөх олон улсын тэмдгийг шилжүүлэх

(1) Хэрэв олон улсын бүртгэлд бүртгүүлсэн барааны тэмдгийг эзэмшигчийнх нь оронд бус хэлэлцэн тохирогч өөр оронд оршин суугаа этгээдэд шилжүүлэх тохиолдолд тухайн орны байгууллага энэ тухай олон улсын товчоонд мэдэгдэнэ. Олон улсын товчоо эрх шилжүүлснийг бүртгээд энэ тухай бусад байгууллагуудад мэдэгдэж, өөрийн хэвлэлд нийтэлнэ. Хэрэв олон улсын бүртгэлд орсноос хойш таван жилийн хугацаа дуусаагүй байхад эрхийн шилжүүлэлт хийгдвэл олон улсын товчоо шинэ эзэмшигчийн орны байгууллагын зөвшөөрлийг авч, боломжтой бол шинэ эзэмшигчийн оронд уг барааны тэмдгийг бүртгэсэн огноогоор нийтэлнэ.

(2) Барааны тэмдгээ олон улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах эрхгүй этгээдэд олон улсын бүртгэлд бүртгэгдсэн барааны тэмдгийн эрхийг шилжүүлэх тохиолдолд түүнийг бүртгэхгүй.

(3) Шинэ эзэмшигчийн орон зөвшөөрөөгүй, эсхүл мэдүүлэг гаргах эрхгүй этгээдэд эрхийг шилжүүлсний улмаас эрх шилжүүлсэн тухай олон улсын бүртгэлд бүртгэх боломжгүй тохиолдолд тэмдгийн өмнөх эзэмшигчийн орны байгууллага бүртгэлээсээ уг барааны тэмдгийг хасах тухай олон улсын товчооноос шаардах эрхтэй.

9 ter зүйл

Олон улсын бүртгэлд бүртгэгдсэн бараа буюу үйлчилгээний зарим хэсгийн хувьд эсхүл хэлэлцэн тохирогч зарим орнуудын хувьд эрх шилжүүлэх, Парисын конвенцийн 6 quater зүйлд хамаарах /Барааны тэмдэг шилжүүлэх/

(1) Бүртгэгдсэн бараа буюу үйлчилгээний зөвхөн заримд олон улсын барааны тэмдгийн эрхийг шилжүүлж байгаа тухай олон улсын товчоонд мэдэгдвэл тэрээр энэ тухай өөрийн бүртгэлд оруулна. Ийнхүү шилжүүлсэн хэсэгт хамаарагдах зарим бараа буюу үйлчилгээ нь шилжүүлсэн этгээдэд үлдсэн бүртгэгдсэн барааны тэмдэгтэй адил төстэй байвал хэлэлцэн тохирогч аливаа орон энэ шилжүүлгийг хүчинтэйд тооцохгүй байх эрх эдэлнэ.

(2) Олон улсын товчоо зөвхөн хэлэлцэн тохирогч нэг буюу хэд хэдэн орны хувьд олон улсын барааны тэмдгийн талаар хийсэн шилжүүлгийг бүртгэнэ.

(3) Хэрэв дурдсан тохиолдолд эзэмшигчийн орон өөрчлөгдсөн буюу олон улсын бүртгэлд орсноос хойш таван жилийн хугацаа дуусаагүй байхад тэмдгийг шилжүүлсэн бол шинэ эзэмшигчийн орны байгууллага 9 bis зүйлийн дагуу зохих зөвшөөрөл өгөх ёстой.

(4) Өмнөх хэсгийн заалтуудыг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 6 quater зүйлийн заалтын дагуу хэрэглэнэ.

9 quater зүйл

Хэд хэдэн хэлэлцэн тохилогч орны нэгдсэн байгууллага, хэд хэдэн хэлэлцэн тохилогч орныг нэг орон гэж авч үзэх тухай хүсэлт

(1) Тусгай холбооны хэд хэдэн орон барааны тэмдгийн тухай үндэснийхээ хууль тогтоомжийг нэгтгэхээр тохирвол тэд ерөнхий захиралд дараахь зүйлийг мэдэгдэж болно:

(a) орон бүрийн үндэсний байгууллагыг нэгдсэн байгууллага орлон гүйцэтгэх;

(b) тэдгээр орнуудын нутаг дэвсгэрийн нийлбэрийг энэхүү зүйлийн өмнөх заалтуудыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлэхэд нэг орон гэж үзэх.

(2) Ерөнхий захирал хэлэлцэн тохилогч бусад орнуудад мэдэгдсэн өдрөөс хойш зургаан сарын дараа энэхүү мэдэгдэл хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл

Тусгай холбооны Ассамблей

(1) (a) Тусгай холбоо энэхүү баримт бичгийг баталсан буюу түүнд нэгдэн орсон орнуудаас бүрдсэн Ассамблейтай байна.

(b) Орон бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэр нь орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгчдийн зардлыг түүнийг томилсон засгийн газар, харин гишүүн орон бүрийн нэг төлөөлөгчийн байр, замын зардлыг тусгай холбоо хариуцна.

(2) (a) Ассамблей:

(i) тусгай холбоог эрхлэх, хөгжүүлэх болон энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдох бүх асуудлыг авч хэлэлцэх;

(ii) хянан өөрчлөх бага хуралд бэлтгэхтэй холбоотой асуудлаар болон энэхүү актыг соёрхон батлаагүй, түүнд нэгдэн ороогүй тусгай холбооны гишүүн орнуудаас өгсөн санал, тайлбарын талаар олон улсын товчоонд чиглэл өгөх;

(iii) журам өөрчлөх, 8 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан хураамж болон олон улсын бүртгэлд хамаарах бусад хураамжийн хэмжээг тогтоох;

- (iv) тусгай холбооны талаарх ерөнхий захирлын илтгэл, үйл ажиллагааг хянаж, батлах, тусгай холбооны эрх хэмжээнд багтах аливаа асуудлаар түүнд зааварчлах;
 - (v) тусгай холбооны хөтөлбөр тодорхойлох ба хоёр жил тутмын төсвийг батлах, түүний санхүүгийн тайланг батлах;
 - (vi) тусгай холбооны санхүүгийн журмыг батлах;
 - (vii) тусгай холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал гэж үзсэн шинжээчдийн хороо, ажлын хэсгүүдийг байгуулах;
 - (viii) тусгай холбооны гишүүн бус ямар орон, засгийн газар хоорондын болон засгийн газрын бус ямар байгууллага тусгай холбооны уулзалтуудад ажиглагчаар оролцож болохыг тодорхойлох;
 - (ix) 10- 13 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - (x) тусгай холбооны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд холбогдох аливаа бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
 - (xi) энэхүү хэлэлцээрээр түүнд хүлээлгэсэн бусад бүх үүргийг хэрэгжүүлэх.
- (b) байгууллагаас удирдаж байдаг бусад холбоодын сонирхсон асуудлаар Ассамблей нь байгууллагын зохицуулах хорооны саналтай танилцсаны дараа шийдвэр гаргана.
- (3) (a) Ассамблейн гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.
- (b) Ассамблейн гишүүн орнуудын тэн хагас нь кворум бүрдүүлнэ.
- (c) (b) дэд хэсэгт заасан дүрмийг үл харгалзан хэрэв ямар нэг чуулган дээр төлөөлөх орнуудын тоо тэн хагасаас бага байх боловч Ассамблейн гишүүн орнуудын гуравны нэгтэй тэнцүү буюу илүү байвал Ассамблей шийдвэр гаргаж болно. Гэхдээ Ассамблейн өөрийнх нь үйл ажиллагаанд хамаарах шийдвэрээс бусад шийдвэрүүд нь дараахь нөхцөл бүрдсэн үед хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо Ассамблейн чуулганд оролцоогүй гишүүн орнуудад шийдвэрийг хүргүүлэх ба уг шийдвэрийг батлах, батлахгүй, эсхүл түдгэлзэж байгаа алин болохыг шийдвэрийг тийнхүү хүргүүлснээс хойш гурван сарын хугацаанд бичгээр ирүүлэхийг мэдэгдэнэ. Хэрэв энэ хугацаа дуусах үед шийдвэрийг баталсан буюу түдгэлзсэн орны тоо хуралдааны үеэр санал хураахад дутаж байсан орны тоонд хүрсэн тохиолдолд уг шийдвэр олонхоор хүчин төгөлдөр болно.
- (d) Ассамблей 13 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн заалтын дагуу гарсан гуравны хоёрын олонхын саналаар шийдвэр гаргана.
- (e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(f) Нэг төлөөлөгч нэг орныг төлөөлж зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгөх эрхтэй.

(g) Ассамблейн гишүүн бус тусгай холбооны орнуудыг Ассамблейн чуулганд ажиглагчаар оролцуулна.

(4) (a) Онцгой тохиолдлоос бусад тохиолдолд ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг байгууллагын Ерөнхий Ассамблей чуулдаг газарт болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдана.

(b) Ассамблейн гишүүн орнуудын дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу ерөнхий захирал Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.

(c) Ерөнхий захирал чуулган бүрийн хэлэлцэх асуудлыг дэгийн төслийг бэлтгэнэ.

(5) Ассамблей өөрийн ажиллагааны журмыг батална.

II дүгээр зүйл

Олон улсын товчоо

(1) (a) Олон улсын бүртгэл болон холбогдох үүрэг, тусгай холбооны захиргааны асуудлыг олон улсын товчоо эрхэлнэ.

(b) Тухайлбал, олон улсын товчоо хуралдаанд бэлтгэх, Ассамблейн болон шинжээчдийн хороо, ажлын хэсгүүдийн нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

(c) Ерөнхий захирал тусгай холбооны дээд удирдлага бөгөөд тусгай холбоог төлөөлнө.

(2) Ерөнхий захирал ба түүний томилсон ажилтан Ассамблей, шинжээчдийн хорооны болоод ажлын хэсгүүдийн хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцох бөгөөд ерөнхий захирал, түүний томилсон ажилтан эдгээр хуралдааны нарийн бичгийн дарга байна.

(3) (a) Олон улсын товчоо Ассамблейн журмын дагуу хэлэлцээрийн 10- 13 дугаар зүйлийн заалтуудаас бусад заалтыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулна.

(b) Олон улсын товчоо ханан өөрчлөх бага хуралд бэлтгэх асуудлаар засгийн газар хоорондын буюу олон улсын төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал, түүний томилсон ажилтан бага хурлуудаар асуудал хэлэлцэхэд санал өгөх эрхгүйгээр оролцоно.

(4) Олон улсын товчоо түүнд даалгасан бусад аливаа үүргийг хэрэгжүүлнэ.

12 дугаар зүйл

Санхүү

(1) (a) Тусгай холбоо төсөвтэй байна.

(b) Тусгай холбооны төсөвт тусгай холбооны орлого, зарлага, холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт оруулах хандив, зарим тохиолдолд байгууллагын бага хурлын төсөвт орох зардал багтана.

(c) Холбоодод хамаарах нийтийн зардал гэдэгт зөвхөн тусгай холбоонд хамаатай бус, мөн захиргааны үүргийг нь байгууллага гүйцэтгэдэг бусад нэг буюу хэд хэдэн холбоод хамаарах зардлыг ойлгоно. Эдгээр нийтийн зардалд тусгай холбооны хувь нь эдгээр холбоодод тусгай холбооны сонирхлын хэмжээтэй адил байна.

(2) Тусгай холбооны төсвийг байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) Тусгай холбооны төсөв нь дор дурдсан эх үүсвэрээс санхүүжнэ:

- (i) олон улсын бүртгэлд хамаарах үндсэн болон бусад хураамж, олон улсын товчооноос үзүүлдэг бөгөөд тусгай холбоонд хамаарах бусад үйлчилгээнээс орох хураамж, төлбөр;
- (ii) Тусгай холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтаас худалдсанаас олсон болон бусад холбогдох орлого;
- (iii) бэлэг, гэрээслэлээр үлдээсэн өв, хөрөнгө, татаас;
- (iv) түрээс, зээлийн хүү, бусад орлого;

(4) (a) 8 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан хураамж болон олон улсын бүртгэлд хамаарах бусад хураамжийн хэмжээг ерөнхий захирлын санал болгосноор Ассамблей тогтооно.

(b) Хураамжийн хэмжээг тогтоохдоо 8 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b), (c) дэд хэсэгт заасан нэмэлт болон тусгай хураамжаас бусад хураамжаас олсон тусгай холбооны орлого, мөн түүнчлэн орлогын бусад эх үүсвэрээс орсон орлого нь наад зах нь олон улсын товчооны тусгай холбоонд хамаарах зардлыг нөхөх бололцоотой байхаар бодож тогтооно.

(c) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнөх жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Тусгай холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлдэг бусад үйлчилгээний хураамж, төлбөрийн хэмжээг (4) дэх хэсгийн (a) дэд хэсгийн заалтыг харгалзан ерөнхий захирал тогтоодог бөгөөд тэрээр энэ тухай Ассамблейд илтгэнэ.

(6) (a) Тусгай холбоо эргэлтийн хөрөнгийн сантай байх бөгөөд энэ нь тусгай холбооны гишүүн орон бүрээс төлдөг нэг удаагийн төлбөрөөс бүрдэнэ. Хэрэв эргэлтийн хөрөнгийн хэмжээ хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх шийдвэр гаргана.

(b) Дээр дурдсан санд орон бүрээс төлөх анхны төлбөрийн хэмжээ, уг санг нэмэгдүүлэхэд оруулах хандив нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын холбооны гишүүний хувьд уг орноос дээрх санг бий болгосон жилд буюу түүнийг нэмэгдүүлэх шийдвэр гарсан жилд энэхүү холбооны төсөвт төлөх татварын хувьтай адил байна.

(c) Энэ харьцаа, төлбөрийн нөхцөлийг Ассамблей ерөнхий захирлын саналаар байгууллагын зохицуулах хорооны саналыг харгалзан тогтооно.

(d) Ассамблей тусгай холбооны нөөцийн санг эргэлтийн хөрөнгийн сан болгон ашиглахыг зөвшөөрдөг ч Ассамблей өөрөө (a), (b), (c) дэд хэсгийн заалтыг хэрэглэхийг зогсоож болно.

(7) (a) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг оронтой байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн орон урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг тусдаа байгууллага, тухайн орон хоорондын хэлэлцээрээр зохицуулна.

(b) (a) дэд хэсэгт заасан орон, байгууллага аль аль нь урьдчилгаа олгох, авах тухай үүргээ цуцлах талаар бичгээр мэдэгдэх эрхтэй. Цуцлалт нь мэдэгдэл хийсэн жил дууссанаас хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(8) Санхүүгийн шалгалтыг санхүүгийн журамд зааснаар тусгай холбооны нэг буюу хэд хэдэн орон, эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрснөөр Ассамблей томилно.

13 дугаар зүйл

10 - 13 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах

(1) 10, 11, 12 дугаар зүйл болон энэхүү зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ассамблейн аль ч гишүүн орон, эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Ийм саналыг Ассамблейн гишүүн орнуудад ерөнхий захирал чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө мэдэгдэнэ.

(2) (1) дэх хэсэгт заасан зүйлүүдэд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей дөрөвний гурвын олонхын саналаар батлах бөгөөд харин 10 дугаар зүйл ба энэхүү хэсэгт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) (1) дэх хэсэгт заасан зүйлүүдэд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь орон бүрийн үндсэн хуулийн дагуу хүлээн авсан тухай бичгээр өгсөн мэдэгдлийг ерөнхий захирал нэмэлт, өөрчлөлтийг батлах үед Ассамблейн гишүүн байсан орнуудын дөрөвний гурваас нь авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Ийнхүү

батлагдсан аливаа нэмэлт өөрчлөлтийг түүнийг батлах үед Ассамблейн гишүүн байсан буюу түүнээс хойш гишүүн болсон орнууд хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

14 дүгээр зүйл

**Соёрхон батлах, нэгдэн орох, хүчин төгөлдөр болох, өмнөх актуудад нэгдэн орох,
Парисын конвенцийн 24 дүгээр зүйлд хамаарах /нутаг дэвсгэр/**

(1) Энэхүү актад гарын үсэг зурсан тусгай холбооны гишүүн аливаа орон түүнийг соёрхон баталж болох бөгөөд гарын үсэг зураагүй бол түүнд нэгдэн орж болно.

(2) а) Тусгай холбооны гишүүн биш бөгөөд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч тал болох аливаа орон энэхүү актад нэгдэн орж тусгай холбооны гишүүн болж болно.

б) Олон улсын товчоо аливаа орон энэхүү актад нэгдэн орсон тухай мэдэгдлийг хүлээн авмагцаа тухайн орны байгууллагад 3 дугаар зүйлийн дагуу тухайн үед хамгаалалт эдэлж байгаа тэмдгүүдийн тухай багц мэдэгдэл хүргүүлнэ.

с) Ийнхүү мэдэгдсэнээр тухайн орны нутаг дэвсгэр дээр, дурдсан барааны тэмдгүүд өмнөх заалтад заасан эрх эдлэх нөхцөл хангагдах бөгөөд эхлэх хугацааг нэг жилээр тогтооно. Энэ хугацаанд холбогдох байгууллага 5 дугаар зүйлд заасны дагуу тайлбар хийж болно.

д) Харин энэхүү актад нэгдэн орж буй аливаа орон өмнө нь тэр орны үндэсний бүртгэлд авч байсан, сонирхогч талуудын хүсэлтээр шууд хүлээн зөвшөөрөгдөх, одоо хамгаалагдаж байгаа олон улсын барааны тэмдгүүдийг хөндөхгүйгээр тухайн орны нэгдэн орж буй баримт бичиг нь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж бүртгэгдсэн барааны тэмдгийн хувьд л уг актыг хэрэглэнэ гэсэн тайлбар хийж болно.

е) Ийм мэдэгдэл нь дээр дурдсан барааны тэмдгийн талаарх мэдэгдлийг хийхээс олон улсын товчоог чөлөөлөх бөгөөд олон улсын товчоо нь нэгдэж орсноосоо хойш нэг жилийн дотор (d) дэд хэсэгт дурдсан ялгавартай хэрэглэх хөнгөлөлтийг эдлэх тухай хүсэлтээ ирүүлсэн орны тухайд зөвхөн хүсэлтэд дурдсан барааны тэмдгийн тухай мэдэгдэл гаргана.

ф) Олон улсын товчоо энэхүү актын дагуу 3 bis зүйлд заасан эрхийг эдлэх тухайгаа мэдэгдсэн орнуудад барааны тэмдгийн тухай мэдэгдэл хүргүүлэхгүй. Эдгээр орон тухайн орны нэгдэн орж буй баримт бичиг нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш бүртгэгдсэн барааны тэмдгүүдэд л энэхүү актыг хэрэглэхээ мэдэгдэж болно. Харин энэ хязгаарлалт нь уг оронд өмнө нь үндэсний бүртгэлд авч байсан олон улсын барааны тэмдэгт хамаарахгүй бөгөөд тэдгээр барааны тэмдэг нь 3 ter зүйл, 8 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (с) дэд хэсгийн дагуу хамгаалалтыг өргөтгөх тухай мэдэгдэл хийх үндэс болно.

г) Энэхүү хэсэгт заасан мэдэгдлүүдийн аль нэг мэдэгдлийн сэдэв болох барааны тэмдгийн бүртгэл нь хэлэлцэн тохирогч шинэ оронд түүний нэгдэн орохоос өмнө хийгдсэн бүртгэлийг орлоно гэж ойлгоно.

(3) Батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулна.

(4) а) Энэхүү акт нь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн эхний таван орны хувьд тав дахь баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

б) Аливаа бусад орны хувьд энэхүү акт нь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай бичигт өөр хугацаа заагаагүй тохиолдолд соёрхон баталсан буюу нэгдэн орсныг ерөнхий захирал нотолсон өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хугацаа заасан тохиолдолд энэхүү акт тухайн орны хувьд уг заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

(5) Соёрхон баталсан буюу нэгдэн орсноор энэхүү актын бүх заалтыг шууд хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд давуу эрхийг ч эдэлж эхэлнэ.

(6) Энэхүү акт хүчин төгөлдөр болсны дараа зөвхөн энэхүү актыг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орохтой холбогдуулан тухайн орон 1957 оны 6 дугаар сарын 15- ны Ниццийн актад нэгдэн орж болно. Энэхүү актыг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орохтой холбоотойгоор ч гэсэн Ниццийн актаас өмнөх актуудад нэгдэн орохыг зөвшөөрөхгүй.

(7) Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 24 дүгээр зүйлийн заалтыг энэхүү хэлэлцээрт хэрэглэнэ.

15 дугаар зүйл

Цуцлах

(1) Энэхүү хэлэлцээр хугацаа хязгаарлахгүй хүчин төгөлдөр үйлчилнэ.

(2) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдэл өгөх замаар энэхүү актыг цуцалж болно. Энэхүү актыг цуцалснаар өмнөх бүх актыг мөн адил цуцлах бөгөөд энэ нь зөвхөн мэдэгдэл гаргасан оронд хамаарах болно. Харин тусгай холбооны бусад орны хувьд хэлэлцээр хүчинтэй хэвээр үлдэнэ.

(3) Цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэ зүйлийн дагуу олгосон цуцлах эрхийг тусгай холбооны гишүүн болсон өдрөөс хойш таван жилийн хугацаанд ямар ч орон эдлэхгүй.

(5) Цуцлалт хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө бүртгэгдсэн бөгөөд 5 дугаар зүйлд дурдсан ёсоор нэг жилийн хугацаанд хамгаалуулахаас татгалзсан шийдвэр гаргаагүй олон улсын барааны тэмдэг нь цуцалж байгаа оронд шууд бүртгэгдсэний нэгэн адил олон улсын хамгаалалтын бүх л хугацаанд үргэлжлэн хамгаалагдана.

16 дугаар зүйл

Өмнөх актуудыг хэрэглэх

(1) а) Энэхүү акт түүнийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон тусгай холбооны гишүүн орнуудын хоорондын харилцаанд, уг акт тэдгээр орны хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөсөө эхлэн 1891 оны Мадридын хэлэлцээрийн энэхүү актаас өмнөх үеийн бүх эх бичвэрийг орлоно.

б) Энэхүү актыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон орон бүр энэхүү актыг соёрхон батлаагүй буюу түүнд нэгдэн ороогүй оронтой харьцахад 1957 оны 6 дугаар сарын 15- ны Ниццийн актын 13 дугаар зүйлийн үндсэн дээр өмнө нь цуцлаагүй байсан өмнөх үеийн эх бичвэрийг мөрдөнө.

(2) Тусгай холбоонд ороогүй боловч энэхүү актад оролцогч орнууд энэхүү актад оролцоогүй боловч тусгай холбооны гишүүн аль ч орны үндэсний байгууллагаар дамжуулан олон улсын товчооноос хийдэг олон улсын бүртгэлд энэхүү актыг хэрэглэнэ. Чингэхдээ тухайн орнуудын хувьд бүртгэл энэхүү актын шаардлагыг хангасан байна. Тусгай холбоонд ороогүй боловч энэхүү актад нэгдэн орсон орон өөрийн байгууллагаар дамжуулан олон улсын товчоонд хийдэг олон улсын бүртгэлийн хувьд тусгай холбооны дээр дурдсан гишүүн орон нь нэгдэн орсон сүүлийн актын шаардлагыг хангахыг шаардаж болно гэдгийг хүлээн зөвшөөрнө.

17 дугаар зүйл

Гарын үсэг, хэл, хадгалах үүрэг

(1)

а) Энэхүү актын франц хэлээрх нэг хувьд гарын үсэг зурж Швед Улсын Засгийн газарт хадгалуулна.

б) Албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний дараа чуулганаар тогтоосон бусад хэлээр гаргана.

(2) Энэхүү акт 1968 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл Стокгольм хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна.

(3) Ерөнхий захирал энэхүү актын гарын үсэг зурсан эх бичвэрийн хоёр хувийг Швед Улсын Засгийн газраар баталгаажуулан тусгай холбооны бүх орны засгийн газарт болон хүсэлт гаргасан аливаа бусад орны засгийн газарт хүргүүлнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү актыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал тусгай холбооны бүх орны засгийн газарт гарын үсэг зурсан тухай, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай, эдгээр баримт бичгүүдэд агуулагдаж байгаа тайлбар, мэдэгдлийн тухай, энэхүү актын аливаа заалт хүчин төгөлдөр болсон тухай, цуцалсан тухай мэдэгдэл болон 3 bis, 9 quater, 13, 14 (7), 15 (2) дугаар зүйлүүдийн дагуу хийсэн мэдэгдлийн тухай тус тус мэдээлнэ.

18 дугаар зүйл

Шилжилтийн заалтууд

(1) Анхны ерөнхий захирлыг албан тушаалдаа орох хүртэл энэхүү актад тусгасан байгууллагын олон улсын товчоо буюу ерөнхий захирлын тухай заалтыг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцоор байгуулагдсан холбооны товчоо буюу түүний захирлын тухай заалтад хамруулж ойлгоно.

(2) Энэхүү актыг соёрхон батлаагүй буюу түүнд нэгдэн ороогүй орнууд Байгууллага байгуулах тухай конвенц хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн хугацаанд өөрсдөө хүсвэл энэхүү актын 10, 13 дугаар зүйлүүдэд заасан эрхийг эдэлж болно. Ийм эрх эдлэхийг хүссэн аливаа орон ерөнхий захиралд хүсэлтээ бичгээр мэдэгдэнэ. Тухайн хүсэлт нь түүнийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Эдгээр орныг заасан хугацаа дуусах хүртэл чуулганы гишүүн гэж үзнэ.

**62. БАРААНЫ ТЭМДГИЙН ОЛОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ
МАДРИДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ПРОТОКОЛ***

1989 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Мадрид хотноо гарын үсэг зурсан байдлаар

1 дүгээр зүйл

Мадридын холбооны гишүүнчлэл

Энэхүү протоколд оролцогч улсууд (цаашид “хэлэлцэн тохирогч улс” гэнэ) 1967 онд Стокгольм хотноо хянан өөрчилж, 1979 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр (цаашид “Мадридын хэлэлцээр (Стокгольм)” гэнэ)-т мөн оролцогч биш байсан ч 14 дүгээр зүйлийн (1) дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан энэхүү протоколд оролцогч байгууллага (цаашид “хэлэлцэн тохирогч байгууллагууд” гэнэ) Мадридын хэлэлцээр (Стокгольм)-т оролцогч улсуудын гишүүдийн адил холбооны гишүүд байна. Энэхүү протоколд “хэлэлцэн тохирогч тал” гэдэгт хэлэлцэн тохирогч улс, хэлэлцэн тохирогч байгууллага аль алиныг хэлнэ.

2 дугаар зүйл

Олон улсын бүртгэлээр хамгаалалтыг хангах

(1) Хэрэв барааны тэмдгийг бүртгүүлэх мэдүүлгийг хэлэлцэн тохирогч талын байгууллагад гаргасан эсхүл хэлэлцэн тохирогч талын байгууллагын бүртгэлд барааны тэмдэг бүртгүүлсэн бол мэдүүлэг /цаашид” үндсэн мэдүүлэг” гэнэ/ гаргагч, эсхүл бүртгэл /цаашид “үндсэн бүртгэл” гэнэ/ эзэмшигч энэхүү протоколын заалтын дагуу

* Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр соёрхон баталсан

барааны тэмдгийг Дэлхийн оюуны өмчийн байгууллагын олон улсын товчооны бүртгэлд /цаашид тус тус “ олон улсын бүртгэл”, “ олон улсын бүртгэгч”, “олон улсын товчоо”, “байгууллага” гэнэ/ бүртгүүлэх замаар хэлэлцэн тохирогч талуудын нутаг дэвсгэр дээр өөрийн барааны тэмдгийн хамгаалалтыг дараахь тохиолдолд хангана:

- (i) хэрэв хэлэлцэн тохирогч улсын байгууллагад үндсэн мэдүүлэг гаргасан, эсхүл уг байгууллага үндсэн бүртгэлийг хийсэн бол мэдүүлэгч гаргагч, эсхүл бүртгэл эзэмшигч тухайн хэлэлцэн тохирогч орны харьяат, эсхүл тэнд байнга оршин суудаг эсхүл бодит болон үр ашиг бүхий үйлдвэрлэлийн буюу худалдааны байгууллагатай байгаа бол;
- (ii) хэрэв хэлэлцэн тохирогч байгууллагад үндсэн мэдүүлэг гаргасан, эсхүл уг байгууллага үндсэн бүртгэлийг хийсэн бол мэдүүлэгч гаргагч, эсхүл бүртгэл эзэмшигч нь тухайн хэлэлцэн тохирогч байгууллагын гишүүн улсын харьяат, эсхүл тэнд байнга оршин суудаг, эсхүл тухайн хэлэлцэн тохирогч байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрт бодит болон үр ашиг бүхий үйлдвэрлэлийн буюу худалдааны байгууллагатай байгаа бол.

(2) Олон улсын бүртгэлийн мэдүүлгийг /цаашид “олон улсын мэдүүлэг” гэнэ/ тухайн тохиолдлоос шалтгаалан үндсэн мэдүүлгийг хүлээн авсан, эсхүл үндсэн бүртгэл хийсэн байгууллагын зуучлагчаар /цаашид “ гарлын байгууллага” гэнэ/ дамжуулан олон улсын товчоонд өгнө.

(3) Энэхүү протоколд “байгууллага” эсхүл “хэлэлцэн тохирогч талын байгууллага” гэдэгт барааны тэмдгийн бүртгэл хариуцсан хэлэлцэн тохирогч талын байгууллагыг, “ барааны тэмдэг” гэдэгт бараа буюу үйлчилгээний тэмдгийг ойлгоно.

(4) Энэхүү протоколд “хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэр” гэдэгт хэлэлцэн тохирогч тал нь улс байх тохиолдолд тухайн улсын нутаг дэвсгэрийг, хэрэв хэлэлцэн тохирогч тал нь засгийн газар хоорондын байгууллага байх тохиолдолд тухайн засгийн газар хоорондын байгууллагыг үүсгэн байгуулагч гэрээ үйлчилж байгаа газар нутгийг тус тус ойлгоно.

3 дугаар зүйл

Олон улсын мэдүүлэг

(1) Энэхүү протоколын дагуу гаргасан олон улсын мэдүүлгийг журмаар тогтоосон тусгай маягтаар гаргах ёстой. Гарлын байгууллага олон улсын мэдүүлгийн өгөгдөхүүнүүд нь нотолгооны үе дэх олон улсын мэдүүлгийн, эсхүл олон улсын бүртгэлийн өгөгдөхүүнүүдтэй нийцэж байгааг нотолно. Түүнээс гадна гарлын байгууллага дараахь зүйлийг заах ёстой:

- (i) үндсэн мэдүүлгийн хувьд түүний огноо ба дугаар;

- (ii) үндсэн бүртгэлийн хувьд түүний огноо, дугаар болон үндсэн бүртгэлийг үндэслэн гарсан мэдүүлгийн дугаар ба огноо.

Түүнчлэн гарлын байгууллага олон улсын мэдүүлгийн огноог заана.

(2) Мэдүүлэг гаргагч хамгаалалт шаардлагатай байгаа тэмдгийг ашиглах бараа буюу үйлчилгээг заах бөгөөд боломжтой бол Барааны тэмдэг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох тухай Ниццийн хэлэлцээрээр тогтоосон ангиллын дагуу, түүнд хамаарах ангиллыг заах ёстой. Хэрэв мэдүүлэг гаргагч ангиллыг заагаагүй бол олон улсын товчоо нь дурдсан олон улсын ангиллын аль тохирох ангилалд бараа, үйлчилгээг ангилна. Мэдүүлэг гаргагчийн заасан ангиллыг гарлын байгууллагатай хамтран олон улсын товчоо хянана. Дурдсан байгууллага болон олон улсын товчооны хооронд санал зөрөлдөх тохиолдолд олон улсын товчооны шийдвэр эцсийн байна.

(3) Хэрэв мэдүүлэг гаргагч барааны тэмдгийн өнгийг өөрийн барааны тэмдгийн ялгагдах шинж тэмдэг болгон хамгаалуулахыг хүсвэл тэрээр:

- (i) энэ тухай мэдүүлэг гарган хамгаалуулахаар хүсэж байгаа өнгө буюу өнгөнүүдийн хослолыг мэдүүлэгтээ заана;
- (ii) мэдүүлгийн хамт уг барааны тэмдгийн өнгөт хуулбарыг хавсаргана. Хуулбарын тоог журмаар тогтооно.

(4) Олон улсын товчоо нь 2 дугаар зүйлийн дагуу мэдүүлсэн барааны тэмдгийг цаг алдалгүй бүртгэнэ. Гарлын байгууллага олон улсын мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр сарын дотор олон улсын товчоо уг мэдүүлгийг хүлээн авсан бол олон улсын бүртгэлд гарлын байгууллага олон улсын мэдүүлгийг хүлээн авсан өдрөөр бүртгэнэ. Хэрэв олон улсын мэдүүлгийг дээрх хоёр сарын хугацаанд хүлээн аваагүй бол олон улсын мэдүүлгийг олон улсын товчоо хүлээн авсан өдрөөр бүртгэнэ. Олон улсын товчоо нь цаг алдалгүй сонирхсон байгууллагад олон улсын бүртгэлийн тухай мэдэгдэнэ. Олон улсын бүртгэлд бүртгүүлсэн барааны тэмдгийг олон улсын товчоо өөрийн тогтмол эрхлэн гаргадаг хэвлэлд олон улсын мэдүүлэгт багтсан мэдээллийн үндсэн дээр хэвлэн нийтэлнэ.

(5) Олон улсын бүртгэлд бүртгүүлсэн барааны тэмдгийг сурталчлах зорилгоор 10 дугаар зүйлд дурдсан бөгөөд Ассамблейгаас тогтоосон /цаашид “Ассамблей” гэнэ/ нөхцөлийн дагуу байгууллага бүр олон улсын товчооноос дээрх хэвлэлийн тодорхой хувийг үнэгүй, зарим хувийг хөнгөлөлттэй үнээр авна. Энэхүү сурталчилгаа бүх хэлэлцэн тохирогч талд хангалттай байх ёстой бөгөөд бүртгэл эзэмшигчээс өөр ямарваа сурталчилгаа шаардахгүй.

3 bis зүйл

Нутаг дэвсгэрийн үйлчлэл

Зөвхөн олон улсын бүртгэл эзэмшигч, эсхүл олон улсын мэдүүлэг гаргасан этгээдийн мэдүүлгээр олон улсын бүртгэлээс үүсэх хамгаалалтыг хэлэлцэн тохирогч талд үзүүлнэ. Гэхдээ ийм хүсэлтийг байгууллага нь гарлын байгууллага болох хэлэлцэн тохирогч талд гаргахгүй.

3 ter зүйл

“Нутаг дэвсгэрийг өргөсгөх” тухай хүсэлт

(1) Аливаа хэлэлцэн тохирогч талд хийх олон улсын бүртгэлээс үүсэх хамгаалалтыг өргөтгөх аливаа хүсэлтийг олон улсын мэдүүлэгт тусгайлан тэмдэглэнэ.

(2) Нутаг дэвсгэрийн хүрээг өргөтгөх тухай хүсэлтийг олон улсын бүртгэлийн дараа гаргаж болно. Уг хүсэлтийг журмаар тогтоосон маягтын дагуу гаргана. Түүнийг олон улсын товчоо шууд бүртгэж сонирхсон байгууллага болон байгууллагуудад цаг алдалгүй мэдэгдэнэ. Энэ бүртгэлийн тухай олон улсын товчооны тогтмол хэвлэлд нийтэлнэ. Нутаг дэвсгэрийн өргөтгөл түүнийг олон улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхэлж түүний үйлчлэл олон улсын бүртгэлийн хугацаа дууссанаар дуусгавар болно.

4 дүгээр зүйл

Олон улсын бүртгэлийн үйлчлэл

(1) (a) 3 дугаар болон 3 ter зүйлийн дагуу бүртгэсэн өдрөөс эхлэн сонирхсон хэлэлцэн тохирогч тал бүрийн барааны тэмдгийн хамгаалалт нь тухайн хэлэлцэн тохирогч талын байгууллагад уг барааны тэмдгийг шууд мэдүүлсэнтэй адил байна. Хэрэв 5 дугаар зүйлийн (1) ба (2) дахь хэсгийн дагуу олон улсын товчоонд татгалзсан тухай мэдэгдэл хийгээгүй, эсхүл дээрх зүйлийн дагуу татгалзсан тухай хийсэн мэдэгдлээ татан авсан бол сонирхсон хэлэлцэн тохирогч талд хэрэгжиж буй барааны тэмдгийн хамгаалалтыг дээрх өдрөөс эхлэн тухайн хэлэлцэн тохирогч талын байгууллагад бүртгүүлсэн барааны тэмдгийн нэгэн адил үзнэ.

(b) 3 дугаар зүйлд тусгагдсан бараа, үйлчилгээний ангиллын заалт барааны тэмдгийн хамгаалалтын хүрээний хувьд хамгаалалтын хэлэлцэн тохирогч талууд үүрэг хүлээхгүй.

(2) Олон улсын аливаа бүртгэл Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 4 дүгээр зүйлд заасан давуу эрхийг эдлэх бөгөөд 4.D хэсэгт заасан шаардлагыг заавал дагахгүй.

4 bis зүйл

Үндэсний болон бүс нутгийн бүртгэлийг олон улсын бүртгэлээр орлуулах

(1) Хэрэв барааны тэмдэг хэлэлцэн тохирогч талын байгууллагад үндэсний болон бүс нутгийн бүртгэлд орохоор байвал олон улсын бүртгэлд бүртгүүлэх зүйл болох бөгөөд хоёр бүртгэл нь нэг хүний нэр дээр байгаа бол олон улсын бүртгэл нь үндэсний болон бүс нутгийн бүртгэлийг дараахь нөхцөлд орлоно:

- (i) олон улсын бүртгэлээс үүсэх хамгаалалт нь 3 тег зүйлийн (1) ба (2) дахь хэсэгт дурдсан хэлэлцэн тохирогч талд хамаарч байх;
- (ii) (ii) үндэсний болон бүс нутгийн бүртгэлийн жагсаалтад орсон бүх бараа, үйлчилгээ тухайн хэлэлцэн тохирогч талын хувьд олон улсын бүртгэлийн жагсаалтад мөн орсон байх;
- (iii) хамгаалалтын дээр дурдсан өргөтгөл үндэсний ба бүс нутгийн бүртгэл хийсэн өдрөөс хойш хүчин төгөлдөр болох.

(2) Энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасан байгууллага нь гаргасан хүсэлтийн дагуу олон улсын бүртгэлийн тухай өөрийн бүртгэлдээ тэмдэглэнэ.

5 дугаар зүйл

Зарим хэлэлцэн тохирогч талын хувьд олон улсын бүртгэлийг хүчингүй болгох ба хамгаалахаас татгалзах

(1) Үйлчилж байгаа хууль тогтоомжоор зөвшөөрч байгаа бол 3 тег зүйлийн (1) ба (2) дахь хэсгийн дагуу олон улсын бүртгэлээс үүсэх хамгаалалтын хүрээг өргөтгөх тухай олон улсын товчооноос мэдэгдэл авсан хэлэлцэн тохирогч талын байгууллага нь тухайн хэлэлцэн тохирогч талд тэр барааны тэмдгийн үйлчлэх хүрээг өргөтгөхөд түүний хамгаалалтаас татгалзсан тухай мэдэгдэх эрхтэй. Ингэхдээ татгалзах тухай мэдэгдсэн байгууллагад шууд бүртгүүлсэн барааны тэмдгийн хувьд зөвхөн Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн хүрээнд бий болсон шалтгааны үндсэн дээр татгалзах эрхтэй. Гэвч хэрэгжиж байгаа хууль тогтоомжоор ангиллын, эсхүл бараа буюу үйлчилгээний хязгаарлагдмал тоогоор зөвшөөрч байгаа гэсэн шалтгаанаар хэсэгчилсэн байдлаар ч гэсэн татгалзах ёсгүй.

(2) а) Дээрх эрхийг эдлэх хүсэлтэй байгууллага олон улсын товчоонд бүх шалтгааныхаа хамтаар татгалзсан тухайгаа, өөрийн хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд (b) ба (c) дэд хэсгийн заалтын дагуу (1) дэх хэсэгт тусгагдсан хамгаалалт хийх тухай мэдэгдлийг олон улсын товчооноос тухайн байгууллагад илгээсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаа өнгөрөхөөс өмнө мэдэгдэх ёстой.

b) (a) дэд хэсгийн заалтыг үл харгалзан хэлэлцэн тохирогч тал энэхүү протоколын хүрээнд хэрэгжиж буй олон улсын бүртгэлийн хувьд (a) дэд хэсэгт заасан нэг жилийн хугацааг арван найман сараар солих тухайгаа мэдэгдэж болно.

c) Уг мэдэгдэлд хамгаалалт олгохоос татгалзсан тохиолдолд татгалзсан тухайгаа хэлэлцэн тохирогч талын байгууллага олон улсын товчоонд 18 сарын хугацаа

өнгөрснөөс хойш мэдэгдэж болно. Тэрхүү байгууллага олон улсын тодорхой бүртгэлийн хувьд хамгаалахаас татгалзсан тухайгаа арван найман сарын хугацаа өнгөрснөөс хойш зөвхөн дараахь тохиолдолд мэдэгдэж болно:

- (i) байгууллага нь арван найман сарын хугацаа дуусахаас өмнө аливаа эсэргүүцэл уг хугацаа дууссанаас хойш гарч болзошгүй гэдгийг олон улсын товчоонд мэдэгдсэн, болон
- (ii) эсэргүүцлийн үндсэнд татгалзсан тухай мэдэгдэл эсэргүүцлийг тооцох өдрөөс эхлэн дээд тал нь долоон сарын хугацаанд хийгдсэн хэрэв эсэргүүцлийн хугацаа долоон сараас өмнө дуусвал эсэргүүцлийн заасан хугацаа дууссанаас хойш нэг сарын дотор мэдэгдэл хийх ёстой.

d) (b) болон (c) дэд хэсэгт заасан мэдэгдлийг 14 дүгээр зүйлийн (2) дахь хэсэгт заасан баримт бичгээр хийж болох ба мэдэгдэл хүчин төгөлдөр болох өдөр нь мэдэгдэл хийсэн улс эсхүл засгийн газар хоорондын байгууллагуудын хувьд энэхүү протокол хүчин төгөлдөр болсон өдөртэй адил байна. Мөн тийм мэдэгдлийн хүчин төгөлдөр болох хугацаа нь тухайн мэдэгдлийг байгууллагын ерөнхий захирал /цаашид” ерөнхий захирал” гэнэ/ хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дараа, эсхүл мэдэгдэл хүчин төгөлдөр болсон өдөр, эсхүл түүнээс хойш хүчин төгөлдөр болсон олон улсын бүртгэлийн хувьд мэдэгдэлд заасан хожуу хугацаа байж болно.

e) Энэхүү протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн хугацаа дууссаны дараа Ассамблейгаас (a) болон (d) дэд хэсгээр тогтоосон тогтолцооны хэрэгжилтийг шалгана. Үүний дараа дээрх дэд хэсгүүдийн заалтыг Ассамблей санал нэгтэй шийдвэрээр өөрчилж болно.

(3) Олон улсын товчоо олон улсын бүртгэл эзэмшигчид татгалзсан тухай мэдэгдлийн нэг хувийг цаг алдалгүй дамжуулах ёстой. Дээрх эзэмшигч татгалзсан тухай мэдэгдэл гаргасан байгууллагад шууд хадгалуулахаар өгсний адил хууль зүйн хамгаалалт эдэлнэ. Олон улсын товчоо (2) дахь хэсгийг (c) дэд хэсгийн (i)-д заасны дагуу мэдэгдэл авсан бол уг мэдэгдлийг олон улсын бүртгэл эзэмшигчид цаг алдалгүй дамжуулна.

(4) Барааны тэмдгийг хамгаалалтад авахаас татгалзсан шалтгааныг олон улсын товчоо хүсэлт гаргасан аливаа сонирхогч талд мэдэгдэнэ.

(5) Олон улсын товчоонд (1) болон (2) дахь хэсгийн дагуу олон улсын тодорхой бүртгэлийн талаар урьдчилсан болон эцсийн байдлаар татгалзаж буйгаа мэдэгдээгүй аливаа байгууллага, тэрхүү олон улсын бүртгэлийн хувьд (1) дэх хэсэгт заасан эрхийг эдлэх боломжоо алдана.

(6) Олон улсын бүртгэл эзэмшигчид өөрийн эрхээ хамгаалах боломжийн хугацааг олгоогүй тохиолдолд хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага тухайн хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт олон улсын бүртгэл хүчингүй болсон тухай зарлаж болохгүй. Олон улсын бүртгэлийг хүчингүй болгосон тухай олон улсын товчоонд мэдэгдэнэ.

5 bis зүйл

Барааны тэмдгийн бүрдэл хэсгийн хууль ёсны ашиглалтыг нотлох баримт

Сүлд, тэмдэгт бамбай, хөрөг, цол, ялгах тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр, мэдүүлэг гаргагчаас бусад хүний нэр, эсхүл адил төстэй тэмдэглэл зэрэг барааны тэмдэгт агуулагдаж байгаа зарим бүрдлийн хууль ёсны ашиглалтыг нотлох баримтыг хэлэлцэн тохирогч талын байгууллага шаардаж болох бөгөөд гарлын байгууллагын хамгаалалтын гэрчилгээ болон хуульчлах шаардлагаас чөлөөлөгдөнө.

5 ter зүйл

**Олон улсын бүртгэлд хийсэн тэмдэглэлийн хуулбар, хайлт хийх,
олон улсын бүртгэлийн хуулга**

(1) Олон улсын товчоо хүсэлт гаргасан этгээдэд журмаар тогтоосон хураамжийг төлсний үндсэн дээр олон улсын бүртгэлд орсон барааны тэмдгийн холбогдолтой тэмдэглэлийн хуулбарыг өгнө.

(2) Олон улсын товчоо хураамж авсны үндсэн дээр олон улсын бүртгэлийн санд хамаарах барааны тэмдгийн хайлт хийж болно.

(3) нь Хэлэлцэн тохирогч аль нэг талд үйлдвэрлэх зорилгоор хүсэлт гаргасан олон улсын бүртгэлээс авсан хуулбар нь аливаа хуульчлах шаардлагаас чөлөөлөгдөнө.

6 дугаар зүйл

Олон улсын бүртгэлийн хүчинтэй байх хугацаа, олон улсын бүртгэлийн хараат болон хараат бус байдал

(1) Олон улсын товчоонд барааны тэмдгийн бүртгэл нь арван жилийн хугацаанд хүчинтэй байх ба 7 дугаар зүйлд заасан нөхцөлөөр хугацааг сунгах боломжтой.

(2) Олон улсын бүртгэлийн огнооноос эхлэн таван жил өнгөрсний дараа уг бүртгэл нь үндсэн мэдүүлгээс, эсхүл түүнээс үүссэн бүртгэлээс, эсхүл дараахь нөхцөлийн дагуу үндсэн бүртгэлээс хараат бус байна.

(3) Олон улсын бүртгэлээс үүссэн хамгаалалтыг түүнийг шилжүүлсэн эсэхээс үл хамааран олон улсын бүртгэлийн жагсаалтад орсон бүх болон зарим бараа, үйлчилгээг олон улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн таван жилийн хугацаа дуусахаас өмнө үндсэн мэдүүлэг, эсхүл түүнээс үүссэн бүртгэл, эсхүл үндсэн бүртгэлийг татаж авсан, хугацаа нь дууссан, түүнээс татгалзсан, эсхүл татгалзах,

хэрэгсэхгүй болгох, бүртгэлээс хасах, эсхүл хүчингүй болгох тухай эцсийн шийдвэр гарсан бол хэрэглэж болохгүй. Үүнийг дараахь нөхцөлд мөн дагаж мөрдөнө:

- (i) үндсэн мэдүүлгийг хүчингүйд тооцох тухай шийдвэрт эсэргүүцэж гомдол гаргах;
- (ii) үндсэн мэдүүлгийг татан авах, эсхүл үндсэн бүртгэл буюу үндсэн мэдүүлгээс үүссэн бүртгэлийг хасах, хэрэгсэхгүй болгох, эсхүл хүчингүй болгохыг шаардах үйлдэл хийх;
- (iii) үндсэн мэдүүлгээс татгалзах нь таван жилийн хугацаа дууссаны дараа үндсэн мэдүүлгээс татгалзах, түүнийг өөрчлөх, бүртгэлээс хасах, хүчингүй болгох тухай эцсийн шийдвэрт, эсхүл түүнийг татан авах, түүнчлэн түүнээс үүсэх бүртгэлд зэрэгт нөлөөлөх, эсхүл уг мэдүүлэг, үйл ажиллагаа татгалзах нөхцөлийг бүрдүүлсэн, үндсэн бүртгэл дээрх хугацаа дуусахаас өмнө эхэлсэн бол (i), (ii), эсхүл (iii) дэд хэсэгт тогтоосон хугацаа дуусахаас өмнө татаж авах, татгалзах үед эхэлсэн аливаа үйл ажиллагааны бүрэлдэхүүн болох нөхцөлд таван жил өнгөрсний дараа, хэрэв үндсэн мэдүүлгийг буцааж авсан болон үндсэн мэдүүлгээс үүсэн бүртгэлээс, эсхүл үндсэн бүртгэлээс татгалзана.

(4) Гарлын байгууллага журамд заасны дагуу (3) дахь хэсэгт заасан байдал, шийдвэрийн талаар олон улсын товчоонд мэдэгдэх бөгөөд олон улсын товчоо сонирхогч талуудад журамд заасны дагуу мэдэгдэх ба хэвлэх шаардлагатай бүх ажлыг гүйцэтгэнэ. Шаардлагатай нөхцөлд гарлын байгууллага олон улсын товчоонд хандаж зөвшөөрөгдсөн журмаар олон улсын бүртгэлийг хасахыг хүсэх ба олон улсын товчоо хүсэлтийг биелүүлнэ.

7 дугаар зүйл

Олон улсын бүртгэлийн хугацааг сунгах

(1) Олон улсын бүртгэлийг 8 дугаар зүйлийн (7) дахь хэсэгт заасан үндсэн хураамжийн энгийн төлбөрийг хийсний үндсэн дээр, эсхүл 8 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн нэмэгдэл буюу нэмэлт хураамжийн үндсэн дээр арван жилээр сунгаж болно.

(2) Сунгахдаа олон улсын барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн эцсийн байдалд өөрчлөлт хийхгүй.

(3) Хамгаалалтын хугацаа дуусахаас зургаан сарын өмнө олон улсын товчоо олон улсын бүртгэл эзэмшигч болон эрх бүхий итгэмжлэгчтэй бол эрх бүхий итгэмжлэгчид албан бус мэдээлэл илгээх замаар сануулах шаардлагатай тохиолдолд түүний дурдсан хугацаа дуусах огноог сануулна.

(4) Журмаар тогтоосон нэмэгдэл хураамж төлөх нөхцөлд олон улсын бүртгэлийг сунгахад зургаан сарын хөнгөлөлттэй хугацаа олгоно.

8 дугаар зүйл

Олон улсын мэдүүлэг болон олон улсын бүртгэлийн хураамж

(1) Гарлын байгууллага олон улсын мэдүүлэг гаргах болон олон улсын бүртгэлийг шинэчлэхэд олон улсын бүртгэлийг эзэмшигчээс, эсхүл мэдүүлэг гаргагчаас үйл ажиллагаанд авах үндэсний хураамжийг өөрийн үзэмжээр тогтоох эрх эдэлнэ.

(2) Олон улсын товчоонд барааны тэмдгийн бүртгэлийг (7) дахь хэсгийн (а) дэд хэсгийн нөхцөлийн дагуу дараахь олон улсын хураамжийн урьдчилсан төлбөрийг хийсэн нөхцөлд гүйцэтгэнэ.

- (i) үндсэн хураамж;
- (ii) барааны тэмдэг ашиглаж байгаа бараа, үйлчилгээнд хамаарах гурваас дээш олон улсын ангилал бүрд төлөх нэмэлт хураамж;
- (iii) 3 төг зүйлийн дагуу хамгаалалтыг өргөжүүлэх тухай мэдүүлэг бүрд төлөх нэмэлт хураамж.

(3) Хэрвээ бараа, үйлчилгээний ангиллын тоог олон улсын товчоо тогтоож шалгасан бөгөөд тэр нь олон улсын бүртгэлийн өдөрт нөлөөлөхгүй бол (2) дахь хэсгийн (ii) дэд хэсэгт заасан нэмэлт хураамжийг журмаар тогтоосон хугацаанд хийж болно. Хэрэв дээрх хугацаа дууссаны дараа нэмэлт төлбөрийг хийгээгүй, эсхүл бараа, үйлчилгээний жагсаалтыг мэдүүлэг гаргагч шаардлагатай арга хэмжээ авч хорогдуулаагүй бол олон улсын бүртгэлд цаашид бүртгэх ажлыг зогсоосонд тооцно.

(4) Олон улсын бүртгэлийн төрөл бүрийн эх үүсвэрээс олж байгаа жилийн орлогыг (2) дахь хэсгийн (ii) ба (iii) дэд хэсэгт заасан хураамжийн эх үүсвэрийг оролцуулалгүйгээр энэхүү протоколыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг суутган хасаад үлдэгдлийг нь олон улсын товчоо нь хэлэлцэн тохирогч талуудад адил тэнцүү хуваарилна.

(5) (2) дахь хэсгийн (ii) дэд хэсэгт заасан нэмэлт хураамжаас үүссэн мөнгийг жил бүрийн сүүлээр сонирхогч хэлэлцэн тохирогч талуудад тухайн өнгөрсөн жилд хэлэлцэн тохирогч тал бүрд хамгаалалт хүссэн барааны тэмдгийн тоонд тэнцүүлэн хуваарилах ба харин урьдчилсан шүүлт хийдэг хэлэлцэн тохирогч талуудын хувьд энэ тоог журмаар тогтоосон итгэлцүүрээр тооцож гаргана.

(6) (2) дахь хэсгийн (iii) дахь дэд хэсэгт заасан нэмэлт хураамжаас үүссэн мөнгийг (5) дахь хэсэгт заасан дүрмээр мөн хуваарилна.

(7) а) Хэлэлцэн тохирогч тал 3 *ter* зүйлд заасан олон улсын бүртгэл бүрийн хувьд мөн тийм олон улсын бүртгэлийн сунгалтын хувьд нэмэгдэл ба нэмэлт хураамжаас шимтгэх хэсгийн оронд өөрөө хураамж авахыг хүсэж мэдүүлж болох бөгөөд /цаашдаа “ганцаарчилсан хураамж” гэнэ/ мэдүүлэгт заасан болон цаашдын мэдүүлэгт өөрчлөгдсөн байж болох хэмжээ нь олон улсын үйл ажиллагаанаас гарах үр ашгийг хассаны дараахь хэмжээнээс илүү гарч болохгүй бөгөөд хэлэлцэн тохирогч талын байгууллага нь өөрийн бүртгэлд барааны тэмдгийг бүртгүүлэх мэдүүлэг гаргагчаас арван жилийн хугацаагаар бүртгүүлсний төлөө буюу бүртгэлийг эзэмшигчээс энэхүү бүртгэлийг арван жилээр сунгасны төлөө хураамж авах эрх эдэлнэ. Хэрвээ ганцаарчилсан хураамж төлбөл:

- (i) хэрэв 3 *ter* зүйлд дурдсан зөвхөн тухайн хэлэлцэн тохирогч талууд энэ дэд хэсгийн дагуу мэдэгдэл хийсэн бол тэдгээр талуудаас (2) дахь хэсгийн (ii) дэд хэсэгт заасан ямар ч нэмэгдэл хураамжийг шаардахгүй;
- (ii) энэхүү дэд хэсгийн дагуу мэдэгдэл гаргасан хэлэлцэн тохирогч талын хувьд (2) дахь хэсгийн (iii)-г заасан төлбөрийн ямар ч нэмэлт хураамж шаардахгүй.

b) (a) дэд хэсгийн дагуу хийх аливаа мэдэгдлийг 14 дүгээр зүйлийн (2) дахь хэсэгт заасан баримт бичигт оруулж болох бөгөөд уг мэдэгдэл нь энэхүү протокол мэдэгдэл гаргасан тухайн улс буюу засгийн газар хоорондын байгууллагын хувьд хүчинтэй болох өдөр хүчинтэй болно. Мэдэгдэл хүчинтэй болох өдөр буюу түүнээс хойш хүчин төгөлдөр болох олон улсын бүртгэлийн хувьд ийм мэдэгдлийг дараа нь гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд уг мэдэгдэл нь мэдэгдлийг ерөнхий захирал хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дараа, эсхүл мэдэгдэлд заасан түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр болно.

9 дүгээр зүйл

Олон улсын бүртгэлийн эзэмшигч өөрчлөгдсөн тухай тэмдэглэл

Өөрийн нэр дээр олон улсын бүртгэл хийгдсэн хүний мэдүүлэг, эсхүл сонирхогч байгууллага буюу сонирхогч хүний хүсэлтээр олон улсын товчоо хэлэлцэн тохирогч бүх буюу зарим талын нутаг дэвсгэр дээр хүчинтэй үйлчилж байгаа тухайн бүртгэлийн хувьд, эсхүл бүртгэлийн жагсаалтад орсон бүх буюу хэсэгчилсэн бараа, үйлчилгээний хувьд шинэ эзэмшигч 2 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн дагуу олон улсын хүсэлт гаргах эрх бүхий хүн байх нөхцөлд олон улсын бүртгэлд тэрхүү бүртгэл эзэмшигчийн талаарх бүх өөрчлөлтийг оруулна.

9 bis зүйл

Олон улсын бүртгэлд хамаарах зарим тэмдэглэл

Олон улсын товчоо олон улсын бүртгэлд дараахь тэмдэглэл хийнэ:

- (i) олон улсын бүртгэл эзэмшигчийн нэр, хаягийн талаарх аливаа өөрчлөлтийн тухай;
- (ii) олон улсын бүртгэл эзэмшигчийн бүрэн эрхт итгэмжлэгчийг томилсон болон тэрхүү итгэмжлэгчтэй холбогдох бусад мэдээллийн тухай;
- (iii) бүх хэлэлцэн тохирогч буюу зарим талын хувьд олон улсын бүртгэлд жагсаасан бараа, үйлчилгээний аливаа хязгаарлалтын тухай;
- (iv) хэлэлцэн тохирогч бүх буюу зарим талын хувьд олон улсын бүртгэлийг хүчингүйд тооцох, бүртгэлээс хасах, татгалзах тухай мэдээллийн тухай;
- (v) журамд тодорхойлсон олон улсын бүртгэлийн зүйл болон барааны тэмдгийн эрхэд хамаарах аливаа бусад мэдээллийн тухай.

9 ter зүйл

Зарим тэмдэглэл хийхэд төлөх хураамж

9 дүгээр буюу 9 bis зүйлийн дагуу хийсэн тэмдэглэл хийхэд хураамж төлнө.

9 quater зүйл

Хэлэлцэн тохирогч хэд хэдэн улсын нэгдсэн байгууллага

(1) Хэрэв хэлэлцэн тохирогч хэд хэдэн улс барааны тэмдгийн талаар өөрсдийн үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэн ижил болгох тухай тохиролцоонд хүрвэл тэд ерөнхий захиралд дараахь зүйлийг мэдэгдэж болно:

- (i) нэгдсэн байгууллага эдгээр улс бүрийн үндэсний байгууллагыг орлох бөгөөд;
- (ii) энэхүү зүйлийн өмнөх заалтууд болон 9 *quinquies* ба 9 *sexies* зүйлийн заалтуудыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлээд тэдгээрийн тус бүрийн нутаг дэвсгэрийг нэг улс гэж тооцно.

(2) Энэхүү мэдэгдэл нь ерөнхий захирал бусад хэлэлцэн тохирогч талуудад энэ тухай мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

9 quinquies зүйл

Олон улсын бүртгэлийг үндэсний ба бүсийн мэдүүлэг болгон өөрчлөх

Хэрэв олон улсын бүртгэл гарлын байгууллагын хүсэлтээр бүртгэлд заасан бүх буюу зарим бараа үйлчилгээний хувьд 6 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн дагуу хасагдсан тохиолдолд олон улсын бүртгэл эзэмшигч байсан этгээд тэр барааны тэмдгийг олон улсын бүртгэл нутаг дэвсгэр дээр нь хүчин төгөлдөр байсан хэлэлцэн тохирогч талын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргахад энэхүү мэдүүлэг 3 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн дагуу олон улсын бүртгэлийн өдөр, эсхүл 3 тег зүйлийн (2) дахь хэсгийн дагуу газар нутгийн өргөтгөл хийлгэх тэмдэглэл хийсэн өдөр өгөгдсөн гэж тооцогдох бөгөөд хэрэв олон улсын бүртгэл давуу эрх эдэлж байвал энэ мэдүүлэг доорх нөхцөлөөр тэр давуу байдлаа хадгална:

- (i) дурдсан мэдүүлгийг олон улсын бүртгэлээс хасагдсан өдрөөс хойш гурван сарын дотор гаргасан;
- (ii) мэдүүлэгт жагсаасан бараа, үйлчилгээ сонирхогч хэлэлцэн тохирогч талын хувьд олон улсын бүртгэлд байгаа бараа, үйлчилгээний жагсаалттай бүрэн тохирч байгаа;
- (iii) дурдсан мэдүүлэг нь холбогдох хууль тогтоомж, түүнчлэн хураамжид тавих шаардлагыг оролцуулсан бүх шаардлагад нийцэж байгаа бол.

9 sexies зүйл

Мадридын (Стокгольм) хэлэлцээрийг хадгалах

(1) Хэрэв гаргасан олон улсын мэдүүлэг буюу олон улсын бүртгэлийн хувьд гарлын байгууллага энэхүү протокол болон Мадридын хэлэлцээрт оролцогч улсын байгууллага байх тохиолдолд энэхүү протоколын болон Мадридын /Стокгольм/ хэлэлцээрийн заалтууд тэдгээрт оролцогч бусад улсын нутаг дэвсгэр дээр үйлчлэхгүй.

(2) Энэхүү протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн арван жилийн хугацаа өнгөрснөөс хойш Ассамблей дөрөвний гурвын олонхоор (1) дэх хэсгийг өөрчлөх буюу түүний хамаарах хүрээг хязгаарлаж болно, гэхдээ Мадридын /Стокгольм/ хэлэлцээрт оролцогч орнуудын олонх нь энэхүү протоколд оролцогч тал болсон өдрөөс хойш таван жилийн хугацаа өнгөрсөн байх ёстой. Зөвхөн дээр дурдсан хэлэлцээр ба протоколд оролцогч улс Ассамблейд санал өгөх эрхтэй оролцоно.

10 дугаар зүйл

Ассамблей

(1) а) Хэлэлцэн тохирогч талууд Мадридын /Стокгольм/ хэлэлцээрт оролцогч орны адил Ассамблейн гишүүн байна.

b) Хэлэлцэн тохирогч тал бүрийг Ассамблейд нэг төлөөлөгч төлөөлөх ба тэр нь орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

c) Холбооны сангаас төлөх хэлэлцэн тохирогч тал тус бүрийн нэг төлөөлөгчийн замын зардал, байх хугацааны зардлаас бусад зардлыг тухайн төлөөлөгчийг томилсон хэлэлцэн тохирогч тал хариуцна.

(2) Ассамблей Мадридын /Стокгольм/ хэлэлцээрийн дагуу хүлээх үүргээс гадна дараахь үүрэг гүйцэтгэнэ:

- (i) энэхүү протоколын хэрэгжилттэй холбогдолтой бүх асуудлыг хэлэлцэнэ;
- (ii) энэхүү протоколыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэлтэй холбогдолтой чиглэлийг энэхүү протоколд оролцогч биш боловч холбооны гишүүн орны саналыг зохих ёсоор тусгаж олон улсын товчоонд өгнө;
- (iii) энэхүү протоколыг хэрэгжүүлэхтэй холбогдох журмыг баталж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулна;
- (iv) энэхүү протоколын дагуу бусад үүргийг гүйцэтгэнэ.

(3) a) Хэлэлцэн тохирогч тал бүр Ассамблейд нэг санал өгөх эрхтэй. Зөвхөн Мадридын (Стокгольм) хэлэлцээрт оролцогч тал оронтой холбогдолтой асуудлаар дээрх хэлэлцээрт оролцогч тал бус хэлэлцэн тохирогч талууд санал өгөх эрхгүй, харин зөвхөн хэлэлцэн тохирогч талуудтай холбоотой асуудлаар санал өгөх эрхтэй байна.

b) Тодорхой асуудлаар санал өгөх эрх бүхий Ассамблейн гишүүний хагас нь тухайн асуудлаар санал өгөх кворум бүрдүүлнэ.

c) (b) дэд хэсгийн заалтыг үл харгалзан хуралд тодорхой асуудлаар санал өгөх эрх бүхий, Ассамблейд оролцож байгаа гишүүдийн тоо нь тэн хагаст хүрэхгүй боловч тухайн асуудлаар санал өгөх эрх бүхий Ассамблейн гишүүдийн гуравны нэгтэй тэнцүү буюу түүнээс илүү байвал Ассамблей өөрийн үйл ажиллагаанд хамаарах шийдвэрээс бусад асуудлаар шийдвэр гаргаж болох бөгөөд тэрхүү шийдвэр нь зөвхөн дараахь нөхцөлийг мөрдсөн тохиолдолд хүчинтэй болно. Олон улсын товчоо дурдсан асуудлаар санал өгөх эрх бүхий хуралд оролцоогүй Ассамблейн гишүүдэд тэр шийдвэрийн талаар мэдэгдэх ба чингэхдээ тэдгээрийг мэдэгдэл хийсэн өдрөөс эхлэн гурван сарын дотор энэ шийдвэрт саналаа өгөх, түдгэлзэх, эсхүл эсрэг байгаагаа бичгээр ирүүлэхийг санал болгоно. Хэрэв энэхүү хугацаа дуусахад саналаа өгсөн болон түдгэлзсэн гишүүдийн тоо хуралд оролцох ёстой дутагдаж байсан гишүүдийн тоонд хүрч байвал тэр шийдвэр хүчин төгөлдөр болно.

d) 5 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (e) дэд хэсэг, 9 *sexies* зүйлийн (2) дахь хэсэг, 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн заалтын дагуу Ассамблейн шийдвэрийг гуравны хоёрын саналаар батална.

е) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

f) Төлөөлөгч Ассамблейн зөвхөн нэг гишүүнийг төлөөлөх ба зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.

(4) Мадридын /Стокгольм/ хэлэлцээрт тусгасан ээлжит болон ээлжит бус чуулганаас гадна чуулганы хөтөлбөрт оруулж хэлэлцэх асуудлаар санал өгөх эрх бүхий гишүүний дөрөвний нэгний хүсэлтийн дагуу, ерөнхий захирал ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Тийм ээлжит бус чуулганы хэлэлцэх хэргийн дэгийн төслийг ерөнхий захирал бэлтгэнэ.

11 дүгээр зүйл

Олон улсын товчоо

(1) Энэхүү протоколын дагуу олон улсын бүртгэлийн холбогдолтой үйл ажиллагаа болон энэхүү протоколд хамаарах захиргааны бусад үүргийг олон улсын товчоо гүйцэтгэнэ.

(2) а) Олон улсын товчоо Ассамблейгаас өгсөн чиглэлийн дагуу протоколыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэлийг хийнэ.

б) Олон улсын товчоо энэхүү протоколыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлын тухай засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөнө.

с) Ерөнхий захирал болон түүний томилсон албан тушаалтан санал өгөх эрхгүйгээр хянан өөрчлөх бага хуралд оролцоно.

(3) Олон улсын товчоо нь энэхүү протоколд хамаарах түүний үйл ажиллагааны бусад бүх зорилтыг гүйцэтгэнэ.

12 дугаар зүйл

Санхүүжилт

Хэлэлцэн тохирогч талуудын хувьд Холбооны санхүүжилтийг Мадридын /Стокгольм/ хэлэлцээрийн 12 дугаар зүйлд тодорхойлсон нөхцөлөөр зохицуулна, гэхдээ дурдсан хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн заалтыг энэхүү протоколын 8 дугаар зүйлтэй адилтгана. Түүнээс гадна дурдсан хэлэлцээрийн 12 дугаар сарын (б) дахь хэсгийн (b) дэд хэсгийн дагуу хэрэв Ассамблей өөр шийдвэрийг санал нэгтгэйгээр хүлээж аваагүй бол Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн дагуу хэлэлцэн тохирогч байгууллагыг татварын 1/нэг/ дүгээр ангилалд хамааруулахаар тооцно.

13 дугаар зүйл

Протоколын зарим зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах

(1) Энэхүү зүйл болон 10, 11, 12 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн тохирогч талууд эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Тэдгээр саналыг ерөнхий захирал Ассамблейгаар хэлэлцүүлэхээс наад зах нь зургаан сарын өмнө хэлэлцэн тохирогч талуудад илгээнэ.

(2) Дээрх (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей батлах ба үүний тулд дөрөвний гурвын санал шаардагдана, гэхдээ 10 дугаар зүйлд болон энэхүү дэд хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлтийг тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) Дээрх (1) дэх хэсэгт заасан зүйлүүдэд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь ерөнхий захирал нэмэлт, өөрчлөлтийг батлах үед Ассамблейн гишүүн байсан, нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж санал өгөх эрх бүхий улс буюу засгийн газар хоорондын байгууллагын дөрөвний гурав нь үндсэн хуулийн журмын дагуу нэмэлт, өөрчлөлтийг хүлээн авсан тухай мэдэгдлийг бичгээр хүлээн авснаас хойш нэг сарын дараа хүчинтэй болно. Дээрх журмаар хүлээн авсан тэрхүү зүйлүүдийн аливаа нэмэлт, өөрчлөлтийг нь түүнийг хүчин төгөлдөр болох үед, эсхүл түүнээс хойш хэлэлцэн тохирогч тал болсон улс болон засгийн газар хоорондын байгууллагууд дагаж мөрдөнө.

14 дүгээр зүйл

Протоколд оролцогч тал болох, протокол хүчин төгөлдөр болох

(1) а) Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч аливаа улс энэхүү протоколд оролцогч тал болж болно.

б) Түүнээс гадна аливаа засгийн газар хоорондын байгууллагууд дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд энэхүү протоколд оролцогч тал болж болно.

- (i) энэхүү байгууллагын гишүүн улсуудын наад зах нь нэг гишүүн улс нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч тал бол;
- (ii) дурдсан байгууллага тухайн байгууллагын нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр барааны тэмдгийг бүртгэх бүсийн байгууллагатай байх ба тэр байгууллага нь 9 quater зүйлийн дагуу мэдэгдэлд хамаарахгүй бол.

(2) (1) дэх хэсэгт заасан аливаа улс, эсхүл байгууллага энэхүү протоколд гарын үсэг зурж болно. (1) дэх хэсэгт заасан аливаа улс, эсхүл байгууллага энэхүү протоколд гарын үсэг зурсан бол энэхүү протоколын батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан тухай баримт бичгээ хадгалуулж болох ба энэхүү протоколд гарын үсэг зураагүй бол энэхүү протоколд нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулж болно.

(3) (2) дахь хэсэгт заасан дээрх баримт бичгийг ерөнхий захирал хадгалуулна.

(4) а) Энэхүү протокол нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай дөрөв дэх баримт бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болох ба гэхдээ наад зах нь эдгээр баримт бичгүүдийн нэгийг Мадридын хэлэлцээр /Стокгольм/-т оролцогч нэг гишүүн улс, мөн нэгийг нь дээрх хэлэлцээрт оролцогч биш улс, эсхүл (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан нэг байгууллага байвал зохино.

b) (1) дэх хэсэгт заасан аливаа бусад улс эсхүл байгууллагын хувьд энэхүү протокол нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

(5) (1) дэх хэсэгт заасан улс эсхүл байгууллага энэхүү протоколыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан тухай болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан баримт бичгээ энэхүү протоколыг хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө дээрх протоколын хүрээнд хэрэгжсэн олон улсын бүртгэлээс гарах хамгаалалт нь тухайн улс, байгууллагын хувьд хамаарахгүй болохыг мэдэгдэж болно.

15 дугаар зүйл

Цуцлах

(1) Энэхүү протокол хугацаагүй үйлчилнэ.

(2) Аливаа хэлэлцэн тохирогч тал ерөнхий захиралд мэдэгдэл гаргах замаар энэхүү протоколыг цуцалж болно.

(3) Энэхүү цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэхүү зүйлд тусгагдсан цуцлах эрхийг хэлэлцэн тохирогч тал тухайн хэлэлцэн тохирогч талын хувьд энэхүү протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн хугацаа дуусахаас өмнө хэрэгжүүлж болохгүй.

(5) а) Хэрэв энэхүү протоколыг цуцалж байгаа улсад эсхүл засгийн газар хоорондын байгууллагад хүчинтэй байгаа барааны тэмдгийг олон улсын бүртгэлд байгаа бол цуцлалт хүчинтэй болох өдөр, дээрх бүртгэл эзэмшигч нь тухайн улсын

байгууллагад буюу олон улсын байгууллагад тэр барааны тэмдгийг бүртгүүлэх мэдүүлэг гаргаж болох бөгөөд энэхүү мэдүүлгийг олон улсын бүртгэлд 3 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн дагуу өгсөнд тооцох, эсхүл 3-тэй зүйлийн (2) дахь хэсгийн дагуу нутаг дэвсгэрийн өргөтгөлийн тухай тэмдэглэл хийсэн өдөр хадгалагдсантай адилаар авч үзэх ба хэрэв олон улсын бүртгэл давуу байдлаа хадгалж байвал дээрх мэдүүлэг дараахь тохиолдолд тэр давуу байдлаа хадгална:

- (i) тэр мэдүүлэг нь цуцлалт хүчинтэй болсон өдрөөс хойш хоёр жилийн дотор бүртгэгдсэн;
- (ii) мэдүүлэгт жагсаасан бараа, үйлчилгээ нь энэхүү протоколыг цуцалсан улс эсхүл засгийн газар хоорондын байгууллагын хувьд олон улсын бүртгэлд байгаа бараа, үйлчилгээний жагсаалтад багтсан бараа, үйлчилгээтэй тохирч байвал;
- (iii) тухайн мэдүүлэг холбогдох хууль, тогтоомж, түүний дотор хураамжид тавих шаардлагыг оролцуулсан бүх шаардлагад нийцэж байвал.

b) (a) дэд хэсгийн нөхцөл нь энэхүү протоколыг цуцалсан улс буюу засгийн газар хоорондын байгууллагаас бусад хэлэлцэн тохирогч талд үйлчилж байгаа олон улсын бүртгэлийн барааны тэмдгийн хувьд хэрэгжих бөгөөд цуцлалт нь хүчинтэй болох өдрөөс, түүний эзэмшигч нь цуцалсны үр дагавраар 2 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн дагуу олон улсын мэдүүлэг гаргах эрхээ цаашид эдлэхгүй.

16 дугаар зүйл

Гарын үсэг зурах, хэл, хадгалагчийн үүрэг

(1) а) Энэхүү протоколыг франц, англи, испани хэлээр нэг хувь үйлдэж гарын үсэг зурах бөгөөд Мадрид хотод гарын үсэг зурах хугацаа дууссаны дараа бол ерөнхий захиралд хадгалуулна. Гурван хэлээрх эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

b) Энэхүү протоколын албан ёсны бичвэрийг ерөнхий захирал сонирхогч засгийн газар болон байгууллагуудтай зөвлөлдсөний дараа араб, хятад, герман, итали, япон, португали, орос хэлээр болон Ассамблейгаас тогтоох бусад хэлээр үйлдэнэ.

(2) Энэхүү протокол нь 1989 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл Мадрид хотод гарын үсэг зурахад нээлттэй байна.

(3) Ерөнхий захирал энэхүү протоколын гарын үсэг зурсан Испани Улсын Засгийн газраас зохих ёсоор батламжилсан бичвэрийн хоёр хувийг энэхүү протоколд оролцогч болох бүх улс буюу засгийн газар хоорондын байгууллагад илгээнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү протоколыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал энэхүү протоколд оролцогч болж болох буюу эсхүл гишүүн болсон улс буюу олон улсын байгууллагуудад батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичигт гарын үсэг зурсан, түүнийг хадгалуулсан тухай болон энэхүү протоколын хүчин төгөлдөр болсон, түүнд хийсэн аливаа нэмэлт, өөрчлөлт, цуцлах тухай аливаа мэдэгдэл болон энэхүү протоколд дурдсан аливаа мэдэгдлийн тухай мэдээлнэ.

63. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ОЛОН УЛСЫН ХАДГАЛАЛТЫН ТУХАЙ ГААГИЙН ХЭЛЭЛЦЭЭР*

1960 оны 11 дүгээр сарын 28-ны Гаагийн акт

1 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохирогч улсууд бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тусгай холбоо байгуулна.

(2) Зөвхөн аж үйлдвэрийн өмчийг хамгаалах олон улсын холбооны гишүүн улсууд энэхүү хэлэлцээрт оролцогч тал болж болно.

2 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

“1925 оны хэлэлцээр” гэж 1925 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээрийг;

“1934 оны хэлэлцээр” гэж 1925 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээрийг 1934 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Лондонд хянан өөрчилсөн байдлаар;

“энэ хэлэлцээр” эсхүл “энэхүү хэлэлцээр” гэж энэхүү актаар байгуулсан Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээрийг;

“журам” гэж энэ хэлэлцээрийг хэрэгжүүлэх журмыг;

“олон улсын товчоо” гэж Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах олон улсын холбооны товчоог;

“олон улсын хадгалалт” гэж олон улсын товчоонд хийсэн хадгалалтыг;

“үндэсний хадгалалт” гэж хэлэлцэн тохирогч улсын үндэсний байгууллагад хийсэн хадгалалтыг;

* Монгол Улс 1997 оны 3 дугаар сарын 12-ны өдөр нэгдэн орсон

“нэгдмэл хадгалалт” гэж хэд хэдэн загвар хамруулсан хадгалалтыг;

“олон улсын хадгалалтын гарлын улс” гэж мэдүүлэг гаргагчийн бодит болон үр ашиг бүхий үйлдвэрлэлийн буюу худалдааны байгууллага байгаа улсыг, эсхүл хэрэв мэдүүлэг гаргагч нь хэлэлцэн тохирогч хэд хэдэн улсад тийм байгууллагатай бол мэдүүлэгтээ заасан хэлэлцэн тохирогч улсыг; хэрэв мэдүүлэг гаргагч нь хэлэлцэн тохирогч аль ч улсад тийм байгууллагагүй бол түүний байнга оршин суудаг хэлэлцэн тохирогч улсыг, хэрэв мэдүүлэг гаргагч нь хэлэлцэн тохирогч аль нэг улсад байнга оршин суудаггүй бол түүний иргэний харьяаллын хэлэлцэн тохирогч улсыг;

“шинэлэгийг тогтоох шүүлт хийдэг улс” гэж үндэсний байгууллага нь хадгалуулж буй загвар бүрт урьдчилсан хайлт ба шүүлт хийдэг систем тогтоосон үндэсний хууль тогтоомж бүхий хэлэлцэн тохирогч улсыг тус тус хэлнэ.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улсуудын харьяат болон хэлэлцэн тохирогч аль нэг улсын харьяат бус боловч хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт бодит болон үр ашиг бүхий үйлдвэрлэлийн буюу худалдааны байгууллагатай эсхүл байнга оршин суудаг этгээд олон улсын товчоонд загвар хадгалуулж болно.

4 дүгээр зүйл

(1) Олон улсын хадгалалтыг олон улсын товчоонд:

1. шууд, эсхүл
2. хэрэв хэлэлцэн тохирогч улсын хуулиар зөвшөөрөгдсөн бол тухайн улсын үндэсний байгууллагаар уламжлан хийж болно.

(2) Хэлэлцэн тохирогч аль ч улсын үндэсний хууль тогтоомж тус улс нь олон улсын хадгалалтын гарлын улс байх тохиолдолд хадгалалтыг үндэсний байгууллагаар уламжлан хийхийг шаардаж болно. Энэ шаардлагыг мөрдөөгүй байх нь хэлэлцэн тохирогч бусад улсад хийгдсэн олон улсын хадгалалтад нөлөөлөхгүй.

5 дугаар зүйл

(1) Олон улсын хадгалалт нь мэдүүлэг, загварын нэг буюу түүнээс олон гэрэл зураг, эсхүл график дүрслэлээс бүрдэх бөгөөд журмаар тогтоосон хураамжийн төлбөр хийсэн байна.

(2) Мэдүүлэг нь:

1. мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр олон улсын хадгалалт үйлчлэх хэлэлцэн тохирогч улсуудын нэрсийн жагсаалтыг;
2. загварыг нэвтрүүлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн буюу бүтээгдэхүүнүүд;

3. хэрэв мэдүүлэг гаргагч 9 дүгээр зүйлд заасан давамгайлах эрх эдлэхийг хүссэн тохиолдолд давамгайлах эрх үүсгэх хадгалалтын огноо, улс, уг эрхийг эдлэх хадгалуулж буй загварын тоо;
 4. Журмаар тогтоосон бусад мэдээллийг тус тус агуулна.
- (3) (а) Түүнчлэн мэдүүлэг нь:
1. загварын онцлог шинж чанарын товч тодорхойлолтыг;
 2. загварын зохион бүтээгч хэн болох тухай мэдэгдлийг;
 3. 6 дугаар зүйлийн (4) дэх хэсэгт заасан хэвлэн нийтлэхийг хойшлуулах тухай хүсэлтийг тус тус агуулсан байж болно.
- б) Загварыг нэвтрүүлсэн бүтээгдэхүүн буюу бүтээгдэхүүнүүдийг, эсхүл тэдгээрийн загварыг мэдүүлэгт хавсаргаж болно.

(4) Нэгдмэл хадгалалт нь 21 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн 4 дэх заалтад дурдсан загварын олон улсын ангиллын нэг ангилалд хамаарах бүтээгдэхүүнүүдэд хэрэгжүүлж болох хэд хэдэн загварыг агуулж болно.

6 дугаар зүйл

(1) Олон улсын товчоо нь загварын олон улсын бүртгэл хөтөлж, түүнд олон улсын хадгалалтыг бүртгэнэ.

(2) Олон улсын хадгалалтыг олон улсын товчоо нь зохих ёсоор үйлдсэн мэдүүлэг, мэдүүлгийн хамт төлөх хураамж, загварын гэрэл зураг буюу гэрэл зургууд эсхүл график дүрслэлийг хүлээн авсан өдөр, эсхүл олон улсын товчоо нь эдгээрийг өөр өдрүүдэд хүлээн авсан бол сүүлчийн хүлээн авсан өдөр хийсэнд тооцно. Бүртгэлийг мөн энэ өдрөөр хийнэ.

(3) а) Олон улсын товчоо нь олон улсын хадгалалт бүрийн талаар тогтмол хэвлэлд дараахь зүйлийг нийтэлнэ:

1. хадгалуулсан гэрэл зураг буюу график дүрслэлийн хар цагаан буюу хэрэв мэдүүлэг гаргагч хүсвэл өнгөт хуулбар;
2. олон улсын хадгалалтын огноо;

3. Журмаар тогтоосон бусад мэдээллийг тогтмол хэвлэлд тус тус нийтэлнэ.

б) Олон улсын товчоо нь уг тогтмол хэвлэлийг аль болох богино хугацаанд үндэсний байгууллагуудад илгээнэ.

(4) а) Мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр (3) дахь хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан нийтлэлийг түүний хүссэн хугацаагаар хойшлуулна. Энэ хугацаа нь олон улсын

хадгалалтын огнооноос эхлэн арван хоёр сараас хэтэрч үл болно. Харин давамгайлах эрх хүссэн тохиолдолд энэ хугацааг давамгайлах огнооноос эхлэн тооцно.

b) Мэдүүлэг гаргагч нь (a) дэд хэсэгт заасан хугацаанд хэдийд ч нийтлэл даруй хийхийг хүсэлт болгох буюу хадгалалтыг буцаан авч болно. Хадгалалтыг хэлэлцэн тохирогч нэг буюу зөвхөн зарим улсын хувьд, нэгдмэл хадгалалт хийсэн тохиолдолд зөвхөн зарим загварын хувьд буцаан авч болно.

c) Хэрэв мэдүүлэг гаргагч (a) дэд хэсэгт заасан хугацаанд төлбөл зохих хураамжийг төлөөгүй бол олон улсын товчоо хадгалалтыг хүчингүй болгож (3) дахь хэсгийн (a) дэд хэсэгт заасан нийтлэлийг хэрэгсэхгүй болгоно.

d) Олон улсын товчоо нь нийтлэлийг нь хойшлуулах нөхцөлөөр хийгдсэн хадгалалтын бүртгэлийг (a) дэд хэсэгт заасан хугацаа дуустал нууц байлгах бөгөөд ийнхүү хадгалалтад холбогдох аливаа баримт буюу бүтээгдэхүүнийг нийтийн хүртээл болгохгүй. Заасан хугацаа дуусахаас өмнө мэдүүлэг гаргагч хадгалалтаа хүчингүй болгосон тохиолдолд ч эдгээр заалтыг хугацааны хязгаарлалтгүйгээр хэрэглэнэ.

(5) (4) дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд бүртгэл болон олон улсын товчоонд мэдүүлсэн баримт бичиг болон бүтээгдэхүүн нь олон нийт танилцахад нээлттэй байна.

7 дугаар зүйл

(1) a) Олон улсын товчоонд бүртгүүлсэн хадгалалт нь мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгтээ заасан хэлэлцэн тохирогч улс бүрт тухайн улсын үндэсний хуулиар эрхийн хамгаалалт олгох бүх шаардлагыг мэдүүлэг гаргагч хангасан, үндэсний байгууллага нь энэ талаар захиргааны бүхий л шаардагдах үйлдлийг гүйцэтгэсэнтэй нэгэн адил үйлчлэх болно.

b) Олон улсын товчоонд бүртгүүлсэн хадгалалтад хамрагдах загварыг хамгаалах асуудлыг 11 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн тохирогч улс бүрт үндэсний хадгалалтад үндэслэн хамгаалалт хийлгэх хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох бүхий л шаардлага болон захиргааны үйлдлийг хэрэгжүүлж гүйцэтгэсэн загварын хувьд хэрэглэгдэх тухайн улсын үндэсний хуулийн заалтуудаар зохицуулна.

(2) Гарлын улсын хуулиар ийнхүү тогтоосон бол олон улсын хадгалалт нь тухайн улсад үйлчлэхгүй.

8 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч улсын үндэсний хуульд үндэсний байгууллага нь шүүлт буюу гуравдагч этгээдийн эсэргүүцлийн үндсэн дээр эрхийн хамгаалалт олгохоос татгалзаж болохоор заасан бол ийнхүү татгалзсан тохиолдолд үндэсний байгууллага нь 7 дугаар зүйлд заасныг үл харгалзан тухайн загвар нь 7 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт дурдсан захиргааны болон бусад шаардлагаас өөр тухайн улсын үндэсний хуулийн шаардлагыг хангахгүй байгааг зургаан сарын дотор олон улсын товчоонд мэдэгдэнэ. Хэрэв зургаан сарын дотор татгалзсан тухай мэдэгдээгүй бол

олон улсын хадгалалт нь тухайн улсад уг хадгалалтын огнооноос эхлэн хүчин төгөлдөр болно. Харин шинэлэгийг тогтоох шүүлт хийдэг хэлэлцэн тохирогч улсад үндэсний хуулиар нь үндэсний байгууллагад хийгдсэн хадгалалтад түрүү огноо олгохоор заагаагүй бол олон улсын хадгалалт нь зургаан сарын дотор татгалзсан тухай мэдэгдээгүй тохиолдолд давамгайлах эрхээ хадгалан уг хугацаа дууссанаас эхлэн хүчин төгөлдөр болно.

(2) (1) дэх хэсэгт заасан зургаан сарын хугацааг үндэсний байгууллага олон улсын хадгалалтын бүртгэлийн тухай нийтэлсэн тогтмол хэвлэлийг хүлээн авсан өдрөөс эхлэн тооцно. Үндэсний байгууллага нь хүсэлт гаргасан аливаа этгээдэд энэ огноог мэдэгдэнэ.

(3) Мэдүүлэг гаргагч нь (1) дэх хэсэгт дурдсан үндэсний байгууллагын татгалзсан шийдвэрийн талаар загвараа тэрхүү байгууллагад хадгалуулсантай адил нөхцөлөөр гомдол гаргах эрхтэй бөгөөд ямар ч тохиолдолд татгалзсан шийдвэрийн талаар дахин шүүлт хийлгэхийг хүсэх буюу гомдол гаргаж болно. Татгалзсан шийдвэрийн тухай мэдэгдэлд:

1. загвар нь үндэсний хуулийн шаардлагыг хангахгүй байна гэж шийдвэр гаргасан үндэслэл;
2. (2) дахь хэсэгт заасан огноог;
3. дахин шүүлт хийлгэхийг хүсэх буюу гомдол гаргаж болох хугацааг;
4. ийнхүү хүсэлт буюу гомдол гаргах байгууллагыг тус тус заана.

(4) а) (1) дэх хэсэгт дурдсаны адил загварын зохион бүтээгч нь хэн болох тухай мэдэгдэл буюу загварын тодорхойлолт байхыг шаардсан заалт бүхий үндэсний хуультай хэлэлцэн тохирогч улсын үндэсний байгууллага нь мэдүүлэг гаргагчид хүсэлт тавьж ийнхүү хүсэлт илгээсэн өдрөөс жараас доошгүй хоногийн дотор:

1. загварын зохион бүтээгч хэн болох тухай мэдэгдэл;
2. загварын гэрэл зураг буюу график дүрслэлд харуулсан үндсэн онцлог шинжийг тайлбарласан товч тодорхойлолтыг олон улсын товчоонд гаргасан мэдүүлгийн хэл дээр тус тус ирүүлэхийг шаардаж болно.

б) Үндэсний байгууллага нь ийм мэдэгдэл буюу тодорхойлолт гаргах, эсхүл тэдгээрийг нийтлэхэд хураамж авахгүй.

(5) а) (1) дэх хэсэгт дурьдсантай ижил заалт бүхий үндэсний хуультай хэлэлцэн тохирогч аливаа улс нь энэ тухайгаа олон улсын товчоонд мэдэгдэнэ.

б) Хэрэв хэлэлцэн тохирогч улс нь хууль тогтоомжийнхоо дагуу загварыг хамгаалах хэд хэдэн системтэй бөгөөд тэдгээрийн нэгийг нь дагуу шинэлэгийг тогтоох шүүлт хийдэг бол тийм шүүлт хийдэг улсуудад хамаарах энэ хэлэлцээрийн заалтуудыг зөвхөн тэр системийн хувьд л хэрэглэнэ.

9 дүгээр зүйл

Загварын олон улсын хадгалалтыг, мөн загварыг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах олон улсын холбооны гишүүн улсад анх хадгалуулснаас хойш зургаан сарын дотор хийж, олон улсын хадгалалтад давамгайлах эрхийг хүссэн тохиолдолд давамгайлах огноог тэрхүү анхны хадгалалтын огноогоор тогтооно.

10 дугаар зүйл

(1) Журмаар тогтоосон хугацаа сунгуулах хураамжийг ээлжит таван жилийн хугацааны сүүлчийн жилд багтаан төлж олон улсын хадгалалтын хугацааг тав таван жилээр сунгуулж болно.

(2) Журмаар тогтоосон нэмэгдэл хураамжийг төлсөн нөхцөлд олон улсын хадгалалтыг сунгуулахад зургаан сарын хөнгөлөлтийн хугацаа олгоно.

(3) Хугацаа сунгуулах хураамжийг төлөх үед олон улсын хадгалалтын дугаарыг, мөн хадгалалтын хугацаа дуусах гэж буй бүх хэлэлцэн тохирогч улсын хувьд хугацааг сунгуулахгүй байх тохиолдолд хугацааг сунгуулах хэлэлцэн тохирогч улсуудыг тус тус заана. Нэгдмэл хадгалалтад хамаарах зөвхөн зарим загварын хувьд хугацаа сунгуулж болно.

(4) Нэгдмэл хадгалалтад хадгалуулсан загварын хадгалалтын сунгалтыг зөвхөн зарим загвараар хязгаарлаж болно.

(5) Олон улсын товчоо нь хугацааны сунгалтыг бүртгэж, нийтэлнэ.

11 дүгээр зүйл

(1) а) Олон улсын хадгалалт бүхий загварын хувьд хэлэлцэн тохирогч улсад олгосон хамгаалалтын хугацаа нь:

1. хэрэв хадгалалтын хугацааг сунгуулсан бол олон улсын хадгалалтын огнооноос эхлэн арван жилээс;
2. хадгалалтын хугацааг сунгуулаагүй бол олон улсын хадгалалтын огнооноос эхлэн таван жилээс доошгүй байна.

б) Харин шинэлэгийг тогтоох шүүлт хийдэг хэлэлцэн тохирогч улсын үндэсний хуулийн дагуу хамгаалалт нь олон улсын хадгалалтынхаас хойших огнооноос эхэлдэг бол (а) дэд хэсэгт заасан доод хугацааг тухайн улсад хамгаалалт эхлэх огнооноос тооцно. Олон улсын хадгалалтыг сунгуулаагүй буюу зөвхөн нэг удаа сунгуулах явдал нь ийнхүү тогтоосон хамгаалалтын доод хугацаанд нөлөөлөхгүй.

(2) Хэлэлцэн тохирогч улсын үндэсний хуулиар үндэсний хадгалалт бүхий загварыг хамгаалах хугацаа нь сунгуулсан буюу сунгуулаагүй ч арван жилээс илүү байх тохиолдолд тухайн улсад олон улсын хадгалалт бүхий загварыг олон улсын хадгалалтын болон түүний хугацааг сунгасны үндсэн дээр мөн тэр хугацаанд хамгаална.

(3) Хэлэлцэн тохирогч улс нь үндэсний хуулиараа олон улсын хадгалалт бүхий загварыг хамгаалах хугацааг (1) дэх хэсэгт заасан хугацаагаар хязгаарлаж болно.

(4) Хэлэлцэн тохирогч улсын үндэсний хуульд олон улсын хадгалалтын хугацаа дууссанаас хойш хамгаалалт үргэлжилнэ гэж заагаагүй бол тухайн улсад хамгаалалт нь (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасныг харгалзан олон улсын хадгалалтын хугацаа дууссан өдрөөс үйлчлэхээ болино.

12 дугаар зүйл

(1) Олон улсын товчоо нь хүчин төгөлдөр олон улсын хадгалалт бүхий загварын эзэмшигч өөрчлөгдсөнийг бүртгэж энэ тухай нийтэлнэ . Хэлэлцэн тохирогч зөвхөн нэг буюу зарим улсын хувьд болон нэгдмэл хадгалалтын тохиолдолд түүнд хамрагдах зөвхөн зарим загварын хувьд олон улсын хадгалалтаас үүсэх эрхийн эзэмшигч нь өөрчлөгдөж болно гэж ойлгоно.

(2) (1) дэх хэсэгт дурьдсан бүртгэл нь хэлэлцэн тохирогч улсын үндэсний байгууллагад хийгдсэн бүртгэлтэй нэгэн адил үйлчилнэ.

13 дугаар зүйл

(1) Олон улсын хадгалалтын эзэмшигч нь олон улсын товчооны нэр дээр мэдэгдэл ирүүлснээр хэлэлцэн тохирогч бүх буюу зөвхөн зарим улсын хувьд болон нэгдмэл хадгалалтын тохиолдолд түүнд хамрагдах зөвхөн зарим загварын хувьд өөрийн эрхээсээ татгалзаж болно.

(2) Олон улсын товчоо нь энэхүү мэдэгдлийг бүртгэж энэ тухай нийтэлнэ.

14 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохирогч аль ч улс хамгаалалт олгох нөхцөл болгож загварт багтаж байгаа зүйлийн загварын хадгалалт хийгдсэн тухай тэмдэг буюу тэмдэглэл тавихыг шаардаж болохгүй.

(2) Хэлэлцэн тохирогч улсын үндэсний хуулиар бүтээгдэхүүн дээр ямар нэг өөр зорилгоор тэмдэг тавьж байхаар заасан тохиолдолд тэр улс нь загварын эзэмшигчийн зөвшөөрөлтэйгээр нийтэд гаргасан бүх бүтээгдэхүүн буюу тэдгээрийн шошго дээр олон улсын загварын тэмдэглэл тавьсныг уг шаардлагыг хангасан гэж үзнэ.

(3) Олон улсын загварын тэмдэглэл нь D (дугуй доторх том D үсэг) гэсэн тэмдгээс бүрдэхийн зэрэгцээ:

1. олон улсын хадгалалтын он ба хадгалуулагчийн нэр буюу товчилсон нэрийг, эсхүл
2. олон улсын хадгалалтын дугаарыг тэмдэглэн дагалдуулсан байна.

(4) Бүтээгдэхүүн буюу шошго дээр олон улсын загварын тэмдэглэл тавьсан байх нь л аливаа байдлаар зохиогчийн эрхийн буюу аливаа бусад хамгаалалтаас

татгалзсан гэж, харин тэмдэглэл тавиагүй тохиолдолд ийнхүү хамгаалалтыг хүсэлт болгож болно гэж үзэхгүй.

15 дугаар зүйл

(1) Журмаар тогтоосон хураамж нь:

1. олон улсын товчоонд төлөх хураамж;
2. мэдүүлэг гаргагчийн заасан хэлэлцэн тохирогч улсад төлөх хураамж, үүнд:

а) хэлэлцэн тохирогч улс бүрт төлөх хураамж;

б) шинэлэгийг тогтоох шүүлт хийсний хураамж авдаг хэлэлцэн тохирогч улс бүрт төлөх хураамжаас тус тус бүрдэнэ.

(2) Нэг ижил загварын хувьд хэлэлцэн тохирогч улсад (1) дэх хэсгийн (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасны дагуу төлсөн аливаа хураамжийн дүнг хэрэв (1) дэх хэсгийн (2) дахь хэсгийн (б) дэд хэсэгт дурдсан хураамжийг мөн улсад төлөх бол уг хураамжийн дүнгээс хасна.

16 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч улсуудад төлөх 15 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн 2 дахь заалтад дурдсан хураамжийг олон улсын товчоо хуримтлуулж жил бүр мэдүүлэг гаргагчийн заасан хэлэлцэн тохирогч улсуудад хуваарилан төлнө.

(2) (а) Хэлэлцэн тохирогч аливаа улс олон улсын хадгалалтын хувьд гарлын улс болох хэлэлцэн тохирогч бусад улсыг 15 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн 2 дахь заалтын (а) дэд хэсэгт дурдсан нэмэгдэл хураамж авах эрхээсээ татгалзахад мөн ийнхүү татгалзаж буй тухайгаа олон улсын товчоонд мэдэгдэж болно.

(б) Тухайн улс нь олон улсын хадгалалтын хувьд өөрөө гарлын улс болох тохиолдолд мөн ийнхүү татгалзаж болно.

17 дугаар зүйл

Журам нь энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдох зүйл, заалтуудыг тогтооно. Тухайлбал:

1. хадгалалтын мэдүүлгийг үйлдэх хэл, хадгалуулахаар өгөх мэдүүлгийн хуулбарын тоо, мэдүүлэгт тусгах огноо.
2. Олон улсын товчоо болон бусад улсад төлөх хураамжийн төлбөрийн дүн, огноо, төлбөр хийх хэлбэр, мөн шинэлэгийг тогтоох шүүлт хийдэг хэлэлцэн тохирогч улсад ноогдох хураамжийн хязгаар;

3. хадгалуулсан загвар бүрийн гэрэл зураг буюу бусад график дүрслэлийн тоо, хэмжээ ба бусад шинж;
4. загварын онцлог шинжийн тодорхойлолтын хэмжээ;
5. загварт багтаж байгаа зүйлийн үлгэр буюу загварыг мэдүүлэгт хавсаргаж болох нөхцөл, хязгаарлалт;
6. нэгдмэл хадгалалтад хамруулж болох загварын тоо болон нэгдмэл хадгалалтад холбогдох бусад нөхцөл;
7. 6 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан тогтмол хэвлэлийг нийтлэх, тараахтай холбогдох бүх асуудал, түүнчлэн уг хэвлэлийг үндэсний байгууллагуудад үнэ төлбөргүй тараах болон үнэ хямдруулан худалдаж болох хувийн тоо хэмжээ;
8. хэлэлцэн тохирогч улсууд 8 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу татгалзсан тухайгаа мэдэгдэх журам, энэ тухай мэдэгдлийг олон улсын товчоо хүлээн авах ба нийтлэх журам;
9. олон улсын товчоо 12 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу загварын эзэмшигч өөрчлөгдсөнийг, 13 дугаар зүйлд заасны дагуу эрхээсээ татгалзсаныг бүртгэх ба нийтлэх журам;
10. хугацаа сунгах боломжгүй болсон хадгалалтад хамаарах баримт бичиг болон бүтээгдэхүүнийг буцааж тараах зэрэг болно.

18 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь хэлэлцэн тохирогч улсын үндэсний хэмжээнд олгож болох аливаа давуу хамгаалалт хүсэхийг үгүйсгэхгүй бөгөөд зохиогчийн эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенцийн дагуу урлагийн ба хавсарга урлагийн бүтээлд бүртгэсэн хамгаалалтыг аливаа байдлаар хөндөхгүй.

19 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн дагуу олон улсын товчоо үйлчилгээ үзүүлсний хураамжийг:

а) Олон улсын загварын үйлчилгээний бүх зардал, олон улсын загварын хорооны хурал эсхүл энэхүү хэлэлцээрийг хянан өөрчлөх бага хурлыг бэлтгэж явуулахад шаардагдах бүх зардлыг нөхөж болох;

б) 20 дугаар зүйлд дурдсан нөөцийн санг хадгалж болох хэмжээгээр тогтооно.

20 дугаар зүйл

(1) Нөөцийн санд 250.000 швейцарь франк байна. Нөөцийн сангийн хэмжээг 21 дүгээр зүйлд заасан олон улсын загварын хороо өөрчилж болно.

(2) Нөөцийн санг олон улсын загварын албан орлогын илүүдлээс нөхөн бүрдүүлнэ.

(3) а) Харин энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох үед нөөцийн санг хэлэлцэн тохирогч улс бүр Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 13 дугаар зүйлийн (8) дахь хэсэгт тодорхойлсон тухайн улс хамаарагдах ангилалд тохирох нэгжийн тоонд харьцуулан тогтоосон хэмжээгээр төлөх нэг удаагийн төлбөрөөр бүрдүүлнэ.

б) Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа түүнд оролцогч тал болсон улс нь мөн нэг удаагийн төлбөр төлнө. Энэ төлбөрийн хэмжээг өмнөх хэсэгт тодорхойлсон зарчмын дагуу тогтоох бөгөөд энэхүү хэлэлцээрт хэдийд оролцогч тал болсныг үл харгалзан бүх улсууд нэг нэгжид тохирох ижил хэмжээний төлбөр төлнө.

(4) Нөөцийн сангийн хэмжээ нь тогтоосон хэмжээнээсээ илүү гарвал илүүдлийг хэлэлцэн тохирогч улсуудад тэдгээрийн төлсөн нэг удаагийн төлбөрийн харьцаагаар уг төлбөрийн хэмжээнд хүртэл тухай бүр хуваарилан тараана.

(5) Олон улсын загварын хороо нь нэг удаагийн төлбөрүүдийг бүрэн нөхөн олгож дууссан тохиолдолд цаашид энэхүү хэлэлцээрт оролцогч тал болох улсуудаас нэг удаагийн төлбөр төлөхийг шаардахгүй байхаар шийдвэрлэж болно.

21 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохирогч улсуудын төлөөлөгчдөөс бүрдсэн олон улсын загварын хороо байгуулна.

(2) Хороо нь дараахь эрх, үүрэгтэй:

1. өөрийн дотоод журмыг боловсруулах;
2. журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;
3. 20 дугаар зүйлд дурьдсан нөөцийн сангийн хэмжээг шинэчлэх;
4. олон улсын загварын ангилал бий болгох;
5. энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хянан өөрчилж болох асуудлыг судлах;
6. загварын олон улсын хамгаалалтын талаарх бусад асуудлыг судлах;
7. олон улсын товчооны жилийн тайланг хэлэлцэн баталж, энэхүү хэлэлцээрийн дагуу олон улсын товчооны гүйцэтгэх үүргийн талаар ерөнхий заавар, зөвлөмж өгөх;
8. олон улсын товчооны дараагийн гурван жилийн хугацааны зардлын талаар урьдчилсан тайлан бэлтгэх.

(3) (2) дахь хэсгийн 1, 2, 3, 4 дүгээр заалтад заасан хорооны шийдвэрийг хороонд оролцож буй эсхүл төлөөлүүлж буй гишүүдийн тавны дөрвийн олонхын саналаар, бусад тохиолдолд энгийн олонхын саналаар тус тус батална. Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(4) Хороо нь олон улсын товчооны захирлын зарласнаар:

1. гурван жилд нэгээс доошгүй удаа;
2. хэлэлцэн тохирогч улсуудын гуравны нэгийн шаардлагаар буюу олон улсын товчооны захирал буюу Швейцарийн Холбооны Улсын Засгийн газрын санаачилгаар аль ч үед хуралдана.

(5) Хорооны гишүүдийн замын зардал, байр хоногийн зардлыг тэдгээрийн засгийн газар хариуцна.

22 дугаар зүйл

(1) Журамд нэмэлт өөрчлөлтийг 21 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн 2 дахь заалтын дагуу Хорооны зүгээс, эсхүл энэ зүйлийн (2) дахь хэсэгт тогтоосон бичгээр үйлдэх дүрмийн дагуу оруулж болно.

(2) Бичгээр үйлдэх дүрмээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг олон улсын товчооны захирал хэлэлцэн тохирогч улс бүрийн засгийн газарт захидал илгээж санал болгоно. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 1 жилийн хугацаанд хэлэлцэн тохирогч аль нэг улс татгалзахгүй бол нэмэлт өөрчлөлтийг баталсанд тооцно.

23 дугаар зүйл

(1) Энэхүү хэлэлцээр нь 1961 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

(2) Хэлэлцээрийг соёрхон батлах ёстой бөгөөд батламж жуух бичгийг Нидерландын Засгийн газарт хадгалуулна.

24 дүгээр зүйл

(1) Энэхүү хэлэлцээрт гарын үсэг зураагүй Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах олон улсын холбооны гишүүн улсууд түүнд нэгдэн орж болно.

(2) Ийнхүү нэгдэн орж буйг дипломат шугамаар Швейцарийн Холбооны Улсын Засгийн газарт, түүгээр уламжлан хэлэлцэн тохирогч бусад улсын засгийн газарт мэдэгдэнэ.

25 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч улс бүр бүтээгдэхүүний загварыг хамгаалах нөхцөл бүрдүүлэх, өөрийн Үндсэн хуулийн дагуу энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

(2) Хэлэлцэн тохирогч улс нь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулах үед үндэсний хууль тогтоомжийн дагуу энэхүү хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлэх чадвартай байх ёстой.

26 дугаар зүйл

(1) Энэхүү хэлэлцээр нь түүнийг байгуулсан өдөр 1925 буюу 1934 оны хэлэлцээрүүдэд оролцогч тал байгаагүй дөрвөөс цөөнгүй улсын, нийт арван батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай мэдэгдлийг Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хэлэлцэн тохирогч улсуудад илгээсэн өдрөөс хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

(2) Цаашид батламж жуух бичиг ба нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан тухайг хэлэлцэн тохирогч улсуудад Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар мэдэгдэж байна. Ийнхүү соёрхон баталсан болон нэгдэн орсон нь, хэрвээ нэгдэн орсон тохиолдолд нэгдэн орсон тухай баримт бичигт хожмын өдөр заагаагүй бол тухайн мэдэгдлийг илгээсэн өдрөөс хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

27 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аливаа улс гадаад харилцааных нь тухайд хариуцлага хүлээж буй бүх буюу зарим нутаг дэвсгэрийн хувьд энэхүү хэлэлцээр үйлчлэх тухайг Швейцарийн Холбооны Улсын Засгийн газарт хэдийд ч мэдэгдэж болно. Улмаар Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар ийнхүү мэдэгдсэн тухай хэлэлцэн тохирогч улсуудад мэдээлэх бөгөөд энэхүү хэлэлцээр нь тухайн мэдэгдэлд хожмын өдөр заагаагүй бол Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хэлэлцэн тохирогч улсуудад мэдээлэл илгээсэн өдрөөс хойш нэг сарын дараа тухайн нутаг дэвсгэрийн хувьд үйлчлэх болно.

28 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч аливаа улс Швейцарийн Холбооны Улсын Засгийн газарт мэдэгдэл илгээж өөрийн нэрийн өмнөөс эсхүл 27 дугаар зүйлийн дагуу хийсэн мэдэгдэлд заасан бүх буюу зарим нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү хэлэлцээрийг цуцалж болно. Энэхүү мэдэгдэл нь Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар түүнийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа үйлчлэх болно.

(2) Ийнхүү цуцлах нь хэлэлцэн тохирогч аливаа улсыг цуцалсан өдрөөс өмнө энэхүү хэлэлцээрийн дагуу олон улсын товчоонд хадгалуулсан загварын хувьд хүлээсэн үүргээс нь чөлөөлөхгүй.

29 дүгээр зүйл

(1) Загварын олон улсын хадгалалтаас үүсэх хамгаалалтыг боловсронгуй болгоход чиглэгдсэн нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор энэхүү хэлэлцээрийг үе үе хянан өөрчлөхөөр авч үзнэ.

(2) Хянан өөрчлөх бага хурлыг олон улсын загварын хорооны буюу хэлэлцэн тохирогч улсуудын тэн хагасаас багагүй улсуудын хүсэлтээр хуралдуулна.

30 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч хоёр буюу түүнээс дээш улсууд мэдэгдэлдээ заасан нөхцөлийн дагуу:

1. тэдгээрийн үндэсний байгууллагыг нэг байгууллага төлөөлөх;

2. тэдгээр нь энэхүү хэлэлцээрийн 2-17 дугаар зүйлийн хувьд нэг улс гэж тооцогдох тухайгаа Швейцарийн Холбооны Улсын Засгийн газарт хэдийд ч мэдэгдэж болно.

(2) Энэхүү мэдэгдэл нь Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хэлэлцэн тохирогч бусад улсуудад энэ тухай мэдээлэл илгээсэн өдрөөс хойш зургаан сар болохоос өмнө үйлчлэхгүй.

31 дүгээр зүйл

(1) Энэхүү хэлэлцээрт болон 1925 оны буюу 1934 оны хэлэлцээрт нэгэн зэрэг оролцогч талууд болох улсуудын хоорондын харилцааны хувьд зөвхөн энэхүү хэлэлцээрийг ганцаар нь хэрэглэнэ. Харин эдгээр улсын хоорондын харилцааны хувьд энэхүү хэлэлцээрийг хэрэглэж эхэлсэн өдрөөс өмнө олон улсын товчоонд хадгалуулсан загварын талаарх хоорондын харилцаанд тухайн байдлыг харгалзан 1925 оны буюу 1934 оны хэлэлцээрийг хэрэглэнэ.

(2) а) Энэхүү хэлэлцээрт болон 1925 оны хэлэлцээрт нэгэн зэрэг оролцогч тал болох хэлэлцэн тохирогч аливаа улс нь зөвхөн 1925 оны хэлэлцээрт оролцогч тал болох улстай харилцахдаа хэрэв тухайн улс нь 1925 оны хэлэлцээрийг цуцлаагүй бол 1925 оны хэлэлцээрийн заалтыг хэрэглэнэ.

б) Энэхүү хэлэлцээрт болон 1934 оны хэлэлцээрт оролцогч тал болох хэлэлцэн тохирогч аливаа улс нь зөвхөн 1934 оны хэлэлцээрт оролцогч тал болох улстай харилцахдаа хэрэв тухайн улс нь 1934 оны хэлэлцээрийг цуцлаагүй бол 1934 оны хэлэлцээрийн заалтыг хэрэглэнэ.

(3) Зөвхөн энэхүү хэлэлцээрт оролцогч улс нь энэхүү хэлэлцээрт оролцогч бус 1925 оны буюу 1934 оны хэлэлцээрт оролцогч улсын хувьд ямар ч үүрэг хүлээхгүй.

32 дугаар зүйл

(1) Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдөр 1925 оны буюу 1934 оны хэлэлцээрт оролцогч улс энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурж соёрхон баталсан буюу нэгдэн орсныг хэрэв тухайн улс гарын үсэг зурахдаа буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахдаа татгалзсан мэдэгдэл хийгээгүй бол энэхүү хэлэлцээрт хавсаргасан протоколд гарын үсэг зурж соёрхон баталсан буюу нэгдэн орсонд тооцно.

(2) (1) дэх хэсэгт дурдсан мэдэгдэл хийсэн хэлэлцэн тохирогч аливаа улс эсхүл 1925 оны буюу 1934 оны хэлэлцээрт оролцогч бус хэлэлцэн тохирогч бусад улс энэхүү хэлэлцээрт хавсаргасан протоколд гарын үсэг зурах буюу нэгдэн орж болно. Гарын

үсэг зурахдаа буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахад тухайн улс нь протоколын 2 дахь хэсгийн (а) буюу (b) дэд хэсэгт заасны хувьд үүрэг хүлээхгүй тухайгаа мэдэгдэж болох бөгөөд энэ тохиолдолд протоколд оролцогч бусад улс тухайн улстай харилцахдаа тэрхүү мэдэгдэлд заасан заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй. 23-28 дугаар зүйлийн заалтыг тохируулан хэрэглэнэ.

33 дугаар зүйл

Энэхүү актыг нэг хувь үйлдэн гарын үсэг зурж Нидерландын Засгийн газарт хадгалуулахаар хүлээлгэн өгнө. Баталгаажуулсан хувийг гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон улс бүрийн засгийн газарт илгээнэ.

Протокол

Энэхүү протоколд оролцогч улсууд дараахь зүйлийг тохиролцов:

(1) Олон улсын хадгалалтад хамаарах загварын хувьд энэхүү протоколд оролцогч улсуудын нэг нь гарлын улс гэж тооцогдоход энэхүү протоколын заалтуудыг тэр загварын хувьд хэрэглэх болно.

(2) (1) дэх хэсэгт дурдсан загварын хувьд:

а) (1) дэх хэсэгт дурдсан загварын хувьд энэхүү протоколд оролцогч улсын олгодог хамгаалалтын хугацаа нь тухайн байдлыг харгалзан 11 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (а) буюу (b) дэд хэсэгт заасан огнооноос эхлэн 15 жилээс багагүй байна.

б) Энэхүү протоколд оролцогч улс нь аливаа тохиолдолд түүний нутаг дэвсгэр дээр олон улсын хадгалалтаас үүсэх эрхийг эдлэхийн тулд эсхүл аливаа бусад зорилгоор загварыг хэрэгжүүлсэн бүтээгдэхүүн буюу тэдгээрийн шошго дээр тэмдэглэл тавихыг шаардахгүй.

**64. БАРААНЫ ТЭМДГИЙГ БҮРТГЭХ ЗОРИЛГООР
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ ТОГТООХ ТУХАЙ
НИЦЦИЙН ХЭЛЭЛЦЭЭР***

*1982 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон
/1979 оны нэмэлт, өөрчлөлт/*

*1957 оны 6 дугаар сарын 15-нд гарын үсэг зурсан, 1967 оны 7 дугаар сарын 14-нд Стокгольмд, 1977
оны 5 дугаар сарын 13-нд Женевт хянан өөрчилж,
1979 оны 9 дүгээр сарын 28-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар*

1 дүгээр зүйл

**Тусгай холбоо байгуулах; олон улсын ангиллыг тогтоох;
ангиллын тодорхойлолт ба хэл**

* Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр соёрхон баталсан.

(1) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлж буй орнууд тусгай холбоо байгуулж барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний нэгдмэл ангиллын хүлээн зөвшөөрнө (цаашид “ангилал” гэнэ).

(2) Ангилал нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- (i) ангиллын жагсаалт болон шаардлагатай тохиолдолд тайлбар тэмдэглэл;
- (ii) бараа, үйлчилгээний цагаан толгойн үсгийн дараалал бүхий жагсаалт, (цаашид “цагаан толгойн үсгийн дарааллын жагсаалт” гэнэ) тэдний ангиллыг заана.

(3) Ангилал нь дараахь зүйлийг багтаана:

- (i) Оюуны өмчийн олон улсын товчооноос (цаашид “олон улсын товчоо” гэнэ) 1971 онд хэвлэн нийтэлсэн Дэлхийн оюуны өмчийн байгууллагыг байгуулах тухай конвенцид тусгагдсан ангилал, гэхдээ 3 дугаар зүйлийн дагуу шинжээчдийн хорооноос ангиллын жагсаалтад тайлбар хийх хүртэл тэрхүү нийтлэлд оруулсан ангиллын жагсаалтын тайлбарыг түр хугацааны зөвлөмж, тайлбар хэлбэрээр хэрэглэнэ;
- (ii) энэхүү акт хүчин төгөлдөр болохоос өмнө 1957 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Ниццийн хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн болон энэхүү хэлэлцээрийн 1967 оны 7 дугаар сарын 14-ны өдрийн Стокгольмын актын дагуу хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтүүд;
- (iii) энэхүү актын 3 дугаар зүйлийн дагуу хийгдэх болон энэхүү актын 4 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн дагуу хүчин төгөлдөр болох аливаа өөрчлөлт.

(4) Ангиллыг англи буюу франц хэлээр боловсруулах бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

(5) а) (3) дахь хэсгийн (i)–д заасан ангиллын энэхүү актад гарын үсэг зурахад нээлттэй болох хугацаанаас өмнө хүчин төгөлдөр болсон (3) дахь хэсгийн (ii)–д заасан нэмэлт, өөрчлөлтүүдийн хамт франц хэлээр үйлдсэн албан ёсны эх хувийг Дэлхийн оюуны өмчийн байгууллагын ерөнхий захиралд (цаашид “ерөнхий захирал”, “байгууллага” гэнэ) хадгалуулахаар өгнө. Энэхүү актад гарын үсэг зурахад нээлттэй болсны дараа хүчин төгөлдөр болсон (3) дахь хэсгийн (ii)–д заасан нэмэлт, өөрчлөлтийн франц хэлээрх албан ёсны эх хувийг мөн адил ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

б) 3 дугаар зүйлд дурдсан шинжээчдийн хороо нь энэхүү актыг хүчин төгөлдөр болмогц (а) дэд хэсэгт заасан эх бичвэрийг англи хэлээр үйлдэнэ. Түүний албан ёсны эх хувийг ерөнхий захиралд хадгалуулна.

с) (3) дахь хэсгийн (iii)-д заасан өөрчлөлтийн англи, франц хэлээр үйлдсэн албан ёсны эх хувийг ерөнхий захиралд хадгалуулна.

(6) Ангиллын араб, герман, итали, португали, орос, испани хэлээр болон 5 дугаар зүйлд заасны дагуу Ассамблейгаас тогтоох бусад албан ёсны хэлээрх эх бичвэрийг гаргах асуудлыг сонирхогч засгийн газартай зөвлөлдөн тухайн засгийн газраас гаргасан орчуулгыг үндэслэн эсхүл тусгай холбооны болон байгууллагын төсөвт хүндрэл учруулахгүйгээр ерөнхий захирал шийдвэрлэнэ.

(7) Цагаан толгойн үсгийн дарааллын жагсаалтад бараа, үйлчилгээний заалт бүрийн эсрэг талд жагсаалтыг үйлдсэн хэлтэй уялдуулан серийн дугаарыг заах бөгөөд, энэ нь:

- (i) цагаан толгойн үсгийн дарааллын жагсаалтыг англи хэлээр үйлдсэн тохиолдолд өөрийн дугаар нь цагаан толгойн үсгийн дарааллын франц хэлээрх жагсаалтад заасан серийн дугаартай адил байх бөгөөд эсрэгээр мөн ойлгоно;
- (ii) 6 дахь хэсгийн дагуу тогтоох аливаа цагаан толгойн үсгийн дарааллын англи хэлээрх эсхүл франц хэлээрх жагсаалтад серийн дугаарыг хамт бичнэ.

2 дугаар зүйл

**Ангиллын хэрэглээ ба эрх зүйн
үр дагавар**

(1) Энэхүү хэлэлцээрт тусгагдсан шаардлагын дагуу ангилал нь тусгай холбооны орон бүрийн саналыг оруулсан байна. Тухайлбал, ангилал нь тухайн орны аливаа барааны тэмдэгт олгож буй хамгаалалтын хүрээг тодорхойлох эсхүл үйлчилгээний тэмдгийг хүлээн зөвшөөрөх талаар тусгай холбооны орнуудад үүрэг хүлээлгэхгүй.

(2) Тусгай холбооны орон бүр ангиллыг үндсэн буюу туслах тогтолцоогоор хэрэглэх эрхтэй.

(3) Тусгай холбооны гишүүн орны эрх бүхий байгууллага барааны тэмдгийг бүртгэсэн тухай албан ёсны баримт бичиг буюу хэвлэлд тухайн бүртгэсэн тэмдэгт хамаарах бараа, үйлчилгээний ангиллын дугаарыг оруулна.

(4) Цагаан толгойн үсгийн дарааллын жагсаалтад оруулсан нэр томъёо нь тухайн нэр томъёонд хамаарах аливаа эрхийг аль ч утгаар хөндөхгүй.

3 дугаар зүйл

Шинжээчдийн хороо

(1) Тусгай холбооны гишүүн орон бүрээс бүрдсэн шинжээчдийн хороог байгуулна.

(2) а) Ерөнхий захирал байгууллагын гишүүн мөн боловч тусгай холбооны гишүүн бус, эсхүл Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч орныг шинжээчдийн хорооны хуралдаанд ажиглагчаар оролцуулахаар урьж болох бөгөөд шинжээчдийн хорооноос тийм хүсэлт гаргасан тохиолдолд тэдгээрийг заавал урина.

б) Ерөнхий захирал барааны тэмдгийн салбарт мэргэшсэн, дор хаяж нэг гишүүн орон нь тусгай холбооны гишүүн байгаа засгийн газар хоорондын байгууллагуудыг шинжээчдийн хорооны хуралдаанд ажиглагчаар оролцуулахаар урина.

с) Ерөнхий захирал засгийн газар хоорондын байгууллага болон олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг тэдгээрийн сонирхсон ярилцлагад оролцуулахаар урьж болох ба шинжээчдийн хорооноос тийм хүсэлт гаргасан тохиолдолд тэдгээрийг заавал урина.

(3) Шинжээчдийн хороо нь:

- (i) ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- (ii) тусгай холбооны гишүүн орнуудад зориулан ангиллыг нэгдсэн болон хялбар аргаар хэрэглэх талаар зөвлөмж өгөх;
- (iii) тусгай холбооны төсөв буюу байгууллагад санхүүгийн хүндрэл учруулахгүйгээр хөгжиж буй орнуудад ангиллыг хэрэглэх талаар дөхөм болох бусад бүх арга хэмжээ авах;
- (iv) дэд хороо болон ажлын хэсэг байгуулах эрхтэй байна.

(4) Шинжээчдийн хороо нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална. Уг дүрмийн дагуу ангиллыг боловсронгуй болгох талаар (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан чухал үүрэг гүйцэтгэж чадах засгийн газар хоорондын байгууллагыг дэд хороо болон ажлын хэсгийн хуралдаанд оролцуулах боломжийг бүрдүүлнэ.

(5) Тусгай холбооны аливаа гишүүн орны эрх бүхий байгууллага, олон улсын товчоо, (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасны дагуу шинжээчдийн хороонд төлөөлөлтэй засгийн газар хоорондын байгууллага болон шинжээчдийн хорооноос тусгайлан санал авах зорилгоор уригдсан бусад байгууллага ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа өгч болно. Саналыг түүнийг хэлэлцэх хорооны хуралдаан эхлэхээс хоёр сарын өмнө олон улсын товчоо шинжээчдийн хорооны гишүүд, ажиглагч нарт тараана.

(6) Тусгай холбооны гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

(7) а) (b) дэд хэсэгт заасны дагуу шинжээчдийн хорооны шийдвэрийг хуралдаанд оролцогч болон санал өгч буй орнуудын олонхын саналаар батална.

б) ангилалд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах шийдвэрийг хуралдаанд оролцогч болон санал хураалтад оролцож буй тусгай холбооны гишүүн орнуудын

тавны дөрөвний саналаар батална. “Нэмэлт, өөрчлөлт” гэж бараа, үйлчилгээг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, эсхүл шинэ ангилал тогтоохыг хэлнэ.

с) (4) дэх хэсэгт заасан үйл ажиллагааны дүрэмд онцгой тохиолдлоос бусад үед ангилалд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тодорхой хугацааны эцэст батлах бөгөөд тэрхүү хугацааг шинжээчдийн хороо тогтооно.

(8) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

4 дүгээр зүйл

**Мэдэгдэл, нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох ба тэдгээрийг
хэвлэн нийтлэх**

(1) Олон улсын товчоо нь шинжээчдийн хороогоор шийдвэрлэсэн ангилалд оруулсан өөрчлөлт ба хорооны зөвлөмжийг тусгай холбооны гишүүн орнуудын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Нэмэлт, өөрчлөлт нь ийнхүү мэдэгдэл илгээсэн өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно. Аливаа бусад нэмэлт, өөрчлөлт нь тухайн нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед шинжээчдийн хорооноос тогтоосон өдрөөс хүчин төгөлдөр болно.

(2) Олон улсын товчоо нь хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтийг ангилалд тусгана. Ийм өөрчлөлтийг зарлахдаа 5 дугаар зүйлд дурдсаны дагуу Ассамблейн шийдвэрээр нийтэлнэ.

5 дугаар зүйл

Тусгай холбооны Ассамблей

(1) а) Тусгай холбоо нь энэхүү актыг баталсан буюу түүнд нэгдэн орсон орнуудаас бүрдсэн Ассамблейтай байна.

б) Тусгай холбооны гишүүн орон бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэр нь орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

с) Төлөөлөгчдийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) а) 3 ба 4 дүгээр зүйлийн заалтын дагуу Ассамблей нь:

(i) тусгай холбоог удирдах, хөгжүүлэх болон энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх бүх асуудлыг эрхлэх;

(ii) хянан өөрчлөх бага хуралд бэлтгэхтэй холбоотой асуудлаар олон улсын товчоонд чиглэл өгнө. Ингэхдээ, актад нэгдэн ороогүй, соёрхон батлаагүй орнуудаас ирүүлсэн санал, зөвлөмжийг анхаарч үзэх;

(iii) тусгай холбооны талаарх ерөнхий захирлын илтгэл, үйл ажиллагааг хянах, батлах. Тусгай холбооны эрхлэх асуудлын хүрээнд багтах аливаа асуудлаар түүнд зааварчлах;

- (iv) тусгай холбооны хөтөлбөрийг тодорхойлж, хоёр жилийн төсөв, санхүүгийн тайланг хэлэлцэн батлах;
- (v) тусгай холбооны санхүүгийн журмыг батлах;
- (vi) тусгай холбооны зорилтыг хэрэгжүүлэхэд чухал гэж үзвэл 3 дугаар зүйлийн дагуу байгуулсан шинжээчдийн хорооноос гадна бусад шинжээчдийн хороод, ажлын хэсгүүдийг байгуулах;
- (vii) тусгай холбооны гишүүн бус ямар орон, засгийн газар хоорондын байгууллага, олон улсын төрийн бус байгууллагыг Ассамблейн чуулганд ажиглагчаар оролцуулахыг шийдвэрлэх;
- (viii) 5- 8 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- (ix) тусгай холбооны зорилтыг хэрэгжүүлэхийн тулд холбогдох бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- (x) энэхүү хэлэлцээрээр түүнд хүлээлгэсэн бусад бүх үүргийг хэрэгжүүлэх.

b) Байгууллагаас удирдаж байдаг бусад холбоодод хамаарах асуудлаар Ассамблей байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжтэй танилцсаны дараа шийдвэр гаргана.

(3) a) Ассамблейн гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

b) Ассамблейн гишүүн орнуудын тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

c) Чуулганд оролцож буй орнуудын тоо Ассамблейн гишүүн орнуудын тэн хагасаас бага боловч гуравны нэгтэй тэнцүү буюу түүнээс дээш байвал (b) дэд хэсэгт заасныг үл харгалзан шийдвэр гаргаж болно. Гэвч, Ассамблейн дотоод журмын холбогдолтой шийдвэрээс бусад ийнхүү гаргасан шийдвэрүүд нь дараахь нөхцөл бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо тухайн шийдвэрийг чуулганд оролцоогүй Ассамблейн гишүүн орнуудад илгээж ийнхүү илгээснээс хойш гурван сарын хугацаанд санал өгөх буюу түдгэлзсэн тухайг бичгээр мэдэгдэхийг хүсэлт болгоно. Хэрэв энэ хугацаа өнгөрөхөд санал өгсөн буюу түдгэлзсэн орнуудын тоо чуулганыг хүчинтэйд тооцоход хүрэлцэхгүй байсан тоонд хүрсэн тохиолдолд тухайн шийдвэр олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

(d) Ассамблей нь 8 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн заалтыг харгалзан гуравны хоёрын олонхын саналаар шийдвэр гаргана.

(e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(f) Нэг төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж түүний нэрийн өмнөөс санал өгөх эрхтэй.

(g) Ассамблейн гишүүн бус тусгай холбооны гишүүн орнуудыг чуулганд ажиглагчаар оролцуулна.

(4) (a) Онцгой тохиолдлоос бусад тохиолдолд ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг байгууллагын Ерөнхий Ассамблей чуулдаг газарт болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал Ассамблейн онцгой чуулганыг Ассамблейн гишүүн орнуудын дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу зарлан хуралдуулна.

(c) Чуулган бүрийн хэлэлцэх асуудлын дэгийн төслийг ерөнхий захирал бэлтгэнэ.

(5) Ассамблей өөрийн үйл ажиллагааны журмыг батална.

6 дугаар зүйл

Олон улсын товчоо

(1) (a) Олон улсын бүртгэл, түүнтэй холбогдох ажиллагаа болон тусгай холбооны захиргааны бусад үүргийг олон улсын товчоо гүйцэтгэнэ.

(b) Олон улсын товчоо нь тухайлбал Ассамблейн болон түүний байгуулсан шинжээчдийн хороо, ажлын хэсгийн хуралдааныг бэлтгэж нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

(c) Ерөнхий захирал нь тусгай холбооны гүйцэтгэх дээд албан тушаалтан бөгөөд тусгай холбоог төлөөлнө.

(2) Ерөнхий захирал ба түүний томилсон аливаа ажилтан Ассамблейн болон түүний байгуулсан шинжээчдийн хороо, ажлын хэсгийн хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий захирал ба түүний томилсон ажилтан нь эдгээр байгууллагын нарийн бичгийн дарга байна.

(3) (a) Олон улсын товчоо нь Ассамблейн өгсөн удирдамжийн дагуу хэлэлцээрийн 5-8 дугаар зүйлээс бусад заалтыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг хангана.

(b) Олон улсын товчоо нь хянан өөрчлөх бага хуралд бэлтгэх асуудлаар засгийн газар хоорондын ба олон улсын төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал ба түүний томилсон ажилтан эдгээр бага хурлаар асуудал хэлэлцэхэд санал өгөх эрхгүйгээр оролцоно.

(4) Олон улсын товчоо нь түүнд даалгасан бусад үүргийг биелүүлнэ.

7 дугаар зүйл

Санхүү

(1) а) Тусгай холбоо нь төсөвтэй байна.

б) Тусгай холбооны төсөв нь тусгай холбооны орлого, зарлага, холбооны зардлаас холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт орох хандив, тэрчлэн байгууллагын бага хурлын төсөвт орох зардал зэргээс бүрдэнэ.

с) Зөвхөн тусгай холбоонд бус харин байгууллагын удирдлаган дор ажилладаг нэг буюу хэд хэдэн бусад холбоодод хамаарах зардлыг холбоодод хамаарах нийтийн зардал гэж үзнэ. Энэхүү нийтийн зардлаас холбоонд оногдох хувь нь тэдгээр холбоод дахь холбооны сонирхлын эзлэх хэмжээтэй адил байна.

(2) Тусгай холбооны төсвийг захиргааны үүргийг нь байгууллага гүйцэтгэдэг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) Тусгай холбооны төсөв нь дор дурдсан эх үүсвэрээс санхүүжинэ:

(i) тусгай холбооны гишүүн орнуудын татвар;

(ii) тусгай холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлж буй үйлчилгээний хураамж, төлбөр;

(iii) тусгай холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтаас олсон болон хэвлэх эрхийг шилжүүлсэнтэй холбогдох бусад орлого;

(iv) бэлэг, гэрээсэлж үлдээсэн өв, хөрөнгө, татаас;

(v) түрээс, зээлийн хүү ба бусад орлого.

(4) а) (3) дахь хэсгийн (i)-т заасан татварыг тогтоох зорилгоор тусгай холбооны гишүүн орон бүр Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Парисын холбооны ангилалтай адил ангилалд хамаарах ба тэр холбоонд тухайн ангилалд тогтоосон хэмжээгээр жилийн татвар төлнө.

б) Орон бүрийн жилийн татвар нь түүний нэгжийн тоог татвар төлж байгаа бүх орны нэгжийн нийлбэрт харьцуулах хэлбэрээр тогтоосон, холбооны төсөвт төлөх нийт татварт эзлэх хувьтай тэнцүү байна.

с) Татварыг жил бүрийн нэгдүгээр сарын нэгнээс эхэлж төлнө.

д) Өмнөх хоёр бүтэн жилд өгөх ёстой татварын хэмжээтэй тэнцүү буюу түүнээс дээш өртэй орон тусгай холбооны аливаа байгууллагад санал өгөх эрхгүй. Гэхдээ төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд тусгай холбооны аль нэг байгууллага тухайн оронд санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

е) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнөх жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Тухайн тусгай холбооны хувьд олон улсын товчооноос үзүүлж байгаа үйлчилгээний хураамж, төлбөрийг ерөнхий захирал тогтоож Ассамблейд илтгэнэ.

(6) (а) Тусгай холбоо нь холбооны гишүүн орон бүрээс өгөх нэг удаагийн төлбөрөөс бүрдэх эргэлтийн хөрөнгийн сантай байна. Хэрэв эргэлтийн хөрөнгийн сан хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(b) Дурдсан санд орон бүрийн төлөх анхны татварын хэмжээ буюу энэ санг нэмэгдүүлэхэд төлөх орон бүрийн хувь хэмжээ нь санг байгуулсан жил, эсхүл түүнийг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан жилд тухайн орноос төлөх татварын хувьтай адил байна.

(c) Энэ харьцаа, төлбөрийн нөхцөлийг ерөнхий захирлын саналын үндсэн дээр болон байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг авсны дараа Ассамблей тогтооно.

(7) а) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг оронтой байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн орон урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг тусдаа байгууллага, тухайн орон хоорондын хэлэлцээрээр зохицуулна.

b) (а) дэд хэсэгт дурдсан орон ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(8) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу холбооны нэг буюу хэд хэдэн орон эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ассамблей томилно.

8 дугаар зүйл

5-8 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

(1) 5, 6, 7 дугаар зүйл болон энэхүү зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ассамблейн гишүүн аль ч орон эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Ерөнхий захирал ийм саналыг Ассамблейн чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө Ассамблейн гишүүн орон бүрт илгээнэ.

(2) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей дөрөвний гурвын олонхын саналаар батална. Гэхдээ 5 дугаар зүйл болон энэхүү хэсэгт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтын тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед Ассамблейн гишүүн байсан орны дөрөвний гурав нь өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн

зөвшөөрсөн тухай бичгээр гаргасан мэдэгдлийг ерөнхий захирал хүлээж авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүчин төгөлдөр болох хугацаанд Ассамблейн гишүүн байсан орнууд буюу түүнээс хойш Ассамблейн гишүүн болсон бүх орон заавал дагаж мөрдөнө. Гэхдээ тусгай холбооны гишүүн орны санхүүгийн хүлээх үүргийг өндөржүүлэх талаар аливаа нэмэлт, өөрчлөлтийг тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргасан орон л дагаж мөрдөнө.

9 дүгээр зүйл

**Соёрхон батлах ба түүнд нэгдэн орох;
хүчин төгөлдөр болох**

(1) Энэхүү актад гарын үсэг зурсан тусгай холбооны орон түүнийг соёрхон батлах бөгөөд гарын үсэг зураагүй орны хувьд түүнд нэгдэн орж болно.

(2) Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч боловч тусгай холбооны гишүүн бус аливаа орон энэхүү актад нэгдэн орж болох бөгөөд ингэснээр тусгай холбооны гишүүн орон болно.

(3) Батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(4) а) Энэхүү акт нь дараахь хоёр нөхцөл хангагдсан тохиолдолд гурван сарын дараа хүчин төгөлдөр болно:

(i) зургаа буюу түүнээс дээш орон батламж жуух бичгээ буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн байх;

(ii) энэхүү акт гарын үсэг зурахад нээлттэй болох үед дээрх орнуудын наад зах нь гурав нь тусгай холбооны гишүүн орон байх.

b) (a) дэд хэсгийн дагуу хүчин төгөлдөр болох тохиолдол нь батламж жуух бичгээ буюу нэгдэн орсон баримт бичгээ энэхүү акт хүчин төгөлдөр болохоос наад зах нь гурван сарын өмнө хадгалуулахаар өгсөн орнуудад хамаарна.

c) (b) дэд хэсэгт хамаарахгүй бусад орны хувьд энэхүү акт нь хэрэв батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигт өөр хугацаа заагаагүй бол соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай ерөнхий захиралд мэдэгдэл хийсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хугацаа заасан тохиолдолд энэхүү акт нь тухайн орны хувьд уг заасан хугацаанаас хүчин төгөлдөр болно.

(5) Соёрхон баталсан буюу нэгдэн орсноор энэхүү актын бүх заалтыг шууд хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд мөн түүний давуу талыг эдлэх болно.

(6) Энэхүү актыг хүчин төгөлдөр болсны дараа энэхүү хэлэлцээрийн өмнөх аливаа актыг ямар ч орон соёрхон батлах буюу тэдгээрт нэгдэн орох эрхгүй.

10 дугаар зүйл

Хугацаа

Энэхүү хэлэлцээр нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн нэгэн адил хугацаанд үйлчилнэ.

11 дүгээр зүйл

Хянан өөрчлөх

(1) Энэхүү хэлэлцээрийг тусгай холбооны гишүүн орнуудын төлөөлөгчдийн бага хурлаар хянан өөрчилнө.

(2) Хянан өөрчлөх бага хурлыг Ассамблей зарлан хуралдуулна.

(3) 5-8 дугаар зүйлийг хянан өөрчлөх асуудлыг хянан өөрчлөх бага хурлаар эсхүл 8 дугаар зүйлийн дагуу өөрчилж болно.

12 дугаар зүйл

Цуцлах

(1) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдэл өгөх замаар энэхүү актыг цуцалж болно. Энэхүү актыг цуцалснаар тухайн орны соёрхон баталсан буюу нэгдэн орсон энэхүү хэлэлцээрийн өмнөх бүх акт болон актуудыг мөн адил цуцлах ба энэ нь зөвхөн мэдэгдэл гаргасан оронд хамаарах болно. Харин тусгай холбооны бусад орны хувьд энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр хэвээр байна.

(2) Цуцлалт ерөнхий захирал мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(3) Энэ зүйлийн дагуу олгосон цуцлах эрхийг тусгай холбооны гишүүн болсон өдрөөс хойш таван жилийн хугацаанд ямар ч орон эдлэхгүй.

13 дугаар зүйл

Парисын конвенцийн 24 дүгээр зүйлд хамаарах

Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 1967 оны Стокгольмын актын 24 дүгээр зүйлийн заалт нь энэхүү хэлэлцээрт дараахь тохиолдолд, тухайлбал цаашид тус заалтад нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн энэ өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тусгай холбооны гишүүн орнуудад хамаарна.

14 дүгээр зүйл

Гарын үсэг зурах; хэл; хадгалагчийн үүрэг; мэдэгдэл

(1) а) Энэхүү актыг англи, франц хэлээр нэг хувь үйлдэн гарын үсэг зурах бөгөөд хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна. Эх бичвэрүүдийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

б) Албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч орны засгийн газартай зөвлөлдсөний дараа энэхүү актад гарын үсэг зурснаас хойш хоёр сарын хугацаанд (а) дэд хэсэгт дурдсан бусад хэлний хамт орос, испани хэлээр гаргах бөгөөд Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенцийн албан ёсны эх бичвэрийг дээр дурдсан хэлээр үйлдэн гарын үсэг зурсан байна.

с) Албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч орны засгийн газартай зөвлөлдсөний дараа араб, герман, итали, португали хэлээр болон Ассамблейгаас тогтоосон бусад хэлээр гаргана.

(2) Энэхүү акт 1977 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

(3) а) Ерөнхий захирал өөрийн баталгаажуулсан, гарын үсэг зурсан энэхүү актын хоёр хувийг тусгай холбооны гишүүн бүх орны засгийн газарт, мөн хүсэлт гаргасан бусад аль ч орны засгийн газарт илгээнэ.

б) Ерөнхий захирал өөрийн баталгаажуулсан, энэхүү актад оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийн хоёр хувийг тусгай холбооны бүх орны засгийн газарт болон хүсэлт гаргасан бусад орны засгийн газарт илгээнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү актыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч бүх гишүүн орны засгийн газарт дараахь зүйлийг мэдэгдэнэ:

- (i) (1) дэх хэсэгт заасны дагуу гарын үсэг зурсан тухай;
- (ii) 9 дүгээр зүйлийн (3) дахь хэсгийн дагуу хадгалуулахаар өгсөн батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийн тухай;
- (iii) 9 дүгээр зүйлийн (4) дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу хүчин төгөлдөр болсон он, сар, өдөр;
- (iv) 8 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн дагуу энэхүү актад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн баримт бичиг;
- (v) эдгээр нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон он, сар, өдөр;
- (vi) 12 дугаар зүйлийн дагуу хүлээн авсан цуцлалт.

**65. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ ТОГТООХ ТУХАЙ
ЛОКАРНОГИЙН ХЭЛЭЛЦЭЭР***

*1968 оны 10 дугаар сарын 8-нд Локарнод гарын үсэг зурж,
1979 оны 9 дүгээр сарын 28-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар*

1 дүгээр зүйл

Тусгай холбоо байгуулах: Олон улсын ангиллыг батлах

- (1) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлж буй орнууд тусгай холбоо байгуулна.
- (2) Эдгээр орон бүтээгдэхүүний загварын нийтлэг ангиллыг (цаашид "олон улсын ангилал" гэнэ) батална.
- (3) Олон улсын ангилалд дараахь зүйлийг багтаана. Үүнд:
 - (i) ангилал болон дэд ангиллын жагсаалт;
 - (ii) бүтээгдэхүүний загварыг агуулсан барааны цагаан толгойн дараалал бүхий жагсаалт, чингэхдээ тэдгээр нь хамаарагдах ангилал болон дэд ангиллыг заасан байна;
 - (iii) тайлбар бичиг.
- (4) Ангилал болон дэд ангиллын жагсаалт гэж 3 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан шинжээчдийн хороо /цаашид "шинжээчдийн хороо" гэнэ/ оруулж болох нэмэлт, өөрчлөлт бүхий энэхүү хэлэлцээрт хавсаргасан жагсаалтыг хэлнэ.
- (5) Барааны цагаан толгойн үсгийн дараалал бүхий жагсаалт болон тайлбар бичгийг 3 дугаар зүйлд заасан журмын дагуу шинжээчдийн хороо батална.
- (6) 3 дугаар зүйлд заасан журмын дагуу шинжээчдийн хороо олон улсын ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- (7)
 - a) олон улсын ангиллыг англи ба франц хэлээр үйлдэнэ.
 - b) 5 дугаар зүйлд дурдсан Ассамблейгаас тогтоох олон улсын ангиллын бусад хэлээрх албан ёсны бичвэрийг Дэлхийн оюуны өмчийн байгууллага /цаашид "байгууллага" гэнэ/ байгуулах тухай конвенцид дурдсан Оюуны өмчийн олон улсын товчоо /цаашид "олон улсын товчоо" гэнэ/ сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний үндсэн дээр тогтооно.

2 дугаар зүйл

Ангиллыг хэрэглэх ба олон улсын ангиллын эрх зүйн хүрээ

* Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр соёрхон баталсан

(1) Энэхүү хэлэлцээрт тусгагдсан шаардлагын дагуу олон улсын ангилал нь зөвхөн захиргааны шинжтэй байна. Тэгэхдээ тухайн орон бүр түүнийг зохистой гэж үзсэн эрх зүйн хүрээнд хамааруулж болно. Тухайлбал, олон улсын ангилал нь тусгай холбооны гишүүн оронд бүтээгдэхүүний загварт олгож буй хамгаалалтын мөн чанар, хүрээний хувьд үүрэг хүлээлгэхгүй.

(2) Тусгай холбооны гишүүн орон бүр олон улсын ангиллыг үндсэн буюу туслах тогтолцоо болгон хэрэглэх эрхээ хадгална.

(3) Тусгай холбооны гишүүн орны байгууллага нь загвар хадгалуулах буюу бүртгүүлэх албан ёсны баримт бичигт, хэрэв албан ёсоор хэвлэгдсэн бол тус хэвлэлд, тухайн загвар бүхий бараа хамаарагдах олон улсын ангиллын ангилал буюу дэд ангиллын тоог тусгана.

(4) Шинжээчдийн хороо нь барааны цагаан толгойн үсгийн дараалал бүхий жагсаалтад оруулах нэр томъёог сонгохдоо онцгой эрх агуулж болох нэр томъёог хэрэглэхээс зайлсхийх талаар тодорхой хэмжээгээр анхаарна. Цагаан толгойн үсгийн дараалал бүхий жагсаалтад аливаа үг оруулах нь онцгой эрхэд хамаарах эсэхээс үл шалтгаалан шинжээчдийн хорооны саналын илэрхийлэл болохгүй.

3 дугаар зүйл

Шинжээчдийн хороо

(1) Шинжээчдийн хороо нь 1 дүгээр зүйлийн (4), (5) болон (6) дахь хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлнэ. Тусгай холбооны гишүүн орон бүр оролцогч орнуудын энгийн олонхоор баталсан үйл ажиллагааны журмын дагуу зохион байгуулах шинжээчдийн хороонд төлөөлөлтэй байна.

(2) Шинжээчдийн хороо нь тусгай холбооны гишүүн орнуудын энгийн олонхын саналаар цагаан толгойн үсгийн дараалал бүхий жагсаалт болон тайлбар бичгийг батална.

(3) Олон улсын ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тусгай холбооны аливаа гишүүн орны байгууллага эсхүл олон улсын товчоо гаргана. Санал гаргаж буй байгууллага энэ тухайгаа олон улсын товчоонд мэдэгдэнэ. Байгууллага буюу олон улсын товчооны саналыг олон улсын товчоо тухайн саналыг хэлэлцэх хорооны хуралдаан эхлэхээс хоёр сараас доошгүй хугацааны өмнө шинжээчдийн хорооны гишүүдэд хүргүүлнэ.

(4) Олон улсын ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шинжээчдийн хорооны шийдвэрийг тусгай холбооны гишүүн орнуудын энгийн олонхоор батална. Гэхдээ дээрх шийдвэрээр шинэ ангилал бий болгох буюу барааг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх тохиолдолд нэгдмэл санал шаардлагатай.

(5) Шинжээч бүр шуудангаар санал өгөх эрхтэй.

(6) Хэрэв аливаа орон шинжээчдийн хорооны тухайн хуралдаанд төлөөлөгч томилоогүй, эсхүл томилогдсон шинжээч нь хуралдааны үеэр буюу шинжээчдийн

хорооны үйл ажиллагааны журмаар тогтоосон хугацаанд өөрийн саналаа өгөөгүй бол, тухайн орон хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

4 дүгээр зүйл

Ангилал болон түүний нэмэлт, өөрчлөлтийн тухай мэдэгдэх, хэвлэн нийтлэх

(1) Олон улсын товчоо нь шинжээчдийн хороогоор баталсан цагаан толгойн үсгийн дараалал бүхий барааны жагсаалт, тайлбар бичиг болон хорооны шийдвэрлэсэн олон улсын ангилалд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг тусгай холбооны гишүүн орнуудын байгууллагад хүргүүлнэ. Шинжээчдийн хорооны шийдвэр нь мэдэгдэл хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Хэрэв дээрх шийдвэрээр шинэ ангилал бий болгох буюу барааг нэг ангиллаас нөгөө ангилалд шилжүүлэх бол, тэр нь мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс зургаан сарын хугацаанд хүчин төгөлдөр болно.

(2) Олон улсын товчоо нь олон улсын ангиллын хадгалагчийн хувьд хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтийг тус ангилалд тусгана. Нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг Ассамблейн тогтоосон хэвлэлд нийтэлж зарлана.

5 дугаар зүйл

Тусгай холбооны Ассамблей

(1) а) Тусгай холбоо нь тусгай холбооны гишүүн орнуудаас бүрдсэн Ассамблейтай байна.

б) Орон бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

в) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) а) 3 дугаар зүйлийн заалтын дагуу Ассамблей нь:

(i) тусгай холбоог удирдах, хөгжүүлэх болон энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх бүх асуудлыг эрхэлнэ;

(ii) хянан өөрчлөх бага хуралд бэлтгэхтэй холбоотой асуудлаар олон улсын товчоонд чиглэл өгнө;

(iii) байгууллагын ерөнхий захирал /цаашид “ерөнхий захирал” гэнэ/-ын тусгай холбооны талаар явуулсан үйл ажиллагааны тайланг хянаж батлах, холбооны эрх мэдэлд багтах бүх асуудлаар шаардлагатай бүх зааврыг түүнд өгнө;

(iv) тусгай холбооны хөтөлбөрийг тодорхойлж, хоёр жилийн төсөв болон түүний санхүүгийн тайланг батална;

- (v) тусгай холбооны санхүүгийн журмыг батална;
 - (vi) англи ба франц хэлнээс бусад хэлээрх олон улсын ангиллын албан ёсны бичвэрийг тогтоох асуудлыг шийдвэрлэнэ;
 - (vii) 3 дугаар зүйлийн дагуу байгуулсан шинжээчдийн хорооноос гадна тусгай холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзэх бусад шинжээчдийн хороо, ажлын хэсэг байгуулна;
 - (viii) холбооны гишүүн бус ямар орон, түүнчлэн ямар засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагыг түүний чуулганд ажиглагчаар оролцуулж болохыг тодорхойлно;
 - (ix) 5- 8 дугаар зүйлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батална;
 - (x) тусгай холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа шаардлагатай бусад арга хэмжээ авна;
 - (xi) энэхүү хэлэлцээрийн дагуух бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ;
- b) Байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын сонирхсон асуудлын хувьд Ассамблей зохицуулах хорооны зөвлөмжийг сонссоны дараа шийдвэр гаргана.
- (3) a) Ассамблейн гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.
- b) Ассамблейн гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.
- c) (b) дэд хэсгийг үл харгалзан аль нэг чуулганд Ассамблейн нийт гишүүн орны тэн хагасаас бага боловч гуравны нэг буюу түүнээс илүү гишүүн орон төлөөлөгчдөө ирүүлсэн бол Ассамблей өөрийн ажиллагааны журамд хамаарахаас бусад бүх шийдвэр гаргаж болно. Ийм шийдвэр нь гагцхүү дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо нь чуулганд оролцоогүй Ассамблейн гишүүн орнуудад дээр дурдсан шийдвэрийг илгээж, уг шийдвэрийг илгээснээс хойш гурван сарын дотор эдгээр шийдвэрт санал өгч, түдгэлзсэн эсэх тухай саналаа бичгээр ирүүлэхийг хүснэ. Тогтоосон хугацаа өнгөрөх үед энэ журмаар саналаа өгсөн буюу түдгэлзсэнээ мэдэгдсэн орны тоо чуулган хүчинтэй болоход дутуу байсан тоонд хүрч байвал зохих олонхи байна гэж үзэж шийдвэр хүчин төгөлдөр болно.
- d) 8 дугаар зүйлийн (2) дахь хэсгийг харгалзан Ассамблей нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрээ гаргана.
- e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.
- f) Нэг төлөөлөгч нэг орныг төлөөлж зөвхөн түүний өмнөөс саналаа өгнө.

(4) а) Онцгой тохиолдлоос бусад тохиолдолд ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулдаг газарт болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулна.

б) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны буюу Ассамблейн гишүүн орны дөрөвний нэгийн хусэлтийн дагуу ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.

с) Ерөнхий захирал хуралдаан бүрийн хэлэлцэх асуудлыг бэлтгэнэ.

(5) Ассамблей өөрийн ажиллагааны журмыг батална.

6 дугаар зүйл

Олон улсын товчоо

(1) а) Тусгай холбооны захиргааны асуудлыг олон улсын товчоо эрхэлнэ.

б) Түүнчлэн олон улсын товчоо нь уулзалт, хуралдаанд бэлтгэх, Ассамблейн болон шинжээчдийн хороо, ажлын хэсгүүдийн нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

с) Ерөнхий захирал тусгай холбооны гүйцэтгэх тэргүүн болох бөгөөд холбоог төлөөлнө.

(2) Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа ажилтан Ассамблей, гүйцэтгэх хорооны болон аливаа бусад шинжээчдийн хороо, ажлын хэсгийн бүх хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий захирал болон түүний томилсон ажилтан өөрийн албан тушаалын дагуу эдгээр байгууллагын нарийн бичгийн дарга байна.

(3) а) Олон улсын товчоо Ассамблейгаас өгсөн чиглэлийн дагуу хэлэлцээрийн 5-8 дугаар зүйлээс бусад заалтыг хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг хангана.

б) Олон улсын товчоо нь хянан өөрчлөх бага хуралд бэлтгэх асуудлаар засгийн газар хоорондын ба олон улсын төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

с) Ерөнхий захирал болон түүний томилсон ажилтан тэдгээр бага хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

(4) Олон улсын товчоо түүнд оногдуулсан бусад бүх даалгаврыг гүйцэтгэнэ.

7 дугаар зүйл

Санхүү

(1) а) Тусгай холбоо нь төсөвтэй байна.

b) Тусгай холбооны төсөв нь холбооны орлого, зарлага, холбооны зардлаас холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт орох хандив, тэрчлэн байгууллагын бага хурлын төсөвт орох зардал зэргээс бүрдэнэ.

c) Тусгай холбоонд бус харин байгууллагын удирдлаган дор ажилладаг нэг буюу хэд хэдэн бусад холбоодод хамаарах зардлыг холбоодод хамаарах нийтийн зардал гэж үзнэ. Энэхүү нийтийн зардлаас тусгай холбоонд оногдох хувь нь тэдгээр холбоод дахь тусгай холбооны сонирхлын эзлэх хэмжээтэй адил байна.

(2) Тусгай холбооны төсвийг байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) Тусгай холбооны төсөв дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

- (i) холбооны гишүүн орнуудын татвар;
- (ii) холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамж;
- (iii) холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтын үнэ, түүнийг ашиглуулсны хураамж;
- (iv) бэлэг, гэрээслэлээр шилжүүлсэн зүйл, татаас;
- (v) түрээс, зээлийн хүү болон бусад орлого.

(4) а) (3) дахь хэсгийн i-т заасан татварыг тогтоох зорилгоор тусгай холбооны гишүүн бүр Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид заасантай адил нэг ангилалд хамаарах бөгөөд тэр холбоонд тухайн ангилалд тогтоосон нэгжийн хэмжээгээр жилийн татвараа төлнө.

b) Тусгай холбооны гишүүн орон бүрийн жилийн татвар нь түүний нэгжийн тоог татвар төлж буй бүх орны нэгжийн нийлбэрт харьцуулах хэлбэрээр тогтоосон тусгай холбооны төсөвт төлөх нийт татварт эзлэх хувьтай тэнцүү байна.

c) Татварыг жил бүрийн нэгдүгээр сарын нэгнээс эхэлж төлнө.

d) Өмнөх хоёр бүтэн жилд өгөх ёстой татварын хэмжээтэй тэнцүү буюу түүнээс дээш өртэй орон тусгай холбооны аливаа байгууллагад санал өгөх эрхгүй. Гэхдээ төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд тусгай холбооны аль нэг байгууллага тухайн оронд санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

e) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнөх жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Тусгай холбооны нэрийн өмнөөс олон улсын товчооны үзүүлсэн үйлчилгээний төлбөрт авах төлбөр, хураамжийн хэмжээг ерөнхий захирал тогтоож Ассамблейд тайлагнана.

(6) а) Тусгай холбоо нь тусгай холбооны гишүүн орон бүрээс өгөх нэг удаагийн төлбөрөөс бүрдэх эргэлтийн хөрөнгийн сантай байна. Хэрэв эргэлтийн хөрөнгийн сан хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

б) Дурдсан санд орон бүрийн төлөх анхны татварын хэмжээ буюу энэ санг нэмэгдүүлэхэд төлөх орон бүрийн хувь хэмжээ нь санг байгуулсан жил, эсхүл түүнийг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан жилд тухайн орноос төлөх татварын хувьтай адил байна.

с) Энэ харьцаа болон төлбөрийн нөхцөлийг ерөнхий захирлын саналын үндсэн дээр байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг авсны дараа Ассамблей тогтооно.

(7) а) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг оронтой байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн орон урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг байгууллага, тухайн орон хоорондын тусгай хэлэлцээрээр зохицуулна.

(б) (а) дэд хэсэгт дурдсан орон ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт нь мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(8) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу тусгай холбооны нэг буюу хэд хэдэн орон эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ассамблей томилно.

8 дугаар зүйл

5-8 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах

(1) 5, 6, 7 дугаар зүйл болон энэхүү зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тусгай холбооны гишүүн аль ч орон эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Ерөнхий захирал ийм саналыг Ассамблейн чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө тусгай холбооны гишүүн орон бүрт илгээнэ.

(2) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей дөрөвний гурвын олонхын саналаар батална. Гэхдээ 5 дугаар зүйл болон энэхүү хэсэгт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтын тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед тусгай холбооны гишүүн байсан орны дөрөвний гурав нь өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр гаргасан мэдэгдлийг ерөнхий захирал хүлээж авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно. Дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүчин төгөлдөр болох хугацаанд тусгай холбооны гишүүн байсан орнууд буюу түүнээс хойш тусгай холбооны гишүүн болсон бүх орон заавал дагаж мөрдөнө. Гэхдээ тусгай холбооны гишүүн орны санхүүгийн хүлээх үүргийг

өндөржүүлэх талаар аливаа нэмэлт, өөрчлөлтийг тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргасан орон л дагаж мөрдөнө.

9 дүгээр зүйл

Хэлэлцээрийг соёрхон батлах, түүнд нэгдэн орох, хүчин төгөлдөр болох

(1) Энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч аливаа орон түүнийг соёрхон баталж болох бөгөөд хэрэв түүнд гарын үсэг зураагүй бол түүнд нэгдэн орж болно.

(2) Батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(3) а) Энэхүү хэлэлцээр батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн эхний таван орны хувьд ийм тав дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

б) Аливаа бусад орны хувьд энэхүү хэлэлцээр нь хэрэв батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй бол соёрхон баталсан буюу нэгдэн орсон талаар ерөнхий захирал мэдэгдэл хийсэн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Хэрэв дээрх баримт бичигтээ аливаа орон илүү хожуу хугацааг заасан бол энэхүү хэлэлцээр тухайн орны хувьд уг заасан өдөрт хүчин төгөлдөр болно.

(4) Соёрхон батлах буюу нэгдэн орсноор энэхүү хэлэлцээрийн бүх заалтуудыг хүлээн зөвшөөрөх бөгөөд түүгээр олгох бүх давуу талыг эдэлнэ.

10 дугаар зүйл

Хэлэлцээр хүчин төгөлдөр байх хугацаа

Энэхүү хэлэлцээр нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн нэгэн адил хүчинтэй бөгөөд түүний ижил хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

11 дүгээр зүйл

1-4 ба 9-15 зүйлийг хянан өөрчлөх

(1) Энэхүү хэлэлцээрийн 1-4 ба 9-15 дугаар зүйлийг боловсронгуй болгох зорилгоор хянан өөрчилж болно.

(2) Хянан өөрчлөх аливаа асуудлыг тусгай холбооны гишүүн орнуудын төлөөлөгчдийн бага хурлаар хэлэлцэнэ.

12 дугаар зүйл

Хэлэлцээрийг цуцлах

(1) Аливаа орон ерөнхий захиралд мэдэгдэл илгээснээр энэхүү хэлэлцээрийг цуцалж болно. Тийм цуцлалт нь зөвхөн тухайн оронд хамаарах бөгөөд тусгай холбооны бусад орны хувьд хэлэлцээр хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.

(2) Цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(3) Энэхүү зүйлд заасан цуцлах эрх аль ч оронд тусгай холбооны гишүүн болсон өдрөөс хойш таван жилийн хугацаа дуусахаас өмнө үүсэхгүй.

13 дугаар зүйл

Нутаг дэвсгэр

Энэхүү хэлэлцээрт Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 24 дүгээр зүйлийн заалтыг хэрэглэнэ.

14 дүгээр зүйл

Гарын үсэг, хэл, мэдэгдэл

(1) а) Энэхүү хэлэлцээрийг англи, франц хэлээр нэг хувь үйлдэж гарын үсэг зурах бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Эх бичвэрийг Швейцарийн Холбооны Улсын Засгийн газарт хадгалуулахаар өгнө.

б) Энэхүү хэлэлцээр нь 1969 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл Берн хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна.

(2) Албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний дараа Ассамблейгаас тогтоох бусад хэлээр гаргана.

(3) Энэхүү хэлэлцээрийн гарын үсэг зурсан, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газраас баталгаажуулсан хоёр хувийг ерөнхий захирал тусгай холбооны гишүүн бүх орны засгийн газарт болон хүсэлт гаргасан бусад орны засгийн газарт илгээнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү хэлэлцээрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал гарын үсэг зурсан болон батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай, хэлэлцээр хүчин төгөлдөр болсон тухай, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулсныг хүлээн зөвшөөрсөн тухай, нэмэлт өөрчлөлт орсон өдрийн тухай, цуцалсан тухай мэдэгдлийн талаар тусгай холбооны гишүүн бүх орны засгийн газарт мэдэгдэнэ.

15 дугаар зүйл

Шилжилтийн заалт

Анхны ерөнхий захирал албан тушаалдаа орох хүртэл энэхүү хэлэлцээрт дурдсан байгууллагын олон улсын товчооны, эсхүл ерөнхий захирлын талаарх тайлбарыг Оюуны өмчийг хамгаалах олон улсын нэгдсэн товчоо (БИРПИ)-ны эсхүл түүний захирлын талаарх тайлбар гэж үзнэ.

66. ПАТЕНТЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ*

1970 оны 6 дугаар сарын 19-ны өдөр Вашингтонд үйлдэж, 1979 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, 1984 оны 2 дугаар сарын 3-ны өдөр, 2001 оны 10 дугаар сарын 3-ны өдөр өөрчлөлт оруулсан байдлаар.

УДИРТГАЛ

Хэлэлцэн тохирогч улсууд,

шинжлэх ухаан, техникийн дэвшилд хувь нэмэр оруулахыг хүсэж, шинэ бүтээлийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгохыг хүсэн,

хэд хэдэн оронд ингэж хамгаалуулахыг хүсвэл шинэ бүтээлийн хамгаалалтыг хялбарчлах болон илүү хэмнэлттэй болгохыг эрмэлзэн,

шинэ бүтээлийг тайлбарласан баримт бичгүүдэд агуулагдаж буй техникийн мэдээллийг нийтэд хүргэхийг хөнгөвчлөх болон түргэтгэхийг эрмэлзэн,

үндэсний, бүс нутгийн аль алиных нь шинэ бүтээлийн хамгаалалтын эрхзүйн тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах замаар болон тэдний өвөрмөц хэрэгцээнд нийцсэн техникийн шийдлийн тухай мэдээллийг илүү түргэн олж авах боломжоор хангах, орчин үеийн техникийн байнга өсөн нэмэгдэж байгаа ололттой танилцах явдлыг хөнгөвчлөх аргаар хөгжиж буй орны эдийн засгийн дэвшилд түлхэц өгч, хурдасгахыг хүсэн,

улс орнуудын хоорондын хамтын ажиллагаа энэ зорилгод хүрэхэд үлэмж хэмжээгээр дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэн,

энэхүү гэрээг байгуулав.

ОРШИЛ

1 дүгээр зүйл.

Холбоо байгуулах

(1) Энэхүү гэрээнд оролцогч талууд (цаашид “хэлэлцэн тохирогч улсууд” гэнэ) нь шинэ бүтээлийг хамгаалах мэдүүлэг гаргах, мэдүүлэгт хайлт, шүүлт хийх, түүнчлэн техникийн тусгай үйлчилгээ үзүүлэх салбарт хамтран ажиллахын тулд холбоо байгуулав. Энэ холбоог олон улсын патентын хамтын ажиллагааны холбоо гэж нэрлэнэ.

* Монгол Улс 1991 оны 2 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон

(2) Энэхүү гэрээний аливаа заалт нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч орны аливаа харьяат эсхүл тухайн оронд оршин суугаа хүний уг конвенцид заасан эрхийн хязгаарлалт гэж ойлгогдох ёсгүй.

2 дугаар зүйл

Тодорхойлолт

Өөрөөр тайлбарлаагүй бол энэхүү гэрээ, журмын зорилгоор:

- (i) "мэдүүлэг" гэж шинэ бүтээлийг хамгаалах талаар гаргасан мэдүүлгийг хэлэх бөгөөд "мэдүүлгийг нэр заах" гэж патент, зохиогчийн гэрчилгээ, ашигтай байдлын гэрчилгээ, ашигтай загвар, нэмэлт патент эсхүл гэрчилгээ, зохиогчийн нэмэлт гэрчилгээ болон ашигтай байдлын нэмэлт гэрчилгээний талаар гаргасан мэдүүлгийг нэр заахыг хэлнэ;
- (ii) "патентыг нэр заах" гэж патент, зохиогчийн гэрчилгээ, ашигтай байдлын гэрчилгээ, ашигтай загвар, нэмэлт патент эсхүл гэрчилгээ, зохиогчийн нэмэлт гэрчилгээ болон, ашигтай байдлын нэмэлт гэрчилгээг нэр заахыг хэлнэ;
- (iii) "үндэсний патент" гэж үндэсний байгууллагаас олгосон патентыг хэлнэ;
- (iv) "бүс нутгийн патент" гэж нэгээс олон улсад үйлчлэх патент олгох эрх бүхий үндэсний болон засгийн газар хоорондын байгууллагаас олгосон патентыг хэлнэ;
- (v) "бүс нутгийн мэдүүлэг" гэж бүс нутгийн патент хүсэх мэдүүлгийг хэлнэ;
- (vi) "үндэсний мэдүүлгийг нэр заах" гэж энэхүү гэрээний дагуу гаргасан мэдүүлгээс бусад үндэсний патент, бүс нутгийн патентын мэдүүлгийг нэр заасныг ойлгоно;
- (vii) "олон улсын мэдүүлэг" гэж энэхүү гэрээний дагуу гаргасан л мэдүүлгийг хэлнэ;
- (viii) "мэдүүлгийг нэр заах" гэж олон улсын болон үндэсний мэдүүлгийг нэр заасныг ойлгоно;
- (ix) "патентыг нэр заах" гэж үндэсний патент, бүс нутгийн патентыг нэр заасныг ойлгоно;
- (x) "үндэсний хууль тогтоомжийг нэр заах" гэж хэлэлцэн тохиролцогч улсын үндэсний хууль тогтоомж эсхүл бүс нутгийн мэдүүлэг, бүс нутгийн патентын тухай яригдаж байгаа бол бүс нутгийн мэдүүлэг гаргах эсхүл бүс нутгийн патент олгох тухай гэрээг нэр заасныг ойлгоно;

- (xi) хугацаа тооцох “давамгайлах огноо” гэж:
- (a) хэрэв олон улсын мэдүүлэгт 8 дугаар зүйлийн дагуу давуу эрх хүссэн байвал ийм журмаар давуу эрх хүссэн мэдүүлэг гаргасан огноог;
- (b) хэрэв олон улсын мэдүүлэгт 8 дугаар зүйлийн дагуу хэд хэдэн давуу эрх хүссэн байвал ийм журмаар давуу эрх хүссэн анхны мэдүүлэг гаргасан огноог;
- (c) хэрэв олон улсын мэдүүлэгт 8 дугаар зүйлийн дагуу давуу эрх хүсээгүй байвал уг мэдүүлгийг олон улсын хэмжээнд гаргасан огноог;
- (xii) "үндэсний байгууллага" гэж хэлэлцэн тохирогч улсын патент олгох эрх бүхий засгийн газрын байгууллагыг хэлнэ, "үндэсний байгууллагыг нэр заах" гэж наад зах нь нэг нь хэлэлцэн тохирогч улс байх хэд хэдэн улсаас олгосон бүс нутгийн патент олгох, үндэсний байгууллагын энэхүү гэрээ, журмаар тогтоосон үүргийг өөртөө хүлээж, эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий засгийн газар хоорондын аливаа байгууллагыг нэр заахыг мөн адил ойлгоно;
- (xiii) "нэрлэсэн байгууллага" гэж тухайн улсын үндэсний байгууллагыг эсхүл энэхүү гэрээний I бүлгийн дагуу мэдүүлэг гаргагчийн нэр заасан улсын нэрийн өмнөөс ажиллаж буй үндэсний байгууллагыг хэлнэ;
- (xiv) "сонгосон байгууллага" гэж тухайн улсын үндэсний байгууллагыг эсхүл энэхүү гэрээний II бүлгийн дагуу мэдүүлэг гаргагчийн сонгосон улсын нэрийн өмнөөс ажиллаж байгаа үндэсний байгууллагыг хэлнэ;
- (xv) "хүлээн авагч байгууллага" гэж олон улсын мэдүүлэг хүлээн авч байгаа үндэсний байгууллага эсхүл засгийн газар хоорондын байгууллагыг хэлнэ;
- (xvi) "холбоо" гэж олон улсын патентын хамтын ажиллагааны холбоог хэлнэ;
- (xvii) "Ассамблей" гэж холбооны Ассамблейг хэлнэ;
- (xviii) "байгууллага" гэж дэлхийн оюуны өмчийн байгууллагыг хэлнэ;
- (xix) "олон улсын товчоо" гэж байгууллагын олон улсын товчоо болон оюуны өмчийг хамгаалах олон улсын нэгдсэн товчоо (БИРПИ) оршин тогтнож байгаа тохиолдолд олон улсын нэгдсэн товчоог хэлнэ;
- (xx) "ерөнхий захирал" гэж байгууллагын ерөнхий захирал хийгээд (БИРПИ) оршин тогтнож байгаа тохиолдолд олон улсын нэгдсэн товчооны захирлыг хэлнэ.

**I БҮЛЭГ
ОЛОН УЛСЫН МЭДҮҮЛЭГ, ОЛОН УЛСЫН ХАЙЛТ**

3 дугаар зүйл

Олон улсын мэдүүлэг

(1) Хэлэлцэн тохирогч улсын алинд нь ч шинэ бүтээл хамгаалах мэдүүлгийг энэхүү гэрээний дагуу олон улсын мэдүүлэг болгон гаргаж болно.

(2) Энэхүү гэрээ, журамд тодорхойлсноор олон улсын мэдүүлэг нь мэдүүлэг, шинэ бүтээлийн тодорхойлолт, шинэ бүтээлийн нэг эсхүл хэд хэдэн томъёолол, нэг эсхүл хэд хэдэн зураглал (хэрэв шаардлагатай бол), товч тайлбарыг багтаасан байвал зохино.

(3) Товч тайлбар нь гагцхүү техникийн мэдээллийн зорилгод үйлчлэх бөгөөд бусад зорилгоор тухайлбал, хүсэлт болгосон хамгаалалтын хэмжээг тайлбарлахад хэрэглэгдэх ёсгүй.

(4) Олон улсын мэдүүлэг нь:

- (i) тогтоосон хэлээр бичигдсэн байх;
- (ii) олон улсын мэдүүлэг гаргах тогтоосон шаардлагад нийцсэн байх;
- (iii) шинэ бүтээлийн нэгдмэл байдлын тогтоосон шаардлагад нийсэн байх;
- (iv) тогтоосон хураамж төлөгдсөн байх ёстой.

4 дүгээр зүйл

Өргөдөл

(1) Өргөдөл нь дараахь зүйлээс бүрдэнэ:

- (i) олон улсын мэдүүлгийг энэхүү гэрээний дагуу хянан хэлэлцэх тухай хүсэлт;
- (ii) олон улсын мэдүүлгийн үндсэн дээр шинэ бүтээлийн хамгаалалт хийлгэхийг хүсэж байгаа улс эсхүл эсхүл хэлэлцэн тохирогч улсуудыг ("нэрлэсэн улсууд") нэрлэсэн байх; хэрэв нэрлэсэн аль нэг улсын тухайд бүс нутгийн патент хүсэх боломжтой бөгөөд мэдүүлэг гаргагч үндэсний патент бус бүс нутгийн патент авахыг хүсэж байгаа бол мэдүүлэгт энэ тухайгаа тайлбарласан байвал зохино; хэрэв мэдүүлэг гаргагч бүс нутгийн патентын тухай гэрээний дагуу мэдүүлгээ энэхүү гэрээнд оролцогч зарим улсаар хязгаарлах боломжгүй бол

эдгээр улсаас аль нэгийг нь нэрлэсэн нь болон бүс нутгийн патент авах тухай хүсэлт нь энэ гэрээнд оролцогч бүх улсыг нэрлэсэнтэй адил тооцогдоно; хэрэв нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн улсыг нэрлэх нь бүс нутгийн патентын мэдүүлэгтэй адил хүчинтэй бол ингэж нэрлэсэн нь бүс нутгийн патент авах хүсэлтэд тооцогдоно;

- (iii) мэдүүлэг гаргагч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн (хэрэв байгаа бол) нэр, бусад тогтоосон мэдээ баримт;
- (iv) шинэ бүтээлийн нэр;
- (v) хэрвээ нэрлэсэн улсуудын наад зах нь нэгнийх нь үндэсний хууль тогтоомж зохион бүтээгчийн нэр болон түүний тухай бусад тогтоосон мэдээ баримтыг үндэсний мэдүүлгийн хамт ирүүлэхийг шаарддаг бол дурьдсан мэдээ баримтуудаас бүрдэнэ.

Ингээгүй тохиолдолд үндэсний хууль тогтоомж нь уг мэдээ баримтуудыг ирүүлэхийг шаарддаг боловч тэдгээрийг үндэсний мэдүүлэг өгсний дараа ирүүлэхийг зөвшөөрдөг улсын нэрлэсэн байгууллага бүрд илгээсэн мэдүүлгээр эсхүл тусгай захидлаар дурдсан мэдээ баримтуудыг хүргүүлж болно.

(2) Хэлэлцэн тохирогч улс бүрийг нэрлэсний тогтоосон хураамж нь тогтоосон хугацаанд төлөгдөнө.

(3) Хэрвээ мэдүүлэг гаргагч 43 дугаар зүйлд дурьдсан хамгаалалтын аль нэг хэлбэрийг хүсээгүй бол нэрлэсэн улсаас эсхүл энэ улсын хувьд патент олгох явдал нь хүссэн хамгаалалт болох ба үүнийг улсыг нэрлэсэн гэж ойлгоно. Энэхүү зүйлийг мөрдөх зорилгоор 2 дугаар зүйлийн (ii) заалтыг хэрэглэхгүй.

(4) Зохион бүтээгчийн нэр болон түүний тухай бусад тогтоосон мэдээ баримтыг өргөдөлд тусгаагүй нь үндэсний хууль тогтоомж нь ийм мэдээ баримт ирүүлэхийг шаарддаг боловч түүнийг үндэсний мэдүүлэг гаргасны дараа ирүүлэхийг зөвшөөрдөг нэр заасан аливаа улсад ямар ч үр дагавар үүсгэхгүй. Дурдсан мэдээ баримтыг тусгай захидлаар хүргүүлээгүй нь үндэсний хууль тогтоомж нь ингэж хүргүүлэхийг шаарддаггүй, нэр заасан аливаа улсад ямар ч үр дагавар үүсгэхгүй.

5 дугаар зүйл

Шинэ бүтээлийн тодорхойлолт

Тодорхойлолт нь шинэ бүтээлийг тухайн салбарын мэргэжилтэн хэрэгжүүлж чадахуйц тодорхой, бүрэн хэмжээнд нээн харуулсан байвал зохино.

6 дугаар зүйл

Шинэ бүтээлийн томьёолол

Шинэ бүтээлийн томьёоллын заалтууд нь хамгаалалт хийлгэх объектыг тодорхойлно. Шинэ бүтээлийн томьёоллын заалтууд нь ойлгомжтой, товч тодорхой бөгөөд шинэ бүтээлийн тодорхойлолтоор бүрэн баталгаажсан байвал зохино.

7 дугаар зүйл

Зураглал

(1) (2) дахь хэсгийн (ii)-т заасныг харгалзан шинэ бүтээлийг ойлгож мэдэхэд шаардлагатай тохиолдолд зураглалыг хавсаргаж ирүүлнэ.

(2) шинэ бүтээлийг ойлгож мэдэхэд зураглал шаардлагагүй бол шинэ бүтээлийн мөн чанарыг харуулсан тайлбар зургийг зураглалын хэлбэрээр хавсаргаж болно.

- (i) мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэг гаргахдаа дээр дурдсан зураглалыг мэдүүлэгт хавсаргаж болно;
- (ii) нэрлэсэн аливаа байгууллага нь дээр дурдсан зураглалыг тогтоосон хугацаанд ирүүлэхийг мэдүүлэг гаргагчаас шаардаж болно.

8 дугаар зүйл

Давуу эрх эдлэх хүсэлт

(1) олон улсын мэдүүлэг нь журмаар тогтоосны дагуу Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч аливаа улсад эсхүл дурдсан аливаа улсын хувьд урьд нь гаргасан нэг буюу хэд хэдэн мэдүүлгийн давуу эрх тогтоолгох мэдүүлгийг агуулж болно.

(2) (a), (b) дэд хэсэгт заасныг харгалзан (1) дэх заалтын дагуу гаргасан давуу эрх эдлэх аливаа хүсэлтийн болзол, үр дагавар нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн Стокгольмын актын 4 дүгээр зүйлд заасантай нийцэж байвал зохино.

(b) Хэлэлцэн тохирогч улсад эсхүл дурдсан улсын хувьд урьд нь гаргасан нэг буюу хэд хэдэн мэдүүлгийн давуу эрх тогтоолгох тухай олон улсын мэдүүлэгт тухайн улсыг нэрлэж болно. Хэрэв олон улсын мэдүүлэгт ямар нэг нэрлэсэн улсад эсхүл дурдсан улсын хувьд урьд нь гаргасан үндэсний нэг буюу хэд хэдэн мэдүүлгийн давуу эрх тогтоолгохыг хүссэн, эсхүл зөвхөн нэг улсыг нэрлэсэн олон улсын өөр мэдүүлэгт давуу эрх тогтоолгохыг хүссэн байвал дурдсан улсад давуу эрх тогтоолгох болзол, үр дагаврыг уг улсын үндэсний хууль тогтоомжоор зохицуулна.

9 дүгээр зүйл

Мэдүүлэг гаргагч

(1) Хэлэлцэн тохирогч улсын аливаа харьяат эсхүл тухайн улсад байнга оршин суугаа хүн олон улсын мэдүүлэг гаргаж болно.

(2) Ассамблей нь энэхүү гэрээнд оролцдоггүй Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч аливаа улсын харьяатад болон түүнчлэн энэ улсад оршин суугаа хүмүүст олон улсын мэдүүлэг гаргахыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж болно.

(3) Хэд хэдэн мэдүүлэг гаргагч байх эсхүл мэдүүлэг гаргагчид нь нэрлэсэн бүх улсын хувьд ижил биш байх тохиолдолд иргэний харьяалал, байнга оршин суугаа газар гэсэн ойлголт, түүнчлэн эдгээр ойлголтыг хэрэглэх явдал нь журмын дагуу тодорхойлогдоно.

10 дугаар зүйл

Хүлээн авагч байгууллага

Олон улсын мэдүүлгийг тогтоосон хүлээн авагч байгууллагад гаргах бөгөөд уг байгууллага нь энэхүү гэрээ, журамд заасан журмаар уг мэдүүлгийг шалгаж, хянан хэлэлцэнэ.

11 дүгээр зүйл

Олон улсын мэдүүлэг гаргасан өдөр, үр дагавар

(1) Хүлээн авагч байгууллага нь олон улсын мэдүүлэг хүлээн авах үедээ дараахь дүгнэлтэд хүрсэн бол олон улсын мэдүүлэг гаргасан огноог түүнийг хүлээн авсан өдрөөр тогтооно. Үүнд:

- (i) мэдүүлэг гаргагч иргэний харьяалал эсхүл байнга оршин суугаа газрын шалтгаанаар тухайн хүлээн авагч байгууллагад олон улсын мэдүүлэг гаргах эрхээ хасуулаагүй нь илт тодорхой байгаа;
- (ii) олон улсын мэдүүлгийг тогтоосон хэлээр үйлдсэн;
- (iii) олон улсын мэдүүлэг нь наад зах нь дараахь бүрдлийг хангасан. Үүнд:
 - (a) мэдүүлгийг олон улсын мэдүүлэг болгон гаргасан тухай дурдсан;
 - (b) наад зах нь нэг хэлэлцэн тохирогч улсыг нэрлэсэн;
 - (c) мэдүүлэг гаргагчийн нэрийг тогтсон ёсоор дурдсан;
 - (d) гадна байдлаараа шинэ бүтээлийн тодорхойлолт болж чадах хэсгийг агуулж байгаа;
 - (e) гадна байдлаараа шинэ бүтээлийн томъёоллын нэг буюу хэд хэдэн заалт болж чадах хэсгийг агуулж байгаа.

(2) (a) хэрэв хүлээн авагч байгууллага нь олон улсын мэдүүлгийг хүлээн авах үедээ уг мэдүүлэг нь (1) дэх хэсэгт дурдсан шаардлагыг хангаагүй болохыг тогтоовол журамд заасан шаардлагатай засвар хийхийг мэдүүлэг гаргагчид санал болгоно.

(b) хэрэв мэдүүлэг гаргагч дээрх шаардлагыг журмын дагуу биелүүлбэл хүлээн авагч байгууллага нь олон улсын мэдүүлэг хүлээн авсан огноог шаардлагатай засварыг хүлээн авсан өдрөөр тогтооно.

(3) 64 дүгээр зүйлийн (4) дэх хэсэгт заасныг харгалзан (1) дэх хэсгийн (i)-(iii)-т заасан шаардлагыг хангасан болон хүлээн авсан огноо нь тогтоогдсон аливаа олон улсын мэдүүлэг нь олон улсын хэмжээнд мэдүүлэг гаргасан огнооноос эхлэн нэрлэсэн улс бүрт үнэн зөв бүрдүүлж гаргасан үндэсний мэдүүлгийн адил хүчинтэй байна. Олон улсын хэмжээнд мэдүүлэг гаргасан огноо нь нэрлэсэн улс бүрт мэдүүлэг гаргасан огноонд тооцогдоно.

(4) (1) дэх хэсгийн (i)-(iii) дахь дэд хэсэгт заасан шаардлагыг хангасан олон улсын аливаа мэдүүлэг гаргасныг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн агуулгад нийцсэн, үнэн зөв үйлдсэн үндэсний мэдүүлэг гаргасантай адилтгаж үзнэ.

12 дугаар зүйл

**Олон улсын мэдүүлгийг олон улсын
товчоо ба олон улсын хайлтын байгууллагад илгээх**

(1) Журамд заасны дагуу олон улсын мэдүүлгийн нэг хувийг ("хүлээн авагч байгууллагын хувь") хүлээн авагч байгууллагад хадгалж, нэг хувийг олон улсын товчоонд ("бүртгэлийн хувь"), нөгөө хувийг ("хайлтын хувь") 16 дугаар зүйлд дурьдсан олон улсын хайлтын байгууллагад илгээнэ.

(2) Бүртгэлийн хувийг олон улсын мэдүүлгийн жинхэнэ эх гэж үзнэ.

(3) Олон улсын товчоо тогтоосон хугацаанд бүртгэлийн хувийг хүлээн аваагүй бол олон улсын мэдүүлгийг хэрэгсээгүйд тооцно.

13 дугаар зүйл

**Олон улсын мэдүүлгийн хуулбарыг нэрлэсэн
байгууллагад авах боломж**

(1) Аливаа нэрлэсэн байгууллага нь олон улсын мэдүүлгийн хуулбарыг ирүүлэхийг уг мэдүүлгийг 20 дугаар зүйлд заасны дагуу тараахаас өмнө олон улсын товчооноос хүсэж болох ба олон улсын товчоо нь давамгайлах огнооноос эхлэн нэг жилийн дотор уг хуулбарыг нэрлэсэн байгууллагад нэн даруй илгээнэ.

(2) (a) Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлгийнхээ хуулбарыг нэрлэсэн аль ч байгууллагад дуртай хугацаандаа илгээж болно.

(b) Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлгийнхээ хуулбарыг нэрлэсэн аль ч байгууллагад илгээхийг олон улсын товчооноос дуртай хугацаандаа хүсэж болох бөгөөд олон улсын товчоо хуулбарыг уг байгууллагад нэн даруй явуулна.

(c) Үндэсний аливаа байгууллага мэдүүлгийн хуулбарыг (b) дэд хэсэгт заасанчлан авах хүсэлгүй байгаагаар олон улсын товчоонд мэдээлж болох бөгөөд ингэсэн тохиолдолд дурдсан дэд хэсгийг энэ байгууллагын тухайд хэрэглэхгүй.

14 дүгээр зүйл

Олон улсын мэдүүлгийн зарим хангалтгүй байдал

(1) (a) Хүлээн авагч байгууллага олон улсын мэдүүлэгт дараахь хангалтгүй байдлуудын аль нэг нь байгаа эсэхийг шалгана. Тухайлбал:

- (i) журамд заасан ёсоор гарын үсэг зураагүй байх;
- (ii) мэдүүлэг гаргагчийн тухай тогтоосон мэдээ баримт агуулаагүй байх;
- (iii) гарчиг бичээгүй байх;
- (iv) товч тайлбар бичээгүй байх;
- (v) журамд заасан олон улсын мэдүүлэг үйлдэх шаардлагын түвшинг хангаагүй байх.

(b) Хэрэв хүлээн авагч байгууллага дээр дурьдсан хангалтгүй байдлын аль нэгийг илрүүлбэл олон улсын мэдүүлгийг тогтоосон хугацаанд засахыг мэдүүлэг гаргагчид санал болгох ба уг шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд мэдүүлгийг хэрэгсэхгүйд тооцож, хүлээн авагч байгууллага ийнхүү хэрэгсэхгүй болгосон тухай зарлана.

(2) Хэрэв олон улсын мэдүүлэг нь мэдүүлэгт тусгагдаагүй зураглалыг нэр заасан байвал хүлээн авагч байгууллага энэ тухай мэдүүлэг гаргагчид мэдэгдэх ба мэдүүлэг гаргагч нь зураглалыг тогтоосон хугацаанд ирүүлж болно. Хэрэв мэдүүлэг гаргагч зураглалыг ийнхүү ирүүлбэл хүлээн авагч байгууллага олон улсын мэдүүлэг хүлээн авсан огноог зураглалыг хүлээн авсан огноогоор тооцно. Эс тэгвэл нэр заасан зураглалын талаарх аливаа нэр заалтыг хүчингүйд тооцно.

(3) (a) Хэрэв хүлээн авагч байгууллага 3 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн (iv)-т заасан хураамжийг тогтоосон хугацаанд төлөөгүй эсхүл 4 дүгээр зүйл (2) дахь хэсэг заасан хураамжийг нэрлэсэн нэг ч улсад төлөөгүйг тогтоовол олон улсын мэдүүлгийг хэрэгсэхгүйд тооцож хүлээн авагч байгууллага энэ тухай зарлана.

(b) Хэрэв хүлээн авагч байгууллага 4 дүгээр зүйл (2) дахь хэсэгт заасан хураамжийг нэрлэсэн нэг эсхүл хэд хэдэн улсад тогтоосон хугацаанд төлсөн боловч бүх улсад төлөөгүй болохыг тогтоовол тогтоосон хугацаанд хураамж төлөөгүй улсуудыг нэрлэснийг хэрэгсэхгүйд тооцож, хүлээн авагч байгууллага ийнхүү хэрэгсэхгүй болгосон тухай зарлана.

(4) Хэрэв хүлээн авагч байгууллага олон улсын мэдүүлгийг олон улсын хэмжээнд гаргасан огноог тогтоосны дараа 11 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (i)-(iii)-т заасан аль нэг шаардлагыг дээрх хугацаанд хангаагүй болохыг тогтоосон хугацаанд илрүүлбэл, дурдсан мэдүүлгийг хэрэгсэхгүйд тооцож, хүлээн авагч байгууллага энэ тухай зарлана.

15 дугаар зүйл

Олон улсын хайлт

(1) Олон улсын мэдүүлэг бүрд олон улсын хайлт хийнэ.

(2) Олон улсын хайлтын зорилго нь техникийн зохих түвшинг илрүүлэхэд оршино.

(3) Олон улсын хайлтыг шинэ бүтээлийн томъёоллын үндсэн дээр шинэ бүтээлийн тодорхойлолт болон зураглалыг (хэрэв байвал) зохих ёсоор харгалзан хийнэ.

(4) 16 дугаар зүйлд дурьдсан олон улсын хайлтын байгууллага нь техникийн зохих түвшинг өөрийн боломжийн хэрээр илрүүлэхийг эрмэлзэх ба ямар ч тохиолдолд журамд тодорхойлсон баримт бичгүүдийг ашиглана.

(5) (a) хэлэлцэн тохирогч улсын үндэсний байгууллагад эсхүл тухайн улсын нэрийн өмнөөс ажиллаж байгаа үндэсний байгууллагад үндэсний мэдүүлэг гаргагч нь хэрэв хэлэлцэн тохирогч улсын үндэсний хууль тогтоомжоор болон түүнд тодорхойлсон нөхцөлийн дагуу ингэх нь зөвшөөрөгдөж байвал өөрийн мэдүүлэгт олон улсын хайлттай адил ("олон улсын маягийн хайлт") хайлт хийлгэх хүсэлт гаргаж болно.

(b) хэлэлцэн тохирогч улсын үндэсний байгууллага эсхүл тухайн улсын нэрийн өмнөөс ажиллаж байгаа үндэсний байгууллага хэрэв хэлэлцэн тохирогч улсын үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрч байвал, тухайн байгууллагад гаргасан үндэсний аливаа мэдүүлгийг олон улсын маягийн хайлтад оруулж болно.

(c) Хэрэв уг үндэсний мэдүүлэг нь олон улсын мэдүүлэг байсан бөгөөд (a) болон (b) дэд хэсэгт дурьдсан байгууллагад гаргасан байсан бол 16 дугаар зүйлд дурьдсан олон улсын хайлт хийх эрх мэдэл бүхий байх олон улсын хайлтын байгууллагаас олон улсын маягийн хайлт хийнэ. Хэрэв үндэсний мэдүүлгийг олон улсын хайлтын байгууллага хянан шийдвэрлэх боломжгүй хэл дээр үйлдсэн байвал олон улсын мэдүүлэг үйлдэх тогтоосон хэлээр ба тухайн олон улсын хайлтын байгууллагаас олон улсын мэдүүлэг хүлээн авахаар үүрэг хүлээсэн хэл дээр мэдүүлэг гаргагчийн үйлдсэн орчуулгын дагуу олон улсын хайлт хийнэ. Үндэсний мэдүүлэг, шаардлагатай бол түүний орчуулгыг олон улсын мэдүүлэг гаргах тогтоосон хэлбэрээр ирүүлнэ.

16 дугаар зүйл

Олон улсын хайлт хийх байгууллага

(1) Олон улсын хайлтыг олон улсын хайлт хийх байгууллага гүйцэтгэнэ. Үндэсний байгууллага эсхүл засгийн газар хоорондын байгууллага, жишээлбэл, зарлагдсан шинэ бүтээлийн техникийн түвшингийн талаар баримт бичгийн хайлт хийсэн тухай тайлан бэлтгэх үүрэг хүлээдэг олон улсын патентын институт нь олон улсын хайлт хийх байгууллагын үүрэг гүйцэтгэж болно.

(2) Хэрэв олон улсын хайлт хийх нэгдсэн байгууллага байгуулах хүртэлх хугацаанд олон улсын хэд хэдэн хайлт хийх байгууллага байвал, хүлээн авагч байгууллага бүр нь 3 дугаар зүйлийн (b) дэд хэсэгт дурьдсан хэлэлцээрийн нөхцөлийн дагуу олон улсын хайлтын байгууллага эсхүл тухайн хүлээн авагч байгууллагад гаргасан олон улсын мэдүүлэгт хайлт хийх эрх бүхий байгууллагыг нэрлэнэ.

(3) (a) Олон улсын хайлт хийх байгууллагыг Ассамблей томилно. (c) дэд хэсэгт заасан шаардлага хангасан үндэсний аливаа байгууллага эсхүл засгийн газар хоорондын аливаа байгууллагыг олон улсын хайлтын байгууллагаар томилж болно.

(b) Томилгоог дээр дурьдсан байгууллагаар томилогдох үндэсний байгууллага эсхүл засгийн газар хоорондын байгууллагын зөвшөөрлөөр, эдгээр байгууллагууд ба олон улсын товчооны хооронд байгуулсан Ассамблейгаар батлагдах ёстой хэлэлцээрийг үндэслэн гүйцэтгэнэ. Хэлэлцээрт талуудын эрх, үүрэг, тухайлбал, дурдсан үндэсний болон засгийн газар хоорондын байгууллагаас олон улсын хайлтын бүх нийтлэг дүрэм, журмыг хэрэглэх, мөрдөх албан ёсны үүргийг тодорхойлсон байвал зохино.

(c) журам нь дээр дурьдсан ямар ч байгууллага томилогдохоосоо өмнө буюу буюу томилогдсон бүх хугацааны туршид хангаж байвал зохих наад захын, ялангуяа, боловсон хүчин, баримт бичгийн талаарх шаардлагыг тодорхойлно.

(d) Томилгоо нь тодорхой хугацаатай байх ба хугацааг цаашид сунгаж болно.

(e) Ассамблей нь үндэсний аль нэг байгууллага, засгийн газар хоорондын байгууллагыг томилох, түүнчлэн томилсон хугацааг сунгах эсхүл цуцлах шийдвэр гаргахаасаа өмнө тухайн сонирхогч байгууллагын саналыг сонсох эсхүл 56 дугаар зүйлд дурдсан техникийн хамтын ажиллагааны хороо байгуулагдсаны дараа уг хорооны саналыг авна.

17 дугаар зүйл

Олон улсын хайлт хийх байгууллагад мөрдөх журам

(1) Олон улсын хайлт хийх байгууллагад мөрдөх журмыг энэхүү гэрээ, журам болон тэдгээрийн дагуу олон улсын товчооноос уг байгууллагатай байгуулах хэлэлцээрийн заалтаар тодорхойлно.

(2) (a) Хэрэв олон улсын хайлт хийх байгууллага нь:

(i) олон улсын мэдүүлэг нь олон улсын хайлт хийх байгууллагаас журмын дагуу олон улсын хайлт хийх үүрэг хүлээгээгүй

объектод хамаарч байгаа бөгөөд энэ тохиолдолд тус байгууллага дурдсан хайлт хийхгүй шийдвэр гаргасан, эсхүл

- (ii) шинэ бүтээлийн тодорхойлолт, шинэ бүтээлийн томьёолол эсхүл зураглал нь тогтоосон шаардлага хангаагүйн улмаас бүрэн хэмжээний хайлт хийх боломжгүй бол олон улсын хайлт хийх байгууллага нь энэ тухай тайланд тэмдэглэж, олон улсын хайлтын тайлан үйлдэхгүй болохыг мэдүүлэг гаргагчид болон олон улсын товчоонд мэдэгдэнэ.

(b) Хэрэв (a) дэд хэсэгт дурдсан аливаа нөхцөл байдал нь томьёоллын зөвхөн зарим заалтад хамаарч байвал олон улсын хайлтын тайланд уг заалтуудын талаарх зохих тэмдэглэгээг хийж томьёоллын бусад заалтын талаарх тайланг 18 дугаар зүйлийн дагуу бэлтгэнэ.

(3) (a) Хэрэв олон улсын хайлт хийх байгууллага олон улсын мэдүүлэг нь шинэ бүтээлийн нэгдмэл байдлын шаардлагыг журамд тодорхойлсны дагуу хангаагүй гэж үзвэл, нэмэгдэл хураамж төлөхийг мэдүүлэг гаргагчид санал болгоно. Олон улсын хайлт хийх байгууллага нь шинэ бүтээлийн томьёоллын хамгийн эхэнд ("үндсэн шинэ бүтээл") дурдсан шинэ бүтээлд хамаарах олон улсын мэдүүлгийн холбогдох хэсэгт олон улсын шүүлтийн тайлан бэлтгэх ба түүнчлэн шаардсан нэмэлт хураамжийг тогтоосон хугацаанд нь төлсөн нөхцөлд дээрх хураамжийг төлсөн шинэ бүтээлд хамаарах олон улсын мэдүүлгийн холбогдох хэсгүүдийн талаарх олон улсын хайлтын тайланг бэлтгэнэ.

(b) Аливаа нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомж нь тухайн улсын үндэсний байгууллага олон улсын хайлт хийх байгууллагын (a) дэд хэсэгт дурдсан саналыг үндэслэлтэй гэж үзсэн, мэдүүлэг гаргагч бүх нэмэгдэл хураамжийг төлөөгүй, хэрэв мэдүүлэг гаргагч тухайн улсын үндэсний байгууллагад тусгай хураамжийг төлөхгүй бол олон улсын мэдүүлгийн хайлт хийгдээгүй хэсгийг тухайн улсад үйлчлэхгүй байх журам тогтоож болно.

18 дугаар зүйл

Олон улсын хайлтын тайлан

(1) Олон улсын хайлтын тайланг тогтоосон хугацаанд тогтоосон хэлбэрээр бэлтгэнэ.

(2) Олон улсын хайлт хийх байгууллага нь олон улсын хайлтын тайланг бэлэн болмогц нь мэдүүлэг гаргагчид болон олон улсын товчоонд илгээнэ.

(3) Олон улсын хайлтын тайлан эсхүл 17 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан мэдэгдлийг журамд заасан хэлээр орчуулна. Орчуулгыг эсхүл олон улсын товчоо өөрөө, эсхүл тус товчоо хариуцан, түүний захиалгаар гүйцэтгэнэ.

19 дүгээр зүйл

Олон улсын товчоонд шинэ бүтээлийн томьёоллыг өөрчлөх

(1) Мэдүүлэг гаргагч нь олон улсын хайлтын тайланг хүлээн авсныхаа дараа түүнд оруулсан өөрчлөлтөө олон улсын товчоонд тогтоосон хугацаанд танилцуулснаар олон улсын мэдүүлгийн томъёоллыг нэг удаа өөрчлөх эрхтэй. Үүний зэрэгцээ мэдүүлэг гаргагч нь журмын дагуу өөрчлөлтийн товч тайлбарыг ирүүлэх ба тайлбарт уг өөрчлөлтийг шинэ бүтээлийн тодорхойлолт, зураглалд хэрхэн тусгаж болохыг заана.

(2) Өөрчлөлт нь анх гаргасан олон улсын мэдүүлэгт илрүүлсэн хүрээгээр хязгаарлагдана.

(3) Хэрэв аливаа нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомжоор дээрх өөрчлөлт нь анх гаргасан олон улсын мэдүүлэгт илрүүлсэн хүрээнээс халихыг зөвшөөрч байвал (2) дахь хэсгийг мөрдөхгүй байх нь тухайн улсад үр дагавар учруулахгүй.

20 дугаар зүйл

**Олон улсын мэдүүлгийн материалыг нэрлэсэн
байгууллагад илгээх**

(1) (a) Хэрэв нэрлэсэн байгууллага дараахь журмаас бүрэн эсхүл зарим талаар татгалзахгүй бол журамд заасанчлан олон улсын мэдүүлгийг олон улсын хайлтын тайлангийн хамт /17 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан аливаа сануулгыг оролцуулан/ эсхүл 17 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) дэд хэсэгт заасан мэдэгдлийн хамт нэрлэсэн байгууллага бүрт илгээнэ.

(b) Илгээж байгаа материал нь дурдсан тайлан эсхүл мэдэгдлийн орчуулгаас (тогтоосон журмын дагуу үйлдсэн) бүрдэнэ.

(2) Хэрэв шинэ бүтээлийн томъёоллыг 19 дүгээр зүйл (1) дэх хэсгийн дагуу өөрчилсөн бол дээрх материал нь шинэ бүтээлийн томъёоллын бүрэн эх анхны хэлбэрээр болон өөрчлөлт орсон хэлбэрээр, эсхүл шинэ бүтээлийн томъёоллын бүрэн эх анхны хэлбэрээр түүнд оруулсан өөрчлөлтийн хамт, түүнчлэн хэрвээ байгаа бол 19 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт дурдсан тайлбараас бүрдэнэ

(3) Олон улсын хайлтын байгууллага журамд заасанчлан, нэрлэсэн байгууллага эсхүл мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр олон улсын хайлтын тайланд нэр заасан баримт бичгүүдийн хуулбарыг нэрлэсэн байгууллага мэдүүлэг гаргагч тус бүрд илгээнэ.

21 дүгээр зүйл

Олон улсын хэвлэн нийтлэл

(1) Олон улсын товчоо олон улсын мэдүүлгийг хэвлэн нийтэлнэ.

(2) (a), (b) дэд хэсэг болон 64 дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд олон улсын мэдүүлгийг түүний давамгайлах огнооноос хойш арван найман сарын дараа нэн даруй хэвлэн нийтэлнэ.

(b) Мэдүүлэг гаргагч (a) дэд хэсэгт дурдсан хугацаа дуусахаас өмнөх ямар ч хугацаанд түүний олон улсын мэдүүлгийг хэвлэн нийтлэхийг олон улсын товчооноос хүсэж болно. Олон улсын товчоо уг хүсэлтийг журмын дагуу биелүүлнэ.

(3) Олон улсын хайлтын тайлан буюу 17 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан мэдэгдлийг журамд тогтоосны дагуу хэвлэн нийтэлнэ.

(4) Олон улсын хэвлэн нийтлэлийн хэл, хэлбэр түүнчлэн бусад нарийвчилсан зүйлүүдийг журамд заасан ёсоор тодорхойлно.

(5) Хэрэв олон улсын мэдүүлгийг хэвлэн нийтлэх техникийн бэлтгэл ажил дуусахаас өмнө хэрэгсэхгүй болгосон эсхүл хэрэгсэхгүйд тооцсон бол олон улсын мэдүүлгийг хэвлэн нийтлэхгүй.

(6) Хэрэв олон улсын товчооны үзэж байгаагаар олон улсын мэдүүлэг нь ёс суртахуунд болон нийгмийн дэг журамд харш үг хэллэг болон зураглал агуулж байгаа, эсхүл дурдсан товчооны үзэж байгаагаар журамд тодорхойлсон бүдүүлэг үг хэллэг агуулж байгаа бол олон улсын товчоо хэвлэн нийтлэхдээ тэдгээр үг хэллэг, зураглал, бүдүүлэг үг хэллэгийг хасаж, хассан хэсэг, үг болон зургийн тоог заах эрхтэй. Олон улсын товчоо бичвэр буюу зураглалын хасагдсан хэсгийн зарим хуулбарыг хүсэлтийн дагуу илгээнэ.

22 дугаар зүйл

Нэрлэсэн байгууллагад зориулсан хуулбар, орчуулга, хураамж

(1) Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлгийн хуулбар (20 дугаар зүйлийн дагуу нэгэнт тарааснаас бусад тохиолдолд), түүний орчуулгыг /тогтоосон журмын дагуу/ ирүүлж, түүнчлэн давамгайлах огноо тогтоосноос хойш гучин сараас хэтрүүлэлгүйгээр дурдсан байгууллага бүрт үндэсний хураамжийг (хэрэв тэгж заасан бол) төлнө. Хэрэв нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомж нь шинэ бүтээлийн зохиогчийн нэр, бусад тогтоосон мэдээ баримтыг дурьдахыг шаарддаг боловч эдгээр мэдээ баримтыг үндэсний мэдүүлэг гаргасны дараа ирүүлэхийг зөвшөөрдөг бол мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн бүрдэлд ороогүй, дээр дурдсан мэдээ баримтыг давамгайлах огнооноос хойш гучин сараас хэтрүүлэлгүйгээр тухайн улсын үндэсний байгууллагад эсхүл энэ улсын нэрийн өмнөөс ажиллаж байгаа үндэсний байгууллагад хүргүүлнэ.

(2) Олон улсын хайлтын байгууллага 17 дугаар зүйл (2) дахь хэсгийн (а) дэд хэсгийн дагуу олон улсын хайлтын тайланг бэлтгэхгүй гэдгийг мэдэгдэлд тэмдэглэсэн тохиолдолд энэ зүйлийн (1) дэх хэсэгт дурдсан үйлдлийг хэрэгжүүлэх хугацаа нь (1) дэх хэсэгт заасантай адил байна.

(3) Үндэсний аливаа хууль тогтоомжоор (1), (2) дахь хэсэгт дурдсан үйлдлийг хэрэгжүүлэхийн тулд дээрх (1), (2) дахь хэсэгт зааснаас хожим дуусах хугацааг тогтоож болно.

23 дугаар зүйл

Үндэсний журмыг хойшлуулах

(1) Нэрлэсэн байгууллагууд 22 дугаар зүйлд заасан хугацаа дуусахаас өмнө олон улсын мэдүүлэгтэй холбогдолтой үйл ажиллагаа явуулахгүй ба уг мэдүүлэгт шүүлт хийхгүй.

(2) Аливаа нэрлэсэн байгууллага мэдүүлэг гаргагчийн тусгай хүсэлтээр, (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, ямар ч үед олон улсын мэдүүлэгтэй холбогдолтой үйл ажиллагаа явуулах буюу уг мэдүүлэгт шүүлт хийж болно.

24 дүгээр зүйл

**Олон улсын мэдүүлгийн үйлчлэлийг нэрлэсэн
улсуудад зогсоох боломж**

(1) 25 дугаар зүйлийн заалтуудын дагуу, дор дурдсан (ii) дэд хэсэгт тодорхойлсон тохиолдолд хэрэглэдэг 11 дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт заасан олон улсын мэдүүлгийн үйлчлэл нь нэрлэсэн аливаа улсад үндэсний ямар ч мэдүүлгийг хэрэгсэхгүй болгохтой адил үр дагавартайгаар, тухайн улсад дараахь тохиолдолд зогсоно:

- (i) хэрэв мэдүүлэг гаргагч нь өөрийн олон улсын мэдүүлгийг эсхүл тухайн улсыг нэрлэсэн заалтаа хасвал;
- (ii) олон улсын мэдүүлэг нь 12 дугаар зүйлийн (3) дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэг, 14 дүгээр зүйлийн (3) дахь хэсгийн (a) дэд хэсэг эсхүл 14 дүгээр зүйлийн (4) дэх хэсэгт заасанчлан хэрэгсэхгүйд тооцогдсон, эсхүл тухайн улсыг нэрлэсэн нь 14 дүгээр зүйл (3) дахь хэсгийн (b) дэд хэсгийн дагуу хэрэгсэхгүйд тооцогдсон бол;
- (iii) мэдүүлэг гаргагч нь 22 дугаар зүйлд заасан үйлдлийг зохих хугацаанд гүйцэтгэхгүй бол.

(2) Аливаа нэрлэсэн байгууллага (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, олон улсын мэдүүлгийн 11 дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт заасан үйлчлэлийг 25 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасанчлан шаардлагагүй тохиолдолд ч хэвээр хадгалж болно.

25 дугаар зүйл

Нэрлэсэн байгууллагууд шийдвэрийг хянан үзэх

(1) (a) Хэрэв хүлээн авагч байгууллага олон улсын мэдүүлэг гаргасан огноог тогтоохоос татгалзсан, эсхүл олон улсын мэдүүлгийг хэрэгсэхгүйд тооцсоныг зарласан эсхүл олон улсын товчоо 12 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт заасан баримтыг илрүүлсэн бол олон улсын товчоо мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хэргийн аливаа баримт бичгийн хуулбарыг мэдүүлэг гаргагчийн нэрлэсэн байгууллагын аль нэгэнд нэн даруй илгээнэ.

(b) Хэрэв хүлээн авагч байгууллага аливаа улсыг нэрлэснийг хэрэгсэхгүйд тооцсоныг зарласан бол олон улсын товчоо мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хэргийн тухай аливаа баримт бичгийн хуулбарыг тухайн улсын үндэсний байгууллагад нэн даруй илгээнэ.

(с) (а), (b) дэд хэсэгт дурдсан хүсэлтийг тогтоосон хугацаанд гаргана.

(2) (а), (b) дэд хэсгийн заалтыг харгалзан нэрлэсэн байгууллага бүр үндэсний хураамжийг тогтоосон хугацаанд (хэрвээ тийм журам бий бол) төлж, зохих орчуулгыг (тогтсон ёсоор) тогтоосон хугацаанд нь ирүүлсэн нөхцөлд (1) дэх хэсэгт дурдсанаар татгалзах, зарлах эсхүл баримтыг тогтоох нь үндэслэлтэй эсэхийг гэрээ, журмын заалтыг үндэслэн шийдвэрлэнэ. Хэрэв ингэж татгалзсан болон зарласан нь хүлээн авагч байгууллагын зүгээс гаргасан алдаа, дутагдлын уршиг байсан эсхүл баримтыг илрүүлсэн нь олон улсын товчооны зүгээс гаргасан алдаа дутагдлын уршиг байсан гэсэн дүгнэлтэд хүрвэл нэрлэсэн байгууллага олон улсын мэдүүлгийн тухайн улс дахь үйлчлэлийг дээр дурдсан алдаа, дутагдал гараагүй тохиолдолтой адилтган авч үзнэ.

(b) Хэрэв бүртгэлийн хувь нь мэдүүлэг гаргагчийн ямар нэг алдаа дутагдлын улмаас 12 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт заасан хугацаа өнгөрсний дараа олон улсын товчоонд ирсэн бол (а) дэд хэсгийн заалтыг зөвхөн 48 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт дурдсан нөхцөлд хэрэглэнэ.

26 дугаар зүйл

**Нэрлэсэн байгууллагаас олон улсын мэдүүлэгт
засвар оруулах боломж**

Нэрлэсэн байгууллага олон улсын мэдүүлэг энэхүү гэрээ, журмын шаардлагад нийцээгүй гэсэн үндэслэлээр, олон улсын мэдүүлэгт засвар оруулах боломжийг мэдүүлэг гаргагчид дээрх болон дээрхтэй төстэй нөхцөл байдалд үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнд болон үндэсний хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу үндэсний мэдүүлэгт засвар оруулахтай адил түвшинд олгохгүйгээр олон улсын мэдүүлгийг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

27 дугаар зүйл

Үндэсний хууль тогтоомжийн шаардлага

(1) Үндэсний хууль тогтоомжоор олон улсын мэдүүлгийн хэлбэр эсхүл агуулгад энэхүү гэрээ, журамд зааснаас өөр эсхүл нэмэлт шаардлага тавьж болохгүй.

(2) (1) дэх хэсгийн заалт нь 7 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт хамаарахгүй бөгөөд нэрлэсэн байгууллагад олон улсын мэдүүлгийг хянаж эхэлмэгц дараахь зүйлийг үндэсний хууль тогтоомжоор шаардахад саад болохгүй:

- (i) мэдүүлэг гаргагч-хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны нэрийг дурдах;
- (ii) олон улсын мэдүүлгийн бүрэлдэхүүн хэсэг биш боловч энэхүү мэдүүлэгт дурьдсан баталгаа эсхүл мэдүүлгийг батлах нотлох баримт бичгүүдийг ирүүлэх, тухайлбал олон улсын мэдүүлэг гаргахад мэдүүлэг гаргагчийн бие төлөөлөгч эсхүл итгэмжлэгч

гарын үсэг зурсан тохиолдолд мэдүүлэг гаргагчийн гарын үсгээр олон улсын мэдүүлгийг баталгаажуулах.

(3) Мэдүүлэг гаргагч нь шинэ бүтээлийн зохиогч биш учраас нэрлэсэн аливаа улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн улсад мэдүүлэг гаргах эрхгүй бол нэрлэсэн байгууллага олон улсын мэдүүлгийг хүлээн авахаас татгалзаж болно.

(4) Хэрэв үндэсний хууль тогтоомжоор үндэсний мэдүүлгийн хэлбэр, агуулгад тавьж байгаа шаардлага энэхүү гэрээ, журамд заасан олон улсын мэдүүлэгт тавих шаардлагаас илүү тааламжтай гэж мэдүүлэг гаргагч үзэж байгаа бол тухайн нэрлэсэн улсын үндэсний байгууллага, шүүх болон аливаа эрх бүхий байгууллага эсхүл энэ улсын нэрийн өмнөөс ажиллаж байгаа байгууллагууд, мэдүүлэг гаргагч өөрөө энэхүү гэрээ, журамд шаардсан шаардлагыг олон улсын мэдүүлэгтээ хэрэглэхийг шаардаж байгаагаас бусад тохиолдолд, олон улсын мэдүүлэгт үндэсний хууль тогтоомжоор тавих шаардлагыг хэрэглэж болно.

(5) Энэхүү гэрээ, журмын аль ч заалт нь хэлэлцэн тохирогч улс бүрийн патентлаг чадварын эрх зүй-материалын болзлыг тогтоох эрхийг хязгаарлах боломж мэт ойлгогдох ёсгүй. Тухайлбал, техникийн түвшинг тодорхойлох талаарх энэхүү гэрээ, журмын аливаа заалт гагцхүү олон улсын горимыг хэрэгжүүлэх зорилгод үйлчлэх бөгөөд тиймээс хэлэлцэн тохирогч аливаа улс нь олон улсын мэдүүлэгт мэдүүлсэн шинэ бүтээлийн патентлаг чадварыг тодорхойлохдоо мэдүүлгийн хэлбэр, агуулгад тавих шаардлагад үл хамаарах техникийн түвшин, патентлаг чадварын бусад болзлын талаар өөрийн улсын үндэсний хууль тогтоомжийн шалгуурыг хэрэглэх эрхтэй.

(6) Үндэсний хууль тогтоомж нь уг хууль тогтоомжоор тогтоосон патентлаг чадварын эрхзүй-материалын аливаа болзлын талаар нотолгоо ирүүлэхийг мэдүүлэг гаргагчаас шаардсан заалтыг агуулж болно.

(7) Олон улсын мэдүүлгийг хянан хэлэлцэж эхэлсэн аливаа хүлээн авагч байгууллага эсхүл нэрлэсэн байгууллага нь дээрх байгууллагын өмнө мэдүүлэг гаргагчийг төлөөлөх эрхтэй бие төлөөлөгч томилох, эсхүл мэдээлэл авах зорилгоор тухайн улс дахь хаягаа мэдээлэх тухай мэдүүлэг гаргагчид тавих шаардлагын талаар үндэсний хууль тогтоомжийг хэрэглэж болно.

(8) Энэхүү гэрээ, журмын аль ч заалтыг хэлэлцэн тохирогч аливаа улсаас үндэсний аюулгүй байдлаа хангах зорилгоор зайлшгүй шаардлагатай гэж үзсэн арга хэмжээ авах эсхүл улсынхаа эдийн засгийн үндсэн эрх ашгийн үүднээс өөрийн улсын харьяат болон уг улсад байнга оршин суудаг хүмүүсийн олон улсын мэдүүлэг гаргах эрхийг хязгаарлах эрхийн хязгаарлалт гэж ойлгож болохгүй.

28 дугаар зүйл

**Нэрлэсэн байгууллагаас шинэ бүтээлийн
томьёолол, тодорхойлолт, зураглалыг өөрчлөх**

(1) Нэрлэсэн аль ч байгууллага шинэ бүтээлийн томьёолол, шинэ бүтээлийн тодорхойлолт болон зургийн тайлбарт тогтоосон хугацаанд өөрчлөлт хийх боломж мэдүүлэг гаргагчид олгоно. Нэрлэсэн байгууллага нь мэдүүлэг гаргагч тусгайлан

зөвшөөрснөөс бусад тохиолдолд тогтоосон хугацааг дуусахаас өмнө патент олгох эсхүл түүнийг олгохоос татгалзах ёсгүй.

(2) Хэрэв нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөөгүй бол өөрчлөлт нь анх гаргасан олон улсын мэдүүлэгт тодорхойлсон хүрээнд хязгаарлагдана.

(3) Өөрчлөлт нь энэхүү гэрээ болон журамд заагаагүй бүх тохиолдолд нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байвал зохино.

(4) Хэрэв нэрлэсэн байгууллага олон улсын мэдүүлгийн орчуулга ирүүлэхийг шаардвал өөрчлөлтийг орчуулсан хэл дээр ирүүлнэ.

29 дүгээр зүйл

Олон улсын хэвлэн нийтлэлийн үр дагавар

(1) Нэрлэсэн улсад олон улсын мэдүүлгийг олон улсын хэмжээнд хэвлэн нийтэлсний улмаас мэдүүлэг гаргагчийн аливаа эрхийг хамгаалах үр дагавар нь (2)-(4) дэх хэсэгт заасныг харгалзан, шүүлт хийгдээгүй үндэсний мэдүүлгийг үндэсний хэмжээнд заавал хэвлэн нийтэлсэн тохиолдолд нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомжид заасан үр дагавартай адил байна.

(2) Олон улсын хэвлэн нийтлэлийн хэл нь нэрлэсэн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу нэрлэсэн улсад хэвлэн нийтэлдэг хэлнээс ялгаатай бол дараахь тохиолдлууд үүссэний дараа (1) дэх хэсэгт заасан үр дагавар үүсэхээр үндэсний хууль тогтоомжоор тогтоож болно:

- (i) үндэсний хууль тогтоомжийн дагуу үндэсний хэвлэн нийтлэлийн хэлээр хийсэн орчуулга хэвлэн нийтлэгдсэн, эсхүл
- (ii) үндэсний хэвлэн нийтлэлийн хэлээр хийсэн орчуулга нь үндэсний хууль тогтоомжийн дагуу, олон нийтэд танилцуулах зорилгын үүднээс, ил болгох замаар, нийтэд хүртээмжтэй болсон, эсхүл
- (iii) мэдүүлэг гаргагч үндэсний хэвлэн нийтлэлийн хэлээр хийсэн орчуулгыг олон улсын мэдүүлэгт мэдүүлсэн шинэ бүтээлийг хууль бусаар ашиглаж байгаа эсхүл хууль бусаар ашиглаж байж болзошгүй этгээдэд шилжүүлсэн, эсхүл
- (iv) (i) ба (iii)-т дурдсан хоёр тохиолдол эсхүл (ii) ба (iii)-т дурдсан хоёр тохиолдол үүссэн.

(3) олон улсын хэвлэн нийтлэлийг мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр давамгайлах огнооноос хойш арван найман сарын хугацаа дуусахаас өмнө гүйцэтгэсэн тохиолдолд (1) дэх хэсэгт дурдсан үр дагавар нь зөвхөн давамгайлах огнооноос хойш авран найман сарын дараа үйлчилж эхлэхээр нэрлэсэн аливаа улсын үндэсний хууль тогтоомжоор тогтоож болно.

(4) (1) дэх хэсэгт дурдсан үр дагавар нь 21 дүгээр зүйлийн дагуу хэвлэн нийтэлсэн олон улсын мэдүүлгийн хуулбарыг тухайн улсын үндэсний байгууллага

эсхүл уг улсын нэрийн өмнөөс ажиллаж байгаа үндэсний байгууллага хүлээн авсан огнооноос эхлэхээр нэрлэсэн аливаа улсын үндэсний хууль тогтоомжоор тогтоож болно. Дурдсан байгууллага хүлээн авсан огноог өөрийн хэвлэлд нэн даруй нийтэлнэ.

30 дугаар зүйл

Олон улсын мэдүүлгийн нууц байдал

(1) (a) Олон улсын товчоо болон олон улсын хайлтын байгууллага нь (b) дэд хэсгийн заалтыг харгалзан мэдүүлэг гаргагч хүссэн болон зөвшөөрснөөс бусад тохиолдолд олон улсын мэдүүлгийг олон улсын хэмжээнд нийтлэхээс өмнө уг мэдүүлэгтэй танилцахыг аливаа этгээд эсхүл байгууллагад зөвшөөрөхгүй.

(b) (a) дэд хэсгийн заалт нь аливаа материалыг олон улсын хайлт хийх эрх мэдэл бүхий байгууллагад илгээх, 13 дугаар зүйлд заасны дагуу илгээх, түүнчлэн 20 дугаар зүйлд заасны дагуу тараахад хамаарахгүй.

(2) (a) Үндэсний байгууллагууд мэдүүлэг гаргагчийн хүссэн буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд дараахь огнооны хамгийн эхний хугацааг эхлэхээс өмнө олон улсын мэдүүлэгтэй танилцахыг гуравдагч этгээдэд зөвшөөрөх ёсгүй. Үүнд:

- (i) олон улсын мэдүүлгийн олон улсын хэвлэн нийтлэлийн огноо;
- (ii) 20 дугаар зүйлийн дагуу олон улсын мэдүүлгийн материалыг хүлээн авсан огноо;
- (iii) 22 дугаар зүйлийн дагуу олон улсын мэдүүлгийн хуулбарыг хүлээн авсан огноо.

(b) Үндэсний байгууллага нь нэрлэсэн байгууллага мөн болохыг уг байгууллагаас гуравдагч этгээдэд мэдээлэхэд болон энэ баримтыг хэвлэн нийтлэхэд (a) дэд хэсгийн заалт саад болохгүй. Гэхдээ ийм мэдээлэл эсхүл хэвлэн нийтлэл зөвхөн дараахь мэдээ сэлтээс бүрдэнэ: хүлээн авагч байгууллагын тухай мэдээ баримт, мэдүүлэг гаргагчийн нэр, олон улсын мэдүүлэг гаргасан огноо, олон улсын мэдүүлгийн дугаар, шинэ бүтээлийн нэр.

(c) (a) дэд хэсгийн заалт нь нэрлэсэн байгууллага олон улсын мэдүүлэгтэй танилцах зөвшөөрлийг шүүх засаглалын байгууллагад олгоход саад болохгүй.

(3) Хэрэв 12 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт дурьдсан материалыг илгээх асуудалд хамааралгүй бол (2) дахь хэсгийн (a) дэд хэсгийн заалтыг ямар ч хүлээн авагч байгууллагад хэрэглэж болно.

(4) Энэхүү зүйлийн зорилгод "танилцах" гэж хувийн мэдээлэл, ердийн хэвлэн нийтлэл зэрэг гуравдагч этгээдүүдийн мэдээ баримт авч болох аливаа арга хэрэгслэлийг хэлнэ, үүний зэрэгцээ үндэсний байгууллага олон улсын мэдүүлгийг болон түүний орчуулгыг олон улсын хэвлэн нийтлэлээс өмнө эсхүл, хэрэв давамгайлах огнооноос хойш хорин сарын хугацаанд олон улсад хэвлэн нийтлээгүй

бол дурдсан давамгайлах огнооноос хойш хорин сарын хугацаа дуусахаас өмнө хэвлэн нийтэлж болохгүй.

II БҮЛЭГ ОЛОН УЛСЫН УРЬДЧИЛСАН ШҮҮЛТ

31 дүгээр зүйл

Олон улсын урьдчилсан шүүлт хийхийг шаардах

(1) Мэдүүлэг гаргагчийн шаардлагаар түүний олон улсын мэдүүлэгт дараахь заалтууд болон журамд заасан ёсоор олон улсын урьдчилсан шүүлт хийнэ.

(2) (a) журамд тодорхойлсон болон II бүлгийн заалтад хамаарах хэлэлцэн тохирогч улсын харьяат эсхүл энэ улсад байнга оршин суудаг аливаа этгээд олон улсын мэдүүлгээ тухайн улсын хүлээн авагч байгууллагад эсхүл тухайн улсын нэрийн өмнөөс ажиллаж байгаа хүлээн авагч байгууллагад гаргасан бол олон улсын урьдчилсан шүүлт хийхийг шаардах эрхтэй.

(b), Олон улсын мэдүүлэг гаргах эрх бүхий этгээд нь энэхүү гэрээнд оролцдоггүй эсхүл оролцдог ч II бүлгийн заалтад хамаардаггүй улсын харьяат, эсхүл тухайн улсад байнга оршин суугч байсан ч олон улсын урьдчилсан шүүлт хийхийг шаардах эрхийг тэдэнд Ассамблей олгож болно.

(3) Олон улсын урьдчилсан шүүлт хийх шаардлагыг олон улсын мэдүүлгээс тусад нь гаргана. Энэ шаардлага нь тогтоосон хэлээр, тогтоосон хэлбэрээр үйлдэгдэх бөгөөд тогтоосон мэдээ баримтыг агуулсан байна.

(4) (a) Шаардлагад хэлэлцэн тохирогч улс, эсхүл мэдүүлэг гаргагч өөрөө олон улсын урьдчилсан шүүлтийн үр дүнг ашиглах зорилгоор сонгосон улсуудыг ("сонгосон улсууд") тодорхойлсон байх шаардлагатай. Нэмж сонгох хэлэлцэн тохирогч улсуудыг дараа нь жич сонгож болно. Сонголтыг зөвхөн 4 дүгээр зүйлийн дагуу урьд нь нэрлэсэн хэлэлцэн тохирогч улсуудын дундаас хийнэ.

(b) (2) дахь хэсгийн (a) дэд хэсэгт дурьдсан мэдүүлэг гаргагчид II бүлгийн заалтад хамаарах хэлэлцэн тохирогч аль ч улсыг сонгох эрхтэй. (2) дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурьдсан мэдүүлэг гаргагчид нь II бүлгийн заалтад хамаарах дурдсан мэдүүлэг гаргагчдын сонгосон улс байхаас татгалзахгүй гэдгээ зарласан хэлэлцэн тохирогч улсыг л сонгох эрхтэй.

(5) Шаардлага гаргахын өмнө зохих хураамжийг тогтоосон хугацаанд төлсөн байна.

(6) (a) Шаардлагыг 32 дугаар зүйлд дурьдсан олон улсын урьдчилсан шүүлт хийх эрх бүхий Байгууллагад өгнө.

(b) Аливаа нэмэлт сонголт хийх хүсэлтийг олон улсын товчоонд гаргана.

(7) Сонгосон тухайгаа сонгосон байгууллага бүрд мэдэгдэнэ.

32 дугаар зүйл

Олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага

(1) Олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага олон улсын урьдчилсан шүүлтийг хийнэ.

(2) 31 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан шаардлагыг гаргасан тохиолдолд хүлээн авагч байгууллага, харин 31 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн (б) дэд хэсэгт дурдсан шаардлагыг гаргасан тохиолдолд Сонирхогч байгууллага, олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагууд болон олон улсын товчооны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу Ассамблей, урьдчилсан шүүлт хийх эрх бүхий олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага эсхүл байгууллагуудыг тодорхойлно.

(3) 16 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн заалтыг олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагуудын хувьд зохих найруулгатайгаар хэрэглэнэ.

33 дугаар зүйл

Олон улсын урьдчилсан шүүлт

(1) Олон улсын урьдчилсан шүүлтийн зорилго нь мэдүүлсэн бүтээл нь шинэ эсэх, шинэ бүтээлийн түвшин агуулж байгаа эсэх (илэрхий бус) болон аж үйлдвэрлэлд хэрэглэх боломжтой эсэх талаар урьдчилсан буюу заавал мөрдлөг болгохгүй дүгнэлт хийхэд оршино.

(2) Журамд тодорхойлсон техникийн урьдах түвшин мэдүүлсэн шинэ бүтээлийг үгүйсгэхгүй байвал олон улсын урьдчилсан шүүлтийн зорилгын үүднээс мэдүүлсэн бүтээлийг шинэ гэж үзнэ.

(3) Журамд тодорхойлсон техникийн түвшинг авч үзэхэд тогтоосон хугацаанд тухайн салбарын мэргэжилтнүүдэд илэрхий бус байвал мэдүүлсэн бүтээлийг олон улсын урьдчилсан шүүлтийн зорилгын үүднээс шинэ бүтээлийн түвшинтэй гэж үзнэ.

(4) Мэдүүлсэн шинэ бүтээл нь өөрийн шинж чанараараа аж үйлдвэрийн аль нэг салбарт хэрэгжүүлэх эсхүл ашиглаж (технологийн утгаар) болохоор байвал түүнийг олон улсын урьдчилсан шүүлтийн зорилгын үүднээс үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой гэж үзнэ. "Үйлдвэр" гэдгийг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид тодорхойлсон хамгийн өргөн утгаар ойлговол зохино.

(5) Дээр дурдсан шалгуурууд нь зөвхөн олон улсын урьдчилсан шүүлт хийх зорилгод үйлчилнэ. Хэлэлцэн тохирогч аливаа улс нь мэдүүлсэн шинэ бүтээл тухайн улсад патентлаг чанартай эсэхийг шийдвэрлэхдээ нэмэлт буюу өөр бусад шалгуурыг хэрэглэж болно.

(6) Олон улсын урьдчилсан шүүлт хийхэд олон улсын хайлтын тайланд нэр заасан бүх баримт бичгүүдийг хянаж үзнэ. Түүнчлэн тухайн тодорхой тохиолдолд хамаатай гэж үзсэн бусад ямар ч баримт бичгийг мөн ашиглаж болно.

34 дүгээр зүйл

**Олон улсын урьдчилсан шүүлтийн
байгууллагад мөрдөх журам**

(1) Олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагад мөрдөх журам нь энэхүү гэрээ, журам болон олон улсын товчооноос энэхүү гэрээ, журмын дагуу уг байгууллагатай байгуулсан хэлэлцээрийн заалтуудаар тодорхойлогдоно.

(2) (a) Мэдүүлэг гаргагч нь олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагатай амаар болон бичгээр харилцах эрхтэй.

(b) Мэдүүлэг гаргагч нь олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлт гаргахаас өмнө тогтоосон журмаар, тогтоосон хугацаанд шинэ бүтээлийн томъёолол, тодорхойлолт болон зураглалд өөрчлөлт оруулах эрхтэй. Өөрчлөлт нь анх гаргасан олон улсын мэдүүлэгт тодорхойлсон хүрээнд хязгаарлагдана.

(c) Хэрэв олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага дараахь нөхцөлүүд хангагдаагүй байна гэж үзвэл мэдүүлэг гаргагчид саналаа наад зах нь нэг удаа бичгээр мэдээлнэ:

- (i) шинэ бүтээл нь 33 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасан шалгуурт нийцсэн байх;
- (ii) олон улсын мэдүүлэг нь энэхүү гэрээ, журмын шаардлагыг энэ Байгууллагаас тогтоосон хэмжээнд хангасан байх;
- (iii) 35 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу ямар нэгэн шүүмж хийгдээгүй байх (сүүлчийн санал).

(d) Мэдүүлэг гаргагч нь олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагын бичгээр гаргасан саналд хариу өгч болно.

(3) (a) Хэрэв олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага олон улсын мэдүүлэг нь журамд тодорхойлсон шинэ бүтээлийн нэгдмэл байдлын шаардлагыг хангаагүй гэж үзвэл тухайн шаардлагад нийцүүлж томъёоллыг хязгаарлах эсхүл нэмэгдэл хураамж төлөхийн аль нэгийг сонгохыг мэдүүлэг гаргагчид санал болгож болно.

(b) Мэдүүлэг гаргагч (a) дэд хэсэгт заасны дагуу томъёоллыг хязгаарлахыг илүүтэйд үзсэн тохиолдолд хэрэв мэдүүлэг гаргагч тухайн улсын үндэсний байгууллагад тусгай хураамж төлөхгүй бол ийнхүү хязгаарласны улмаас олон улсын мэдүүлгийн олон улсын урьдчилсан шүүлт хийгдээгүй хэсэг нь тухайн улсад үйлчлэхгүй болохыг сонгосон аливаа улс үндэсний хууль тогтоомжоороо тогтоож болно.

(c) Хэрэв мэдүүлэг гаргагч (a) дэд хэсэгт дурьдсан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэхгүй бол олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага, өөрийн үзэж байгаагаар үндсэн шинэ бүтээлд хамаарах олон улсын ийн тухайн хэсгүүдийн талаар дүгнэлт гаргаж дүгнэлтдээ энэ тухай тэмдэглэнэ. Сонгосон улсын үндэсний байгууллага олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагын саналыг үндэслэлтэй гэж

үзсэн тохиолдолд, хэрэв мэдүүлэг гаргагч нь уг үндэсний байгууллагад нэмэлт хураамж төлөхгүй бол үндсэн шинэ бүтээлд хамаарахгүй олон улсын мэдүүлгийн хэсгүүд сонгосон аливаа улсад үйлчлэхгүй болохыг үндэсний хууль тогтоомжоороо тогтоож болно.

(4) (a) Хэрэв олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага:

- (i) олон улсын мэдүүлэг нь журмын дагуу олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага олон улсын урьдчилсан шүүлт хийх үүрэггүй объектод хамаарч байгаа бөгөөд энэ тохиолдолд тус байгууллага тийм шүүлт хийхгүй тухай шийдвэр гаргасан, эсхүл
- (ii) мэдүүлсэн бүтээлийн шинэ шийдэл, шинэ бүтээлийн түвшин /илэрхий бус байдал/, үйлдвэрлэлд ашиглах боломжийн талаар ямар ч тодорхой дүгнэлт хийх боломжгүй хэмжээнд шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол болон зураглалыг үйлдсэн эсхүл шинэ бүтээлийн тодорхойлолтод түүний томъёоллыг хангалтгүй илэрхийлсэн бол дурьдсан байгууллага 33 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн дагуу мэдүүлгийг хянаж үзэхгүй бөгөөд энэ шийдвэр болон түүнийг гаргах болсон шалтгааны талаар мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

(b) Хэрвээ (a) дэд хэсэгт дурьдсан аль нэг нөхцөл байдал шинэ бүтээлийн томъёоллын аль нэг заалтад эсхүл тухайн заалттай холбоотойгоор илэрвэл, дурдсан дэд хэсгийн заалтыг шинэ бүтээлийн томъёоллын холбогдох заалтад хамааруулан хэрэглэнэ.

35 дугаар зүйл

Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлт

(1) Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг тогтоосон хугацаанд, тогтоосон хэлбэрээр гаргана.

(2) Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтэд мэдүүлсэн шинэ бүтээл аливаа үндэсний хууль тогтоомжийн дагуу патентлаг чадвартай, патентлаг чадваргүй эсэх талаар ямар нэг нотолгоог тусгахгүй. Дүгнэлтэд (3) дахь хэсгийн заалтуудыг харгалзан, олон улсын урьдчилсан шүүлтийн зорилгын үүднээс 33 дугаар зүйлийн (1)-(4) дэх хэсэгт тодорхойлсон бүтээлийн шинэ шийдэл, шинэ бүтээлийн түвшин, шинэ бүтээлийн үйлдвэрлэлд хэрэглэгдэх боломжийг тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа гэж үзэж болох эсэхийг томъёоллын заалт бүрээр нотолно. Энэхүү нотолгоонд тухайн тодорхой нөхцөл байдалд шаардагдах тайлбар бүхий дүгнэлтийг баталгаажуулах баримт бичгүүдийг нэр заана. Журамд заасанчлан нотолгоонд бусад шүүмжийг мөн хавсаргаж болно.

(3) (a) Хэрэв олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага дүгнэлт гаргахдаа 34 дүгээр зүйлийн (4) дэх хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан нөхцөл байдлын аль нэг байна гэсэн дүгнэлтэд хүрвэл олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтэд

тэрхүү дүгнэлт болон түүний үндэслэлийг дурдана. Энэ дүгнэлт нь (2) дахь хэсэгт заасан ямар нэг нотолгоог агуулахгүй.

(b) Хэрэв 34 дүгээр зүйлийн (4) дэх хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан нөхцөл байдал байвал шинэ бүтээлийн томьёоллын дурдсан заалтын талаарх олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтэд (a) дэд хэсэгт заасан дүгнэлтийг тусгаж шинэ бүтээлийн томьёоллын бусад заалтын адил (2) дахь хэсэгт дурдсан нотолгоо бүхий дүгнэлт гаргана.

36 дугаар зүйл

**Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг
илгээх, орчуулах, тараах**

(1) Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг тогтоосон хавсралтын хамт мэдүүлэг гаргагч болон олон улсын товчоонд илгээнэ.

(2) (a) Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлт, түүний хавсралтуудыг тогтоосон хэлээр орчуулна.

(b) Дурдсан дүгнэлтийг олон улсын товчоо өөрөө эсхүл олон улсын товчооны хариуцлагын дор түүний захиалгаар орчуулах ба үүний зэрэгцээ дурдсан хавсралтуудыг мэдүүлэг гаргагч орчуулж болно.

(3) (a) Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг түүний орчуулга (тогтсон ёсоор) болон хавсралтуудын (эх хувийг үйлдсэн хэл дээр хийгдсэн) хамт олон улсын товчооноос сонгосон байгууллага бүрт илгээнэ.

(b) Хавсралтуудын тогтоосон орчуулгыг мэдүүлэг гаргагч сонгосон байгууллагуудад тогтоосон хугацаанд илгээнэ.

(4) 20 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн заалтыг олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтэд нэр заасан болон олон улсын хайлтын тайланд нэр заагаагүй аливаа баримт бичгийн хуулбарын хувьд зохих найруулгатайгаар хэрэглэнэ.

37 дугаар зүйл

**Олон улсын урьдчилсан шүүлт
хийлгэх шаардлага болон улсын сонголтыг эгүүлэн авах**

(1) Мэдүүлэг гаргагч нь аль нэг эсхүл бүх улсыг сонгосноо эгүүлэн авч болно.

(2) Бүх улсыг сонгосноо эгүүлэн авах нь олон улсын урьдчилсан шүүлт хийх шаардлагыг эгүүлэн авсанд тооцогдоно.

(3) (a) Эгүүлэн авсан тухай олон улсын товчоонд мэдэгдэнэ.

(b) Олон улсын товчоо нь холбогдох сонгосон байгууллага болон олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагад мэдэгдэнэ.

(4) (a) Олон улсын урьдчилсан шүүлт хийлгэх шаардлагыг эсхүл хэлэлцэн тохирогч улсыг сонгосноо эгүүлэн авах нь хэрэв тухайн улсын үндэсний хууль тогтоомжоор өөр үр дагавар тогтоогоогүй бол (b) дэд хэсэгт заасанчлан олон улсын мэдүүлгийг энэ улсын хувьд эгүүлэн авсанд тооцно.

(b) Хэрэв 22 дугаар зүйлд заасан зохих хугацаа дуусахаас өмнө шаардлага, сонголтоо эгүүлэн авсан бол ингэж цуцалсны улмаас олон улсын мэдүүлгийг цуцлагдсан гэж үзэж болохгүй. Гэвч аливаа хэлэлцэн тохирогч улс түүний үндэсний байгууллага дурдсан хугацаанд олон улсын мэдүүлгийн хуулбар, түүний орчуулга (тогтоосон ёсоор) болон үндэсний хураамжийг хүлээн авсан тохиолдолд дээр дурьдсан заалтыг хэрэглэж болох тухай үндэсний хууль тогтоомждоо тусгаж болно.

38 дугаар зүйл

Олон улсын урьдчилсан шүүлтийн нууц байдал

(1) Олон улсын товчоо болон олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага мэдүүлэг гаргагчийн хүсэлт эсхүл зөвшөөрөлгүйгээр ямар ч үед, аливаа этгээд, байгууллагад олон улсын урьдчилсан шүүлтийн материалтай танилцахыг /30 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн утгаар болон түүнд заасан нөхцөлийг харгалзан/ зөвшөөрөхгүй. Энэ заалт нь олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлт гарсны дараа сонгосон байгууллагад хэрэглэгдэхгүй.

(2) (1) дэх хэсэг тэрчлэн 36 дугаар зүйлийн (1) ба (3) дахь хэсэг, 37 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн (b) дэд хэсгийн заалтыг харгалзан олон улсын товчоо, олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага нь мэдүүлэг гаргагчийн хүсэлт эсхүл зөвшөөрөлгүйгээр олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлт гаргах эсхүл дүгнэлт гаргахаас татгалзах тухай, тэрчлэн аливаа улсыг сонгосноо болон шаардлагаа цуцлах эсхүл хадгалах тухай мэдээллийг өгөхгүй.

39 дүгээр зүйл

**Сонгосон байгууллагад зориулсан
хуулбар, орчуулга, хураамж**

(1) (a) Хэрэв хэлэлцэн тохирогч аливаа улсыг давамгайлах огнооноос хойш арван есөн сарын дотор сонгосон бол энэ улсад 22 дугаар зүйлийн заалт хамаарахгүй бөгөөд мэдүүлэг гаргагч давамгайлах огнооноос хойш гучин сарын дотор олон улсын мэдүүлгийн хуулбар (20 дугаар зүйлд заасны дагуу нэгэнт тарааснаас бусад тохиолдолд), түүний орчуулгыг (тогтоосон ёсоор) сонгосон байгууллага бүрт илгээх ба тэрчлэн үндэсний хураамж (хэрэв тэгж заасан бол) төлнө.

(b) (a) дэд хэсэгт дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд аливаа үндэсний хууль тогтоомжоор энэ дэд хэсэгт зааснаас хожуу дуусах хугацааг тогтоож болно.

(2) Хэрэв мэдүүлэг гаргагч (1) дэх хэсгийн (a) дэд хэсэгт заасан үйлдлийг (1) дэх хэсгийн (a), (b) дэд хэсэгт дурдсан хугацаанд гүйцэтгээгүй бол 11 дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт заасан олон улсын мэдүүлгийн үйлчлэлийг эгүүлэн авах нь сонгосон

улсын хувьд, тухайн улсын үндэсний аливаа мэдүүлгийг цуцлахтай адил үр дагавартай байна.

(3) Аливаа сонгосон байгууллага мэдүүлэг гаргагч (1) дэх хэсгийн (а),(b) дэд хэсэгт заасан шаардлагыг биелүүлээгүй байсан ч 11 дүгээр зүйлийн (3) дахь хэсэгт заасан олон улсын мэдүүлгийн үйлчлэлийг хэвээр хадгалж болно.

40 дүгээр зүйл

Үндэсний шүүлт болон бусад ажиллагааг хойшлуулах

(1) Хэрэв хэлэлцэн тохирогч аль нэг улсыг давамгайлах огнооноос хойш 19 сарын дотор сонгосон бол тухайн улсын хувьд 23 дугаар зүйлийн заалтыг хэрэглэхгүй бөгөөд энэ улсын үндэсний байгууллага эсхүл энэ улсын нэрийн өмнөөс ажилладаг байгууллага (2) дахь хэсгийн заалтыг харгалзан, 39 дүгээр зүйлд дурдсан хугацааг дуустал олон улсын мэдүүлэгт шүүлт хийх болон бусад ажиллагаа явуулахгүй.

(2) Сонгосон аливаа байгууллага (1) дэх хэсэгт заасныг үл харгалзан мэдүүлэг гаргагчийн тусгай хүсэлтээр ямар ч хугацаанд олон улсын мэдүүлэгт шүүлт хийх болон бусад ажиллагаа явуулж болно.

41 дүгээр зүйл

Сонгосон байгууллагад шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол, зураглалыг өөрчлөх

(1) Сонгосон байгууллага бүр мэдүүлэг гаргагчид шинэ бүтээлийн томъёолол, тодорхойлолт, зураглалд тогтоосон хугацаанд өөрчлөлт оруулах боломж олгоно. Сонгосон байгууллага мэдүүлэг гаргагч тусгай зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд тогтоосон хугацаа дуусахаас өмнө патент олгож болохгүй, олгохоос татгалзаж болохгүй.

(2) Сонгосон улсын үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөөгүй бол өөрчлөлт нь анх гаргасан олон улсын мэдүүлэгт тайлбарласан хүрээнд хязгаарлагдана.

(3) Өөрчлөлт нь энэхүү гэрээ, журамд заагаагүй бүх тохиолдолд сонгосон улсын үндэсний хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байх ёстой.

(4) Хэрэв сонгосон байгууллага олон улсын мэдүүлгийн орчуулгыг ирүүлэхийг шаардсан бол өөрчлөлтийг орчуулга хийсэн хэл дээр үйлдэж ирүүлнэ.

42 дугаар зүйл

Сонгосон байгууллагын үндэсний шүүлтийн үр дүн

Сонгосон байгууллага, олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг авахдаа баримт бичгийн хуулбар эсхүл бусад сонгосон аливаа байгууллагад олон улсын нэг мэдүүлэгт хийсэн шүүлтэд хамаарах ямар нэгэн баримт бичгийн агуулгын тухай мэдээлэл ирүүлэхийг мэдүүлэг гаргагчаас шаардаж болохгүй.

**III БҮЛЭГ
НИЙТЛЭГ ЗААЛТ**

43 дугаар зүйл

Хамгаалалтын тодорхой төрлийг хүсэх

Зохиогчийн гэрчилгээ, ашигтай байдлын гэрчилгээ, ашигтай загварын гэрчилгээ, нэмэлт патент, нэмэлт гэрчилгээ, зохиогчийн нэмэлт гэрчилгээ, ашигтай байдлын нэмэлт гэрчилгээ олгохоор хууль тогтоомждоо тусгасан аливаа нэр заасан буюу сонгосон улсын хувьд журамд заасны дагуу мэдүүлэг гаргагч нь тухайн улсын хувьд түүний олон улсын мэдүүлэгт патент биш, харин зохиогчийн гэрчилгээ, ашигтай байдлын гэрчилгээ, ашигтай загвар, нэмэлт патент эсхүл нэмэлт гэрчилгээ, зохиогчийн нэмэлт гэрчилгээ эсхүл ашигтай байдлын нэмэлт гэрчилгээ хүссэнийг зааж болох ба үр дагавар нь мэдүүлэг гаргагчийн ийнхүү заасны дагуу тодорхойлогдоно. Энэхүү зүйл болон түүнд хамааралтай аливаа дүрэм журмын зорилгод 2 дугаар зүйлийн (ii)-т заасныг хэрэглэхгүй.

44 дүгээр зүйл

Хамгаалалтын хоёр төрлийг хүсэх

Патент эсхүл 43 дугаар зүйлд заасан хамгаалалтын аль нэг төрлийг хүсэхийн зэрэгцээ дурьдсан өөр бусад төрлийн хамгаалалт хүсэж болохыг хууль тогтоомжоороо зөвшөөрсөн, нэрлэсэн эсхүл сонгосон улсын хувьд мэдүүлэг гаргагч нь, журамд заасны дагуу хүсэж буй хамгаалалтын хоёр төрлийг зааж болох бөгөөд үр дагавар нь мэдүүлэг гаргагчийн ийнхүү заасны дагуу тодорхойлогдоно. Энэ зүйлийн зорилгод 2 дугаар зүйлийн (ii) заалтыг хэрэглэхгүй.

45 дугаар зүйл

Бүс нутгийн патентын тухай гэрээ

(1) Бүс нутгийн патент олгох тухай болон (Бүс нутгийн патентын тухай гэрээ), 9 дүгээр зүйлд заасны дагуу, олон улсын мэдүүлэг гаргах эрх бүхий бүх этгээдэд бүс нутгийн патент авах мэдүүлэг гаргах эрх олгосон аливаа гэрээнд бүс нутгийн патентын тухай гэрээ болон энэхүү гэрээнд хоёуланд нь оролцогч улсыг нэрлэсэн эсхүл сонгосон олон улсын мэдүүлгийг бүс нутгийн патент авах мэдүүлгийн нэгэн адилаар гаргаж болох тухай тусгаж болно.

(2) олон улсын мэдүүлэгт дурдсан тухайн улсын аливаа нэрлэлт эсхүл сонголтыг бүс нутгийн патентын тухай гэрээний дагуу бүс нутгийн патент авах тухай мэдэгдэл гаргагчийн хүсэлтэд тооцох тухай нэрлэсэн эсхүл сонгосон улсын үндэсний хууль тогтоомжид тусгаж болно.

46 дугаар зүйл

Олон улсын мэдүүлгийн буруу орчуулга

Хэрэв олон улсын мэдүүлгийн дагуу олгосон аль нэг патентаас үүдэн гарч буй хамгаалалтын хэмжээ олон улсын мэдүүлгийг буруу орчуулсны улмаас олон улсын

мэдүүлгийн эхийг үйлдсэн хэл дээр гаргасан мэдүүлгээр хүссэн хамгаалалтын хэмжээнээс хэтэрч байвал сонирхогч хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага патентаас үүдэн гарч буй хамгаалалтын хэмжээг хамгаалалтын зохих хэмжээнд хүртэл болон эргэж үйлчлэхээр хязгаарлаж, хэтэрсэн хэмжээг хүчингүйд тооцсоныг зарлах, олон улсын өийн эхийг үйлдсэн хэл дээр гаргасан мэдүүлгээр хүссэн хамгаалалтын хэмжээнээс хэтэрч байгаа хэсгийг цуцлах эрхтэй.

47 дугаар зүйл

Хугацаа

(1) Энэхүү гэрээнд заасан хугацааг тооцох тодорхой нарийвчлалыг журмаар тодорхойлно.

(2) (a) Энэхүү гэрээний I, II бүлэгт тогтоосон бүх хугацааг 60 дугаар зүйлд заасны дагуу хянан өөрчлөхөөс бусад тохиолдолд хэлэлцэн тохиролцогч улсуудын шийдвэрээр өөрчилж болно.

(b) Дээрх шийдвэр нь чуулганаар эсхүл бичгээр харилцаж авсан санал хураалтаар санал нэгтэй батлагдсан байх ёстой.

(c) Горимын бусад дэлгэрэнгүй зүйлийг журмаар тодорхойлно

48 дугаар зүйл

Зарим тохиолдолд хугацааг хэтрүүлэх

(1) Хэрэв энэхүү гэрээ болон журамд тогтоосон аливаа хугацааг шуудангийн үйлчилгээнд саатал гарсан, зайлшгүй хохирол учирсан, эсхүл илгээмж саатсан шалтгаанаар хугацаа хэтрүүлсэн боловч журамд тодорхойлсон бусад болзлыг зөрчөөгүй бөгөөд нотолгоо гаргасан бол дээрх хугацааг журамд тусгаснаар мөрдсөнд тооцно.

(2) (a) Хэлэлцэн тохирогч аливаа улс үндэснийхээ хууль тогтоомжид заасан шалтгаанаар тухайн улсад хугацаа мөрдөхөд гарах аливаа саатлыг зөвшөөрнө.

(b) Хэлэлцэн тохирогч аливаа улс тухайн улсад хугацаа мөрдөхөд, (a) дэд хэсэгт дурдсанаас бусад шалтгаанаар гарах аливаа саатлыг зөвшөөрч болно.

49 дүгээр зүйл

Олон улсын байгууллагад хэрэг хөтлөх эрх

Олон улсын мэдүүлэг гаргасан үндэсний байгууллагад хэрэг хөтлөх эрх бүхий аливаа итгэмжлэгдсэн төлөөлөгч, патентын төлөөлөгч эсхүл бусад этгээд тухайн мэдүүлгийн талаар олон улсын товчоо, эрх бүхий олон улсын хайлтын байгууллагад болон эрх бүхий олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагад мөн хэрэг хөтлөх эрхтэй.

IV БҮЛЭГ ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

50 дугаар зүйл

Патентын мэдээллийн салбарын үйлчилгээ

(1) Олон улсын товчоо нь хэвлэн нийтлэгдсэн баримт бичиг, юуны өмнө патент, хэвлэн нийтлэгдсэн мэдүүлэгт үндэслэн олж авсан техникийн болон ямарваа бусад зохих мэдээлэл өгөх замаар энэхүү зүйлд "мэдээллийн үйлчилгээ" гэж нэрлэсэн үйлчилгээг үзүүлж болно.

(2) Олон улсын товчоо нь мэдээллийн эдгээр үйлчилгээг шууд буюу олон улсын хэд хэдэн хайлтын байгууллагаар дамжуулан, эсхүл олон улсын товчоотой хэлэлцээр байгуулж болох үндэсний эсхүл олон улсын мэдээллийн төрөлжсөн бусад байгууллагаар дамжуулан гүйцэтгэж болно.

(3) Мэдээллийн үйлчилгээг техникийн мэдлэг, технологи, түүний дотор хэвлэн нийтлэгдсэн "ноу-хау"-г олж авахад нь, ялангуяа хөгжиж буй хэлэлцэн тохирогч улсуудад тус дөхөм үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

(4) Мэдээллийн үйлчилгээг хэлэлцэн тохирогч улсуудын засгийн газар, харьяат, эдгээр улсад байнга оршин сууж буй хүмүүст үзүүлнэ. Ассамблей уг үйлчилгээг бусад хүмүүст ч үзүүлж болох тухай шийдвэр гаргаж болно.

(5) (a) Хэлэлцэн тохирогч улсуудын засгийн газарт аливаа үйлчилгээг үзүүлэхдээ өөрийн өртгөөр төлбөр авна, гэвч энэ нь хөгжиж буй хэлэлцэн тохирогч улсын засгийн газар бол төлбөрийн ялгааг хэлэлцэн тохирогч улсуудын засгийн газарт бус бусад этгээдэд үзүүлсэн үйлчилгээний ашгаас эсхүл 51 дүгээр зүйлийн (4) дэх хэсэгт дурьдсан эх үүсвэрээс нөхөх боломжтой тохиолдолд, харьцангуй бага үнээр үйлчилнэ.

(b) (a) дэд хэсэгт дурьдсан төлбөрийг үндэсний байгууллагын үзүүлсэн үйлчилгээ болон олон улсын шүүлтийн байгууллага хүлээсэн үүргээ биелүүлсний төлбөрөөс давсан буюу гадуурх үйлчилгээний төлбөр гэж ойлгоно.

(6) Энэхүү зүйлийн заалтуудыг хэрэглэх нарийвчилсан журмыг Ассамблейн шийдвэрээр, Ассамблейгаас тогтоосон хэмжээнд, энэ зорилгоор Ассамблейгаас байгуулж болох ажлын хэсгүүдээс тогтоосон хэмжээнд тодорхойлно.

(7) Ассамблей шаардлагатай гэж үзсэн үедээ (5) дахь хэсэгт заасан журамд нэмэлт болгон, санхүүжилтийн журмыг санал болгоно.

51 дүгээр зүйл

Техникийн тусламж

(1) Ассамблей техникийн тусламжийн хороо (энэ зүйлд "хороо" гэж нэрлэнэ) байгуулна.

(2) (a) Хорооны гишүүдийг хөгжиж буй орнуудын төлөөллийг зохих ёсоор харгалзан хэлэлцэн тохирогч улсуудаас сонгоно.

(b) Ерөнхий захирал өөрийн санаачилгаар эсхүл хорооны хүсэлтээр хөгжиж буй орнуудад техникийн тусламж үзүүлэх асуудал эрхэлдэг засгийн газар хоорондын байгууллагуудын төлөөлөгчдийг хорооны ажилд оролцуулахаар урина.

(3) (a) Хорооны зорилго нь хөгжиж буй хэлэлцэн тохирогч улсуудад үзүүлэх техникийн тусламжийг зохион байгуулах, хянах, тэдгээрийн патентын системийг үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хөгжүүлэхэд оршино.

(b) Техникийн тусламж нь эдгээрээс гадна мэргэжилтэн бэлтгэх, шинжээчдийг томилох, сурталчлах болон практикт нэвтрүүлэх зорилгоор тоног төхөөрөмж нийлүүлэх зэргээс бүрдэнэ.

(4) Энэ зүйлд заасны дагуу төслүүдийг санхүүжүүлэхийн тулд олон улсын товчоо, нэг талаас, олон улсын санхүүгийн байгууллагууд, засгийн газар хоорондын байгууллагууд, тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагатай холбоотой бөгөөд техникийн тусламж үзүүлэх асуудал эрхэлсэн төрөлжсөн байгууллагууд, нөгөө талаас, техникийн тусламж авч буй улсуудын засгийн газартай хэлэлцээр байгуулахыг эрмэлзэнэ.

(5) Энэхүү зүйлийн заалтуудыг хэрэглэх тухай тодорхой нарийвчлалыг энэ зорилгоор Ассамблейгаас байгуулж болох Ассамблейн ажлын хэсгүүдийн тогтоосон хэмжээнд Ассамблейн шийдвэрээр тодорхойлно.

52 дугаар зүйл

Гэрээний бусад заалттай холбогдох

Энэхүү бүлэг гэрээний бусад бүлэгт заасан санхүүгийн холбогдолтой заалтуудыг хөндөхгүй. Эдгээр заалт энэхүү бүлэгт эсхүл түүнийг хэрэглэхэд хамаарахгүй.

V БҮЛЭГ ЗАХИРГААНЫ ЗААЛТУУД

53 дугаар зүйл

Ассамблей

(1) (a) 57 дугаар зүйлийн (8) дахь хэсэгт заасны дагуу Ассамблей нь хэлэлцэн тохирогч улсуудаас бүрдэнэ.

(b) Хэлэлцэн тохирогч улс бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(2) (a) Ассамблей нь:

(i) холбоог удирдах, хөгжүүлэх болон энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх асуудлыг эрхэлнэ;

- (ii) энэхүү гэрээний бусад заалтаар түүнд тусгайлан ногдуулсан үүргийг гүйцэтгэнэ;
- (iii) гэрээг хянан өөрчлөх бага хуралд бэлтгэх талаар олон улсын товчоонд заавар өгнө;
- (iv) байгууллагын ерөнхий захирлаас холбооны талаар явуулсан үйл ажиллагааны тайланг хянаж батлах, холбооны эрх мэдэлд багтах бүх асуудлаар шаардлагатай бүх зааврыг түүнд өгнө;
- (v) (9) дахь хэсэгт заасны дагуу байгуулагдсан гүйцэтгэх хорооны тайлан болон үйл ажиллагааг хянаж баталж, түүнд чиглэл өгнө;
- (vi) холбооны хөтөлбөрийг тодорхойлж, гурван жилийн төсөв болон түүний санхүүгийн тайланг батална /жич: 1980 оноос хойш холбоо хоёр жилийн төсөвтэй болов/;
- (vii) холбооны санхүүгийн журмыг батална;
- (viii) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзэх хороо, ажлын хэсгүүдийг байгуулна;
- (ix) хэлэлцэн тохирогч бус ямар орон, түүнчлэн (8) дахь хэсгийг харгалзан ямар засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагыг түүний чуулганд ажиглагчаар оролцуулж болохыг тодорхойлно;
- (x) холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн болон энэхүү гэрээнээс үүдэн гарч буй аливаа бусад шаардлагатай арга хэмжээ авна.

(b) Байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын сонирхсон асуудлын хувьд Ассамблей байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг сонссоны дараа шийдвэр гаргана.

(3) Төлөөлөгч нэг улсыг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгөх эрхтэй.

(4) Хэлэлцэн тохирогч улс бүр нэг санал өгөх эрхтэй.

(5) (a) Хэлэлцэн тохирогч улсуудын тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(b) Кворум бүрдээгүй үед Ассамблей өөрийн ажиллагааны журамд хамаарахаас бусад бүх шийдвэр гаргаж болно. Ийм шийдвэрийг журамд заасны дагуу харилцаж, шаардагдах олонхын саналыг авсан болон кворум бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.

(6) (a) 47 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсэг, 58 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (b) дэд хэсэг, 58 дугаар зүйлийн (3) дахь хэсэг ба 61 дүгээр зүйлийн

(2) дахь хэсгийн (b) дэд хэсгийг харгалзан Ассамблей нь санал хураалтад оролцогсдын гуравны хоёрын олонхын саналаар шийдвэр гаргана.

(b) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(7) II бүлгийг дагаж мөрддөг улсуудын онцгой сонирхож буй асуудлаар (4), (5), (6) дахь хэсэгт хэлэлцэн тохирогч улсуудад хамаарах аливаа заалтыг зөвхөн II бүлгийг дагаж мөрддөг улсуудад хамаарна гэж үзнэ.

(8) Олон улсын хайлтын байгууллага эсхүл олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагаар томилогдсон, засгийн газар хоорондын аливаа байгууллагыг Ассамблейн чуулганд ажиглагчаар оролцуулна.

(9) Хэлэлцэн тохирогч улсын тоо дөчөөс хэтэрч байвал Ассамблей гүйцэтгэх хороо байгуулна. Энэхүү гэрээ болон журмын гүйцэтгэх хороонд хамаарах заалтыг уг хороог байгуулснаас хойш түүнд хамаарна гэж үзнэ.

(10) Гүйцэтгэх хороог байгуулахаас өмнө Ассамблей хөтөлбөр, гурван жилийн төсвийн хүрээнд ерөнхий захирлын бэлтгэсэн жилийн хөтөлбөр, төсвийг батална.

(11) (a) Онцгой тохиолдлоос бусад тохиолдолд ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг байгууллагын Ерөнхий Ассамблей чуулдаг газар болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны буюу хэлэлцэн тохирогч улсуудын дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу Ассамблей ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.

(12) Ассамблей өөрийн үйл ажиллагааны журмыг батална.

54 дүгээр зүйл

Гүйцэтгэх хороо

(1) Гүйцэтгэх хороо нь Ассамблейгаас байгуулагдсаныхаа дараа дараахь заалтуудыг удирдлага болгоно:

(2) (a) 57 дугаар зүйлийн (8) дахь хэсгийн заалтыг харгалзан гүйцэтгэх хороо нь Ассамблей Ассамблейн гишүүн орнуудаас сонгосон улсуудаас бүрдэнэ.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүн улсын засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(3) Гүйцэтгэх хорооны гишүүн улсын тоо нь Ассамблейн гишүүн нийт орны дөрөвний нэгтэй тэнцүү байна. Эзэлбэл зохих суудлын тоог тодорхойлохдоо дөрөвт хуваасны дараахь үлдэгдлийг тооцоонд авахгүй.

(4) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгохдоо Ассамблей газар зүйн шударга хуваарилалтад зохих ёсоор анхаарна.

(5) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн бүр түүнийг сонгосон Ассамблейн чуулган хааснаас хойш Ассамблейн дараагийн ээлжит чуулган хаах хүртэл үүргээ хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүд дахин сонгогдож болох бөгөөд гэхдээ тоо нь уг бүрэлдэхүүний гуравны хоёроос хэтэрч болохгүй.

(c) Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгох, дахин сонгох тухай тодорхой дүрмийг Ассамблей тогтооно.

(6) (a) Гүйцэтгэх хороо нь:

- (i) Ассамблейн хэлэлцэх асуудлын дэгийн төслийг бэлтгэнэ;
- (ii) ерөнхий захирлын бэлтгэсэн холбооны хоёр жилийн төсөв, хөтөлбөрийн төслийн талаарх саналыг Ассамблейд оруулна;
- (iii) (хасагдсан);
- (iv) ерөнхий захирлын болон санхүүгийн жилийн аудитын тайланг саналын хамт Ассамблейд оруулна;
- (v) Ассамблейн шийдвэрийн дагуу болон Ассамблейн ээлжит чуулганы хооронд буй болсон нөхцөл байдлыг харгалзан ерөнхий захирал холбооны хөтөлбөрийг биелүүлэх явдлыг хангахад шаардагдах бүх арга хэмжээ авна;
- (vi) энэхүү гэрээний дагуу түүнд оноосон бусад бүх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(b) Гүйцэтгэх хороо нь захиргааны үүргийг нь байгууллага хэрэгжүүлдэг бусад холбооны сонирхолд хамаарах асуудлаар байгууллагын зохицуулах хорооны саналыг сонссоны дараа шийдвэр гаргана.

(7) (a) Ерөнхий захирал гүйцэтгэх хорооны ээлжит хуралдааныг байгууллагын зохицуулах хороо хуралддаг газар болон хугацаанд жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал өөрийн санаачилгаар эсхүл хорооны даргын эсхүл гүйцэтгэх хорооны гишүүдийн дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу гүйцэтгэх хорооны ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

(8) (a) Гүйцэтгэх хорооны гишүүн улс бүр нэг санал өгөх эрхтэй.

(b) Гүйцэтгэх хорооны гишүүдийн улсуудын тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(c) Санал хураалтад оролцогсдын энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.

(d) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(е) Төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.

(9) Гүйцэтгэх хорооны гишүүн бус хэлэлцэн тохирогч улсыг олон улсын хайлтын байгууллага эсхүл олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагаар томилогдсон засгийн газар хоорондын аль ч байгууллагын нэгэн адил тус хорооны хуралдаанд ажиглагчаар оролцуулна.

(10) Гүйцэтгэх хороо өөрийн үйл ажиллагааны журмыг батална.

55 дугаар зүйл

Олон улсын товчоо

(1) Холбооны захиргааны зорилтыг олон улсын товчоо хэрэгжүүлнэ.

(2) Олон улсын товчоо холбооны төрөл бүрийн байгууллагын нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

(3) Ерөнхий захирал холбооны гүйцэтгэх тэргүүн болох бөгөөд холбоог төлөөлнө.

(4) Олон улсын товчоо мэдээллийн товхимол болон журамд заасан буюу Ассамблейгаас тодорхойлсон бусад хэвлэлийг нийтлэх асуудлыг эрхэлнэ.

(5) Олон улсын товчоо, олон улсын хайлтын байгууллага, олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагуудад энэхүү гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхэд нь тус дөхөм болох үүднээс үндэсний байгууллагаас тэдгээрт үзүүлэх үйлчилгээг журмаар тодорхойлно.

(6) Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа ажилтан Ассамблей, гүйцэтгэх хорооны болон энэхүү гэрээ эсхүл журмын дагуу байгуулсан бусад аливаа хороо буюу ажлын хэсгийн бүх хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа ажилтан өөрийн албан тушаалын дагуу эдгээр байгууллагын нарийн бичгийн дарга байна.

(7) (a) Олон улсын товчоо Ассамблейгаас өгсөн чиглэлийн дагуу болон гүйцэтгэх хороотой хамтран хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг хангана.

(b) Олон улсын товчоо хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажилтай холбогдуулан олон улсын засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал болон түүний томилсон ажилтан тэдгээр бага хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

(8) Олон улсын товчоо түүнд оногдуулсан бусад бүх даалгаврыг гүйцэтгэнэ.

56 дугаар зүйл

Техникийн хамтын ажиллагааны хороо

(1) Ассамблей техникийн хамтын ажиллагааны хороо (энэ зүйлд "хороо" гэнэ) байгуулна.

(2) (a) Ассамблей хорооны бүрэлдэхүүнийг тодорхойлж, түүний гишүүдийг хөгжиж буй орнуудын төлөөллийг шударгаар хангасан байхаар томилно.

(b) Олон улсын хайлтын байгууллага, олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага нь хорооны албан ёсны бус гишүүд байна. Хэлэлцэн тохирогч улсын үндэсний байгууллага тийм байгууллагын үүрэг гүйцэтгэж байвал, хороонд тухайн улсаас нэмэлт төлөөлөгч оруулахгүй.

(c) Хэлэлцэн тохирогч улсуудын тоо хүрэлцээтэй бол хорооны гишүүдийн нийт тоо түүний албан ёсны бус гишүүдийн тооноос хоёр дахин олон байх ёстой.

(d) Ерөнхий захирал холбогдогч байгууллагуудыг тэдний сонирхож буй асуудлыг хэлэлцэхэд санаачилгаараа эсхүл хорооны хүсэлтээр урьж оролцуулна.

(3) Хорооны зорилт нь санал, зөвлөмж бэлтгэх замаар дараахь үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино. Үүнд:

- (i) энэхүү гэрээнд заасан үйлчилгээг байнга боловсронгуй болгох;
- (ii) хэд хэдэн олон улсын хайлтын байгууллага, олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллага үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд баримт бичиг, ажлын арга барилыг нэг хэв загварт оруулах, тайлан, дүгнэлтийн ижил өндөр чанарыг дээд зэргээр хангах;
- (iii) Ассамблей болон гүйцэтгэх хорооны санаачилгаар техник үйл ажиллагааны тулгамдсан асуудлууд, ялангуяа олон улсын хайлт хийх нэгдсэн байгууллага байгуулахтай холбоотой асуудлаар шийдвэр гаргах.

(4) Аливаа хэлэлцэн тохирогч улс, аливаа сонирхогч олон улсын байгууллага өөрийн эрх мэдэлд хамаарах аль ч асуудлаар хороонд бичгээр хандаж болно.

(5) Хороо өөрийн санал, зөвлөмжөө ерөнхий захиралд эсхүл түүгээр дамжуулан Ассамблейд, гүйцэтгэх хороонд, бүх эсхүл зарим олон улсын хайлтын байгууллагад, түүнчлэн бүх эсхүл зарим хүлээн авагч байгууллагад өгч болно.

(6) (a) Ерөнхий захирал ямар ч тохиолдолд хорооны санал, зөвлөмжийн эх бичвэрийг гүйцэтгэх хороонд явуулна. Ерөнхий захирал эдгээр эх бичвэрийг тайлбарлах эрхтэй.

(b) Гүйцэтгэх хороо, хорооны ямар ч санал, зөвлөмжийн талаар болон бусад үйл ажиллагааны талаар саналаа илэрхийлж, тэрчлэн өөрийн эрх мэдэлд хамаарах аливаа асуудлыг судлах, энэ тухай илтгэхийг хороонд даалгаж болно.

Гүйцэтгэх хороо нь хорооны санал, зөвлөмж, илтгэлийг зохих тайлбарын хамт Ассамблейд хэлэлцүүлэхээр оруулж болно.

(7) Гүйцэтгэх хороо байгуулагдах хүртэл (6) дахь хэсэгт заасан гүйцэтгэх хороод хамаарах заалтыг Ассамблейд хамааруулна.

(8) Хорооны үйл ажиллагааны нарийвчилсан журмыг Ассамблейн шийдвэрээр тодорхойлно.

57 дугаар зүйл

Санхүү

(1) (a) Холбоо төсөвтэй байна.

(b) Холбооны төсөв нь холбооны орлого, зарлага, холбооны зардлаас холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт орох хандив зэргээс бүрдэнэ.

(c) Холбоонд бус харин байгууллагын удирдлаган дор ажилладаг нэг буюу хэд хэдэн бусад холбоодод хамаарах зардлыг холбоодод хамаарах нийтийн зардал гэж үзнэ. Энэхүү нийтийн зардлаас холбоонд оногдох хувь нь тэдгээр холбоод дахь холбооны сонирхлын эзлэх хэмжээтэй адил байна.

(2) Холбооны төсвийг байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) (5) дахь хэсэгт заасныг харгалзан холбооны төсөв дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

- (i) холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамж;
- (ii) холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтын үнэ, түүнийг ашиглуулсны хураамж;
- (iii) бэлэг, гэрээслэлээр шилжүүлсэн зүйл, татаас;
- (iv) түрээс, зээлийн хүү болон бусад орлого.

(4) Олон улсын товчооны үйлчилгээний хураамж, төлбөрийн хэмжээ, түүнчлэн хэвлэн нийтлэлийн үнийг, хэвийн нөхцөлд олон улсын товчооноос энэхүү гэрээнд хамаарах захиргааны үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх зардлыг нөхөж чадахуйц байдлаар тогтооно.

(5) (a) Санхүүгийн аль нэг жил алдагдалтай дууссан тохиолдолд хэлэлцэн тохиролцогч улсууд (b), (c) дэд хэсгийн заалтыг харгалзан уг алдагдлыг нөхөх татвар төлөх үүрэгтэй.

(b) Хэлэлцэн тохирогч улс бүрийн татварын хэмжээг тухайн жилд улс тус бүрээс гаргасан олон улсын мэдүүлгийн тоог зохих ёсоор харгалзан Ассамблей тогтооно.

(с) Хэрэв бүх алдагдал, түүний аль нэг хэсгийг нөхөх бусад түр эх үүсвэр байвал Ассамблей энэ алдагдлыг дараа жилд шилжүүлэх, хэлэлцэн тохирогч улсуудаас татвар төлөхийг шаардахгүй байх шийдвэр гаргаж болно.

(d) Холбооны санхүүгийн байдал боломжтой бол (a) дэд хэсэгт заасны дагуу төлсөн аливаа татварыг хэлэлцэн тохирогч улсуудад тэдний татвар төлсөн хэмжээгээр нөхөн олгох шийдвэрийг Ассамблей гаргаж болно.

(e) Хэлэлцэн тохирогч улс (b) дэд хэсэгт заасны дагуу Ассамблейгаас тогтоосон хугацаанаас хойш хоёр жилийн хугацаанд татвараа төлөөгүй бол холбооны аль ч байгууллагад санал өгөх эрхгүй. Гэхдээ төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд холбооны аливаа байгууллага тухайн оронд санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

(б) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнөх жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(7) (a) Холбоо нь хэлэлцэн тохиролцогч улс бүрээс өгөх нэг удаагийн төлбөрөөс бүрдэх эргэлтийн хөрөнгийн сантай байна. Хэрэв эргэлтийн хөрөнгийн сан хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв сангийн хөрөнгийн зарим хэсэг цаашид хэрэггүй болбол түүнийг хэлэлцэн тохирогч улсуудад эргүүлж олгоно.

(b) Дурдсан санд хэлэлцэн тохирогч улс бүрээс төлөх анхны төлбөрийн хэмжээ, энэ санг нэмэгдүүлэхэд ногдох хувийг 5 дугаар хэсгийн (b) дэд хэсгийн заалтын зарчмыг үндэслэн Ассамблей тогтооно.

(c) Төлбөрийн нөхцөлийг ерөнхий захирлын саналын үндсэн дээр болон байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг авсны дараа Ассамблей тогтооно.

(d) Татварын аливаа нөхөн төлөлтийг татвар төлсөн огноог харгалзан хэлэлцэн тохирогч улс бүрээс төлсөн татварын хэмжээтэй хувь тэнцүү байхаар тогтооно.

(8) (a) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг улстай байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн улс урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг байгууллага, тухайн улс хоорондын тусдаа хэлэлцээрээр зохицуулна. Тухайн орон урьдчилгаа өгөх үүрэг өөртөө хүлээж байгаа хугацаандаа Ассамблей болон гүйцэтгэх хороонд тус тус суудалтай байна.

(b) (a) дэд хэсэгт дурдсан улс ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(9) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу хэлэлцэн тохирогч нэг буюу хэд хэдэн улс эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ассамблей томилно.

58 дугаар зүйл

Журам

(1) Энэхүү гэрээнд хавсаргасан журам нь дараахь дүрмийг агуулна:

- (i) энэхүү гэрээний дагуу зориуд журамд үндэслэсэн шаардлагууд, эсхүл гэрээнд зориуд дурьдсан, тогтоосон буюу тогтоох шаардлагуудын тухай;
- (ii) захиргааны аливаа шаардлага, асуудал, горимын тухай;
- (iii) энэхүү гэрээний заалтуудыг хэрэглэхэд ашигтай аливаа тодорхой нарийвчлалын талаар.

(2) (a) Ассамблей журамд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.

(b) Нэмэлт, өөрчлөлтийг (3) дахь хэсгийн заалтыг харгалзан санал хураалтад оролцогсдын дөрөвний гурвын олонхын саналаар батална.

(3) (a) Журмаар дараахь дүрмийг тодорхойлох бөгөөд түүнд:

- (i) зөвхөн санал нэгтэй шийдвэрээр эсхүл;
- (ii) үндэсний байгууллага нь олон улсын хайлтын байгууллага эсхүл олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагын үүрэг гүйцэтгэж буй хэлэлцэн тохирогч нэг ч улс татгалзаагүй, харин дээрх байгууллагуудын үүргийг засгийн газар хоорондын байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд, тухайн засгийн газар хоорондын байгууллагын гишүүн бөгөөд тухайн засгийн газар хоорондын байгууллагын зохих шатанд гишүүн бусад улсаас олгосон эрх мэдэл бүхий хэлэлцэн тохирогч улс татгалзаагүй

тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

(b) Мөрдөгдөж буй шаардлагуудыг цаашид дээрх журамд хамааруулахгүй явдал нь (a) дэд хэсгийн (i) эсхүл (ii)-т заасан нөхцөлийн аль тохирохыг биелүүлэхийг шаардана.

(c) (a) дэд хэсэгт заасан шаардлагуудыг цаашид аль нэг журамд хамааруулах асуудал нь санал нэгтэй баталсан шийдвэрийг шаардана.

(4) Ерөнхий захирал Ассамблейн хяналтын дор удирдлагын зааварчилгаа боловсруулах тухай журамд тусгана.

(5) Энэхүү гэрээ болон журмын заалтууд зөрчилдсөн тохиолдолд гэрээний заалтыг мөрдөнө.

VI БҮЛЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

59 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

64 зүйлийн (5) дахь заалтыг харгалзан, хэлэлцэн тохирогч хоёр буюу хэд хэдэн улсын хооронд үүссэн, хэлэлцээ хийх замаар шийдвэрлэж чадаагүй, энэхүү гэрээ болон журмыг тайлбарлах эсхүл хэрэглэх асуудлаарх аливаа маргааныг, хэрэв сонирхогч улсууд маргааныг зохицуулах өөр аргын талаар хэлэлцэн тохиролцохгүй бол, аль ч сонирхогч улс шүүхийн дүрмийн дагуу мэдүүлэг гаргах замаар олон улсын шүүхэд шилжүүлж болно. Мэдүүлэг гаргагч хэлэлцэн тохирогч улс шүүхэд хянуулахаар өгсөн маргааныхаа тухай олон улсын товчоонд мэдэгдэнэ. Олон улсын товчоо хэлэлцэн тохирогч бусад улсад энэ тухай мэдэгдэнэ.

VII БҮЛЭГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

60 дугаар зүйл

Гэрээг хянан өөрчлөх

(1) Энэхүү гэрээг хэлэлцэн тохирогч улсуудын тусгай бага хурлаар үе үе хянан өөрчилнө.

(2) Хянан өөрчлөх бага хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг Ассамблей гаргана.

(3) Олон улсын хайлтын байгууллага эсхүл олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагаар томилогдсон засгийн газар хоорондын аливаа байгууллага нь хянан өөрчлөх бага хуралд ажиглагчаар оролцоно.

(4) 53 дугаар зүйлийн (5), (9) болон (11) дэх хэсэг, 54 дүгээр зүйл, 55 дугаар зүйлийн (4)-(8) дахь хэсэг, 56, 57 дугаар зүйлд хянан өөрчлөх бага хурлаар эсхүл 61 дүгээр зүйлд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

61 дүгээр зүйл

Гэрээний зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах

(1) (а) 53 дугаар зүйлийн (5), (9) болон (11) дэх хэсэг, 54 дүгээр зүйл, 55 дугаар зүйлийн (4)-(8) дахь хэсэг, 56, 57 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ассамблейн гишүүн аль ч улс, гүйцэтгэх хороо эсхүл ерөнхий захирал гаргаж болно.

(b) Ерөнхий захирал ийм саналыг Ассамблейн чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө хэлэлцэн тохирогч улсуудад илгээнэ.

(2) (a) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей батална.

(b) Нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтад оролцогсдын дөрөвний гурвын олонхын саналаар батална.

(3) (a) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед Ассамблейн гишүүн байсан улсын дөрөвний гурав нь өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр гаргасан мэдэгдлийг ерөнхий захирал хүлээж авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

(b) Дээр дурьдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүчин төгөлдөр болох хугацаанд Ассамблейн гишүүн байсан бүх улс заавал дагаж мөрдөнө. Гэхдээ хэлэлцэн тохирогч улсуудын санхүүгийн хүлээх үүргийг өндөржүүлэх талаар аливаа нэмэлт, өөрчлөлтийг тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргасан улс л дагаж мөрдөнө.

(c) (a) дэд хэсгийн заалтын дагуу оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг дурдсан нэмэлт, өөрчлөлт (a) дэд хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш Ассамблейн гишүүн болох бүх улсууд заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

VIII БҮЛЭГ ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

62 дугаар зүйл

Гэрээнд оролцогч тал болох

(1) Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах олон улсын холбооны гишүүн аль ч улс дараахь замаар энэхүү гэрээнд оролцогч тал болж болно:

(i) батламж жуух бичгийг дараа хадгалуулахаар гэрээнд гарын үсэг зурах;

(ii) гэрээнд нэгдэн орох тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөх.

(2) Батламж жуух бичиг эсхүл нэгдэн орох тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(3) Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн Стокгольмын актын 24 дүгээр зүйлийн заалтыг энэхүү гэрээнд хэрэглэнэ.

(4) (3) дахь хэсгийн заалтыг уг хэсэгт заасны дагуу хэлэлцэн тохирогч бусад улс энэхүү гэрээг хэрэглэж байгаа нутаг дэвсгэрийн хувьд бодит байдлыг хэлэлцэн тохирогч аливаа улс дуугүй хүлээн зөвшөөрсөн эсхүл хүлээн авсан мэтээр ямар ч тохиолдолд ойлгох ёсгүй.

63 дугаар зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

(1) (a) Энэхүү гэрээ нь (3) дахь хэсэгт заасныг харгалзан батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ найман улс хадгалуулахаар өгсөн хойш гурван сарын дараа, найман улсаас доод тал нь дөрвөн улс нь дараахь шаардлагыг хангаж байгаа тохиолдолд хүчин төгөлдөр болно:

- (i) тухайн улсад хандаж гаргасан мэдүүлгийн тоо олон улсын товчооноос хэвлэн нийтэлсэн жил тутмын тоо бүртгэлийн сүүлчийн мэдээгээр 40000-аас дээш байх;
- (ii) тухайн улсын харьяат эсхүл энэ улсад байнга оршин сууж буй хүмүүс олон улсын товчооноос хэвлэн нийтэлсэн жил тутмын тоо бүртгэлийн сүүлчийн мэдээгээр гадаадын аль нэг оронд наад зах нь 1000 мэдүүлэг гаргасан байх;
- (iii) тухайн улсын үндэсний байгууллага, олон улсын товчооноос хэвлэн нийтэлсэн жил тутмын тоо бүртгэлийн сүүлчийн мэдээгээр гадаадын харьяат, эдгээр улсад байнга оршин сууж буй хүмүүсээс наад зах нь 10000 мэдүүлэг хүлээн авсан байх.

(b) энэхүү хэсгийн зорилгоор "мэдүүлэг" гэсэн нэр томъёог ашигтай загварын мэдүүлэгт хамааруулахгүй.

(2) (3) дахь хэсгийн заалтыг харгалзан энэхүү гэрээ (1) дэх хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болох үед энэхүү гэрээнд оролцоогүй аливаа улс батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа энэхүү гэрээний заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

(3) II бүлгийн заалтууд, тэдгээрт хамаарах энэхүү гэрээний хавсралт журмын заалтууд нь (1) дэх хэсэгт дурдсан гурван шаардлагын доод тал нь аль нэгийг тус бүрдээ хангаж байгаа гурван улс, II бүлгийн заалтуудыг дагаж мөрдөхгүй тухай 64 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан тайлбарыг хийхгүйгээр энэхүү гэрээний оролцогч болсон өдрөөс эхлэн хэрэглэгдэнэ. Гэхдээ энэ өдөр нь (1) дэх хэсэгт заасны дагуу гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө байж болохгүй.

64 дүгээр зүйл

Тайлбар

(1) (a) Аливаа улс II бүлгийн заалтыг дагаж мөрдөхгүйгээ мэдэгдэж болно.

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу тайлбар хийж байгаа улс II бүлгийн заалт болон журмын түүнд хамаарах заалтыг дагаж мөрдөхгүй.

(2) (a) (1) дэх хэсгийн (a) дэд хэсэгт заасны дагуу тайлбар хийгээгүй аливаа улс дараахь зүйлийг мэдэгдэж болно:

- (i) олон улсын мэдүүлгийн хуулбар, түүний орчуулгыг (тогтоосон ёсоор) ирүүлэх талаарх 39 дүгээр зүйлийн (1) дэх заалтыг дагаж мөрдөхгүй тухай;
- (ii) 40 дүгээр зүйлд заасны дагуу олон улсын мэдүүлгийг үндэсний үе шатанд хэлэлцэхийг хойшлуулах үүрэг нь олон улсын мэдүүлэг эсхүл түүний орчуулгыг тухайн улсын үндэсний байгууллага эсхүл энэ байгууллагын зуучлалаар хэвлэн нийтлэхэд саад болохгүй. Гэхдээ тухайн улс 30, 38 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас чөлөөлөгдөхгүй гэж ойлгоно.

(b) Ийм тайлбар хийж байгаа улс мэдэгдлийнхээ хүрээнд дурдсан заалтыг дагаж мөрдөнө.

(3) (a) Аливаа улс тухайн улсад хамаатай тохиолдолд олон улсын мэдүүлгийг олон улсын хэмжээнд хэвлэн нийтлэх шаардлагагүй болохыг мэдэгдэж болно.

(b) Хэрэв давамгайлах огнооноос хойш арван найман сарын хугацаа өнгөрөхөд олон улсын мэдүүлэгт зөвхөн (a) дэд хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн улсуудыг нэрлэсэн байвал 21 дүгээр зүйл (2) дахь хэсэгт заасан ёсоор олон улсын мэдүүлгийг хэвлэн нийтлэхгүй.

(c) Гэхдээ (b) дэд хэсэгт заасныг хэрэглэсэн хэдий ч дараахь тохиолдолд олон улсын мэдүүлгийг олон улсын товчоо хэвлэн нийтэлнэ:

- (i) журамд дурдсанчлан мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр;
- (ii) Нэрлэсэн улс (a) дэд хэсэгт заасны дагуу, гэхдээ давамгайлах огнооноос хойш арван найман сараас багагүй хугацааны дараа мэдэгдэл хийсэн бөгөөд олон улсын мэдүүлэгт үндэслэсэн үндэсний мэдүүлэг эсхүл патентыг нэрлэсэн улсын үндэсний байгууллага эсхүл түүний нэрийн өмнөөс хэвлэн нийтэлсэн бол.

(4) (a) Хэвлэн нийтлэхээс өмнөх үеийн техникийн түвшинд өөрийн патентын үзүүлэх нөлөөг үндэсний хууль тогтоомждоо тусгасан боловч техникийн түвшин тодорхойлох зорилгоор Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн дагуу мэдүүлсэн давамгайлах огноог тухайн улсад мэдүүлэг гаргасан жинхэнэ огноотой адилтган үздэггүй аль ч улс, тухайн улсын гадна, түүнийг нэрлэж олон улсын мэдүүлэг гаргасан явдлыг техникийн түвшинг тодорхойлох зорилгоор уг улсад олон улсын мэдүүлэг гаргасантай адилтгаж үзэхгүй тухай мэдэгдэж болно.

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу тайлбар хийж буй аливаа улс энэ хэсэгт, 11 дүгээр зүйлийн (3) дахь заалтыг дагаж мөрдөхгүй.

(c) (a) дэд хэсгийн дагуу тайлбар хийж буй аль ч улс тухайн улсад түүнийг нэрлэсэн олон улсын аливаа мэдэгдлийн техникийн түвшинд үзүүлэх нөлөө ямар хугацаанаас эхэлж, ямар нөхцөлд хүчинтэй болохыг нэгэн зэрэг бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Энэ мэдэгдлийг ерөнхий захиралд мэдэгдэх замаар хэдийд ч өөрчилж болно.

(5) Аль ч улс 59 дүгээр зүйлийн заалтыг дагаж мөрдөхгүйгээ мэдэгдэж болно. Ийм тайлбар хийсэн хэлэлцэн тохирогч ямар нэг улс болон бусад хэлэлцэн тохирогч аль ч улсын хооронд гарсан аливаа маргаанд 59 дүгээр зүйлийн заалтыг хэрэглэхгүй.

(6) (a) Энэ зүйлийн дагуу хийх аливаа тайлбарыг бичгээр үйлдэнэ. Энэхүү гэрээнд гарын үсэг зурах үед эсхүл батламж жуух бичиг, нэгдэн орох тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөх үед эсхүл (5) дахь хэсэгт дурдсанаас бусад тохиолдолд үүнээс хожуу ямар ч хугацаанд ерөнхий захиралд бичгээр мэдэгдэх замаар ийм тайлбар хийж болно. Ийм замаар тайлбар гаргасан тохиолдолд уг тайлбар нь ерөнхий захирал мэдэгдлийг хүлээж авсан огнооноос хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болох ба дурдсан зургаан сарын хугацаа дуусахаас өмнө гаргасан олон улсын мэдүүлэгт хамаарахгүй.

(b) Энэ зүйлд заасны дагуу гаргасан аливаа тайлбарыг ерөнхий захиралд мэдэгдэх замаар ямар ч үед цуцалж болно. Уг цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болох ба (3) дахь хэсгийн заалтын дагуу хийсэн тайлбарыг буцаан авах тохиолдолд дээр дурдсан гурван сарын хугацаа дуусахаас өмнө өгсөн олон улсын мэдүүлэгт хамаарахгүй.

(7) Энэхүү гэрээ нь (1)-(5) дахь хэсэгт дурдсан тайлбараас өөр тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.

65 дугаар зүйл

Гэрээ, журмыг аажмаар хэрэглэх

(1) Хэрэв олон улсын хайлтын аль нэг байгууллага олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагатай байгуулсан хэлэлцээрт тухайн байгууллага хянан хэлэлцэх үүрэг авсан олон улсын мэдүүлгийн тоо, нэр төрлийг түр хязгаарлахаар заасан бол Ассамблей энэхүү гэрээ, журмыг олон улсын мэдүүлгийн тодорхой ангиллын хувьд аажмаар хэрэглэхэд шаардлагатай арга хэмжээ авна. Түүнчлэн, энэ заалт нь 15 дугаар зүйлийн (5) дахь хэсэгт заасны дагуу олон улсын маягийн хайлт хийлгэх тухай хүсэлтэд мөн адил хамаарна.

(2) Ассамблей (1) дэх хэсэгт заасныг харгалзан олон улсын мэдүүлэг гаргах, олон улсын урьдчилсан шүүлт хийх тухай шаардлага өгч болох эхний хугацааг тогтооно. Уг хугацаа нь 63 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш эсхүл зүйл 63 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт заасны дагуу II бүлгийг хэрэглэж эхэлснээс хойш зургаан сараас хожуугүй байх ёстой.

66 дугаар зүйл

Цуцлах

(1) Хэлэлцэн тохирогч аливаа улс ерөнхий захиралд мэдэгдэх замаар энэхүү гэрээг цуцалж болно.

(2) Цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно. Цуцлалт нь хэрэв олон улсын мэдүүлгийг дурдсан зургаан сарын хугацаа дуусахаас өмнө гаргасан ба цуцлалт хийсэн улсыг сонгосон

бөгөөд энэ сонголт нэгэнт хийгдсэн тохиолдолд, олон улсын мэдүүлгийн үйлчлэлийг цуцлалт хийж буй улсад зогсоохгүй.

67 дугаар зүйл

Гарын үсэг зурах, хэл

(1) (a) Энэхүү гэрээ нь англи, франц хэлээр нэг хувь үйлдэж гарын үсэг зурах бөгөөд хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

(b) Сонирхсон засгийн газартай зөвлөлдсөний дараа ерөнхий захирал албан ёсны эх бичвэрийг герман, япон, португали, орос, испани болон Ассамблейгаас тогтоосон бусад хэлээр үйлдэнэ.

(2) Энэхүү гэрээ 1970 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл Вашингтон хотод гарын үсэг зурахад нээлттэй байна.

68 дугаар зүйл

Хадгалагчийн чиг үүрэг

(1) Энэхүү гэрээний жинхэнэ эхийг гарын үсэг зурахад нээлттэй байх хугацаа дууссаны дараа ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(2) Ерөнхий захирал энэхүү гэрээ, түүнд хавсаргасан журмын зохих ёсоор баталгаажуулсан хоёр хуулбарыг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн гишүүн бүх улсын засгийн газарт болон хүсэлт гаргасан бусад улсын засгийн газарт илгээнэ.

(3) Ерөнхий захирал энэхүү гэрээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү гэрээ, журамд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийн өөрийн баталгаажуулсан хоёр хуулбарыг хэлэлцэн тохирогч бүх улсын засгийн газар болон хүсэлт гаргасан бусад улсын засгийн газарт илгээнэ.

69 дүгээр зүйл

Мэдэгдэл

Ерөнхий захирал нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн гишүүн бүх улсын засгийн газарт:

- (i) 62 дугаар зүйлд заасны дагуу гарын үсэг зурсан тухай;
- (ii) 62 дугаар зүйлд заасны дагуу батламж жуух бичиг эсхүл нэгдэн орох тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай;
- (iii) энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр болон 63 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт заасны дагуу II бүлгийг хэрэглэж эхэлсэн өдрийн тухай;

- (iv) 64 дүгээр зүйлийн (1)-(5) дахь хэсэгт заасны дагуу хийсэн аливаа тайлбарын тухай;
- (v) аливаа тайлбарыг 64 дүгээр зүйлийн (6) дахь хэсгийн (b) дэд хэсэгт зааснаар хэрэгсээгүй тухай;
- (vi) 66 дугаар зүйлийн дагуу хүлээн авсан цуцлалтын тухай;
- (vii) 31 дүгээр зүйлийн (4) дэх хэсэгт заасны дагуу хийсэн аливаа мэдэгдлийн тухай тус тус мэдэгдэнэ.

67. ПАТЕНТЫН ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫН ТУХАЙ СТРАСБУРГИЙН ХЭЛЭЛЦЭЭР*

*(1971 оны 3 дугаар сарын 24)
1979 оны 9 дүгээр сарын 28-нд хянан өөрчилсөн.*

Хэлэлцэн тохирогч талууд,

патент, зохиогчийн гэрчилгээ, ашигтай загвар, ашигтай байдлын гэрчилгээний ангиллын нэгдсэн системийг бүх нийтээр батлах нь нийтлэг эрх ашигт нийцэх бөгөөд аж үйлдвэрийн өмчийг хамгаалах салбар дахь олон улсын хамтын ажиллагааг илүү нягт болгох, дурдсан салбарын үндэсний хууль тогтоомжийг уялдуулахад тус дөхөм үзүүлнэ хэмээн үзэж,

Европын холбоо шинэ бүтээлийн патентын олон улсын ангиллыг тогтоохдоо үндэслэл болгосон Шинэ бүтээлийн патентын олон улсын ангиллын тухай 1954 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Европын конвенцийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

Энэхүү ангиллын нийтлэг үнэ цэнэ болон Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч бүх улсын хувьд ач холбогдолтойг анхааралдаа авч,

Байнга өсөн нэмэгдэж буй орчин үеийн технологийн дэвшлийг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэх явдлыг хөнгөвчилж буй энэхүү ангиллын уг орнуудад үзүүлэх ач холбогдлыг анхааралдаа авч,

1883 оны 3 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан, 1900 оны 12 дугаар сарын 14-нд Брюссельд, 1911 оны 6 дугаар сарын 2-нд Вашингтонд, 1925 оны 11 дүгээр сарын 6-нд Гаагад, 1934 оны 6 дугаар сарын 2-нд Лондонд, 1958 оны 10 дугаар сарын 31-нд Лиссабонд, 1967 оны 7 дугаар сарын 14-нд Стокгольмд тус тус хянан өөрчилсөн Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 19 дүгээр зүйлийг анхааралдаа авч,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

* Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр соёрхон баталсан

1 дүгээр зүйл

**Тусгай холбоо байгуулах;
Олон улсын ангиллыг батлах**

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлж буй орнууд тусгай холбоо байгуулж, шинэ бүтээлийн патент, зохиогчийн гэрчилгээ, ашигтай загвар, ашигтай байдлын гэрчилгээний нэгдсэн ангиллыг батална. Ангилал нь “патентын олон улсын ангилал” гэж нэрлэгдэнэ (цаашид “ангилал” гэнэ).

2 дугаар зүйл

Ангиллын тодорхойлолт

(1) (a) Ангилал нь :

- (i) 1968 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болж, Европын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга хэвлэн нийтэлсэн 1954 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Шинэ бүтээлийн патентын олон улсын ангиллын тухай Европын конвенц (цаашид “Европын конвенц” гэнэ)-ийн заалтын дагуу боловсруулсан эх бичвэр;
- (ii) энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болохоос өмнө Европын конвенцийн 2 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтүүд;
- (iii) үүнээс хойш 5 дугаар зүйлийн дагуу оруулсан бөгөөд 6 дугаар зүйлийн заалтын дагуу хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтүүдээс бүрдэнэ.

(b) Ангиллын эх бичвэрт хавсаргасан гарын авлага болон тайлбар бичиг нь уг ангиллын салшгүй хэсэг болно.

(2) (a) (1) дэх хэсгийн (a) дэд хэсгийн (i)-т дурдсан бичвэр нь англи, франц хэлээр үйлдсэн адил хүчинтэй хоёр эх хувь байх бөгөөд тэдгээрийн нэг хувийг энэхүү хэлэлцээр гарын үсэг зурахад нээлттэй болох үед Европын холбооны ерөнхий нарийн бичгийн даргад, нөгөө хувийг 1967 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн конвенцоор байгуулсан Дэлхийн оюуны өмчийн байгууллагын ерөнхий захирал (цаашид “байгууллага” ба “ерөнхий захирал” гэнэ)-д тус тус хадгалуулна.

(b) (1) дэх хэсгийн (a) дэд хэсгийн (ii)-т дурдсан нэмэлт, өөрчлөлтийн англи, франц хэлээр үйлдсэн адил хүчинтэй хоёр эх хувийн нэг хувийг Европын холбооны ерөнхий нарийн бичгийн даргад, нөгөө хувийг ерөнхий захиралд тус тус хадгалуулна.

(с) (1) дэх хэсгийн (а) дэд хэсгийн (iii)-т дурдсан нэмэлт өөрчлөлтийн англи, франц хэлээр үйлдсэн адил хүчинтэй зөвхөн нэг эх хувийг ерөнхий захиралд хадгалуулна.

3 дугаар зүйл

Ангиллын хэл

(1) Ангиллыг англи, франц хэлээр үйлдэх бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

(2) Ангиллын испани, герман, орос, португали, япон хэлээрх, түүнчлэн 7 дугаар зүйлд дурдсан Ассамблей тогтоож болох бусад хэлээрх албан ёсны эх бичвэрийг байгууллагын олон улсын товчоо (цаашид “олон улсын товчоо” гэнэ) сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний дараа эсхүл эдгээр засгийн газраас ирүүлсэн орчуулгын үндсэн дээр эсхүл тусгай холбооны болон байгууллагын төсөвт санхүүгийн хүндрэл учруулахааргүй бусад аргаар үйлдэнэ.

4 дүгээр зүйл

Ангиллыг хэрэглэх

(1) Ангилал нь зөвхөн захиргааны шинжтэй байна.

(2) Тусгай холбооны гишүүн орон бүр ангиллыг үндсэн буюу туслах тогтолцоо болгон хэрэглэх эрхтэй.

(3) Тусгай холбооны гишүүн орнуудын эрх бүхий байгууллага нь

- (i) эдгээр байгууллага хэвлэн нийтэлсэн буюу эсхүл зөвхөн нийтэд танилцуулахаар нээлттэй байгаагаас үл шалтгаалан өөрийн олгосон патент, зохиогчийн гэрчилгээ, ашигтай загвар, ашигтай байдлын гэрчилгээ, түүнчлэн дурдсан хамгаалалтын төрлүүдэд хамаарах мэдүүлэг болон;
- (ii) (i)-т заасан хэвлэн нийтэлсэн буюу нийтэд танилцуулахаар нээлттэй байгаа баримт бичгийн тухай албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлсэн зарлалд (i)-т дурдсан баримт бичгүүдэд хамаарах шинэ бүтээлийн ангиллын бүрэн индексийг тусгана.

(4) Энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах буюу батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахдаа:

- (i) аливаа орон (3) дахь хэсэгт заасан нийтэд танилцуулахаар нээлттэй байгаа мэдүүлэг болон үүнд хамаарах зарлалд ангиллын хэсэг буюу дэд хэсгийн индексийг тусгах үүрэг хүлээхгүй тухайгаа мэдэгдэж болно, мөн
- (ii) шинэлэгийг тогтоох шууд буюу хойшлогдсон шүүлт хийдэггүй, патент олгох буюу бусад төрлийн хамгаалалт нь техникийн

түвшин тодорхойлох хайлт хийдэггүй аливаа орон (3) дахь хэсэгт дурдсан баримт бичиг буюу зарлалд ангиллын хэсэг буюу дэд хэсгийн индексийг тусгах үүрэг хүлээхгүй тухай мэдэгдэж болно. Хэрэв ийм нөхцөл байдал нь зөвхөн зарим төрлийн хамгаалалт буюу технологийн зарим салбарыг хамарч байвал тухайн орон зөвхөн дурдсан нөхцөл байдалдаа хамаарах тайлбар хийж болно.

(5) Ангиллын индексийг “патентын олон улсын ангилал” гэсэн үгээр эсхүл 5 дугаар зүйлд дурдсан шинжээчдийн хорооноос тодорхойлсон эдгээр үгийн товчлолоор эхлэх буюу хэвлэхдээ тод үсгээр эсхүл (3) дахь хэсгийн (i)-т дурдсан баримт бичиг бүрийн эхэнд тод харагдахуйц бусад аргаар хэвлэнэ.

(6) Хэрэв тусгай холбооны аливаа орон патент олгох асуудлыг засгийн газар хоорондын ямар нэгэн байгууллагад даалгасан бол тухайн орон тус байгууллагаас ангиллыг энэ зүйлийн дагуу хэрэглэх талаар боломжтой бүх арга хэмжээг авна.

5 дугаар зүйл

Шинжээчдийн хороо

(1) Шинжээчдийн хороог тусгай холбооны гишүүн орон бүрийн төлөөлөлтэй байгуулна.

(2) (a) Ерөнхий захирал наад зах нь нэг гишүүн орон нь энэхүү хэлэлцээрт оролцогч тал байгаа, патентын салбарт мэргэшсэн засгийн газар хоорондын байгууллагын төлөөлөгчдийг шинжээчдийн хорооны хуралдаанд ажиглагчаар оролцуулахаар урина.

(b) Ерөнхий захирал өөрийн санаачилгаар эсхүл шинжээчдийн хорооны хүсэлтийн дагуу засгийн газар хоорондын бусад байгууллагын болон олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг тэдний сонирхсон асуудлаарх хэлэлцүүлэгт оролцуулахаар урина.

(3) Шинжээчдийн хороо нь:

- (i) ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулна;
- (ii) тусгай холбооны гишүүн орнуудад ангиллыг ашиглахад дэмжлэг үзүүлэх, түүнийг нэгдсэн журмаар хэрэглэх талаар зөвлөмж хүргүүлнэ;
- (iii) шинэ бүтээлийн шүүлт хийхэд ашигладаг баримт бичгүүдийг дахин ангилах асуудлаарх олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хөгжиж буй орнуудын хэрэгцээг харгалзан дэмжлэг үзүүлнэ;
- (iv) тусгай холбооны төсөв буюу байгууллагад санхүүгийн хүндрэл учруулахгүйгээр хөгжиж буй орнуудад ангиллыг хэрэглэхэд дөхөм болох бусад бүх арга хэмжээг авна;

(v) дэд хороо ба ажлын хэсэг байгуулах эрхтэй.

(4) Шинжээчдийн хороо нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална. Уг дүрмээр ангиллыг боловсронгуй болгох талаар чухал үүрэг гүйцэтгэж чадах (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан засгийн газар хоорондын байгууллагыг дэд хороо болон ажлын хэсгийн хуралдаанд оролцуулах боломжийг бүрдүүлнэ.

(5) Тусгай холбооны аливаа гишүүн орны эрх бүхий байгууллага, олон улсын товчоо, (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасны дагуу шинжээчдийн хороонд төлөөлөлтэй засгийн газар хоорондын ямар ч байгууллага болон санал авах зорилгоор шинжээчдийн хорооноос зориуд урьсан аливаа байгууллага ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Саналыг олон улсын товчоонд илгээх ба уг байгууллага нь дурдсан саналыг хэлэлцэх шинжээчдийн хорооны чуулган эхлэхээс хоёр сараас багагүй хугацааны өмнө шинжээчдийн хорооны гишүүдэд болон ажиглагчдад илгээнэ.

(6) (а) Шинжээчдийн хорооны гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

(b) Шинжээчдийн хорооны шийдвэрийг санал хураалтад оролцогч орнуудын энгийн олонхын саналаар батална.

(c) Ангиллын үндсэн бүтцэд шинэчлэлт хийх буюу дахин ангилах ажиллагаа шаардах шийдвэр гэж санал хураалтад байлцагч болон оролцогч орнуудын тавны нэг нь үзсэн аливаа шийдвэрийг санал хураалтад байлцагч болон оролцогч орнуудын дөрөвний гурвын олонхын саналаар батална;

(d) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

6 дугаар зүйл

**Мэдэгдэх, хүчин төгөлдөр болох, нэмэлт, өөрчлөлт
болон бусад шийдвэрийг хэвлэн нийтлэх**

(1) Олон улсын товчоо нь ангилалд өөрчлөлт оруулах тухай шинжээчдийн хорооны шийдвэр бүрийн талаар болон тус хорооны зөвлөмжийн тухай тусгай холбооны гишүүн орнуудын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Нэмэлт, өөрчлөлт нь мэдэгдэл явуулсан өдрөөс зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

(2) Олон улсын товчоо нь хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтийг ангилалд тусгана. Нэмэлт, өөрчлөлтийн тухай мэдээллийг 7 дугаар зүйлд дурдсан Ассамблейгаас тогтоосон тогтмол хэвлэлд нийтэлнэ.

7 дугаар зүйл

Тусгай холбооны Ассамблей

(1) (а) Тусгай холбоо нь тусгай холбооны гишүүн орнуудаас бүрдсэн Ассамблейтай байна.

(b) Тусгай холбооны гишүүн орон бүрийн засгийн газрыг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэр нь орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) 5 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан засгийн газар хоорондын аливаа байгууллага нь Ассамблейн чуулганд болон Ассамблейн шийдвэрээр байгуулж болох хороо буюу ажлын хэсгийн хуралдаанд ажиглагчаар оролцож болно.

(d) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон засгийн газар хариуцна.

(2) (a) Ассамблей нь 5 дугаар зүйлийн заалтыг харгалзан:

- (i) тусгай холбоог удирдах, хөгжүүлэх болон энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх асуудлыг эрхэлнэ;
- (ii) хянан өөрчлөх бага хуралд бэлтгэх асуудлаар олон улсын товчоонд зааварчилга өгнө;
- (iii) ерөнхий захирлаас тусгай холбооны талаар явуулсан үйл ажиллагааны тайланг хянаж батлах, холбооны эрх мэдэлд багтах бүх асуудлаар шаардлагатай бүх зааврыг түүнд өгнө;
- (iv) тусгай холбооны хөтөлбөрийг тодорхойлж, хоёр жилийн төсөв болон түүний санхүүгийн тайланг батална;
- (v) тусгай холбооны санхүүгийн журмыг батална;
- (vi) англи, франц болон 3 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт дурдсанаас бусад ямар хэлээр ангиллын албан ёсны эх бичвэрийг үйлдэх асуудлыг шийдвэрлэнэ;
- (vii) тусгай холбооны зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн хороо болон ажлын хэсэг байгуулна;
- (viii) (1) дэх хэсгийн (c) дэд хэсгийг харгалзан тусгай холбооны гишүүн бус ямар орон, түүнчлэн ямар засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагыг түүний чуулганд болон түүний байгуулсан хороо буюу ажлын хэсгийн хуралдаанд ажиглагчаар оролцуулж болохыг тодорхойлно;
- (ix) тусгай холбооны зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа бусад үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;
- (x) энэхүү хэлэлцээрийн дагуух бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ;

(b) Байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын сонирхсон асуудлын хувьд Ассамблей зохицуулах хорооны зөвлөмжийг сонссоны дараа шийдвэр гаргана.

(3) (a) Ассамблейн гишүүн орон бүр нэг санал өгөх эрхтэй.

(b) Ассамблейн гишүүн орны тэн хагас нь кворум бүрдүүлнэ.

(c) Кворум бүрдээгүй тохиолдолд Ассамблей өөрийн ажиллагааны журамд хамаарахаас бусад шийдвэрийг гаргаж болно. Ийм шийдвэр нь гагцхүү дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Олон улсын товчоо нь чуулганд оролцоогүй Ассамблейн гишүүн орнуудад дээр дурдсан шийдвэрийг илгээж, уг шийдвэрийг илгээснээс хойш гурван сарын дотор эдгээр шийдвэрт санал өгч, түдгэлзсэн эсэх тухай саналаа бичгээр ирүүлэхийг хүснэ. Тогтоосон хугацаа өнгөрөх үед энэ журмаар саналаа өгсөн буюу түдгэлзсэнээ мэдэгдсэн орны тоо чуулган хүчинтэй болоход дутуу байсан тоонд хүрч байвал зохих олонхи байна гэж үзэж шийдвэр хүчин төгөлдөр болно.

(d) Ассамблей нь 11 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийг харгалзан Ассамблей нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрээ гаргана.

(e) Түдгэлзсэнийг санал өгсөнд тооцохгүй.

(f) Төлөөлөгч зөвхөн нэг орныг төлөөлж, зөвхөн түүний нэрийн өмнөөс санал өгнө.

(4) (a) Ерөнхий захирал Ассамблейн ээлжит чуулганыг онцгой тохиолдлоос бусад тохиолдолд байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулдаг газарт болон хугацаанд хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулна.

(b) Ерөнхий захирал Ассамблейн гишүүн орны дөрөвний нэгийн хүсэлтийн дагуу ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.

(c) Ерөнхий захирал чуулган бүрийн хэлэлцэх асуудлын дэгийн төслийг бэлтгэнэ.

(5) Ассамблей өөрийн ажиллагааны журмыг батална.

8 дугаар зүйл

Олон улсын товчоо

(1) (a) Тусгай холбооны захиргааны асуудлыг олон улсын товчоо эрхэлнэ.

(b) Түүнчлэн олон улсын товчоо нь хуралдаанд бэлтгэх бөгөөд Ассамблейн болон шинжээчдийн хороо, Ассамблей болон шинжээчдийн хорооноос байгуулж болох бусад хороо, ажлын хэсгүүдийн нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.

(c) Ерөнхий захирал тусгай холбооны гүйцэтгэх тэргүүн болох бөгөөд тусгай холбоог төлөөлнө.

(2) Ерөнхий захирал болон түүний томилсон аливаа ажилтан Ассамблей, шинжээчдийн хорооны болон бусад хороо буюу ажлын хэсгийн бүх хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Ерөнхий захирал болон түүний томилсон ажилтан өөрийн албан тушаалын дагуу эдгээр байгууллагын нарийн бичгийн дарга байна.

(3) (a) Олон улсын товчоо Ассамблейгаас өгсөн чиглэлийн дагуу хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажлыг хангана.

(b) Олон улсын товчоо хянан өөрчлөх бага хурлын бэлтгэл ажилтай холбогдуулан олон улсын засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөж болно.

(c) Ерөнхий захирал болон түүний томилсон ажилтан тэдгээр бага хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

(4) Олон улсын товчоо түүнд оногдуулсан бусад бүх даалгаврыг гүйцэтгэнэ.

9 дүгээр зүйл

Санхүү

(1) (a) Тусгай холбоо төсөвтэй байна.

(b) Тусгай холбооны төсөв нь холбооны орлого, зарлага, холбооны зардлаас холбоодод хамаарах нийтийн зардлын төсөвт орох хандив, тэрчлэн байгууллагын бага хурлын төсөвт орох зардал зэргээс бүрдэнэ.

(c) Зөвхөн тусгай холбоонд бус харин байгууллагын удирдлаган дор ажилладаг нэг буюу хэд хэдэн бусад холбоодод хамаарах зардлыг холбоодод хамаарах нийтийн зардал гэж үзнэ. Энэхүү нийтийн зардлаас холбоонд оногдох хувь нь тэдгээр холбоод дахь холбооны сонирхлын эзлэх хэмжээтэй адил байна.

(2) Тусгай холбооны төсвийг байгууллагын удирдлаган дор ажилладаг бусад холбоодын төсөвтэй зохицуулах шаардлагыг харгалзан тогтооно.

(3) Тусгай холбооны төсөв дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

- (i) тусгай холбооны гишүүн орнуудын татвар;
- (ii) тусгай холбоонд хамаарах олон улсын товчооноос үзүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамж;
- (iii) тусгай холбоонд хамаарах олон улсын товчооны хэвлэлийн борлуулалтын үнэ, түүнийг ашиглуулсны хураамж;
- (iv) гэрээслэлээр шилжүүлсэн зүйл, татаас;
- (v) түрээс, зээлийн хүү болон бусад орлого.

(4) (a) (3) дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасан татварыг тогтоох зорилгоор тусгай холбооны гишүүн орон бүр Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид заасантай адил ангилалд хамаарах бөгөөд Парисын холбоонд тухайн ангилалд тогтоосон нэгжийн хэмжээгээр жилийн татвараа төлнө.

(b) Орон бүрийн жилийн татвар нь түүний нэгжийн тоог татвар төлж байгаа бүх орны нэгжийн нийлбэрт харьцуулах хэлбэрээр тогтоосон тусгай холбооны төсөвт төлөх нийт татварт эзлэх хувьтай тэнцүү байна.

(c) Татварыг жил бүрийн нэгдүгээр сарын нэгнээс эхэлж төлнө.

(d) Өмнөх хоёр бүтэн жилд өгөх ёстой татварын хэмжээтэй тэнцүү буюу түүнээс дээш өртэй орон тусгай холбооны аливаа байгууллагад санал өгөх эрхгүй. Гэхдээ төлбөрийг хойшлуулсан нь онцгой болон зайлшгүй нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэх тохиолдолд тэрхүү хугацаанд тусгай холбооны аль нэг байгууллага тухайн оронд санал өгөх эрхээ үргэлжлүүлэн эдлэхийг зөвшөөрч болно.

(e) Хэрэв төсвийг санхүүгийн шинэ жил эхлэхээс өмнө батлаагүй бол, төсөв нь санхүүгийн журмын дагуу өмнө жилийн төсөвтэй адил хэмжээтэй байна.

(5) Тусгай холбооны нэрийн өмнөөс олон улсын товчооны үзүүлсэн үйлчилгээний төлбөрт авах төлбөр, хураамжийн хэмжээг ерөнхий захирал тогтоож Ассамблейд тайлагнана.

(6) (a) Тусгай холбоо нь тусгай холбооны гишүүн орон бүрээс өгөх нэг удаагийн төлбөрөөс бүрдэх эргэлтийн хөрөнгийн сантай байна. Хэрэв эргэлтийн хөрөнгийн сан хангалтгүй бол Ассамблей түүнийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(b) Дурдсан санд орон бүрийн төлөх анхны татварын хэмжээ буюу энэ санг нэмэгдүүлэхэд төлөх орон бүрийн хувь хэмжээ нь санг байгуулсан жил, эсхүл түүнийг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан жилд тухайн орноос төлөх татварын хувьтай адил байна.

(c) Энэ харьцаа, төлбөрийн нөхцөлийг ерөнхий захирлын саналын үндсэн дээр болон байгууллагын зохицуулах хорооны зөвлөмжийг авсны дараа Ассамблей тогтооно.

(7) (a) Байгууллагын төв байр нь нутаг дэвсгэрт нь байрладаг оронтой байгуулах төв байрны тухай хэлэлцээрт эргэлтийн хөрөнгийн сан хүрэлцэхгүй болох тохиолдолд тухайн орон урьдчилгаа олгох тухай тусгана. Энэ урьдчилгааны хэмжээ болон урьдчилгаа олгох нөхцөлийг байгууллага, тухайн орон хоорондын тусгай хэлэлцээрээр зохицуулна.

(b) (a) дэд хэсэгт дурдсан орон ба байгууллага аль аль нь урьдчилгаа өгөх үүргээ бичгээр мэдэгдэх замаар цуцлах эрхтэй. Цуцлалт нь мэдэгдэл үйлдсэн жилийн төгсгөлөөс хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(8) Санхүүгийн аудитыг санхүүгийн журмын дагуу тусгай холбооны нэг буюу хэд хэдэн орон эсхүл гадны байцаагч хийнэ. Тэднийг өөрсдийнх нь зөвшөөрлөөр Ассамблей томилно.

10 дугаар зүйл

Хэлэлцээрийг хянан өөрчлөх

(1) Энэхүү хэлэлцээрийг тусгай холбооны гишүүн орнуудын тусгай бага хурлаар үе үе хянан өөрчилж болно.

(2) Хянан өөрчлөх бага хурлыг зарлан хуралдуулах асуудлыг Ассамблей шийдвэрлэнэ.

(3) 7, 8, 9 болон 11 дүгээр зүйлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хянан өөрчлөх бага хурлаар эсхүл 11 дүгээр зүйлд заасны дагуу оруулна.

11 дүгээр зүйл

Хэлэлцээрийн зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах

(1) 7, 8, 9 дүгээр зүйл болон энэхүү зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ассамблейн гишүүн аль ч орон эсхүл ерөнхий захирал гаргаж болно. Ерөнхий захирал ийм саналыг Ассамблейн чуулганаар хэлэлцэхээс наад зах нь зургаан сарын өмнө тусгай холбооны гишүүн орон бүрт илгээнэ.

(2) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Ассамблей дөрөвний гурвын олонхын саналаар батална. Гэхдээ 7 дугаар зүйл болон энэхүү хэсэгт оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг санал хураалтын тавны дөрвийн олонхын саналаар батална.

(3) (a) (1) дэх хэсэгт дурдсан зүйлд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг баталсан үед Ассамблейн гишүүн байсан орны дөрөвний гурав нь өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр гаргасан мэдэгдлийг ерөнхий захирал хүлээж авснаас хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

(b) Ийнхүү хүлээн зөвшөөрсөн аливаа нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүчин төгөлдөр болох хугацаанд тусгай холбооны гишүүн байсан орнууд заавал дагаж мөрдөнө. Гэхдээ тусгай холбооны гишүүн орны санхүүгийн хүлээх үүргийг өндөржүүлэх талаар аливаа нэмэлт, өөрчлөлтийг тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргасан орон л дагаж мөрдөнө.

(c) (a) дэд хэсэгт заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн аливаа нэмэлт, өөрчлөлтийг уг нэмэлт, өөрчлөлт (a) дэд хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсноос хойш тусгай холбооны гишүүн болсон бүх орнууд дагаж мөрдөнө.

12 дугаар зүйл

Хэлэлцээрт оролцогч тал болох

(1) Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч тал болох аливаа орон дараахь замаар энэхүү хэлэлцээрт оролцогч тал болж болно:

- (i) гарын үсэг зурж, батламж жуух бичгийг хадгалуулах, эсхүл
- (ii) нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулах.

(2) Батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(3) Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн Стокгольмын актын 24 дүгээр зүйлийн заалтыг энэхүү хэлэлцээрт хэрэглэнэ.

(4) (3) дахь хэсгийн заалтыг тусгай холбооны гишүүн аливаа орон тус заалтын дагуу өөр орноос энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн талаарх бодит байдлыг хүлээн зөвшөөрсөн буюу баталсан гэж хэрхэвч тайлбарлаж болохгүй.

13 дугаар зүйл

Хэлэлцээр хүчин төгөлдөр болох

(1) (a) Энэхүү хэлэлцээр дор дурдсан орон батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно:

- (i) Энэхүү хэлэлцээр гарын үсэг зурахад нээлттэй болох үед Европын конвенцид оролцогч орнуудын гуравны хоёр нь батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн; болон
- (ii) Урьд нь Европын конвенцид оролцогч тал байгаагүй Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Парисын конвенцийн гишүүн гурван орон батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн, гэхдээ эдгээр гурван орны наад зах нь нэг оронд нь патент буюу зохиогчийн гэрчилгээ авах мэдүүлгийн тоо нь олон улсын товчооноос хэвлэн гаргадаг жил тутмын сүүлчийн статистик мэдээний дагуу түүний батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрийн байдлаар 40 000 -аас илүү гарсан байна.

(b) (a) дэд хэсэгт заасны дагуу энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон орнуудаас бусад аливаа орны хувьд уг хэлэлцээр нь хэрэв батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичигтээ хожуу хугацаа заагаагүй бол ерөнхий захирлаас соёрхон баталсан эсхүл нэгдэн орсон тухай мэдэгдэл хийсэн өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Хожуу хугацаа заасан тохиолдолд энэхүү хэлэлцээр нь тухайн орны хувьд уг заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

(c) Энэхүү хэлэлцээрийг соёрхон баталсан эсхүл нэгдэн орсон Европын конвенцид оролцогч орнууд уг конвенцийг цуцлах үүрэг хүлээх бөгөөд чингэхдээ

хамгийн сүүлийн хугацаа нь энэхүү хэлэлцээр тухайн орны хувьд хүчин төгөлдөр болох өдөр байна.

(2) Соёрхон батлах буюу нэгдэн орсноор энэхүү хэлэлцээрийн бүх заалтыг хүлээн зөвшөөрөх бөгөөд түүгээр олгох бүх давуу талыг эдэлнэ.

14 дүгээр зүйл

Хэлэлцээрийн үйлчлэх хугацаа

Энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа нь Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын хүчин төгөлдөр үйлчлэх хугацаатай адил байна.

15 дугаар зүйл

Хэлэлцээрийг цуцлах

(1) Тусгай холбооны гишүүн аливаа орон ерөнхий захиралд мэдэгдэл илгээснээр энэхүү хэлэлцээрийг цуцалж болно.

(2) Цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

(3) Энэхүү зүйлд заасан цуцлах эрх аль ч оронд тусгай холбооны гишүүн болсон өдрөөс хойш таван жилийн хугацаа дуусахаас өмнө үүсэхгүй.

16 дугаар зүйл

Гарын үсэг зурах, хэл, мэдэгдэл, хадгалах чиг үүрэг

(1) (a) Энэхүү хэлэлцээрийг англи, франц хэлээр нэг хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй.

(b) Энэхүү хэлэлцээр нь 1971 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл Страсбург хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна.

(c) Гарын үсэг зурахад хаалттай болсны дараа энэхүү хэлэлцээрийн жинхэнэ эхийг ерөнхий захиралд хадгалуулна.

(2) Албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний дараа испани, герман, португали, орос, япон болон Ассамблейгаас тогтоосон бусад хэлээр үйлдэнэ.

(3) (a) Ерөнхий захирал энэхүү хэлэлцээрийн гарын үсэг зурсан эх бичвэрийн хоёр хувийг зохих ёсоор баталгаажуулж хэлэлцээрт гарын үсэг зурсан бүх засгийн газарт болон хүсэлт гаргасан аль ч орны засгийн газарт илгээнэ. Ерөнхий захирал эх бичвэрийн нэг хувийг зохих ёсоор баталгаажуулж Европын холбооны ерөнхий нарийн бичгийн даргад мөн илгээнэ.

(b) Ерөнхий захирал энэхүү хэлэлцээрт оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийн өөрийн баталгаажуулсан хоёр хувийг тусгай холбооны гишүүн бүх орны засгийн газарт болон хүсэлт гаргасан бусад орны засгийн газарт илгээнэ. Ерөнхий захирал өөрийн баталгаажуулсан нэг хувийг Европын холбооны ерөнхий нарийн бичгийн даргад мөн илгээнэ.

(c) Ерөнхий захирал өөрийн баталгаажуулсан ангиллын англи, франц хэлээрх ангиллын хувийг энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан эсхүл түүнд нэгдэн орсон болон хүсэлт гаргасан аливаа орны засгийн газарт хүргүүлнэ.

(4) Ерөнхий захирал энэхүү хэлэлцээрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

(5) Ерөнхий захирал Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид оролцогч бүх орны засгийн газар болон Европын холбооны нарийн бичгийн дарга нарын газарт дараахь зүйлийг мэдэгдэнэ:

- (i) гарын үсэг зурсан тухай;
- (ii) батламж жуух бичиг эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай;
- (iii) энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;
- (iv) ангиллыг хэрэглэх талаар хийсэн тайлбарын тухай;
- (v) энэхүү хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай;
- (vi) эдгээр нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;
- (vii) хүлээн авсан цуцлалтын тухай.

17 дугаар зүйл

Шилжилтийн заалтууд

(1) Тусгай холбооны гишүүн хараахан болоогүй байгаа Европын конвенцид оролцогч орнууд, хэрэв эдгээр орнууд хүсвэл энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн хугацаанд тусгай холбооны гишүүнтэй адил эрхийг шинжээчдийн хороонд эдэлж болно.

(2) (1) дэх хэсэгт заасан хугацаа дууссанаас хойш гурван жилийн хугацаанд мөн хэсэгт дурдсан орнууд шинжээчдийн хорооны хуралдаанд, хэрэв уг хорооноос тийнхүү шийдвэрлэсэн бол түүний байгуулсан аливаа дэд хороо буюу ажлын хэсгийн хуралдаанд ажиглагчаар оролцож болно. Эдгээр орон нь дээр дурдсан хугацаанд 5 дугаар зүйлийн (5) дахь хэсэгт заасны дагуу ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал гаргаж болох бөгөөд 6 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу шинжээчдийн хорооны шийдвэр, зөвлөмжийн талаар эдгээр оронд мэдэгдэнэ.

(3) Тусгай холбооны гишүүн хараахан болоогүй байгаа Европын конвенцид оролцогч орнууд энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн хугацаанд Ассамблейн чуулганд, хэрэв Ассамблей тийнхүү шийдвэрлэсэн бол түүний байгуулсан аливаа хороо буюу ажлын хэсгийн хуралдаанд ажиглагчаар оролцож болно.

68. ОЛИМПИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ НАЙРОБЫН ГЭРЭЭ*

*Найроби хотноо 1981 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр
баталсан*

I БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗААЛТ

1 дүгээр зүйл

Улсуудын хүлээх үүрэг

Энэхүү гэрээнд оролцогч аливаа улс Олон улсын олимпийн хороо зөвшөөрснөөс бусад тохиолдолд Олон улсын олимпийн хорооны дүрэмд тодорхойлсон олимпийн бэлгэ тэмдэг, эсхүл бэлгэ тэмдгийг агуулсан аливаа илэрхийллийг тэмдгийн хувьд 2, 3 дугаар зүйлд заасны дагуу бүртгэхээс татгалзах эсхүл бүртгэлийг хүчингүй болгох буюу арилжааны зорилгоор ашиглахыг зохих арга хэмжээ авах замаар хориглох үүрэгтэй. Дээр дурдсан бэлгэ тэмдгийн тодорхойлолт болон зураг дүрслэлийг хавсралтаар үзүүлэв.

2 дугаар зүйл

Үүргээс чөлөөлөх

(1) 1 дүгээр зүйлд заасан үүрэг нь дараахь тохиолдолд энэхүү гэрээнд оролцогч улсад хамаарахгүй:

- (i) олимпийн бэлгэ тэмдгээс бүрдсэн болон уг бэлгэ тэмдгийг агуулсан аливаа дүрсэн илэрхийлэл нь тухайн улсад энэхүү гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө бүртгэгдсэн, эсхүл 1 дүгээр зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэх үйл явцыг 3 дугаар зүйлд заасны дагуу зогсоосон хугацаанд;

* Монгол Улс 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр соёрхон баталсан

- (ii) тухайн улсын хувьд энэхүү гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө аливаа хувь хүн болон аж ахуйн нэгж олимпын бэлгэ тэмдгээс бүрдсэн болон уг бэлгэ тэмдгийг агуулсан тэмдэг, эсхүл аливаа дүрсэн илэрхийллийг тухайн улсад арилжааны зорилгоор хууль ёсоор үргэлжлүүлэн ашиглах эсхүл тухайн улсын хувьд 1 дүгээр зүйлд заасан үүргийг 3 дугаар зүйлд заасны дагуу зогсоосон хугацаанд.

(2) Тухайн улс оролцогч тал нь болсон гэрээний дагуу бүртгэгдэж, тус улсад хүчинтэй байгаа тэмдэгт 1 дэх хэсгийн (i) дэд хэсгийг мөн хэрэглэнэ.

(3) 1 дэх хэсгийн (ii) дэд хэсэгт дурдсан хувь хүн буюу аж ахуйн нэгжийн зөвшөөрлөөр ашиглах нь энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгын хувьд тухайн хувь хүн, аж ахуйн нэгж ашиглаж буйтай адилтган үзнэ.

(4) Хэрэв олимпын хөдөлгөөний болон уг хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр олимпын бэлгэ тэмдгийг хэрэглэж байвал энэхүү гэрээнд оролцогч нэг ч улс түүнийг хориглох ёсгүй.

3 дугаар зүйл

Үүргийн хэрэгжилтийг зогсоох

Олон улсын олимпын хороо болон тухайн улсын Үндэсний олимпын хорооны хооронд олимпын бэлгэ тэмдгийг хэрэглэх зөвшөөрлийг тухайн улсад олгох болон уг зөвшөөрлийг олгосноороо Олон улсын олимпын хороонд орох аливаа орлогоос Үндэсний олимпын хороо авах хувийн талаар хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээ байгуулаагүй бүх үеийн туршид 1 дүгээр зүйлд дурдсан үүргийн хэрэгжилтийг зогсоосонд тооцож болно.

II БҮЛЭГ УЛСУУДЫН ХОЛБОО

4 дүгээр зүйл

I бүлгээс чөлөөлөх

I бүлгийн заалт нь энэхүү гэрээнд оролцогч бөгөөд гаалийн холбоо, худалдааны чөлөөт бүс, эдийн засгийн бусад холбоо, бүс нутгийн болон дэд бүсийн холбооны гишүүн аливаа улсын хувьд эдгээр холбоо, бүс, бүлэглэлийг байгуулах тухай хэлэлцээрээс үүдэлтэй, ялангуяа бараа, үйлчилгээг чөлөөтэй солилцох асуудлыг зохицуулсан хэлэлцээрээр хүлээж буй үүргийг хөндөхгүй.

III БҮЛЭГ ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

5 дугаар зүйл

Гэрээнд оролцогч тал болох

(1) Дэлхийн оюуны өмчийн байгууллага (цаашид “байгууллага” гэнэ) эсхүл Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах олон улсын (Парисын) холбоо (цаашид “Парисын холбоо” гэнэ)-ны гишүүн аливаа улс дараахь замаар энэхүү гэрээнд оролцогч болж болно:

- (i) гарын үсэг зурж, батламж жуух бичиг буюу нэгдэн орсон, эсхүл баталсан тухай баримт бичгийг дараа нь хадгалуулахаар өгөх;
- (ii) нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөх.

(2) Энэ зүйлийн (1) дэх хэсэгт дурдаагүй Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүнтэй холбоотой аль нэг төрөлжсөн байгууллагын гишүүн аливаа улс нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөх замаар энэхүү гэрээний оролцогч болж болно.

(3) Батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон буюу баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг байгууллагын ерөнхий захирал (цаашид “ерөнхий захирал” гэнэ)-д хадгалуулахаар өгнө.

6 дугаар зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

(1) Батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон буюу баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн эхний гурван улсын хувьд энэхүү гэрээ гурав дахь батламж жуух бичиг, нэгдэн орсон буюу баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

(2) Батламж жуух бичиг, нэгдэн орсон буюу баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн бусад улсын хувьд энэхүү гэрээ тэдгээрийг хадгалуулахаар өгснөөс хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

7 дугаар зүйл

Гэрээг цуцлах

(1) Аливаа улс ерөнхий захиралд мэдэгдэл илгээх замаар энэхүү гэрээг цуцалж болно.

(2) Цуцлалт нь ерөнхий захирал мэдэгдлийг хүлээж авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

8 дугаар зүйл

Гэрээнд гарын үсэг зурах, гэрээг үйлдэх хэл

(1) Энэхүү гэрээг англи, испани, орос, франц хэлээр нэг эх хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй.

(2) Гэрээний албан ёсны эх бичвэрийг ерөнхий захирал сонирхогч засгийн газартай зөвлөлдсөний дараа араб, итали, герман, португали хэлээр болон байгууллагын бага хурал эсхүл Парисын холбооны Ассамблейн тогтоосон бусад хэлээр үйлдэнэ.

(3) Энэхүү гэрээ нь Найроби хотноо 1982 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс Женев хотноо 1983 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

9 дүгээр зүйл

Гэрээг хадгалах, хуулбарыг илгээх, гэрээг бүртгэх

(1) Энэхүү гэрээний эх хувийг Найроби хотноо гарын үсэг зурахад хаалттай болсны дараа ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

(2) Ерөнхий захирал энэхүү гэрээний баталгаажуулсан хоёр хуулбарыг 5 дугаар зүйлийн (1), (2) дахь хэсэгт дурдсан болон хүсэлт гаргасан аливаа улсад илгээнэ.

(3) Энэхүү гэрээг ерөнхий захирал Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

10 дугаар зүйл

Мэдээлэх


Ерөнхий захирал 5 дугаар зүйлийн (1), (2) дахь хэсэгт дурдсан улсад дараахь зүйлийг мэдээлнэ:

- (i) 8 дугаар зүйлд заасны дагуу гарын үсэг зурсан тухай;

- (ii) 5 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт заасны дагуу батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон буюу баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хүлээн авсан тухай;
- (iii) 6 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;
- (iv) 7 дугаар зүйлд заасны дагуу энэхүү гэрээг цуцалсан тухай.

Хавсралт

Олимпийн бэлгэ тэмдэг нь зүүнээс баруун тийш цэнхэр, шар, хар, ногоон, улаан гэсэн дарааллаар хэлхэлдсэн таван цагиргаас бүрдэнэ. Олимпийн бэлгэ тэмдэг нь нэг эсхүл өөр өөр өнгийн олимпийн цагиргаас бүрдэнэ.



69. ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЭЭ*

*1996 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Женев хотноо баталж,
2002 оны 3 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон*

Хэлэлцэн тохирогч талууд,

утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалах асуудлыг аль болох үр ашигтай, нэгдмэл байдлаар хөгжүүлэн хангахыг хүсч,

эдийн засаг, нийгэм, соёл, технологийн хөгжилтэй уялдан гарч буй шинэ асуудлуудыг зохистой шийдвэрлэхийн тулд олон улсын шинэ дүрэм нэвтрүүлж, одоо мөрдөгдөж байгаа тодорхой дүрмийн тайлбарыг тодруулах шаардлагыг хүлээн зөвшөөрч,

утга зохиол, урлагийн бүтээлийг туурвих, хэрэглэхэд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, дэвшлийн онцгой нөлөөг хүлээн зөвшөөрч,

зохиогчийн эрхийг хамгаалах нь утга зохиол, урлагийн бүтээлийг туурвих хөшүүрэг болдог чухал ач холбогдлыг онцолж,

* Монгол Улс 2002 оны 7 дугаар сарын 25-ны өдөр соёрхон баталсан

Бернийн конвенцид тусгагдсанаар зохиогчийн эрх ба өргөн олон нийтийн ашиг сонирхол, ялангуяа боловсрол, судалгаа, мэдээлэл олж авах боломж хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахын чухлыг хүлээн зөвшөөрч,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Бернийн конвенцтой холбогдох нь

(1) Энэхүү гэрээ нь Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн 20 дугаар зүйлийн утга агуулгын хүрээнд, тэрхүү конвенцийн дагуу байгуулагдсан Холбоонд нэгдсэн орнууд болох хэлэлцэн тохирогч талуудын хувьд тусгай хэлэлцээр болно. Энэхүү гэрээ нь Бернийн конвенцоос өөр аливаа бусад гэрээтэй холбоогүй бөгөөд бусад гэрээгээр хүлээсэн аливаа нэг эрх, үүргийг хөндөхгүй.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт хэлэлцэн тохирогч талуудын Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн дагуу бие биеийнхээ өмнө хүлээсэн үүргийг үгүйсгэхгүй.

(3) Цаашид Бернийн конвенц гэж Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн 1971 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн Парисын актыг ойлгоно.

(4) Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 1-21 дүгээр зүйл болон хавсралтыг мөрдөнө.

2 дугаар зүйл

Зохиогчийн эрхийг хамгаалах хүрээ

Зохиогчийн эрхийн хамгаалалт нь илэрхийлэлд хамаарах бөгөөд харин санаа, үйлдэл, үйл ажиллагааны арга барил эсхүл тоон ойлголтод/математикийн үзэл баримтлалд хамаарахгүй.

3 дугаар зүйл

Бернийн конвенцийн 2-6 дугаар зүйлийг хэрэглэх нь

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээгээр олгосон хамгаалалтын хүрээнд Бернийн конвенцийн 2-6 дугаар зүйлийн заалтуудыг хэрэглэнэ.

4 дүгээр зүйл

Компьютерийн программ/Цахим тооцоолуурын хөтөлбөр

Компьютерийн программыг/цахим тооцоолуурын хөтөлбөрийг Бернийн конвенцийн 2 дугаар зүйлийн утга агуулгын хүрээнд утга зохиолын бүтээлийн нэгэн адил хамгаална. Ийм хамгаалалт нь илэрхийллийн аль ч арга, хэлбэрийг үл харгалзан компьютерийн программд/цахим тооцоолуурын хөтөлбөрт хамаарна.

5 дугаар зүйл

Мэдээллийн эмхтгэл (Мэдээллийн сан)

Агуулгын сонголт, зохиомжийнхоо улмаас оюуны бүтээл болж буй аливаа хэлбэрийн тоон мэдээ эсхүл бусад материалын эмхтгэлийг мөн адил хамгаална. Энэ хамгаалалт нь тоон мэдээ болон материалд өөрт нь хамаарахгүй бөгөөд эмхтгэлд орсон аливаа тоон мэдээ, материалын эх зохиогчийн эрхийг хөндөхгүй.

6 дугаар зүйл

Түгээх эрх

(1) Утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид нь бүтээлийнхээ жинхэнэ эх болон хуулбарыг худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх замаар олон нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт зохиогчийн зөвшөөрлөөр бүтээлийн жинхэнэ эх болон хуулбарыг анх удаа худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлсний дараа (1) дэх хэсэгт заасан эрхийг хэрэглэх нөхцлийг тодорхойлох тухай хэлэлцэн тохирогч талуудын эрх чөлөөг хөндөхгүй.

7 дугаар зүйл

Түрээслэх эрх

- (1) (i) Компьютерийн программ/цахим тооцоолуурын хөтөлбөр;
 - (ii) кино урлагийн бүтээл;
 - (iii) хэлэлцэн тохирогч талын үндэсний хуулиар тодорхойлсны дагуу дуу авианы бичлэгээр илэрхийлэгдэх бүтээлийн зохиогч бүтээлийнхээ жинхэнэ эх буюу хуулбарыг олон нийтэд төлбөртэй хөлслүүлэх буюу түрээслэхийг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.
- (2) (1) дэх хэсэг хэрэглэгдэхгүй тохиолдлууд:
 - (i) компьютерийн программын/цахим тооцоолуурын хөтөлбөрийн хувьд, программ нь өөрөө түрээслэх зайлшгүй гол зүйл биш бол;
 - (ii) кино урлагийн бүтээлийн хувьд, тийнхүү төлбөртэй түрээслэх нь хуулбарлан олшруулах онцгой эрхийг ноцтойгоор хөндөж тэдгээр бүтээлийг өргөнөөр хуулбарлахад хүргээгүй бол.

(3) (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэг бүхий хуулбарын хувийг түрээсэлсний төлөө зохиогчид нь зохих үнэ хөлс төлдөг тогтолцоо үйлчилж байсан бөгөөд үйлчилсээр байгаа хэлэлцэн тохирогч тал тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэг бүхий бүтээлийг түрээслэх нь хуулбарлан олшруулах зохиогчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.

8 дугаар зүйл

Олон нийтэд мэдээлэх эрх

Бернийн конвенцийн 11 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (ii) дэд хэсэг, 11 bis зүйлийн (1) дэх хэсгийн (i) ба (ii) дэд хэсэг, 11 ter зүйлийн (1) дэх хэсгийн (ii) дэд хэсэг, 14 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (ii) дэд хэсэг, 14 bis зүйлийн (1) дэх хэсгийн заалтыг хөндөхгүйгээр утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид бүтээлээ шугаман болон шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрхийг эдлэх бөгөөд үүнд олон нийтийн төлөөлөгчид дээрх бүтээлтэй өөрсдийн сонгосон газар, цагт танилцаж болох боломжтой байна.

9 дүгээр зүйл

Гэрэл зургийн бүтээлийг хамгаалах хугацаа

Гэрэл зургийн бүтээлийн хувьд, хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 7 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн заалтыг хэрэглэхгүй.

10 дугаар зүйл

Хязгаарлалт, онцгой тохиолдол

(1) Хэлэлцэн тохирогч талууд үндэсний хууль тогтоомждоо бүтээлийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр үл хөндөх тохиолдолд энэхүү гэрээний дагуу утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчид олгосон эрхэд хязгаарлалт эсхүл онцгой тохиолдол тогтоож болно.

(2) Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийг хэрэглэхдээ түүгээр тогтоосон эрхийн талаарх хязгаарлалт, онцгой тохиолдлыг бүтээлийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн зохиогчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр үл хөндөх тохиолдолд хэрэглэнэ.

11 дүгээр зүйл

Технологийн арга хэмжээтэй холбогдох үүрэг

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээ болон Бернийн конвенцийн дагуу эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зохиогчийн хэрэглэж байгаа бөгөөд бүтээлийнх нь хувьд тухайн зохиогчийн зөвшөөрөлгүй буюу хуулиар зөвшөөрөгддөггүй үйлдлийг хязгаарлаж байгаа техникийн үйл ажиллагаанаас зайлсхийхийн тулд эрх зүйн зүй зохистой хамгаалалт болон хуулийн үр ашигтай арга хэмжээ авна.

12 дугаар зүйл

Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбогдох үүрэг

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээ буюу Бернийн конвенцоор хамгаалагдсан эрхийг зөрчихөд хүргэх, боломж олгох, туслах, ийм зөрчлийг нуусныг мэдсээр байж, эсхүл иргэний арга хэмжээний хувьд дээрхийг мэдэх бодит үндэслэлтэй байж доорхи аль нэг үйлдлийг санаатайгаар хийж буй аливаа этгээдийн эсрэг хуулийн зүй зохистой, үр ашигтай арга хэмжээ авна:

- (i) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах буюу өөрчлөх;
- (ii) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг устгасан буюу өөрчилсөн гэдгийг мэдсэн хэрнээ бүтээл болон хувийг нь олон нийтэд түгээх буюу түгээхээр импортлох, нэвтрүүлэх эсхүл мэдээлэх.

(2) Энэ зүйлд заасан “эрхийн удирдлагын талаарх мэдээлэл” гэж бүтээл, бүтээлийн зохиогч, бүтээлийн аливаа эрх эзэмшигчийг тодорхойлж буй мэдээлэл эсхүл бүтээлийг ашиглах нөхцөл, болзлын талаарх мэдээлэл, мөн бүтээлийн хуулбарт тавигдсан бүтээлийг олон нийтэд мэдээлэхтэй холбоотойгоор гарч байгаа тийм мэдээллийг илэрхийлж байгаа аливаа тоо болон код мэдээг хэлнэ.

13 дугаар зүйл

Хэрэглэх хугацаа

Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 18 дугаар зүйлийн заалтыг энэхүү гэрээнд заасан бүх хамгаалалтад хэрэглэнэ.

14 дүгээр зүйл

Эрхийн хэрэгжилтийн заалт

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээг хэрэглэхэд шаардлагатай арга хэмжээг өөрийн хуулийн тогтолцоотой уялдуулан авах үүрэг хүлээнэ.

(2) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээнд заасан эрхийг зөрчиж байгаа аливаа үйлдлийн эсрэг үр ашигтай арга хэмжээ авахыг зөвшөөрөхүйц эрхээр хангах журмыг өөрийн хууль тогтоомжид тусгах бөгөөд ялангуяа цаашид гарч болох зөрчилөөс урьдчилан сэргийлэх болон цаашид эрх зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээг өөрсдийн хууль тогтоомжид тусгана.

15 дугаар зүйл

Ассамблей

- (1) (a) Хэлэлцэн тохирогч талууд Ассамблейтай байна.

(b) Хэлэлцэн тохирогч тал тус бүрийг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгч тус бүрийн зардлыг түүнийг томилсон хэлэлцэн тохирогч тал хариуцна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журмын дагуу хөгжиж байгаа оронд тооцогддог эсхүл зах зээлийн эдийн засагт шилжиж буй орон болох хэлэлцэн тохирогч талын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулахыг дэмжих зорилгоор Ассамблей санхүүгийн туслалцаа үзүүлэхийг Дэлхийн оюуны өмчийн байгууллага (цаашид “ДОӨБ” гэнэ)-аас хүсч болно.

(2) (a) Ассамблей энэхүү гэрээг сахих, хөгжүүлэх, хэрэглэх, түүний үйл явцтай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

(b) Ассамблей засгийн газар хоорондын зарим тодорхой байгууллагыг энэхүү гэрээнд элсүүлэх асуудлыг хэлэлцэхдээ 17 дугаар зүйлийн (2) дахь хэсгээр түүнд ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(c) Ассамблей энэхүү гэрээг хянаж өөрчлөх зорилгоор аливаа дипломат бага хурал зарлан хуралдуулах шийдвэр гаргах бөгөөд тийм дипломат бага хуралд бэлтгэхэд шаардлагатай зааварчлагыг ДОӨБ-ын ерөнхий захиралд өгнө.

(3) (a) Хэлэлцэн тохирогч тал болох улс нэг санал өгөх эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн нэрийн өмнөөс санал өгнө.

(b) Засгийн газар хоорондын байгууллага болох хэлэлцэн тохирогч аливаа тал энэхүү гэрээний тал болох гишүүн улсынхаа тоотой тэнцүү тоогоор гишүүн улсынхаа оронд санал өгч болно. Хэрэв аль нэг гишүүн улс саналын эрхээ өөрөө хэрэгжүүлж байгаа бол засгийн газар хоорондын аль ч байгууллага санал өгөхөд оролцохгүй бөгөөд энэ журам мөн урвуугаар үйлчилнэ.

(4) ДОӨБ-ын ерөнхий захирал хоёр жил тутамд нэг удаа ээлжит Ассамблейн чуулганыг зарлан хуралдуулна.

(5) Ассамблей үйл ажиллагааныхаа журмыг тогтоох бөгөөд үүнд ээлжит бус чуулган зарлан хуралдуулах, чуулганы кворум, мөн энэхүү гэрээний заалтын дагуу төрөл бүрийн асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай олонхын хэмжээг тогтооно.

16 дугаар зүйл

Олон улсын товчоо

ДОӨБ-ын Олон улсын товчоо нь энэхүү гэрээтэй холбогдох захиргааны үүргийг гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл

Гэрээнд оролцогч тал болох

(1) ДОӨБ-ын гишүүн аливаа улс энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

(2) Ассамблей нь энэхүү гэрээгээр зохицуулж буй асуудлын талаар тодорхой эрх мэдэлтэй бөгөөд эдгээр асуудлаар гишүүн бүх улсад нь заавал биелүүлэх өөрийн хууль тогтоомжтой, мөн энэхүү гэрээнд нэгдэн орохыг нь зохих ёсоор дотоод журмынхаа дагуу зөвшөөрч эрх олгогдсон засгийн газар хоорондын байгууллагыг гишүүнээр элсүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(3) Европын хамтын нийгэмлэг өмнөх хэсэгт заасан мэдэгдлийг энэхүү гэрээг батласан Дипломат бага хурлын үед хийснээр энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

18 дугаар зүйл

Гэрээний дагуу эдлэх эрх ба үүрэг

Энэхүү гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол хэлэлцэн тохирогч тал тус бүр энэхүү гэрээгээр олгосон бүх эрхийг эдлэх ба үүргийг хүлээнэ.

19 дүгээр зүйл

Гэрээнд гарын үсэг зурах

Энэхүү гэрээ ДООБ-ын гишүүн аливаа улс болон Европын хамтын нийгэмлэг гарын үсэг зурахад 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нээлттэй байна.

20 дугаар зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээ нь гуч дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ДООБ-ын ерөнхий захиралд хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

21 дүгээр зүйл

Гэрээнд нэгдэн орох хугацаа

Энэхүү гэрээний заалтыг:

- (i) 20 дугаар зүйлд дурдсан гучин улс энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж;
- (ii) бусад аливаа улс ДООБ-ын ерөнхий захиралд баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа;
- (iii) Европын хамтын нийгэмлэг, хэрэв батламж жуух бичиг буюу нэгдэн орсон баримт бичгээ энэхүү гэрээ 20 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсны дараа хадгалуулсан бол тийнхүү хадгалуулснаас хойш гурван сарын дараа эсхүл тус баримт бичгээ

энэхүү гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө хадгалуулсан бол гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дараа;

- (iv) энэхүү гэрээнд нэгдэж буй засгийн газар хоорондын өөр бусад байгууллага нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа тус тус заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

22 дугаар зүйл

Тайлбар хийхгүй байх

Энэхүү гэрээнд ямар нэг тайлбар хийхийг хориглоно.

23 дугаар зүйл

Гэрээг цуцлах

Аливаа хэлэлцэн тохирогч тал энэхүү гэрээг цуцлах тухай мэдэгдлээ ДООБ-ын ерөнхий захиралд өгснөөр цуцалж болно. ДООБ-ын ерөнхий захирал дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа гэрээг цуцалсанд тооцно.

24 дүгээр зүйл

Гэрээний хэл

(1) Энэхүү гэрээг англи, араб, хятад, франц, орос, испани хэлээр нэг эх хувь үйлдэж гарын үсэг зурсан эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

(2) (1) дэх хэсэгт дурдсанаас бусад хэлээр нийтлэх албан ёсны эх бичвэрийг сонирхогч бүх талтай зөвлөлдсөний дараа сонирхогч талын хүсэлтээр ДООБ-ын ерөнхий захирал үйлдэнэ. Энэ хэсгийн зорилгоор “сонирхогч тал” гэж албан ёсны хэл эсхүл албан ёсны хэлнүүдийн аль нэгээр нь хүсэлт гаргасан ДООБ-ын гишүүн улс, мөн аль нэг албан ёсны хэлээр нь хүсэлт гаргасан Европын хамтын нийгэмлэг буюу энэхүү гэрээнд нэгдэн орж болох засгийн газар хоорондын аливаа бусад байгууллагыг хэлнэ.

25 дугаар зүйл

Хадгалагч

ДООБ-ын ерөнхий захирал энэхүү гэрээний хадгалагч байна.

70. ТОГЛОЛТ БОЛОН ДУУ АВИАНЫ БИЧЛЭГИЙН ТУХАЙ ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЭЭ*

*1996 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Женев хотноо баталж,
2002 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон*

Удиртгал

Хэлэлцэн тохирогч талууд,

тоглогчид болон дуу авиа бүтээгчдийн эрхийг хамгаалах асуудлыг аль болох үр ашигтай, нэгдмэл байдлаар хөгжүүлэн хангахыг хүсч,

эдийн засаг, нийгэм, соёл, технологийн хөгжилтэй уялдан гарч буй шинэ асуудлуудыг зохистой шийдвэрлэхийн тулд олон улсын шинэ дүрэм журмыг нэвтрүүлэх шаардлагыг хүлээн зөвшөөрч,

тоглолт, дуу авианы бичлэг үйлдвэрлэх, ашиглахад мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, дэвшлийн онцгой нөлөөг хүлээн зөвшөөрч,

тоглогчид болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрх ба өргөн олон нийтийн ашиг сонирхол, ялангуяа боловсрол, судалгаа, мэдээлэл олж авах боломж хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахын чухлыг хүлээн зөвшөөрч,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I БҮЛЭГ НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл

Бусад конвенцтой холбогдох нь

(1) Энэхүү гэрээний аль ч заалт хэлэлцэн тохирогч талуудын 1961 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Ром хотноо үйлдсэн Тоглогчид болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч байгууллагын тухай олон улсын конвенц (цаашид “Ромын конвенц” гэнэ)-ийн дагуу бие биеийнхээ өмнө хүлээсэн үүргийг үгүйсгэхгүй.

(2) Энэхүү гэрээгээр олгосон хамгаалалт утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүй. Үүний дагуу энэхүү гэрээний аль ч заалтыг тийм хамгаалалтыг хөндөнө гэж тайлбарлаж болохгүй.

(3) Энэхүү гэрээ аливаа бусад гэрээтэй ямарваа холбоогүй бөгөөд тэдгээрт тусгагдсан эрх, үүргийг хөндөхгүй.

2 дугаар зүйл

Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү гэрээний зорилгоор:

* Монгол Улс 2002 оны 7 дугаар сарын 25-ны өдөр соёрхон баталсан

(a) “тоглогчид” гэж утга зохиол, уран сайхны болон ардын урлагийн бүтээлийг, дуулж, хөгжимдөх, жүжиглэх, бүжиглэх, унших зэргээр гүйцэтгэн тоглодог жүжигчин, дуучин, хөгжимчин, бүжигчин болон бусад этгээдийг;

(b) “дуу авианы бичлэг” гэж кино урлагийн бүтээл эсхүл дуу, дүрс бичлэгийн бүтээлд оруулсан хэлбэрээс бусад аливаа тоглолтын болон бусад дуу авианы бичлэгийг ;

(c) “бичлэг” гэж холбогдох төхөөрөмжөөр хүлээн авч, дахин үйлдвэрлэж дамжуулж болох дуу авиа буюу түүний илэрхийллийг бодит хэлбэрт шилжүүлэн биежүүлэхийг;

(d) “дуу авианы бичлэг үйлдвэрлэгч” гэж тоглолтын буюу бусад дуу авианы эсхүл тэдгээрийн илэрхийллийн бичлэгийг анх сэдэж хийсэн, хариуцлага хүлээх хувь хүн, хуулийн этгээдийг ;

(e) бичигдсэн тоглолт буюу дуу авианы бичлэгийг “нийтлэх” гэж бичигдсэн тоглолт буюу дуу авианы бичлэгийн хувийг эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр олон нийтэд санал болгох, чингэхдээ хувийг боломжит тоогоор нийтэд гаргахыг;

(f) “нэвтрүүлэх” гэж дуу авиа буюу тэдгээрийн дүрслэлийг шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгон дамжуулахыг; мөн тэдгээрийг сансрын хиймэл дагуулаар дамжуулахыг хэлнэ; Кодлосон дохиог нэвтрүүлэгч байгууллагаас буюу түүний зөвшөөрөлтэйгээр тайлж унших түлхүүрийг олон нийтэд дамжуулах тохиолдолд мөн “нэвтрүүлэх” гэж болно;

(g) тоглолт буюу дуу авианы бичлэгийг “нийтийн хүртээл болгох” гэж тоглолтын бичлэгт бичигдсэн дуу авиа буюу түүний дүрслэлийг нэвтрүүлэхээс бусад аливаа хэрэгслээр олон нийтэд дамжуулахыг хэлнэ. 15 дугаар зүйлийн зорилгоор “нийтийн хүртээл болгох” гэдэгт дуу авианы бичлэгт бичигдсэн дуу авиа буюу түүний дүрслэлийг олон нийтэд сонсогдохуйц илэрхийлэн гаргахыг ойлгоно.

3 дугаар зүйл

Энэхүү гэрээгээр хамгаалагдах хүмүүс

(1) Хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч бусад талын харьяат болох тоглолт гүйцэтгэгч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийг энэхүү гэрээгээр олгосон хамгаалалтад хамруулна.

(2) Хэлэлцэн тохирогч бусад талын харьяат гэдэгт хэрэв энэхүү гэрээний хэлэлцэн тохирогч бүх тал Ромын конвенцийн хэлэлцэн тохирогч тал болж байвал Ромын конвенцоор олгосон хамгаалалтыг эдлэхэд тавих шаардлагын шалгуурыг хангахуйц тоглолт гүйцэтгэгч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийг ойлгоно. Дээрх шаардлагын шалгуурын хувьд хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн холбогдох нэр томъёоны тодорхойлолтыг хэрэглэнэ.

(3) Ромын конвенцийн 5 дугаар зүйлийн (3) дахь хэсэгт эсхүл мөн конвенцийн 5 дугаар зүйлийн зорилгод Конвенцийн 17 дугаар зүйлд тусгагдсан боломжийг ашиглаж

байгаа хэлэлцэн тохирогч аливаа тал тэдгээр заалтад зааснаар Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДООБ)-ын ерөнхий захиралд мэдэгдэл өгнө.

4 дүгээр зүйл

Үндэсний журам

(1) Хэлэлцэн тохирогч тал тус бүр энэхүү гэрээгээр тусгайлан олгосон онцгой эрх, түүнчлэн энэхүү гэрээний 15 дугаар зүйлд заасан зохих үнэ хөлс авах эрхийн хувьд өөрийн харьяатдаа олгож байгаа хамгаалалтыг 3 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт тодорхойлсон хэлэлцэн тохирогч бусад талын харьяатад мөн адил олгоно.

(2) (1) дэх хэсэгт заасан үүрэг нь хэлэлцэн тохирогч нөгөө тал энэхүү гэрээний 15 дугаар зүйлийн (3) дахь хэсгээр зөвшөөрсөн тайлбарыг ашиглах хэмжээнд хэрэглэгдэхгүй.

II БҮЛЭГ ТОГЛОГЧИЙН ЭРХ

5 дугаар зүйл

Тоглогчийн эд хөрөнгийн бус эрх

(1) Тоглогчийн эдийн засгийн эрхээс үл хамаарч, түүнчлэн тэдгээр эрхийг бусдад шилжүүлснээс ч хойш тоглогчид нь амьд тоглолт буюу дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо хувьд, тоглолтыг ашиглах арга барилын улмаас тоглолт гүйцэтгэгч гэж нэрлүүлэхгүйгээс бусад тохиолдолд өөрийн тоглолтын тоглогчид гэж нэрлүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд нэр хүндэд нь хохирол учруулахуйцаар өөрчлөх, гажуудуулахыг хориглох эд хөрөнгийн бус эрх эдэлнэ.

(2) (1) дэх хэсгийн дагуу тоглогчид олгосон эрх нь түүнийг нас барсны дараа дор хаяж эдийн засгийн эрх нь дуустал хадгалагдах бөгөөд уг эрхийг хамгаалалт шаардагдаж буй тухайн хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн хувь хүн буюу байгууллага хэрэгжүүлнэ. Гэхдээ энэхүү гэрээг соёрхон батлах буюу нэгдэн орох үед хууль тогтоомжид нь өмнөх хэсэгт тусгасан тоглогчдын бүх эрхийг нас барснаас нь хойш хамгаалах талаар заагаагүй хэлэлцэн тохирогч талууд дээрх эрхийн заримыг тоглогчийг нас барсны дараа хадгалахгүйгээр зааж болно.

(3) Энэ зүйлээр олгосон эрхийг хангах хамгаалалтын арга хэрэгслийг нь хамгаалалт шаардагдаж буй тухайн хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжоор зохицуулна.

6 дугаар зүйл

Бичлэг хийгдээгүй тоглолтын хувьд эдлэх тоглогчийн эдийн засгийн эрх

Тоглогч нь тоглолтынхоо хувьд:

- (i) бичлэг хийгдээгүй тоглолт нь урьд нэвтрүүлж байсан тоглолтоос бусад тохиолдолд уг тоглолтоо олон нийтэд нэвтрүүлэх буюу мэдээлэх; болон
- (ii) бичлэг хийгдээгүй тоглолтоо бичүүлэхийг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

7 дугаар зүйл

Хуулбарлах эрх

Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтоо шууд буюу шууд бус аль ч хэлбэрээр хуулбарлан олшруулахыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

8 дугаар зүйл

Түгээх эрх

(1) Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо жинхэнэ эх болон хувийг худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх замаар олон нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт тоглогчийн зөвшөөрлөөр бичигдсэн тоглолтын жинхэнэ эх болон хуулбарыг анх удаа худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлсний дараа (1) дэх хэсэгт заасан эрхийг хэрэглэх нөхцлийг тодорхойлох талаарх хэлэлцэн тохирогч талуудын эрх чөлөөг хөндөхгүй.

9 дүгээр зүйл

Түрээслэх эрх

(1) Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо жинхэнэ эх болон хуулбарыг өөрсдийн зөвшөөрлийн дагуу түгээсний дараа ч хэлэлцэн тохирогч талын үндэсний хуулиар тодорхойлсны дагуу олон нийтэд төлбөртэй хөлслүүлэх буюу түрээслэх онцгой эрх эдлэнэ.

(2) (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтынхоо хувийг хөлслүүлсний төлөө тоглогчид нь зохих үнэ хөлс төлдөг тогтолцоо үйлчилж байсан бөгөөд үйлчилсээр байгаа хэлэлцэн тохирогч тал тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэгийг хөлслүүлэх нь дахин хуулбарлан олшруулах тоглогчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.

10 дугаар зүйл

Бичигдсэн тоглолтыг нийтийн хүртээл болгох эрх

Тоглогч нь дуу авианы бичлэгт бичигдсэн тоглолтоо олон нийтийн төлөөлөгчид өөрөө сонгосон газар, цагт танилцаж болохуйцаар шугаман эсхүл шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

III БҮЛЭГ ДУУ АВИАНЫ БИЧЛЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ЭРХ

11 дүгээр зүйл

Хуулбарлах эрх

Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгээ шууд буюу шууд бус аль ч хэлбэрээр хуулбарлан олшруулахыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

12 дугаар зүйл

Түгээх эрх

(1) Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгийнхээ жинхэнэ эх болон хуулбарыг худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх замаар нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

(2) Энэхүү гэрээний аль ч заалт авианы бичлэг үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр дуу авианы бичлэгийн жинхэнэ эх болон хуулбарыг анх удаа худалдах эсхүл өмчлөх эрхийг бусдад шилжүүлсний дараа (1) дэх хэсэгт заасан эрхийг хэрэглэх нөхцлийг тодорхойлох талаарх хэлэлцэн тохирогч талуудын эрх чөлөөг хөндөхгүй.

13 дугаар зүйл

Түрээслэх эрх

(1) Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгийнхээ жинхэнэ эх болон хуулбарыг түүний зөвшөөрлийн дагуу түгээсний дараа ч хэлэлцэн тохирогч талын үндэсний хуулиар тодорхойлсны дагуу нийтэд төлбөртэй хөлслүүлэх буюу түрээслэх онцгой эрх эдлэнэ.

(2) (1) дэх хэсгийн заалтыг үл харгалзан, 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэгийнхээ хуулбарыг хөлслүүлсний төлөө дуу авианы бичлэг үйлдвэрлэгчид нь зохих үнэ хөлс төлдөг тогтолцоо үйлчилж байсан бөгөөд үйлчилсээр байгаа хэлэлцэн тохирогч тал тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэгийг хөлслүүлэх нь хуулбарлан олшруулах дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.

14 дүгээр зүйл

Дуу авианы бичлэгийг нийтийн хүртээл болгох эрх

Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь дуу авианы бичлэгээ олон нийтийн төлөөлөгчид өөрөө сонгосон газар, цагт танилцаж болохуйцаар шугаман буюу шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болгохыг зөвшөөрөх онцгой эрх эдлэнэ.

**IV БҮЛЭГ
НИЙТЛЭГ ЗААЛТ**

15 дугаар зүйл

**Нийтэд нэвтрүүлсэн болон
мэдээлсний төлөө үнэ хөлс авах эрх**

(1) Тоглогчид болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгч нь худалдааны зорилгоор нийтлэсэн дуу авианы бичлэгийг олон нийтэд нэвтрүүлэх буюу мэдээлэхээр шууд буюу шууд бусаар ашигласны төлөө нэг удаагийн зохих үнэ хөлс авах эрх эдлэнэ.

(2) Нэг удаагийн зохих үнэ хөлсийг тоглогч буюу дуу авианы бичлэг үйлдвэрлэгч эсхүл хоёулаа дуу авианы бичлэгийг ашигласан этгээдээс шаардахаар хэлэлцэн тохирогч талууд үндэсний хууль тогтоомждоо тогтоож болно. Тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн хооронд гэрээ байгуулаагүй тохиолдолд нэг удаагийн зохих үнэ хөлсийг хуваах нөхцлийг тогтоосон үндэсний хууль тогтоомжийг хэлэлцэн тохирогч талууд батлаж болно.

(3) Хэлэлцэн тохирогч аливаа тал ДООБ-ын Ерөнхий захиралд хадгалуулсан мэдэгдэлдээ (1) дэх хэсгийн заалтыг зөвхөн зарим тодорхой тохиолдолд хэрэглэх эсхүл тэрхүү заалтыг хэрэглэхийг өөр бусад замаар хязгаарлах болон огт хэрэглэхгүй тухайгаа мэдэгдэж болно.

(4) Энэхүү зүйлийн зорилгод, олон нийтийн төлөөлөгчид өөрөө сонгосон газар, цагт танилцаж болохуйцаар шугаман ба шугаман бус холбоогоор нийтийн хүртээл болсон дуу авианы бичлэгийг худалдааны зорилгоор нийтлэсэн хэмээн үзнэ.

16 дугаар зүйл

Хязгаарлалт, онцгой тохиолдол

(1) Хэлэлцэн тохирогч талууд утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотойгоор үндэсний хууль тогтоомждоо тогтоосон хязгаарлалт буюу онцгой тохиолдолтой адил заалтуудыг тоглогч буюу дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрхийг хамгаалах зорилгоор үндэсний хууль тогтоомждоо тусгаж болно.

(2) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээнд тогтоосон эрхийн хязгаарлалт болон онцгой тохиолдлыг тоглолт буюу дуу авианы бичлэгийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хөндөхгүй тохиолдолд хэрэглэнэ.

17 дугаар зүйл

Хамгаалалтын хугацаа

(1) Энэхүү гэрээгээр тоглогчдоод олгох хамгаалалтын үргэлжлэх хугацаа тоглолтыг дуу авианы бичлэгт бичсэн тухайн жилийн эцсээс хойш 50 жил байна.

(2) Энэхүү гэрээгээр дуу авианы бичлэг үйлдвэрлэгчдэд олгох хамгаалалтын хугацаа дуу авианы бичлэгийг нийтлэсэн жилийн эцсээс хойш 50 жил эсхүл дуу авианы бичлэгийг бичсэнээс хойш 50 жилийн хугацаанд нийтлэгдээгүй бол бичлэг анх хийсэн жилийн эцсээс хойш 50 жилийн хугацаа дуустал үргэлжилнэ.

18 дугаар зүйл

Технологийн арга хэмжээтэй холбогдох үүрэг

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээний дагуу эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тоглогч буюу дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн хэрэглэж байгаа бөгөөд тэдний тоглолт, дуу авианы бичлэгийнх нь хувьд тухайн тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүй буюу хуулиар зөвшөөрөөгүй үйлдлийг хязгаарлаж байгаа техникийн үйл ажиллагаанаас зайлсхийхийн тулд эрх зүйн зүй зохистой хамгаалалт болон хуулийн үр ашигтай арга хэмжээ авна.

19 дүгээр зүйл

Эрхийн удирдлагын мэдээлэлтэй холбогдох үүрэг

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээгээр хамгаалагдсан эрхийг зөрчихөд хүргэх, боломж олгох, зөрчихөд туслах буюу ийм зөрчлийг нуусан үйлдлийг мэдсээр байж, эсхүл иргэний арга хэмжээний хувьд дээрхийг мэдэх бодит үндэслэлтэй байж доорхи аль нэг үйлдлийг санаатайгаар хийж буй аливаа этгээдийн эсрэг хуулийн зүй зохистой, үр ашигтай арга хэмжээ авна.

- (i) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах буюу өөрчлөх;
- (ii) эрхийн удирдлагын талаарх цахим мэдээллийг устгасан буюу өөрчилсөн гэдгийг мэдсэн хэрнээ тоглолт, бичигдсэн тоглолтын хуулбар буюу дуу авианы бичлэгийг олон нийтэд түгээх, түгээхээр импортлох, нэвтрүүлэх, мэдээлэх эсхүл нийтийн хүртээл болгох.

(2) Энэ зүйлд заасан “эрхийн удирдлагын тухай мэдээлэл” гэж тоглогч, тоглогчийн тоглолт, дуу авианы бичлэг үйлдэрлэгч, дуу авианы бичлэг, тоглолт буюу дуу авианы бичлэгийн аливаа эрх эзэмшигчийг тодорхойлж буй мэдээлэл эсхүл тоглолт буюу дуу авианы бичлэгийг ашиглах нөхцөл, болзлын талаарх мэдээлэл, мөн бичигдсэн тоглолт буюу дуу авианы бичлэгийн хуулбарт тавигдсан буюу тоглолт, дуу авианы бичлэгийг олон нийтэд мэдээлэх, нийтийн хүртээл болгохтой холбоотойгоор гарч байгаа тийм мэдээллийг илэрхийлж байгаа аливаа тоо болон код мэдээг хэлнэ.

20 дугаар зүйл

Хэлбэрийн хувьд тавигдах шаардлага

Энэхүү гэрээгээр олгосон эрхийг эдлэж, хэрэгжүүлэхэд хэлбэрийн хувьд ямар нэг шаардлага тавихгүй.

21 дүгээр зүйл

Тайлбар

15 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн заалтыг дагаж мөрдөхийн хамт энэхүү гэрээнд ямар нэг тайлбар хийхийг хориглоно.

22 дугаар зүйл

Хэрэглэх хугацаа

(1) Хэлэлцэн тохирогч талууд Бернийн конвенцийн 18 дугаар зүйлийн заалтыг энэхүү гэрээгээр олгосон тоглогч болон дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрхэд хэрэглэнэ.

(2) (1) дэх хэсгийг үл харгалзан хэлэлцэн тохирогч тал энэхүү гэрээний 5 дугаар зүйлийг хэрэглэхийг энэхүү гэрээ тухайн талын хувьд хүчин төгөлдөр болсны дараа гарсан тоглолтоор хязгаарлаж болно.

23 дугаар зүйл

Эрхийн хэрэгжилтийн тухай заалт

(1) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээг хэрэглэхэд шаардлагатай арга хэмжээг өөрийн хуулийн тогтолцоотой уялдуулан авах үүрэг хүлээнэ.

(2) Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээнд заасан эрхийг зөрчиж байгаа аливаа үйлдлийн эсрэг үр ашигтай арга хэмжээ авахыг зөвшөөрөхүйц эрхээр хангах журмыг өөрийн хууль тогтоомжид тусгах бөгөөд ялангуяа эрх зөрчихөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрсдийн хууль тогтоомжид тусгана.

**V БҮЛЭГ
ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ**

24 дүгээр зүйл

Ассамблей

(1) (a) Хэлэлцэн тохирогч талууд Ассамблейтай байна.

(b) Хэлэлцэн тохирогч тал тус бүрийг нэг төлөөлөгч төлөөлөх бөгөөд тэрээр орлогч, зөвлөх, шинжээчтэй байж болно.

(c) Төлөөлөгчдийн зардлыг тэдгээрийг томилсон хэлэлцэн тохирогч тал хариуцна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журмын дагуу хөгжиж байгаа оронд тооцогддог эсхүл зах зээлийн эдийн засагт шилжиж буй орон болох хэлэлцэн тохирогч талын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулахыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор Ассамблей санхүүгийн туслалцаа үзүүлэхийг ДООБ-аас хүсч болно.

(2) (a) Ассамблей энэхүү гэрээг сахих, хөгжүүлэх, хэрэглэх, түүний үйлчлэлтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

(b) Ассамблей засгийн газар хоорондын зарим тодорхой байгууллагыг энэхүү гэрээнд элсүүлэх асуудлыг хэлэлцэхдээ 26 дугаар зүйлийн (2) дахь хэсгээр түүнд ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(с) Ассамблей энэхүү гэрээг хянаж өөрчлөх зорилгоор аливаа дипломат бага хурал зарлан хуралдуулах шийдвэр гаргах бөгөөд тийм дипломат бага хуралд бэлтгэхэд шаардлагатай зааварчлагыг ДООБ-ын ерөнхий захиралд өгнө.

(3) (а) Хэлэлцэн тохирогч тал болох улс нэг санал өгөх эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн нэрийн өмнөөс санал өгнө.

(b) Засгийн газар хоорондын байгууллага болох хэлэлцэн тохирогч аливаа тал энэхүү гэрээний тал болох гишүүн улсынхаа тоотой тэнцүү тоогоор гишүүн улсынхаа оронд санал өгч болно. Хэрэв аль нэг гишүүн улс саналын эрхээ өөрөө хэрэгжүүлж байгаа бол засгийн газар хоорондын аль ч байгууллага санал өгөхөд оролцохгүй бөгөөд энэ журам мөн урвуугаар үйлчилнэ.

(4) ДООБ-ын ерөнхий захирал хоёр жилд нэг удаа Ассамблейн ээлжит чуулганыг зарлан хуралдуулна.

(5) Үйл ажиллагааныхаа журмыг тогтоох бөгөөд үүнд ээлжит бус чуулган зарлан хуралдуулах, чуулганы кворум, мөн энэхүү гэрээний заалтын дагуу төрөл бүрийн асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай олонхын хэмжээг тогтооно.

25 дугаар зүйл

Олон улсын товчоо

ДООБ-ын Олон улсын товчоо нь энэхүү гэрээтэй холбогдох захиргааны үүргийг гүйцэтгэнэ.

26 дугаар зүйл

Гэрээнд оролцогч тал болох

(1) ДООБ-ын гишүүн аливаа улс энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

(2) Энэхүү гэрээгээр зохицуулж буй асуудлын талаар тодорхой эрх мэдэлтэй бөгөөд эдгээр асуудлаар гишүүн бүх улсад нь заавал биелүүлэх өөрийн хууль тогтоомжтой, мөн энэхүү гэрээнд нэгдэн орохыг нь дотоод журмынхаа дагуу зохих ёсоор эрх олгогдсон засгийн газар хоорондын байгууллагыг гишүүнээр элсүүлэхээр Ассамблей шийдвэрлэнэ.

(3) Европын хамтын нийгэмлэг өмнөх хэсэгт заасан мэдэгдлийг энэхүү гэрээг батласан Дипломат бага хурлын үеэр хийснээр энэхүү гэрээнд оролцогч тал болж болно.

27 дугаар зүйл

Гэрээний дагуу эдлэх эрх ба хүлээх үүрэг

Энэхүү гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол хэлэлцэн тохирогч тал тус бүр энэхүү гэрээгээр олгосон бүх эрхийг эдлэж, бүх үүргийг хүлээнэ.

28 дугаар зүйл

Гэрээнд гарын үсэг зурах

Энэхүү гэрээ ДООБ-ын гишүүн аливаа улс болон Европын хамтын нийгэмлэг гарын үсэг зурахад 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нээлттэй байна.

29 дүгээр зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээ гуч дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг ДООБ-ын ерөнхий захиралд хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

30 дугаар зүйл

Гэрээнд нэгдэн орох хугацаа

Энэхүү гэрээний заалтыг:

- (i) 29 дүгээр зүйлд дурдсан гучин улс энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж;
- (ii) бусад аливаа улс ДООБ-ын ерөнхий захиралд баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа;
- (iii) Европын хамтын нийгэмлэг, хэрэв батламж жуух бичиг буюу нэгдэн орсон баримт бичгээ энэхүү гэрээ 29 дүгээр зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсны дараа хадгалуулсан бол тийнхүү хадгалуулснаас хойш гурван сарын дараа эсхүл тийм баримт бичгээ энэхүү гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө хадгалуулсан бол гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дараа;
- (iv) энэхүү гэрээнд нэгдэж буй засгийн газар хоорондын өөр бусад байгууллага нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа тус тус заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

31 дүгээр зүйл

Гэрээг цуцлах

Аливаа хэлэлцэн тохирогч тал энэхүү гэрээг цуцлах тухай мэдэгдлээ ДООБ-ын ерөнхий захиралд өгснөөр цуцалж болно. ДООБ-ын Ерөнхий захирал дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа гэрээг цуцалсанд тооцно.

32 дугаар зүйл

Гэрээний хэл

(1) Энэхүү гэрээг англи, араб, хятад, франц, орос, испани хэлээр нэг эх хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

(2) (1) дэх хэсэгт дурдсанаас бусад хэлээрх албан ёсны эх бичвэрийг сонирхогч бүх талтай зөвлөлдсөний дараа сонирхогч талын хүсэлтээр ДООБ-ын Ерөнхий захирал үйлдэнэ. Энэ хэсгийн зорилгод “сонирхогч тал” гэж албан ёсны хэл, эсхүл албан ёсны хэлнүүдийн аль нэгээр нь хүсэлт гаргасан ДООБ-ын гишүүн улс, мөн аль нэг албан ёсны хэлээр нь хүсэлт гаргасан Европын хамтын нийгэмлэг болон энэхүү гэрээнд нэгдэн орж болох Засгийн газар хоорондын аливаа бусад байгууллагыг хэлнэ.

33 дугаар зүйл

Хадгалагч

ДООБ-ын ерөнхий захирал энэхүү гэрээний хадгалагч байна.

71. ХУДАЛДААНД ХАМААРАХ ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР*

Гишүүд,

Олон улсын худалдаан дахь гажуудал, саадыг багасгах болон оюуны өмчийн эрхийг үр дүнтэй, зохистойгоор хамгаалахад дэмжлэг үзүүлэх хэрэгцээг харгалзан оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллагаа нь өөрөө хууль ёсны худалдаанд саад болохгүй байх явдлыг хангахыг хүсч,

Энэхүү зорилгоор дараахь асуудалтай холбогдуулан шинэ дүрэм, журам хэрэгтэй байгааг хүлээн зөвшөөрч,

- (a) 1994 оны ТХЕХ болон оюуны өмчийн талаарх олон улсын холбогдох хэлэлцээр буюу конвенцийн үндсэн зарчмыг хэрэглэх;
- (b) худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн хэмжээ, ашиглалттай холбогдох зүй зохистой зарчим, хэм хэмжээг боловсруулах;
- (c) үндэсний эрх зүйн тогтолцооны ялгааг харгалзан худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй, зохистой аргаар хангах;
- (d) засгийн газар хоорондын маргаанаас олон талын түвшинд урьдчилан сэргийлж, зохицуулах үр дүнтэй, шуурхай ажиллагаагаар хангах;
- (e) хэлэлцээний үр дүнд бүрэн оролцоход чиглэсэн шилжилтийн зохицуулалт хийх;

* Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-нд нэгдэн орсон

Хуурамч барааны олон улсын худалдаатай холбоотой олон талын багц зарчим, дүрэм, журам шаардлагатайг хүлээн зөвшөөрч;

Оюуны өмчийн эрх нь хувийн эрх мөн гэдгийг хүлээн зөвшөөрч;

Хөгжил, технологийн зорилт зэрэг оюуны өмчийг хамгаалах үндэсний тогтолцооны нийгмийн бодлогын суурь зорилтыг хүлээн зөвшөөрч;

Технологийн найдвартай, дэвшилттэй суурь бүрдүүлэх чадвартай болгохын тулд нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад хууль, журмыг дотооддоо хамгийн уян хатан хэрэгжүүлэх тусгай хэрэгцээ байгааг мөн хүлээн зөвшөөрч;

Оюуны өмчийн худалдаанд хамаарах асуудлаархи маргааныг олон талт журмаар шийдвэрлэж байх талаар улам хатуу үүрэг амлалт авах замаар хүндрэлийг багасгахын чухлыг онцлон тэмдэглэж;

ДХБ болон Дэлхийн оюуны өмчийн байгууллага (энэхүү хэлэлцээрт цаашид “ДООБ” гэнэ) түүнчлэн олон улсын холбогдох бусад байгууллагын хооронд харилцан дэмжсэн харилцаа тогтоохыг хүсч;

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I ХЭСЭГ НИЙТЛЭГ ЗААЛТ, ҮНДСЭН ЗАРЧИМ

1 дүгээр зүйл

Үүргийн мөн чанар, хамрах хүрээ

1. Гишүүд энэхүү хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлнэ. Гишүүд энэхүү хэлэлцээрт зааснаас илүү өргөн хүрээнд хамгаалалтыг тогтоож болох боловч заавал энэ төрлийн үүрэг хүлээхгүй, чингэхдээ тэр хамгаалалт нь энэхүү хэлэлцээрийн заалтад харшлахгүй байвал зохино. Гишүүд энэхүү хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлэх зохистой арга хэмжээг эрх зүйн тогтолцоо, дадлынхаа хүрээнд чөлөөтэй тодорхойлно.
2. Энэхүү хэлэлцээрийн зорилгод “оюуны өмч” гэдэгт II хэсгийн 1-7 дугаар ангид заасан оюуны өмчийн бүх салбарыг хамруулна.
3. Гишүүд энэхүү хэлэлцээрт заасан журамд бусад гишүүний харьяатыг хамруулна. Оюуны өмчийн эрхийн хувьд бусад гишүүний харьяат гэдэгт ДХБ-ын бүх гишүүн нь байх Парисын конвенц (1967), Бернийн конвенц (1971), Ромын конвенц, Бичил бүдүүвчийн талаарх оюуны өмчийн тухай гэрээнд заасан хамгаалалтыг эдлэх шаардлагын шалгуурыг хангахуйц хувь хүн, хуулийн этгээд гэж ойлгоно. Ромын конвенцийн 5 дугаар зүйлийн (3) дахь хэсэг эсхүл 6 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан боломжийг ашиглаж байгаа аливаа гишүүн тэдгээр заалтын дагуу Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах асуудлаархи зөвлөл (ОӨЭХХА-аарх зөвлөл)-д мэдэгдэл өгнө.

2 дугаар зүйл

Оюуны өмчийн конвенцууд

1. Гишүүд энэхүү хэлэлцээрийн II, III, IV дүгээр хэсгийн хувьд Парисын конвенц (1967)-ийн 1-12, түүнчлэн 19 дүгээр зүйлийг дагаж мөрдөнө.
2. Энэхүү хэлэлцээрийн I-IV хэсгийн аль ч заалт Парисын конвенц, Бернийн конвенц, Ромын конвенц, Бичил бүдүүвчийн тухай оюуны өмчийн тухай гэрээний дагуу гишүүдийн бие биеийнхээ өмнө хүлээсэн үүргийг үгүйсгэхгүй.

3 дугаар зүйл

Үндэсний нөхцөл

1. Гишүүн бүр оюуны өмчийн хамгаалалтын хувьд өөрийн харьяатад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцлийг бусад гишүүний харьяатад олгоно, гэхдээ Парисын конвенц (1967), Бернийн конвенц (1971), Ромын конвенц эсхүл Бичил бүдүүвчийн талаарх оюуны өмчийн тухай гэрээнд заасан онцгой тохиолдол үүнд хамаарахгүй. Тоглогч, дуу авианы бичлэгийн үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч байгуулагын хувьд энэ үүрэг нь зөвхөн энэхүү хэлэлцээрт заасан эрхийн хувьд хэрэглэгдэнэ. Бернийн конвенц (1971)-ийн 6 дугаар зүйл эсхүл Ромын конвенцийн 16 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан боломжийг ашиглаж байгаа аливаа гишүүн тэдгээр заалтын дагуу ОӨЭХХА-аархи зөвлөлд мэдэгдэл өгнө.
2. Гишүүд харьяаллын хүрээнд шүүх болон захиргааны журмаар явуулах ажиллагааны хувьд (1) дэх хэсгийн дагуу зөвшөөрсөн хаяг тогтоох буюу агент томилох зэрэг онцгой тохиолдлыг ашиглаж болно, гэхдээ уг онцгой тохиолдол нь энэхүү хэлэлцээрийн заалттай зөрчилдөөгүй хууль, журмыг дагаж мөрдөх явдлыг баталгаажуулахад зөвхөн шаардлагатай бөгөөд тэрхүү дадлыг худалдаанд нуугдмал хязгаарлалт болох байдлаар хэрэглэхгүй нөхцөлд тийнхүү ашиглаж болно.

4 дүгээр зүйл

Нэн тааламжтай үндэсний нөхцөл

Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын хувьд аль ч орны иргэдэд гишүүнээс бусад аль ч орны иргэдэд олгож буй давуу байдал, тааламжтай байдал, эрх ямба буюу дархан эрхийг бусад бүх гишүүний харьяатад ямарваа болзолгүйгээр нэн даруй олгоно. Гишүүн олгож буй дараахь давуу байдал, тааламжтай байдал, эрх ямба буюу дархан эрх энэ үүргээс чөлөөлөгдөнө:

- (a) оюуны өмчийг хамгаалах асуудлаар тусгайлан хязгаарлаагүй, ерөнхий чанарын шүүхийн туслалцааны буюу хууль хэрэгжүүлэх тухай олон улсын хэлэлцээрээс үүдэн гарсан;
- (b) олгосон нөхцөл нь үндэсний нөхцөл биш, харин бусад улсад олгох нөхцлийг зөвшөөрсөн Бернийн конвенц (1971) буюу Ромын конвенцийн

заалтын дагуу олгосон;

- (с) энэхүү хэлэлцээрт заагаагүй тоглогч, дуу авианы бичлэгийн үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч байгууллагын эрхтэй холбоотой бол,
- (d) ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хүчин төгөлдөр болсон оюуны өмчийг хамгаалах тухай олон улсын хэлэлцээрээс үүдэн гарсан, чингэхдээ тэдгээр хэлэлцээрийн талаар ОӨЭХХА-аархи зөвлөлд мэдэгдсэн бөгөөд бусад гишүүний харьяатыг үндэслэлгүйгээр буюу шударга бусаар алагчилахгүй байвал зохино.

5 дугаар зүйл

**Хамгаалалт олж авах буюу хадгалах тухай
олон талт хэлэлцээр**

3, 4 дүгээр зүйлд заасан үүргийг оюуны өмчийн эрхийг олж авах буюу хадгалах асуудлаар ДООБ-ын ивээл дор байгуулсан олон талт хэлэлцээрүүдэд заасан журамд хэрэглэхгүй.

6 дугаар зүйл

Дуусгавар болох

3, 4 дүгээр зүйлийг дагаж мөрдөхийн хамт энэхүү хэлэлцээрийн дагуу маргаан зохицуулах зорилгоор энэхүү хэлэлцээрийн аль ч заалтыг оюуны өмчийн эрх дуусгавар болох асуудлыг хэлэлцэхэд хэрэглэхгүй.

7 дугаар зүйл

Зорилт

Оюуны өмчийн эрхийг хамгаалж, хэрэгжүүлэх нь технологийн шинэ санаачлагыг дэмжих, технологийг дамжуулж, дэлгэрүүлэх, технологийн мэдлэгийг үйлдвэрлэгч болон ашиглагчид харилцан ашигтай байх, боломжтой байдлаар нийгэм, эдийн засгийн аж байдалд тааламжтай байдлаар нөлөөлөх ба түүнчлэн эрх, үүргийг тэнцвэржүүлэхэд хувь нэмэр оруулах нь зүйтэй.

8 дугаар зүйл

Зарчим

1. Гишүүд хууль, журмаа боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулахдаа нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгэм-эдийн засаг, технологийн хөгжилд амин чухал салбарт олон нийтийн ашиг сонирхлыг дэмжихэд шаардлагатай арга хэмжээг авч болох бөгөөд энэхүү хэлэлцээрийн заалтад нийцсэн байвал зохино.
2. Оюуны өмчийн эрхийг эрх эзэмшигчийн зүгээс урвуулан ашиглахаас эсхүл худалдааг үндэслэлгүйгээр хязгаарлах буюу олон улсын хүрээнд технологи

дамжуулахад сөргөөр нөлөөлөх дадлыг ашиглахаас урьдчилан сэргийлэхэд авах зохистой арга хэмжээ нь хэрэв тэдгээр нь энэхүү хэлэлцээрийн заалтад нийцэж байгаа бол шаардлагатай байж болно.

**II ХЭСЭГ
ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН БАЙДАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ, АШИГЛАЛТАД
ХОЛБОГДОХ ХЭМ ХЭМЖЭЭ**

1 дүгээр анги: Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх

9 дүгээр зүйл

Бернийн конвенцид хамаарах нь

1. Гишүүд Бернийн конвенц (1971)-ийн 1-21 дүгээр зүйл болон түүний хавсралтыг дагаж мөрдөнө. Гэхдээ гишүүд нь тэр конвенцийн 6 bis зүйлээр олгосон эрх буюу түүнээс үүдэн гарах эрхийн хувьд энэхүү хэлэлцээрийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээхгүй.
2. Зохиогчийн эрхийн хамгаалалт нь биелэлээ олсон зүйлд хамаарах бөгөөд харин санаа, үйлдэл, үйл ажиллагааны арга эсхүл математикийн үзэл баримтлалд хамаарахгүй.

10 дугаар зүйл

Компьютерийн программ мэдээллийн эмхтгэл

1. Компьютерийн программын эх сурвалж буюу кодлосон байдлаас үл хамааран Бернийн конвенцийн дагуу утга зохиолын бүтээлийн нэгэн адил хамгаална.
2. Машинаар унших боломжтой буюу өөр хэлбэрт байгаа агуулгын сонголт, найруулгаас шалтгаалан оюуны бүтээл болж буй мэдээллийн эмхтгэл буюу бусад материал оюуны бүтээлийн үр дүн болж байвал энэ утгаараа хамгаалагдана. Энэ хамгаалалт нь тоон мэдээ болон уг материалд хамаарахгүй бөгөөд тухайн тоон мэдээ буюу уг материалд агуулагдаж буй зохиогчийн эрхийг хөндөхгүй.

11 дүгээр зүйл

Түрээслэх эрх

Компьютерийн программ болон кино урлагийн бүтээлийн хувьд, гишүүн нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлийнхээ жинхэнэ эх буюу хуулбарыг олон нийтэд худалдааны зорилгоор түрээслэхийг зөвшөөрөх буюу хориглох эрхийг зохиогч болон тэдгээрийн эрх залгамжлагчид олгоно. Тийнхүү түрээсэлсэн нь тухайн гишүүнээс зохиогч болон эрх залгамжлагчид олгосон хуулбарлан олшруулах онцгой эрхийг бодит байдлаар зөрчих тэдгээр бүтээлийг өргөнөөр хуулбарлахад хүргээгүй бол кино урлагийн бүтээлийн хувьд гишүүн нь энэ үүргээс чөлөөлөгдөнө. Компьютерийн программын хувьд уг программ нь хөлслүүлэх үндсэн зүйл биш бол энэ үүрэг хамаарахгүй.

12 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

Фото зургийн буюу хавсарга урлагийн бүтээлээс бусад бүтээлийг хамгаалах хугацааг хүний амьдралын хугацаанаас өөр үндэслэлээр тооцохдоо ийм хугацаа нь зөвшөөрлийн дагуу хэвлэн нийтэлсэн хуанлийн жилийн эцсээс хойш тавин жилээс багагүй, эсхүл бүтээлийг туурвиснаас хойш тавин жилийн хугацаанд хэвлэн нийтлэх зөвшөөрөл аваагүй тохиолдолд тийнхүү туурвисан хуанлийн жилийн эцсээс хойш тавин жилээс багагүй байна.

13 дугаар зүйл

Хязгаарлалт болон онцгой тохиолдол

Гишүүд бүтээлийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн эрх эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хөндөхгүй онцгой тохиолдолд онцгой эрхэд хязгаарлалт эсхүл онцгой нөхцөл тогтоож болно.

14 дүгээр зүйл

**Тоглогч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгч,
нэвтрүүлэх байгууллагын эрхийг хамгаалах**

1. Тоглогч тоглолтоо дуу авианы бичлэгт бичих талаар түүний зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдлээс урьдчилан сэргийлэх боломжтой: бичигдээгүй тоглолтыг нь бичлэгт буулгах болон тийм бичлэгийг олшруулан хуулбарлах. Тоглогчийн зөвшөөрөлгүйгээр явагдсан дараахь үйлдлээс урьдчилан сэргийлэх боломжтой: амьд тоглолтоо шугаман бус холбоогоор олон нийтэд нэвтрүүлэх.
2. Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч өөрийн дуу авианы бичлэгийг шууд буюу шууд бусаар олшруулан хуулбарлахыг зөвшөөрөх буюу хориглох эрх эдлэнэ.
3. Нэвтрүүлэх байгууллага нь дараахь үйлдлийг түүний зөвшөөрөлгүйгээр хийхээс хориглох эрхтэй: бичлэг хийх, бичлэгийг олшруулан хуулбарлах, шугаман бус холбоогоор нэвтрүүлгийг дахин нэвтрүүлэх, түүнчлэн нэвтрүүлгийг телевизээр олон нийтэд мэдээлэх. Гишүүд хэрэв ийм эрхийг нэвтрүүлэгч байгууллагад олгодохгүй бол нэвтрүүлгийн хувьд зохиогчийн эрх эзэмшигчид дээр дурдсан үйлдлээс (Бернийн конвенц (1971)-ийн заалтын дагуу) урьдчилан сэргийлэх боломж олгоно.
4. Компьютерийн программын талаарх 11 дүгээр зүйлийн заалтыг дуу авианы бичлэг үйлдвэрлэгч болон аль нэг гишүүний хуульд тодорхойлсон дуу авианы бичлэг дэх аливаа бусад эрх эзэмшигчид хэрэглэнэ. Хэрэв гишүүн улсад 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэгээ хөлслүүлсний төлөө эрх эзэмшигчид нь зохих урамшуулал төлдөг тогтолцоо үйлчилж байгаа бол тухайн гишүүн тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэгийг хөлслүүлэх нь хуулбарлан олшруулах эрх эзэмшигчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.

5. Энэхүү хэлэлцээрийн дагуу тоглогч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эдлэж болох хамгаалалтын хугацаа нь бичлэг хийсэн буюу тоглолт болсон хуанлийн жилийн эцсээс хойш наад зах нь тавин жил үргэлжилнэ. (3) дахь хэсгийн дагуу олгосон хамгаалалтын хугацаа нь нэвтрүүлгийг нэвтрүүлсэн хуанлийн жилийн эцсээс хойш наад зах нь хорин жил үргэлжилнэ.
6. (1), (2), (3) дахь хэсгийн дагуу олгосон эрхийн талаар аливаа гишүүн Ромын конвенцоор зөвшөөрсөн хэмжээнд нөхцөл, хязгаарлалт, онцгой тохиолдол тогтоох ба тайлбар хийж болно. Гэхдээ Бернийн конвенц (1971)-ийн 18 дугаар зүйлийн заалтыг тоглогч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрхэд хэрэглэнэ.

2 дугаар анги: Барааны тэмдэг

15 дугаар зүйл

Хамгаалагдвал зохих зүйл

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэг этгээдийн бараа буюу үйлчилгээг бусад этгээдийнхээс ялгаж буй тэмдэг, тэмдгийн хослолыг барааны тэмдэгт тооцож болно. Хувь хүний нэр, үсэг, тоо, дүрс, өнгөний хослолыг багтаасан үг бүхий тэмдэг, тэмдгийн хослолыг барааны тэмдгээр бүртгэж болно. Хэрэв тэмдэг нь шинж чанарын хувьд холбогдох бараа буюу үйлчилгээг ялгах чадваргүй бол гишүүд тэмдгийн бүртгэлийг ашиглалтын явцад бий болсон ялгагдах чадвараас хамааруулж болно. Гишүүд тэмдгийн ялгагдах шинжийг бүртгэх нөхцөл болгон шаардаж болно.
2. Аль нэг гишүүн өөр үндэслэлээр барааны тэмдгийг бүртгэхээс татгалзахад саад болно гэж (1) дэх хэсгийг ойлгож болохгүй бөгөөд чингэхдээ тэдгээр үндэслэл нь Парисын конвенц (1967)-ийн заалтыг зөрчихгүй байвал зохино.
3. Гишүүд ашиглалтыг бүртгэх шалгуур болгож болно. Гэхдээ барааны тэмдгийн жинхэнэ бодит хэрэглээг бүртгүүлэх мэдүүлэг гаргах нөхцөл болгож болохгүй. Мэдүүлэг гаргаснаас хойш гурван жилийн хугацаа дуусахаас өмнө хэрэглээгүй гэсэн ганцхан үндэслэлээр мэдүүлгийг хүлээж авахаас татгалзаж болохгүй.
4. Барааны тэмдэг хэрэглэх бараа буюу үйлчилгээний мөн чанар нь барааны тэмдгийг бүртгэхэд ямар ч тохиолдолд саад болохгүй.
5. Гишүүд барааны тэмдгийг бүртгэхээс өмнө буюу бүртгэсний дараа даруй нийтлэх бөгөөд бүртгэлийг хүчингүй болгох хүсэлт гаргах бодитой боломж олгоно. Үүнээс гадна гишүүд барааны тэмдгийн бүртгэлийг эсэргүүцэж болно.

16 дугаар зүйл

Олгосон эрх

1. Бүртгэгдсэн барааны тэмдгийн эзэмшигч нь бүртгэгдсэн бараа буюу үйлчилгээтэй ижил буюу төсөөтэй бараа буюу үйлчилгээнд ижил буюу төсөөтэй тэмдэг хэрэглэх төөрөгдөлд хүргэж болзошгүй тул бүх гуравдагч талууд эзэмшигчийн зөвшөөрөлгүй бараа болон үйлчилгээг хэрэглэхээс сэрэмжилж

түүнийг урьдчилан зогсоох онцгой эрхтэй. Ижил бараа буюу үйлчилгээнд ижил тэмдэг хэрэглэх тохиолдолд төөрөгдөлд хүргэж болохуйц гэж үзнэ. Дээр дурдсан эрх нь өмнө олгосон эрхийг хөндөхгүй бөгөөд хэрэглээг үндэслэн эрх олж авах боломжинд нөлөөлөхгүй.

2. Парисын конвенц (1967)-ийн 6 bis зүйлийг үйлчилгээнд байдлаар хэрэглэнэ. Гишүүд барааны тэмдгийн нийтэд танил эсэхийг тодорхойлохдоо тухайн барааны тэмдгийг сурталчилгааны үр дүнд тухайн гишүүн улсад нийгмийн тодорхой хэсэгт танил болсон эсэхийг харгалзана.
3. Парисын конвенц (1967)-ийн 6 bis зүйлийг барааны тэмдэг нь бүртгэгдсэн бараа буюу үйлчилгээнээс өөр бараа буюу үйлчилгээнд хэрэглэх бөгөөд чингэхдээ тэдгээр бараа буюу үйлчилгээнд хамаарах тэр барааны тэмдгийг хэрэглэх нь тэдгээр бараа буюу үйлчилгээ болон бүртгэгдсэн барааны тэмдгийн эзэмшигчийн хоорондын холбоог харуулахуйц, түүнчлэн тийнхүү хэрэглэснээр бүртгэгдсэн барааны тэмдгийн эзэмшигчийн ашиг сонирхол зөрчигдөж болохыг анхаарна.

17 дугаар зүйл

Онцгой тохиолдол

Гишүүд нь барааны тэмдэг эзэмшигч болон гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг үл хөндөх, дүрсэлсэн илэрхийллийг зүй зохистой ашиглах гэх иэт хязгаарлагдмал нөхцөл байдлыг тогтоож болно.

18 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

Барааны тэмдгийг анх бүртгэх болон бүртгэлийг сунгах хугацаа нь тус бүр долоон жилээс хэтрэхгүй байна. Барааны тэмдгийн бүртгэлийг хэдэн ч удаа сунгаж болно.

19 дүгээр зүйл

Ашиглалтын шаардлага

1. Хэрэв ашиглалт нь бүртгэлийг хүчинтэй хадгалахад шаардлагатай болж байвал тэмдэг нь наад зах нь тасралтгүй 3 жилийн хугацаанд ашиглагдаагүй бөгөөд барааны тэмдгийн эзэмшигч нь тийнхүү хэрэглэхэд саад болсон бодит шалтгааныг нотлоогүй бол бүртгэлийг хүчингүй болгож болно. Барааны тэмдгээр хамгаалагдсан бараа буюу үйлчилгээнд импортын хязгаарлалт эсхүл засгийн газраас бусад шаардлага тавьсан зэргээр барааны тэмдэг хэрэглэхэд саад учруулж буй барааны тэмдэг эзэмшигчийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг барааны тэмдэг ашиглаагүйн бодит шалтгаан болно.
2. Барааны тэмдгийн эзэмшигчийн хяналтан дор өөр этгээд барааны тэмдгийг ашигласныг барааны тэмдгийн бүртгэлийг хүчинтэй байлгах зорилгоор ашиглаж байна гэж үзнэ.

20 дугаар зүйл

Бусад шаардлага

Барааны тэмдгийг барааны өөр тэмдгийн хамт ашиглах, эсхүл үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг нэг этгээдийн бараа буюу үйлчилгээг бусад этгээдийнхээс ялгах чадварт нь хохирол учруулах байдлаар буюу онцгой хэлбэрээр ашиглах зэрэг тусгай шаардлагаар барааны тэмдгийг худалдааны явцад ашиглахад үндэслэлгүй хязгаарлалт хийж болохгүй. Энэ нь хоорондоо холбоогүй бараа буюу үйлчилгээг хамт эрхэлдэг этгээдийг тодорхойлж буй барааны тэмдгийг тэр этгээдийн тодорхой бараа буюу үйлчилгээг ялгаж буй барааны тэмдгийг ашиглах шаардлагыг үгүйсгэхгүй.

21 дүгээр зүйл

Лиценз олгох, эрх шилжүүлэх

Гишүүд барааны тэмдгийн лиценз олгох, эрх шилжүүлэх нөхцлийг тодорхойлж болно, чингэхдээ үүнийг барааны тэмдгийн лицензийг албадан олгохыг зөвшөөрөхгүй бөгөөд бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч нь барааны тэмдгийн хамаарч буй аж ахуйн үйл ажиллагааг шилжүүлэх эсхүл шилжүүлэлгүйгээр эрхээ шилжүүлэх эрх эдлэнэ гэж ойлгоно.

3 дугаар анги: Газар зүйн заалт

22 дугаар зүйл

Газар зүйн заалтыг хамгаалах

1. Энэхүү хэлэлцээрийн зорилгод газар зүйн заалт нь барааг барааны чанар, нэр хүнд буюу онцлог бусад шинж чанар нь түүний газар зүйн гарал үүсэлтэй салшгүй холбоотой аль нэг гишүүний нутаг дэвсгэрт эсхүл тухайн нутаг дэвсгэрийн аль нэг бүс буюу газар нутагт үйлдвэрлэсэн болохыг илэрхийлсэн заалт болно.
2. Гишүүд газар зүйн заалтын хувьд сонирхогч талуудын ашиг сонирхлын үүднээс дараахь үйлдлээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээг авбал зохино:
 - (a) тухайн барааны газар зүйн гарлын талаар олон нийтийг төөрөгдөлд оруулах байдлаар тухайн барааг үйлдвэрлэсэн жинхэнэ газраас нь өөр газарт үйлдвэрлэсэн мэтээр үзүүлж буй аргыг барааны тодорхойлолт, танилцуулгад ашиглах;
 - (b) Парисын конвенц (1967)-ийн 10 bis зүйлийн утга агуулгын хүрээнд шударга бус өрсөлдөөний үйлдэл болгон ашиглах.
3. Тухайн барааг газар зүйн заалтад нь заасан нутаг дэвсгэрт үйлдвэрлээгүй талаар нутаг дэвсгэрийн газар зүйн заалтыг агуулж буй буюу тийм заалтаас бүрдэх барааны тэмдгийг хэрэв тэр гишүүн оронд тухайн барааны тэмдэгт тухайн

заалтыг хэрэглэх нь тухайн барааны гарлын жинхэнэ газрын талаар олон нийтийг төөрөгдөлд оруулах мөн чанар бүхий байвал гишүүн хууль тогтоомжид нь тийнхүү зөвшөөрсөн бол эсхүл сонирхогч талын хүсэлтээр уг барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах буюу бүртгэлийг нь хүчингүйд тооцож болно.

4. Барааг үйлдвэрлэсэн нутаг дэвсгэр, бүс, газар нутгийг зөв заасан хэдий ч өөр нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн гэх буруу ойлголт олон нийтэд өгч буй газар зүйн заалтын эсрэг (1), (2), (3) дахь хэсэгт заасан хамгаалалтыг хэрэглэнэ.

23 дугаар зүйл

Дарс, спиртийн бүтээгдэхүүний газар зүйн заалтад олгох нэмэлт хамгаалалт

1. Гишүүн тус бүр барааны жинхэнэ гарлыг заасан эсхүл газар зүйн заалтыг орчуулж хэрэглэсэн буюу “хэлбэр”, “төрөл”, “загвар”, “дууриамал” буюу тийм бусад хэллэг ашигласан хэдий ч дарсыг тухайн газар зүйн заалтад заасан газраас гаралтай биш дарс мэтээр тодорхойлсон эсхүл спиртийг тухайн газар зүйн заалтад заасан газраас гаралтай биш спирт мэтээр тодорхойлсон газар зүйн заалтыг хэрэглэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн боломжоор сонирхогч талуудыг хангана.
2. Дарсыг тодорхойлсон газар зүйн заалт агуулсан буюу тийм заалтаас бүрдсэн дарсны барааны тэмдэг эсхүл спиртийг тодорхойлсон газар зүйн заалт агуулсан буюу тийм заалтаас бүрдсэн барааны тэмдгийг бүртгэхээс тийм гарал үүсэлгүй дарс буюу спиртийн хувьд аль нэг гишүүний хууль тогтоомжоор зөвшөөрсөн, эсхүл сонирхогч талын хүсэлтээр татгалзаж буюу хүчингүй болгож болно.
3. Дарсны газар зүйн заалт нь ижил тохиолдолд газар зүйн заалт тус бүрт 22 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн заалтыг баримтлан хамгаалалт олгоно. Гишүүн тус бүр холбогдох үйлдвэрлэгчдэд тэгш шударга нөхцөл олгох, хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахгүй байх хэрэгцээг харгалзан ижил заалт болон хоорондоо ялгагдах бодит нөхцлийг тодорхойлно.
4. Дарсны газар зүйн заалтын хамгаалалтыг хөнгөвчлөн дэмжихийн тулд дарсны газар зүйн заалтын тухай мэдэгдэж, бүртгэх олон талт тогтолцоог уг тогтолцоонд оролцож буй гишүүн орнуудад хамгаалалтад хамрагдах дарсны газар зүйн заалтын хувьд байгуулах хэлэлцээг ОӨЭХХА-аархи зөвлөлийн хүрээнд хийнэ.

24 дүгээр зүйл

Олон улсын хэлэлцээ; Онцгой тохиолдол

1. Гишүүд 23 дугаар зүйлд заасны дагуу газар зүйн бие даасан тодорхой заалтыг хамгаалах зорилгоор хэлэлцээ хийхээр харилцан тохиролцож байна. Аль нэг гишүүн хэлэлцээ явуулах, хоёр болон олон талт хэлэлцээр байгуулахаас татгалзах зорилгоор доорхи (4)-(8) дахь хэсгийн заалтыг хэрэглэхгүй. Ийм хэлэлцээний хүрээнд гишүүд ашиглалт нь ийм хэлэлцээний сэдэв болсон бие даасан тодорхой газар зүйн заалтын хувьд эдгээр заалтыг байнга үргэлжлүүлэн хэрэглэх хүсэлтэй байна.

2. ООЭХХА-аархи зөвлөл энэ ангийн заалтын хэрэгжилтийг байнга хянан үзэж байна: эхний удаад ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор хянан үзнэ. Эдгээр заалтаар хүлээлгэсэн үүргийг биелүүлэхэд сөргөөр нөлөөлж буй аливаа асуудлыг зөвлөл анхааралдаа авах бөгөөд зөвлөл нь холбогдох гишүүд хоёр болон олон талт зөвлөлгөөний шугамаар хангалттай шийдвэрт хүрч чадаагүй асуудлын талаар аль нэг гишүүний хүсэлтээр аливаа бусад гишүүн буюу гишүүдтэй зөвлөлдөнө. Зөвлөл энэ ангийн үйлчлэлийг хөнгөвчлөн дэмжих, зорилгод нь хүргэх талаар тохиролцож болох арга хэмжээ авна.
3. Аль нэг гишүүн энэ ангийг хэрэгжүүлэхдээ ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнөхөн тухайн гишүүн оронд хэрэглэж байсан газар зүйн заалтын хамгаалалтыг бууруулахгүй.
4. Аль нэг гишүүний нутаг дэвсгэрт 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө (а) наад зах нь арван жил эсхүл (б) тэр өдрөөс өмнө сайн санааны үүднээс харьяат буюу байнга оршин суугчдын бараа буюу үйлчилгээний хувьд өөр гишүүний газар зүйн заалтаар дарс буюу спиртийг тодорхойлж байнга үргэлжлүүлэн ашиглаж ирсэн бол газар зүйн тухайн заалтыг цаашид үргэлжлүүлэн буюу төсөөтэй байдлаар ашиглахад саад болохыг энэ ангийн аль ч заалт уг гишүүнээс шаардахгүй.
5. Дараахь хугацаанаас өмнө барааны тэмдгийг бүртгүүлэхээр гаргасан мэдүүлэг түүний бүртгэл санамсаргүйгээр хийгдсэн буюу санамсаргүйгээр ашиглах замаар олж авсан тохиолдолд энэ ангийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ нь барааны тэмдгийн бүртгэл болон бүртгэл хүчин төгөлдөр байх, эсхүл барааны тэмдгийг ашиглах эрхийг ийм барааны тэмдэг нь газар зүйн заалттай ижил буюу төсөөтэй гэсэн үндэслэлээр хохирол учруулахгүй:
 - (а) тухайн гишүүн эдгээр заалтыг VI хэсэгт заасны дагуу хэрэглэж эхлэх өдөр;
 - (б) газар зүйн заалтыг гарлын оронд хамгаалж эхлэх өдөр.
6. Энэ ангийн аль ч заалт аливаа өөр гишүүний газар зүйн заалтын хувьд тухайн заалт нь газар зүйн заалтыг бараа, үйлчилгээний газар зүйн тухайн гишүүний нутаг дэвсгэрт тухайн бараа буюу үйлчилгээнд нийтлэг нэр гэж нийтээр хэлж заншсан нэр томъёотой ижил бол энэ ангийн заалтыг хэрэглэхийг уг гишүүнээс шаардахгүй. Энэ ангийн аль ч заалт аливаа өөр гишүүний дарсны бүтээгдэхүүний газар зүйн заалтын хувьд тухайн заалт нь ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн гишүүний нутаг дэвсгэрт байгаа усан үзмийн төрлийн заншсан нэртэй ижил бол заалтыг хэрэгжүүлэхийг шаардахгүй.
7. Хамгаалагдсан заалтыг буруу ашиглаж байгаа нь тухайн гишүүн оронд нийтэд илэрхий болсноос хойш эсхүл буруу ашиглаж байгаа нь тухайн гишүүн оронд нийтэд илэрхий болохоос өмнө барааны тэмдэг бүртгэгдсэн огноондоо хэвлэгдсэн бол барааны тэмдгийг бүртгэснээс хойш таван жилийн дотор эсвэл барааны тэмдгийг ашиглах буюу бүртгүүлэхтэй холбогдох хүсэлтийг энэ ангийн

дагуу гаргахаар аль нэг гишүүн тогтоож болно, чингэхдээ тухайн газар зүйн заалт санаатайгаар ашиглагдахгүй буюу бүртгэглэхгүй байвал зохино.

8. Аливаа этгээд худалдааны явцад нэрээ эсхүл тухайн бизнес дахь өмнөх хүнийхээ нэрийг хэрэглэх эрхийг олон нийтийг төөрөгдөлд оруулах байдлаар хэрэглэхээс бусад тохиолдолд энэ ангийн заалт ямар ч тохиолдолд хөндөхгүй.
9. Гарлын оронд нь хамгаалаагүй буюу хамгаалахаа больсон эсхүл ашиглахаа больсон газар зүйн заалтыг хамгаалах үүрэг энэхүү хэлэлцээрээр үүсэхгүй.

4 дүгээр анги: Бүтээгдэхүүний загвар

25 дугаар зүйл

Хамгаалалтад тавих шаардлага

1. Гишүүд бие дааж бүтээгдсэн бүтээгдэхүүний шинэ буюу өвөрмөц загварт хамгаалалт олгоно. Гишүүд тухайн үед илэрхий болсон загвар, загварын илэрхий болсон шинж чанарын нэгдлээс их хэмжээгээр ялгаагүй загварыг шинэ буюу өвөрмөц загвар биш гэж үзэж болно. Гишүүдийн хамгаалалтыг техникийн буюу гүйцэтгэх үүрэгтэй холбогдолтойгоор голлон үүссэн загварт хамгаалалтад олгохгүй байж болно.
2. Сүлжмэл эдлэлийн загварын хамгаалалтад тавих шаардлага, ялангуяа аливаа зардал, түүнчлэн шүүлт хийх эсхүл нийтлэхтэй холбогдсон шаардлага нь ийм хамгаалалтыг эрэлхийлэх болон олж авах боломжид үндэслэлгүйгээр хор уршиг учруулахгүй байх явдлыг гишүүн тус бүр хангана. Гишүүд энэ үүргээ бүтээгдэхүүний загварын тухай хууль эсхүл зохиогчийн эрхийн тухай хуулиар биелүүлэх нь чөлөөтэй байна.

26 дугаар зүйл

Хамгаалалт

1. Хамгаалагдсан бүтээгдэхүүний загварын эзэмшигч нь хамгаалагдсан загварын хуулбар буюу тодорхой хэмжээнд хуулбарласан загварыг агуулсан буюу илэрхийлсэн зүйлийг түүний зөвшөөрөлгүйгээр худалдааны зорилгоор гуравдагч талуудад үйлдвэрлэх, худалдах эсхүл импортлохыг хориглох эрхтэй.
2. Гишүүд гуравдагч талын хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан бүтээгдэхүүний загварын хамгаалалтад онцгой тохиолдол хязгаартайгаар тогтоож болох бөгөөд чингэхдээ ийм онцгой тохиолдол нь хамгаалагдсан бүтээгдэхүүний загварыг хэвийн ашиглалтад үндэслэлгүйгээр зөрчилдөх буюу хамгаалагдсан загварын эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хөндөж болохгүй.
3. Хамгаалах хугацаа нь наад зах нь 10 жил байна.

5 дугаар анги: Патент

27 дугаар зүйл

Патент олгох зүйлс

1. (2), (3) дахь хэсэгт заасныг дагаж мөрдөхийн хамт патентыг технологийн бүх салбар дахь шинэ бөгөөд шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой бүтээгдэхүүн буюу арга ажиллагаа болох аливаа шинэ бүтээлд олгоно. 65 дугаар зүйлийн (4) дэх хэсэг, 70 дугаар зүйлийн (8) дахь хэсэг, энэ зүйлийн (3) дахь хэсэгт заасныг дагаж мөрдөхийн хамт бүтээсэн газар, технологийн салбар, мөн бүтээгдэхүүнийг импортлосон буюу дотоодод үйлдвэрлэснээр үл ялгаварлан патент олгож, патентын эрх эдлүүлнэ.
2. Гишүүд үндэсний хуулиар ашиглахыг хориглосон гэдэгт үндэслэлгүйгээр шинэ бүтээлийг нутаг дэвсгэрт нь худалдааны журмаар ашиглахыг хүн, амьтан, ургамал буюу эрүүл мэндийг хамгаалах эсхүл байгаль орчинд ноцтой хохирол учруулахаас сэргийлэх зэргээр *ordre public* буюу ёс суртахууныг хамгаалахад шаардлагатай шинэ бүтээлийг патент олгох зүйлээс хасч болно.
3. Гишүүд мөн дараахь зүйлсийг патент олгохоос хасч болно:
 - (a) хүн болон амьтныг эмчлэх оношлогоо, эмчилгээ, мэс заслын арга;
 - (b) бичил биетнээс бусад ургамал болон амьтан, мөн ургамал, амьтнаас гаргаж авах биологийн бус болон бичил биологийн аргаас бусад биологийн арга. Гэхдээ гишүүд ургамлын төрөл зүйлийг патентаар буюу *sui generis* тогтолцоогоор эсхүл тэдгээрийн хослолоор хамгаална. Энэ дэд хэсгийн заалтыг ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш дөрвөн жилийн дараа хянан үзнэ.

28 дугаар зүйл

Олгосон эрх

1. Патент нь түүний эзэмшигчид дараахь онцгой эрх олгоно:
 - (a) хэрэв патентыг бүтээгдэхүүнд олгосон бол түүний зөвшөөрөлгүйгээр уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ашиглах, худалдах санал тавих, худалдах, эсхүл дээрх зорилгоор импортлохыг гуравдагч этгээдэд хориглох,
 - (b) хэрэв патентыг үйл ажиллагаанд олгох бол түүнийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр уг арга ажиллагааг ашиглах, мөн уг арга ажиллагаагаар шууд гарган авсан бүтээгдэхүүнийг ашиглах, худалдах санал тавих, худалдах, эсхүл эдгээр зорилгоор импортлохыг гуравдагч этгээдэд хориглох.
2. Патент эзэмшигч нь мөн патентаа шилжүүлэх, өв залгамжлан үлдээх, түүнчлэн лицензийн гэрээ байгуулах эрхтэй.

29 дүгээр зүйл

Патентын мэдүүлэг гаргагчид тавих нөхцөл

1. Гишүүд шинэ бүтээлээ тухайн салбарын мэргэжилтэн ашиглаж болохуйцаар хангалттай ойлгомжтой, бүрэн байдлаар илэрхийлэхийг патентын мэдүүлэг гаргагчаас шаардах бөгөөд мэдүүлэг гаргах өдөр эсхүл давамгайлах огноо шаардсан бол мэдүүлгийн давамгайлах огнооны өдөр өөрт нь мэдэгдэж байгаа шинэ бүтээлийг ашиглах хамгийн сайн аргыг заахыг мэдүүлэг гаргагчаас шаардаж болно.
2. Гишүүд гадаадад мэдүүлэг гаргасан болон патент авсан эсэх талаарх мэдээлэл гаргаж өгөхийг патентын мэдүүлэг гаргагчаас шаардаж болно.

30 дугаар зүйл

Олгосон эрхэд тогтоох онцгой тохиолдол

Гишүүд патентаар олгосон онцгой эрхэд хязгаар тогтоож болох бөгөөд чингэхдээ гуравдагч талуудын хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан патентыг хэвийн ашиглахтай үндэслэлгүйгээр зөрчилдөх буюу патент эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхолд үндэслэлгүйгээр хохирол учруулахааргүй нөхцөлтэй байна.

31 дүгээр зүйл

Эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах бусад хэлбэр

Патент олгосон зүйлийг засгийн газар эсхүл засгийн газрын эрх олгосон гуравдагч тал ашиглах зэргээр эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэлбэрээр ашиглахыг аль нэг гишүүний хуулиар зөвшөөрсөн тохиолдолд дараахь заалтыг баримтална:

- (a) ийнхүү ашиглах зөвшөөрөл нь тухайн зүйлийн бие даасан тодорхой шинж байдалд үндэслэнэ,
- (b) ашиглах этгээд ашиглахаасаа өмнө худалдааны үндэслэлтэй нөхцөл, болзлоор эрх эзэмшигчээс зөвшөөрөл авахыг оролдсон бөгөөд уг оролдлого нь боломжит хугацааны дотор амжилт олоогүй тохиолдолд ийнхүү ашиглахыг зөвшөөрнө. Үндэсний онцгой байдал буюу бусад онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд эсхүл ашгийн бус зорилгоор засгийн газар ашиглах тохиолдолд аль нэг гишүүн энэ шаардлагаас татгалзаж болно. Гэхдээ үндэсний онцгой байдал буюу бусад онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд эрх эзэмшигчид аль болох боломжит хугацаанд яаралтай мэдэгдэнэ. Ашгийн бус зорилгоор засгийн газар ашиглах тохиолдолд засгийн газар буюу гэрээлэгч нь хүчин төгөлдөр патентыг засгийн газар өөрөө буюу засгийн газрын төлөө ашиглаж байгаа буюу ашиглах гэж байгааг патентын хайлт хийлгүйгээр мэдэж байгаа эсхүл мэдэх илэрхий үндэслэл байвал эрх эзэмшигчид нэн даруй мэдэгдэнэ;

- (c) ийнхүү ашиглах хүрээ, хугацааг зөвшөөрсөн зорилгоор хязгаарлах бөгөөд хагас дамжуулагчийн технологийн тохиолдолд зөвхөн ашгийн бус зорилгоор засгийн газар ашиглахад эсхүл шүүхийн буюу захиргааны журам хэрглэсний дараа өрсөлдөөний эсрэг хязгаарласан үйл ажиллагааг залруулж болно;
- (d) энэ хэрэглээ нь онцгой бус байна;
- (e) үйлдвэрийн газрын буюу ажил хэргийн нэр төрийн ийнхүү ашиглаж буй хэсэгтэй хамт шилжүүлэхээс бусад тохиолдолд ашиглалтыг шилжүүлж болохгүй;
- (f) ийнхүү ашиглах зөвшөөрөл олгосон гишүүний дотоодын зах зээлийн хэрэгцээг юуны өмнө хангахаар ийнхүү ашиглахыг зөвшөөрнө;
- (g) ийнхүү ашиглах зөвшөөрөл олгоход хүргэсэн нөхцөл байдал үгүй болж, дахин үүсэх үндэслэл багатай болсон бол ашиглах зөвшөөрлийг цуцлах бөгөөд чингэхдээ зөвшөөрөл авсан этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг зохих ёсоор хамгаална. Хэрэв тухайн нөхцөл байдалүргэлжилсээр байвал эрх бүхий байгууллага үндэслэл бүхий хүсэлтийн дагуу нөхцөл байдлыг хянан үзэх эрхтэй;
- (h) тохиолдол тус бүрийн нөхцөл байдалд тухайн зөвшөөрлийн эдийн засгийн үнэ цэнийг харгалзан эрх эзэмшигчид зохих урамшуулал олгоно;
- (i) ийнхүү ашиглах зөвшөөрөл олгоход хамаарах аливаа шийдвэр эрх зүйн хувьд хүчин төгөлдөр эсэхийг тухайн гишүүн улсын шүүх эсхүл дээд шатны эрх бүхий байгууллага бие даан хянаж үзнэ;
- (j) ийнхүү ашиглахтай холбогдуулан олгох урамшуулалд хамаарах аливаа шийдвэрийг тухайн гишүүн улсын шүүх эсхүл дээд шатны эрх бүхий байгууллага бие даан хянаж үзнэ;
- (k) хэрэв шүүх, захиргааны журмаар өрсөлдөөний эсрэг гэж тогтоосон үйл ажиллагааг залруулахаар ийнхүү ашиглах зөвшөөрөл олгосон бол гишүүд (b) болон (f) дэд хэсэгт заасан нөхцлийг хэрэглэх үүрэггүй. Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг залруулах хэрэгцээг эдгээр тохиолдолд урамшууллын хэмжээг тогтоохдоо харгалзан үзнэ. Хэрэв зөвшөөрөл олгоход хүргэсэн нөхцөл байдал дахин үүсвэл эрх бүхий байгууллага зөвшөөрөл дууссаныг хүчингүй болгох эрхтэй байна;
- (l) хэрэв ийнхүү ашиглахыг зөвшөөрсөн нь өөр патент (нэгдүгээр патент)-ыг зөрчихгүйгээр ашиглах боломжгүй патент (хоёрдугаар патент)-ыг ашиглахыг зөвшөөрч байвал дараахь нэмэлт нөхцлийг хэрэглэнэ:

- (i) хоёрдугаар патент бүхий шинэ бүтээл нь нэгдүгээр патент бүхий шинэ бүтээлтэй харьцуулахад эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой технологийн ололтыг агуулсан байна;
- (ii) нэгдүгээр патентын эзэмшигч нь хоёрдугаар патент бүхий шинэ бүтээлийг ашиглах боломжит нөхцлөөр давхар лиценз авах эрхтэй байна;
- (iii) хоёрдугаар патенттай хамт шилжүүлэхээс бусад тохиолдолд нэгдүгээр патентын зөвшөөрсөн ашиглалтыг шилжүүлэхгүй.

32 дугаар зүйл

Патентыг хүчингүй болгох

Патентыг хүчингүй болгох буюу эрхийг цуцлах аливаа шийдвэрийг шүүхийн журмаар хянан үзэх боломж байх ёстой.

33 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

Хамгаалах хугацаа нь мэдүүлэг өгсөн огнооноос хойш хорин жил хүртэл хүчинтэй байна.

34 дүгээр зүйл

Үйл ажиллагааны патент: нотлох үүрэг

1. 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан патент эзэмшигчийн эрх хөндөгдсөн талаарх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод патент олгосон зүйл нь бүтээгдэхүүн гаргаж авах үйл ажиллагаа бол шүүхийн эрх бүхий байгууллага ижил бүтээгдэхүүн гарган авах тухайн үйл ажиллагаа нь патент бүхий үйл ажиллагаанаас ялгаатайг нотлохыг хариуцагчаас шаардах эрхтэй. Иймд гишүүд патент эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн аливаа ижил бүтээгдэхүүнийг үзэхээр патент бүхий үйл ажиллагаагаар гарган авсан гэсэн эсрэг нотолгоо үгүй тохиолдолд дараахь нөхцлийн нэгийг тогтооно:
 - (a) патент бүхий үйл ажиллагаагаар гарган авсан бүтээгдэхүүн нь шинэ бол;
 - (b) ижил бүтээгдэхүүнийг тухайн үйл ажиллагаагаар гарган авсан гэх үндэслэлтэй магадлал байгаа бөгөөд патент эзэмшигч чухам ямар үйл ажиллагаа ашигласнаа боломжит оролдлого хийсний эцэст тодорхойлж чадаагүй бол.
2. Гишүүд (1) дэх хэсэгт заасан нотлох үүргийг зөвхөн (a) дэд хэсэгт заасан эсхүл зөвхөн (b) дэд хэсэгт заасан нөхцлийг хангасан бол эрх зөрчигч гэх этгээдэд хүлээлгэхээр заахад чөлөөтэй байна.

3. Эсрэг нотолгоо гаргахад хариуцагчын үйлдвэрлэл, бизнесийн нууцаа хамгаалах хууль ёсны ашиг сонирхлыг харгалзана.

**6 дугаар анги: Бичил бүдүүвчийн
байршлын загвар (топограф)**

35 дугаар зүйл

**Бичил бүдүүвчид холбогдох
оюуны өмчийн тухай гэрээнд хамаарах нь**

Гишүүд интеграл ороомгийн байршлын загвар (топограф)-ыг (энэхүү хэлэлцээрт цаашид “загвар“ гэнэ)-ыг Интеграл ороомгийн талаарх оюуны өмчийн тухай гэрээний 2-7 дугаар зүйл (6 дугаар зүйлийн (3) дахь хэсгээс бусад), 12 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн дагуу хамгаалахаар заах, мөн дараахь заалтыг мөрдөхөөр харилцан тохиролцов.

36 дугаар зүйл

Хамгаалах хүрээ

Гишүүд 37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дагаж мөрдөхийн хамт эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хийсэн дараахь үйлдлийг хууль бус гэж үзнэ. Үүнд: хамгаалагдсан байршлын загвар, байршил загвар бүхий бичил бүдүүвч, эсхүл бичил бүдүүвч зөвхөн хууль бусаар хуулбарласан байршлын загварыг үргэлжлүүлэн агуулж буй худалдааны зорилгоор импортлох, худалдах, өөрөөр хуваарилах орно.

37 дугаар зүйл

Эрх эзэмшигчийн зөвшөөрөл үл шаардах үйлдлүүд

1. 36 дугаар зүйлийг үл харгалзан энэ зүйлд заасан үйлдэл хийсэн эсхүл хийхийг шаардсан этгээд бичил бүдүүвч эсхүл бичил бүдүүвч бүхий зүйлийг олж авахдаа хууль бусаар хуулбарласан байршлын загвар агуулсан гэдгийг нь мэдээгүй буюу мэдэх үндэслэл байгаагүй бол хууль бусаар хуулбарласан байршлын загвар агуулсан бичил бүдүүвч буюу бичил бүдүүвч тийм ороомог агуулсан зүйлийн хувьд гишүүд уг үйлдлийг нь хууль бус гэж үзэхгүй. Уг этгээд байршлын загварыг хууль бусаар хуулбарласан талаар хангалттай мэдээлэл авсныхаа дараа өөрт нь байгаа буюу урьд нь захиалсан зүйлийн хувьд ямарваа үйлдэл хийж болох боловч байршлын уг загварыг чөлөөтэй хэлэлцэн тохиролцсон лицензийн дагуу төлөх төлбөртэй тэнцэх хэмжээний мөнгийг эрх эзэмшигчид төлөх үүрэгтэй гэж гишүүд заана.
2. Байршлын загварт албадан лиценз олгох эсхүл түүнийг засгийн газар буюу засгийн газрын төлөө эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдолд 31 дүгээр зүйлийн (а)-(к) дэд хэсэгт заасан нөхцлийг хэрэглэнэ.

38 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

1. Хамгаалалт олгохын тулд бүртгүүлсэн байх шаардлага тавьдаг гишүүдэд байршлын загварыг хамгаалах хугацаа нь бүртгүүлэх мэдүүлэг өгснөөс хойш эсхүл дэлхийд анх худалдааны журмаар анх ашигласнаас хойш 10-аас багагүй байна.
2. Хамгаалалтад олгохын тулд бүртгүүлсэн байх шаардлага тавьдаггүй гишүүдэд байршлын загварыг хамгаалах хугацаа нь дэлхийн хаа нэгтээ худалдааны журмаар анх ашигласнаас хойш арван багагүй жил байна.
3. (1)-(2) дахь хэсгийг үл харгалзан байршлын загварыг бүтээснээс хойш арван таван жил өнгөрөхөд хамгаалалт дуусгавар болохоор аль нэг гишүүн зааж болно.

7 дугаар анги: Хаалттай мэдээллийг хамгаалах

39 дүгээр зүйл

1. Гишүүд Парисын конвенц (1967)-ийн 10 bis зүйлд заасны дагуу шударга бус өрсөлдөөний эсрэг үр дүнтэй хамгаалалт олгохдоо (2) дахь хэсэгт заасны дагуу хаалттай мэдээллийг болон (3) дахь хэсэгт заасны дагуу засгийн газар буюу засгийн газрын байгууллагад өгсөн мэдээллийг хамгаална.
2. Хяналтад хууль ёсоор байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр худалдааны шударга дадалд харш хэлбэрээр бусад этгээдэд задлах, бусад этгээд олж авах буюу ашиглахыг урьдчилан сэргийлэх боломжийг хувь хүн болон хуулийн этгээдэд олгох бөгөөд чингэхдээ уг мэдээлэл нь дараахь шаардлагыг хангасан байна:
 - (a) биет байдлаараа эсхүл бүрдэл хэсгийн тодорхой зохион байгуулалт буюу нийлбэрийнхээ хувьд ийм мэдээлэлтэй харьцдаг хүрээний хүмүүст уг мэдээллийг хүртэх боломжгүй бөгөөд энэ утгаараа нууц;
 - (b) нууц учир худаалдааны үнэ цэнэтэй ба;
 - (c) уг мэдээллийг хууль ёсоор хянаж буй этгээд нууц хадгалах үүднээс тухайн нөхцөл байдалд зохих арга хэмжээ авсан байна.
3. Химийн шинэ нэгдлийг ашигласан эм, хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүний зах зээлийг дэмжих нөхцөл болгож хаалттай туршилтын мэдээлэл буюу бэрхшээлтэй олдох бусад мэдээлэл өгөх үзүүлэхийг шаардахдаа гишүүд уг мэдээллийг худалдааны зорилгоор шударга бусаар ашиглахаас хамгаална. Мөн олон нийтийг хамгаалах шаардлагатай эсхүл уг мэдээллийг худалдааны зорилгоор шударга бусаар ашиглахаас хамгаалах талаар арга хэмжээ аваагүй бол гишүүд уг мэдээллийг задруулахаас хамгаална.

**8 дугаар анги: Гэрээт лицензийн
өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хянах**

40 дүгээр зүйл

1. Өрсөлдөөнийг хязгаарлаж буй лицензийн зарим дадал буюу оюуны өмчийн эрхэд хамаарах нөхцөл нь худалдаанд сөргөөр нөлөөлж, технологийг дамжуулж, дэлгэрүүлэхэд саад болж болно гэдгийг гишүүд хүлээн зөвшөөрч байна.
2. Зарим тодорхой тохиолдолд холбогдох зах зээл дээрх өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж оюуны өмчийн эрхийг хортойгоор ашиглаж буй лицензийн үйл ажиллагаа буюу нөхцлийг хууль тогтоомждоо заахад нь энэхүү хэлэлцээрийн аль ч заалт гишүүдэд саад болохгүй. Дээр дурдсанчлан гишүүд онцгой баталгааг буцаах нөхцөл, хүчин төгөлдөр болох талаар маргахыг урьдчилан сэргийлэх нөхцөл, багц лицензийг албадан олгох зэрэг үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх буюу хянах талаар зохистой арга хэмжээг тухайн гишүүний хууль, журмын хүрээнд энэхүү хэлэлцээрийн бусад заалтын дагуу авч болно.
3. Гишүүний харьяат буюу байнга оршин суугч болох оюуны өмчийн эрх эзэмшигч энэ ангиар зохицуулсан зүйлийн талаарх хууль, журмыг нь зөрчсөн үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үндэслэл байгаа бөгөөд хуулийн дагуу авах арга хэмжээнд болон аль нэг гишүүний эцсийн шийдвэр гаргах бүрэн эрх чөлөөг хөндөхгүйгээр хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэхийг хүсч байгаа аливаа гишүүнтэй хүсэлтээр нь гишүүн тус бүр зөвлөлдөнө. Хүсэлт хүлээн авсан гишүүн хүсэлт тавьсан гишүүнтэй зөвлөлдөхдөө бүрэн ойлгох үүднээс хандаж зохих боломж олгох бөгөөд тухайн асуудлаар олон нийтийн хүртээл болсон нууц биш мэдээлэл болон өөрт байгаа бусад мэдээллийг дотоодын хуулийн дагуу болон хүсэлт тавьсан гишүүн нууц хамгаалах асуудлаар байгуулсан хэлэлцээрийн дагуу өгөх замаар хамтран ажиллана.
4. Харьяат буюу байнга оршин суугч нь энэ ангиар зохицуулсан зүйлийн талаарх хууль, журмыг өөр нэг гишүүний нутаг дэвсгэрт зөрчсөн гэж нөгөө гишүүний нутаг дэвсгэрт хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа аль нэг гишүүнд хүсэлт тавьсан бол нөгөө гишүүнтэй (3) дахь хэсэгт заасан нөхцөлтэй адил нөхцлөөр зөвлөлдөх боломж олгоно.

**III ХЭСЭГ
ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

1 дүгээр анги: Нийтлэг үүрэг

41 дүгээр зүйл

1. Гишүүд энэ хэсэгт заасан оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх журмыг хууль тогтоомждоо тусгахдаа зөрчлийг урьдчилан сэргийлэх шуурхай арга хэмжээ болон цаашид зөрчил гаргахгүй байх талаар арга хэмжээ авах зэргээр энэхүү хэлэлцээрт хамрагдсан оюуны өмчийн эрхийг зөрчих аливаа үйлдлийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах боломжоор хангана. Эдгээр журмыг нь хууль ёсны худалдаанд саад үүсгэхээс зайлсхийх, тэдгээрийг урвуулан ашиглахаас хамгаалах байдлаар хэрэглэнэ.
2. Оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх журам нь шударга, тэгш байна. Уг журам

нь төвөгтэй, өндөр өртөгтэй байх ёсгүй бөгөөд хугацаа нь үндэслэлгүй хязгаар тогтоосон буюу зүй бус саад байх ёсгүй.

3. Аливаа хэргийн хувьд тухайн асуудлаар гаргасан шийдвэр бичгээр, үндэслэлтэй байна. Шийдвэрийг наад зах нь хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудад ямар нэгэн сааталгүйгээр хүргэнэ. Үндсэн асуудлаар гаргасан шийдвэр нь талуудад саналаа илэрхийлэх боломж олгосон нотлох баримтанд зөвхөн үндэслэнэ.
4. Захиргааны эцсийн шийдвэр, түүнчлэн хэргийн ач холбогдлын талаар гишүүний хуулийн харьяаллын талаарх заалтыг дагаж мөрдөхийн хамт хэргийн талаар шүүхийн эрх бүий байгууллагаар хянуулах боломжийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудад олгоно. Гэхдээ эрүүгийн хэргийн цагаадах шийдвэрийг хянах боломжийг олгох үүрэг хүлээхгүй.
5. Энэ хэсэг нь хууль хэрэгжүүлэх ерөнхий тогтолцооноос өөр оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх шүүхийн тогтолцоогоо өөрчлөх ямарваа үүрэг үүсгэхгүй, мөн гишүүдийн ерөнхий хуулиа хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй гэж ойлгоно. Энэ хэсгийн аль ч заалт оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх болон ерөнхий хуулийг хэрэгжүүлэхийн хооронд нөхцөл байдлыг хуваарилахтай холбогдуулан ямарваа үүрэг үүсгэхгүй.

**2 дугаар анги: Иргэний болон захиргааны журмаар
хянан хэлэлцэх ажиллагаа болон
хамгаалалтын арга хэмжээ**

42 дугаар зүйл

Шударга, эрх тэгш хэлэлцэх ажиллагаа

Гишүүд энэхүү хэлэлцээрт хамрагдсан оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх асуудлаар иргэний шүүхийн хянан хэлэлцэх ажиллагааг хэрэглэх боломжийг эрх эзэмшигчдэд олгоно. Хариуцагч нь нэхэмжлэлийн үндэслэл зэргийг тусгасан хангалттай дэлгэрэнгүй мэдэгдлийг цаг тухайд нь бичгээр авах эрхтэй. Талууд бие даасан хуулийн зөвлөхөөр төлөөлүүлэхийг зөвшөөрөх бөгөөд бөгөөд уг журмаар хэргийг хэлэлцэхэд заавал биечлэн байх талаар хэт хатуу шаардлага тавьж болохгүй. Уг ажиллагаанд оролцогч бүх талууд нэхэмжлэлдээ үндэслэл заах, холбогдох бүх нотлох баримт гаргах эрхийг зүй ёсоор эдлэнэ. Уг журмаар хууль тогтоомжийн шардлагад нь харшлахгүй бол нууц мэдээллийг тогтоох, хамгаалах арга хэрэгслийг хангана.

43 дугаар зүйл

Нотлох баримт

1. Хэрэв аль нэг тал нэхэмжлэлээ үндэслэх хангалттай боломжит нотлох баримт гаргасан бөгөөд нэхэмжлэлээ үндэслэхтэй холбогдох нотлох баримт эсрэг талын хяналтад байгааг заасан бол шүүхийн эрх бүхий байгууллага уг нотлох баримтыг эсрэг талаас шаардах захирамжийг зохистой тохиолдолд нууц мэдээллийг хамгаалах явдлыг хангах нөхцлийн дагуу гаргах эрхтэй.

2. Хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч аль нэг тал шаардлагатай мэдээллийг авах боломж олгох буюу өөрөөр өгөхөөс өөрийн дураар үндэслэлгүйгээр татгалзсан эсхүл боломжит хугацаанд эрхийг хэрэгжүүлэх журамд их хэмжээгээр саад учруулж байгаа бол аль нэг гишүүн мэдээлэл авах боломж олгохоос татгалзсан явдал сөргөөр нөлөөлсөн талын гаргасан гомдол буюу өргөдөл зэрэг мэдээлэл өгсний үндсэн дээр баталсан буюу үгүйсгэсэн урьдчилсан болон эцсийн шийдвэр гаргах эрхийг шүүхийн эрх бүхий байгууллагад өгч болох бөгөөд чингэхдээ буруутгал буюу нотлох баримтын талаар талуудад саналаа илэрхийлэх боломж олгоно.

44 дүгээр зүйл

Шүүхийн хориг

1. Шүүхийн эрх бүхий байгууллага нь эрх зөрчихийг зогсоохыг, *inter alia* оюуны өмчийн эрхийг зөрчсөн импортын барааны харьяаллын худалдааны зах зээлд гаргахыг гаалийн үзлэгээр орсны дараа нэн даруй зогсоохыг аль нэг талаас шаардсан тогтоол гаргах эрхтэй. Хамгаалалтад байгаа зүйлийг ашиглах нь оюуны өмчийн эрхийг зөрчсөн хэрэг болно гэдгийг аль нэг этгээд мэдэх буюу мэдэх бололцоотой болохоос өмнө худалдаж авсан буюу захиалсан зүйлийн талаар гишүүд ийм эрх мэдэл олгох үүрэггүй.
2. Гишүүд энэ хэсгийн бусад заалтыг үл харгалзан, мөн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр засгийн газар эсхүл засгийн газрын эрх олгосон гуравдагч тал эрх ашиглах асуудлыг тусгайлан зохицуулсан II хэсгийн заалтыг биелүүлсэн нөхцөлд ийнхүү ашиглахын эсрэг хэрэглэж болох эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг 31 дүгээр зүйлийн (h) дэд хэсэгт заасны дагуу урамшуулал олгохоор хязгаарлаж болно. Бусад тохиолдолд энэ хэсэгт заасан эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэглэнэ эсхүл хэрэв тийм арга хэмжээ нь аль нэг гишүүний хуульд нийцэхгүй байгаа бол шүүхийн шийдвэрт тайлбар хийх болон зохистой нөхөн төлбөр олгоно.

45 дугаар зүйл

Хохирол

1. Оюуны өмчийн эрх зөрчиж буйгаа мэдсээр байгаад буюу мэдэх боломжтой байсаар атал эрх зөрчсөн үйл ажиллагаа явуулсны улмаас эрх эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний мөнгийг эрх зөрчигчөөс гаргуулах тогтоолыг шүүхийн эрх бүхий байгууллага гаргах эрхтэй.
2. Мөн өмгөөлөгчийн хөлс зэрэг зардлыг эрх эзэмшигчид төлөхийг эрх зөрчигчөөс шаардсан тогтоолыг шүүх гаргах эрхтэй. Эрх зөрчиж буйгаа мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан тохиолдолд ч орлогын алдагдал буюу урьдчилан тогтоосон хохирлыг нөхөн төлөхийг шаардсан тогтоол гаргах эрхийг гишүүд зохистой нөхцөлд шүүхэд олгож болно.

46 дугаар зүйл

Хуулийн бусад арга хэмжээ

Эрхийн зөрчил гаргахгүй байх үр дүнтэй хуулийн арга хэмжээ авахын тулд шүүхийн эрх бүхий байгууллага нь эрх зөрчиж буй гэж тогтоосон барааг эрх эзэмшигчид хохирол учруулахаас зайлсхийх байдлаар гадуур ямарваа төрлийн нөхөн төлбөр олгохгүйгээр худалдахыг хориглох эсхүл тухайн үед үйлчилж байгаа үндсэн хуулийн шаардлагад харш биш бол устгах тогтоол гаргах эрхтэй. Шүүхийн эрх бүхий байгууллага нь эрх зөрчсөн барааг бий болгоход голлон ашигласан материал, хэрэгслийг ямарваа төрлийн нөхөн төлбөр олгохгүйгээр худалдааны хүрээнээс цаашид зөрчил гарах эрсдлийг аль болох багасгах үүднээс тогтоол гаргах эрхтэй. Ийм хүсэлтийг авч хэлэлцэхдээ эрх зөрчлийн хүнд хөнгөн байдал болон шүүхийн хамгаалалтын арга хэмжээ хоорондоо тохирсон байх хэрэгцээ, мөн гуравдагч талуудын ашиг сонирхлыг харгалзана. Барааны тэмдгийг үйлдсэн барааны хувьд хууль бусаар хэрэглэсэн барааны тэмдгийг устгах нь уг барааг худалдаанд гаргахыг зөвшөөрөх онцгой тохиолдлоос бусад тохиолдолд хангалтгүй.

47 дугаар зүйл

Мэдээлэл авах эрх

Шүүхийн эрх бүхий байгууллага эрх зөрчсөн бараа буюу үйлчилгээг хуваарилахад оролцсон гуравдагч этгээдүүд болон хуваарилсан хүрээний талаар эрх эзэмшигчид мэдээлэхийг эрх зөрчигчөөс шаардсан тогтоолыг энэ зөрчлийн хүнд хөнгөн байдалд нийцүүлэн гаргах эрхтэй гэж гишүүд зааж болно.

48 дугаар зүйл

Хариуцагчийн хохиролгүй болгох

1. Хүсэлтийнх нь дагуу арга хэмжээ авсан бөгөөд оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх журмыг буруугаар ашигласны улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөхөд зохих хэмжээний нөхөн төлбөрийг төлөхийг шаардсан тогтоолыг шүүхийн эрх бүхий байгууллага гаргах эрхтэй. Шүүхийн эрх бүхий байгууллага өмгөөлөгчийн хөлс зэрэг зардлыг хариуцагчид төлөхийг хүсэлт гаргагчаас шаардсан тогтоол гаргах эрхтэй.
2. Гишүүд оюуны өмчийн эрхийг хамгаалах буюу хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа хуулийг биелүүлэх явцад төрийн байгууллага, төрийн албан хаагчдыг шүүхийн хамгаалалтын зохистой арга хэмжээ авах хариуцлагаас энэ арга хэмжээг сайн дураар авсан тохиолдолд чөлөөлнө.

49 дүгээр зүйл

Захиргааны журам

Хэргийн үндсэн асуудлаар захиргааны журмаар хянан хэлэлцэх ажиллагаа нь иргэний эрх зүйн хамгаалалтын аливаа арга хэмжээ шаардагдаж болох ба энэ ангид заасан зарчимд нийцсэн байна

3 дугаар анги: Түр арга хэмжээ

50 дугаар зүйл

1. Шүүх дараахь зорилгоор зохистой бөгөөд үр дүнтэй түр арга хэмжээ авах асуудлаар тогтоол гаргах эрхтэй:
 - (a) оюуны өмчийн эрхийг зөрчил үүсгэхээс урьдчилан сэргийлэх, ялангуяа гаалийн үзлэгийн дараа импортын бараа болон бусад барааг өөрийн хууль тогтоомжид захирагдах худалдаанд орохоос нэн даруй урьдчилан сэргийлэх,
 - (b) илэрсэн зөрчлийн хувьд нотлох баримтыг хадгалах.
2. Зохистой нөхцөлд, ялангуяа асуудлыг хойшлуулах нь эрх эзэмшигчид нөхөшгүй хохирол учруулахаар байвал, эсхүл нотлох баримт устгагдах илэрхий эрсдэл байвал шүүхийн эрх бүхий байгууллага *inaudita altera parte* эсрэг талын тайлбарыг авалгүйгээр түр арга хэмжээ авах эрхтэй.
3. Хүсэлт гаргагч нь эрх эзэмшигч мөн бөгөөд түүний эрх зөрчигдсөн буюу зөрчигдөх магадлалтай талаар хангалттай баталгаат хэмжээгээр нотлох баримт гаргахыг шаардах, түүнчлэн хариуцагчийг хамгаалах болон эрх хэтрүүлэхээс урьдчилан сэргийлэхэд хангалттай баталгаа буюу дэнчин тавихыг хүсэлт гаргагчаас шаардах шийдвэр шүүхийн эрх бүхий байгууллага гаргах эрхтэй.
4. Түр арга хэмжээг *inaudita altera parte* эсрэг талын тайлбар авалгүйгээр авсан бол энэ тухай холбогдох талуудад цаад зах нь арга хэмжээ авмагц ямарваа сааталгүйгээр мэдэгдэнэ. Эдгээр арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эсхүл хэвээр үлдээх асуудлыг уг арга хэмжээний талаар мэдэгдсэнээс хойш боломжит хугацааны дотор шийдвэрлэх үүднээс хариуцагчийн хүсэлтээр асуудлыг хянаж үзэж, хариуцагчийн тайлбарыг сонсоно.
5. Түр арга хэмжээг гүйцэтгэх байгууллага тухайн барааг тодорхойлоход шаардлагатай бусад мэдээлэл өгөхийг хүсэлт гаргагчаас шаардаж болно.
6. (4) дэх хэсгийг хөндөхгүйгээр, хэрэв хэргийн үндсэн асуудлаар шийдвэр гаргахад хүргэж буй ажиллагааг Гишүүний хуулиар зөвшөөрсөн нөхцөлд уг арга хэмжээг авах тогтоол гаргасан шүүхийн байгууллагаас тодорхойлсон хугацаанд эсхүл ийм хугацаа тодорхойлоггүй бол бол ажлын 20 өдөр буюу хуанлийн гучин нэг өдрөөс хэтрэхгүй хугацаанд эхлүүлээгүй бол (1), (2) дахь хэсгийн үндсэн дээр авсан түр арга хэмжээг хариуцагчийн хүсэлтээр цуцлах буюу түдгэлзүүлэх арга хэмжээг авна.
7. Түр арга хэмжээг цуцалсан эсхүл эдгээр нь хүсэлт гаргагчийн аливаа үйлдэл буюу эс үйлдлийн улмаас дуусгавар болсон эсхүл оюуны өмчийн эрх зөрчөөгүй буюу зөрчих аюул байхгүй нь тогтоогдсон нөхцөлд шүүхийн эрх бүхий байгууллага эдгээр арга хэмжээний улмаас учирсан хохирлыг хариуцагчид зохистойгоор нөхөн төлөхийг хүсэлт гаргагчаас шаардсан шийдвэрийг хариуцагчийн хүсэлтээр гаргах эрхтэй.
8. Аливаа түр арга хэмжээг захиргааны хянан хэлэлцэх ажиллагаагаар тогтоосон бөгөөд эдгээр арга хэмжээ нь энэ ангид заасан зарчимд нийцсэн байна.

**4 дүгээр анги: Хил дээр авах арга хэмжээнд
хамаарах тусгай шаардлага**

51 дүгээр зүйл

Гаалийн байгууллага барааг түр саатуулах

Барааны тэмдэг хуурамчаар үйлдсэн буюу зохиогчийн эрхийг зөрчсөн барааг импортлож байна гэж сэжиглэх бодит үндэслэл байгаа бол эрх эзэмшигч уг барааг чөлөөт эргэлтэд оруулахыг гаалийн байгууллагаас түдгэлзүүлэх хүсэлтээ эрх бүхий захиргааны буюу шүүхийн байгууллагад бичгээр гаргах боломж олгох журмыг гишүүд доорхи заалтын дагуу батлана. Оюуны өмчийн эрхийг бусад хэлбэрээр зөрчсөн барааны хувьд ийм хүсэлт гаргах боломжийг гишүүд хангаж болно, чингэхдээ энэ ангийн шаардлагад нийцэж байвал зохино. Гишүүд өөрийн нутаг дэвсгэрээс экспортлоход зориулсан эрх зөрчсөн барааг эргэлтэд оруулахыг гаалийн байгууллагаас түдгэлзүүлэхтэй холбогдсон журмыг тогтоож болно.

52 дугаар зүйл

Мэдүүлэг

51 дүгээр зүйлийн дагуу хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлж буй аливаа эрх эзэмшигч импортлогч орны хуулийн дагуу оюуны өмчийн эрх эзэмшигчийн эрхийг *prima facie* зөрчсөн гэж эрх бүхий байгууллага үзэхүйц хангалттай нотлох баримт, мөн гаалийн байгууллага шууд ялган танихүйц хангалттай нарийвчилсан тайлбар өгөх ёстой. Эрх бүхий байгууллага хүсэлтийг нь хүлээн авсан эсэхээ, түүнчлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон нөхцөлд гаалийн байгууллага арга хэмжээ авах хугацааны талаар зохих хугацааны дотор хүсэлт гаргагчид мэдээлнэ.

53 дугаар зүйл

Барьцаа буюу түүнтэй адилтгах баталгаа

1. Хариуцагч болон эрх бүхий байгууллагыг хамгаалах, урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхэд хангалттай барьцаа өгөх буюу адилтгах баталгаа гаргахыг эрх бүхий байгууллага хүсэлт гаргагчаас шаардах эрхтэй. Ийм барьцаа буюу адилтгах баталгаа нь эдгээр журмыг хэрэглэхэд саад болох ёсүй.
2. Энэ ангийн дагуу гаргасан хүсэлтийн дагуу гаалийн байгууллага бүтээгдэхүүний загвар, патент, байршлын загвар эсхүл хаалттай мэдээлэл бүхий барааг чөлөөт эргэлтэд оруулахыг шүүхийн буюу бие даасан өөр байгууллагаас гаргаснаас бусад шийдвэрийг үндэслэн түр саатуулсан, мөн 55 дугаар зүйлд заасан хугацаа зохих ёсоор эрх олгогдсон байгууллагаас түр чөлөөлөөгүй байхад дууссан нөхцөлд, чингэхдээ барааг импортлох бусад бүх нөхцлийг хангасан бол уг барааг эзэмшигч, импортлогч, хүлээн авагч нь эрх эзэмшигчийг эрх нь зөрчигдөхөөс хамгаалахад хангалттай барьцааг төлсний дараа барааг эргэлтэд оруулах зөвшөөрөл авах эрхтэй. Ийм барьцаа төлөх нь эрх эзэмшигч эдлэж болох эрх зүйн аливаа бусад арга хэмжээг хөндөхгүй бөгөөд хэрэв эрх эзэмшигч арга хэмжээ авах эрхээ боломжит хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлээгүй бол

барьцаа төлөхөөс чөлөөлөгдөнө гэж ойлгоно.

54 дүгээр зүйл

Саатуулах тухай мэдэгдэл

Барааг эргэлтэд оруулахыг 51 дүгээр зүйлийн дагуу түдгэлзүүлснээ барааг импортлогч болон өргөдөл гаргагчид даруй мэдэгдэнэ.

55 дугаар зүйл

Саатуулах хугацаа

Хэрэв түдгэлзүүлсэн талаар хүсэлт гаргагчид мэдэгдэл өгснөөс хойш ажлын 10 өдрөөс хэтрэхгүй хугацааны дотор гаалийн байгууллагад хэргийн үндсэн асуудлаар шийдвэр гаргахад хүргэх хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцагчаас өөр талын санаачлагаар эхлүүлсэн эсхүл зохих ёсоор эрх олгогдсон байгууллага барааг нэвтрүүлэхийг саатуулсан хугацааг сунгах түр арга хэмжээг авсан талаар мэдэгдээгүй бол барааг нэвтрүүлэх бөгөөд чингэхдээ барааг импортлох буюу экспортлох бусад нөхцөл бүрдсэн байвал зохино; тодорхой тохиолдолд энэ хугацааг ажлын арван өдрөөр сунгаж болно. Хэрэв хэргийн үндсэн асуудлаар шийдвэр гаргахад хүргэх хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол эдгээр арга хэмжээг цуцлах, өөрчлөх эсхүл хэвээр үлдээх асуудлыг боломжит хугацааны дотор шийдвэрлэх үүднээс хариуцагчийн хүсэлтээр санал бодлоо илэрхийлэх эрхийг оролцуулан хянан үзнэ. Дээрхийг үл харгалзан, барааг нэвтрүүлэхийг түдгэлзүүлсэн эсхүл шүүхийн түр арга хэмжээний дагуу үргэлжлүүлсэн нөхцөлд 50 дугаар зүйлийн (6) дахь хэсгийн заалтыг хэрэглэнэ.

56 дугаар зүйл

Бараа импортлогч, бараа эзэмшигчийг хохиролгүй болгох

Барааг зүй бусаар саатуулсан эсхүл 55 дугаар зүйлд заасны дагуу нэвтрүүлсэн барааг саатуулсан буюу барааг буруу саатуулсны улмаас барааг импортлогч, хүлээн авагч, эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг хүсэлт гаргагчаас холбогдох байгууллага шаардсан шийдвэр гаргах эрхтэй.

57 дугаар зүйл

Хянан шалгуулах, мэдээлэл авах эрх

Нууц мэдээллийн хамгаалалтыг хөндөхгүйгээр, эрх эзэмшигч нэхэмжлэлээ үндэслэхийн тулд гаалийн байгууллагын саатуулсан аливаа барааг хянан шалгуулах хангалттай боломж олгох эрхийг Гишүүд эрх бүхий байгууллагад олгоно. Эрх бүхий байгууллага нь ийм аливаа барааг хянан шалгуулах адил боломжийг мөн импортлогчид олгох эрхтэй. Хэргийн үндсэн асуудлаар нааштай шийдвэр гарсан бол барааг илгээгч, импортлогч, хүлээн авагчийн нэр, хаяг, мөн барааны тоо хэмжээг эрх эзэмшигчид мэдэгдэх эрхийг Гишүүд эрх бүхий байгууллагад олгоно.

58 дугаар зүйл

Авах арга хэмжээ

Оюуны өмчийн эрх зөрчигдөж байна гэх *prima facie* нотлох баримт байвал олж авсан барааг өөрөө санаачлан нэвтрүүлэхийг саатуулахыг гишүүд эрх бүхий байгууллагаас шаардсан нөхцөлд:

(a) Эрх бүхий байгууллага эдгээр эрхээ хэрэгжүүлэхэд нь тус болох аливаа мэдээлэл өгөхийг эрх эзэмшигчээс хэдийд ч хүсч болно;

(b) Саатуулсан талаар импортлогч болон эрх эзэмшигчид даруй мэдэгдэнэ. Импортлогч тийнхүү саатуулсныг эсэргүүцэж эрх бүхий байгууллагад гомдол мэдүүлсэн нөхцөлд тийнхүү саатуулахад 55 дугаар зүйлд заасан нөхцлийг хэрэглэнэ;

(c) Гишүүд төрийн байгууллага болон төрийн албан хаагчдын аль алийг зөвхөн арга хэмжээг сайн дураар авсан буюу авахыг зорьсон тохиолдолд шүүхийн хамгаалалтын холбогдох арга хэмжээний хариуцлагаас чөлөөлнө.

59 дүгээр зүйл

Хуулийн арга хэмжээ

Арга хэмжээ авах эрх эзэмшигчийн бусад эрхийг хөндөхгүйгээр, мөн асуудлыг шүүхээр дахин хянуулах хариуцагчийн эрхийг хүндэтгэхийн хамт эрх бүхий байгууллага эрх зөрчиж буй барааг 46 дугаар зүйлд заасан зарчмын дагуу устгах буюу хаях шийдвэр гаргах эрхтэй. Хуурамч Барааны тэмдэг бүхий барааны хувьд эрх бүхий байгууллага эрх зөрчиж буй уг барааг өөрчлөхгүйгээр дахин экспортлохыг хориглох буюу онцгой бус нөхцөл байдлаас бусад тохиолдолд гаалийн өөр ажиллагаанд хамааруулахыг зөвшөөрөхгүй.

60 дугаар зүйл

***De minimis* импорт /Барааг бага хэмжээгээр импортлох/**

Гишүүд зорчигчийн хувийн ачаа тээшээр буюу бага хэмжээгээр илгээсэн бөгөөд худалдааны бус зориулалттай бага хэмжээний бараанд дээрх заалтыг хэрэглэхгүй байж болно.

5 дугаар анги: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

61 дүгээр зүйл

Гишүүд наад зах нь худалдааны зорилгоор санаатайгаар барааны тэмдгийг хуурамчаар үйлдсэн буюу зохиогчийн эрхийг зөрчсөн тохиолдолд хэрэглэх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон хариуцлагыг тогтооно. Эрх зүйн хариуцлагын арга хэмжээнд гэмт хэргийн хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэрэгт ногдуулах шийтгэлийн түвшинд гэмт хэргийг таслан зогсоох хангалттай хэмжээнд хорих болон/буюу мөнгөн торгуулийн шийтгэлийг хамруулна. Тодорхой тохиолдолд эдгээр арга хэмжээнд мөн эрх зөрчиж буй барааг болон эрх зөрчихөд голлон ашигласан материал, хэрэгслийг хураах, устгах, арга хэмжээ хамаарна. Гишүүд оюуны өмчийн

эрхийг зөрчсөн бусад тохиолдолд ч, ялангуяа худалдааны зорилгоор санаатайгаар зөрчсөн нөхцөлд, хэрэглэх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, хариуцлага ногдуулах журмыг тогтоож болно.

**IV ХЭСЭГ
ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ОЛЖ АВАХ, ХАДГАЛАХ БА
ТҮҮНД ХАМААРАХ *INTER PARTES* ЖУРАМ**

62 дугаар зүйл

(1) Гишүүд үндэслэл бүхий дүрэм, журмыг мөрдөхийг II хэсгийн 2-6 дугаар ангид заасан оюуны өмчийн эрхийг олж авах буюу хадгалах нөхцөл болгон шаардаж болно. Ийм дүрэм, журмын хувьд тавигдах шаардлага нь энэхүү хэлэлцээрийн заалтад нийцсэн байна.

(2) Хэрэв оюуны өмчийн эрхийг олж авах буюу бүртгэх хэлбэрээр олгодог бол тийнхүү олгох буюу бүртгэх журам нь хамгаалах хугацааг үндэслэлгүйгээр багасгахаас зайлсхийх боломжит хугацааны дотор олгох буюу бүртгэхийг зөвшөөрдөг байх явдлаар гишүүд эрхийг олж авах үндсэн нөхцлийг харгалзан хангана.

(3) Парисын конвенц (1967)-ийн 4 дүгээр зүйлийг үйлчилгээний тэмдэгт хэрэглэнэ.

(4) Оюуны өмчийн эрхийг олж авах буюу хадгалах журам, түүнчлэн хэрэв гишүүний хуулиар тийм журам тогтоосон бол, захиргааны журмаар цуцлах болон эсэргүүцэх, цуцлах, хүчингүй гэж үзэх зэрэг *inter partes* жумыг 41 дүгээр зүйлийн (2), (3) дахь хэсэгт заасан нийтлэг зарчмаар зохицуулна.

(5) (4) дэх хэсэгт заасан аль нэг журмаар гарсан захиргааны эцсийн шийдвэрийг шүүх буюу хагас шүүхийн байгууллага хянан үзэх боломжтой байна. Гэхдээ үндэслэлгүй эсэргүүцэл буюу захиргааны журмаар хүчингүй болгосон нь амжилтгүй болсон, чингэхдээ тийм журмын үндэслэл нь хүчингүй болгох журамтай холбоотой тохиолдолд шийдвэрийг тийнхүү хянан үзэх боломж олгох үүрэггүй.

**V ХЭСЭГ
МАРГААНААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

63 дугаар зүйл

Ил тод байх

1. Гишүүнээс энэхүү хэлэлцээрийн зүйл (оюуны өмчийн эрхийн байдал, хамрах хүрээ, түүнийг олж авах, хэрэгжүүлэх болон түүнчлэн урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх)-ийн талаар хүчин төгөлдөр болгосон хууль тогтоомж, шүүхийн эцсийн шийдвэр болон захиргааны журмыг засгийн газар болон эрх эзэмшигчид танилцах боломж олгох байдлаар үндэсний хэлээр хэвлэн нийтлэх эсхүл ийнхүү хэвлэн нийтлэх бодит боломжгүй бол олон нийтэд мэдээлнэ.. Аль нэг гишүүний засгийн газар буюу засгийн газрын байгууллага болон нөгөө гишүүний засгийн газар буюу засгийн газрын байгууллагын хооронд энэхүү

хэлэлцээрийн талаарх хүчин төгөлдөр үйлчилж буй хэлэлцээрийг мөн хэвлэн нийтлэнэ.

2. Гишүүд (1) дэх хэсэгт дурдсан хууль тогтоомжийг ОӨЭХХА-аархи зөвлөлд мэдэгдэж энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг хянан үзэхэд нь туслана. Зөвлөл гишүүдийн энэ үүргээ хэрэгжүүлэх ачааллыг аль болох багасгахыг хичээх бөгөөд хэрэв хууль тогтоомжийн нэгдсэн бүртгэл бий болгох талаар ДООБ-тай зөвлөлдөж амжилтад хүрвэл дээрх хууль тогтоомжийг Зөвлөлд шууд мэдээлэх үүргээс чөлөөлөхөөр шийдвэрлэж болно. Зөвлөл үүнтэй холбогдуулан Парисын конвенц (1967)-ийн 6 *ter* дугаар зүйлийн заалтаас үүдсэн бөгөөд энэхүү хэлэлцээрт заасан үүргийн дагуу мэдэгдэлтэй холбогдуулан шаардлагатай аливаа арга хэмжээг авна.
3. Гишүүн тус бүр бусад гишүүний бичгээр гаргасан хүсэлтийн дагуу (1) дэх хэсэгт дурдсан мэдээллийг өгөхөд бэлэн байх ёстой. Оюуны өмчийн эрхийн салбар дахь шүүхийн тодорхой нэг шийдвэр эсхүл захиргааны журам эсхүл хоёр талт хэлэлцээр энэхүү хэлэлцээрийн дагуу эдлэх эрхийг нь хөндөж байна гэж үзэх шалтгаан байвал гишүүн шүүхийн тодорхой шийдвэр эсхүл захиргааны журам эсхүл хоёр талт хэлэлцээрийг олж авах эсхүл тэдгээрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах талаар мөн бичгээр хүсэлт тавьж болно.
4. (1), (2), (3) дахь хэсгийн аль ч заалт хууль хэрэгжүүлэхэд саад болох буюу нийтийн ашиг сонирхолд өөрөөр харшлахуйц эсхүл төрийн болон хувийн тодорхой үйлдвэрийн газрын хууль ёсны худалдааны ашиг сонирхолд хохирол учруулахуйцаар нууц мэдээлэл задруулахыг гишүүдээс шаардахгүй.

64 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

1. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Маргаан зохицуулах ойлголцлын дагуу боловсруулж, хэрэглэж буй 1994 оны ТХЕХ-ийн XXII болон XXIII зүйлийн заалтыг энэхүү хэлэлцээрийн дагуу маргааны талаар зөвлөлдөх, маргаан шийдвэрлэхэд хэрэглэнэ.
2. 1994 оны ТХЕХ-ийн XXIII дугаар зүйлийн 1(b) болон 1(c) дэд хэсгийг ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн хугацаанд энэхүү хэлэлцээрийн дагуу маргааныг шийдвэрлэхэд хэрэглэхгүй.
3. 2 дахь хэсэгт дурдсан хугацааны турш ОӨЭХХА-аархи зөвлөл 1994 оны ТХЕХ-ийн XXIII зүйлийн 1(b) болон 1 (c) дэд хэсэгт заасан төрлийн энэхүү хэлэлцээрийн дагуу гаргасан гомдлын хамрах хүрээ, хэлбэрийг шалган үзэж, гаргасан зөвлөмжөө Сайд нарын бага хуралд батлуулахаар өгнө. Ийм зөвлөмжийг батлах, эсхүл (2) дахь хэсэгт заасан хугацааг сунгах тухай вайд нарын бага хурлын аливаа шийдвэрийг зөвхөн зөвшилцлийн замаар гаргах бөгөөд батлагдсан зөвлөмж нь цаашид албан ёсоор хүлээн зөвшөөрөх журамгүйгээр бүх гишүүдийн хувьд шууд хүчин төгөлдөр болно.

VI ХЭСЭГ

ШИЛЖИЛТИЙН ТОХИРОЛЦОО

65 дугаар зүйл

Шилжилтийн тохиролцоо

1. (2), (3), (4) дэх хэсэгт заасныг дагаж мөрдөхийн хамт, аль ч гишүүн энэхүү хэлэлцээрийн заалтыг ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн ерөнхий хугацаа өнгөрөхөөс өмнө хэрэглэх үүрэггүй.
2. Хөгжиж буй гишүүн орон энэхүү хэлэлцээрийн 3, 4, 5 дугаар зүйлээс бусад заалтыг (1) дэх хэсэгт заасны дагуу хэрэглэх өдрөө цаашид дөрвөн жилээр хойшлуулах эрх эдлэнэ.
3. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн чөлөөт эдийн засагт шилжиж буй бөгөөд оюуны өмчийн тогтолцоондоо бүтцийн өөрчлөлт хийж, оюуны өмчийн хууль тогтоомжоо боловсруулж хэрэгжүүлэхдээ онцгой бэрхшээлтэй тулгарч буй аливаа бусад гишүүн (2) дахь хэсэгт заасны дагуу хугацааг мөн хойшлуулж болно.
4. Энэхүү хэлэлцээрийг хэрэглэх ерөнхий хугацаанд нутаг дэвсгэрт нь төдийлөн хамгаалагдаагүй байгаа технологийн салбарт бүтээгдэхүүний патентаар хамгаалах үүргийг (2) дахь хэсэгт зааснаар хөгжиж буй гишүүн орон хүлээх нөхцөлд тухайн гишүүн нь технологийн тэдгээр салбарт II хэсгийн 5 дугаар ангид заасан бүтээгдэхүүний патентын тухай заалтуудыг хэрэглэх хугацааг нэмэлт таван жилийн хугацаагаар хойшлуулж болно.
5. (1), (2), (3) буюу (4) дэх хэсгийн дагуу шилжилтийн хугацааг хэрэглэж буй гишүүн уг хугацааны туршид хууль тогтоомж, үйл ажиллагаанд нь гарах ямарваа өөрчлөлт энэхүү хэлэлцээртэй өмнөхөөсөө илүүгээр зөрчилдөхгүй байх явдлыг хангана.

66 дугаар зүйл

Нэн буурай хөгжилтэй гишүүн орнууд

1. Нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудын онцгой хэрэгцээ, шаардлага, тэдний эдийн засаг, санхүү, захиргааны хязгаарлагдмал боломж, мөн амьдрах чадвартай технологийн суурийг бүрдүүлэхэд уян хатан хандах шаардлагатайн үүднээс тэдгээр гишүүнд энэхүү хэлэлцээрийн 3, 4, 5 дугаар зүйлээс бусад заалтыг хэрэглэх шаардлагыг 65 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасан хэрэгжүүлэх өдрөөс хойш авран жилийн хугацаанд тавихгүй. ОӨЭХХА-аархи зөвлөл нэн буурай хөгжилтэй гишүүн орны зохих үндэслэл бүхий хүсэлтээр уг хугацааг сунгана.
2. Хөгжилтэй гишүүн орнууд нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад технологийн бат бэх, амьдрах чадвартай суурь бүрдүүлэх нөхцлийг хангахын тулд тэдгээрт технологи дамжуулахыг хөхиүлэн дэмжиж, урамшуулах зорилгоор өөрийн нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлт олгоно.

67 дугаар зүйл

Техникийн хамтын ажиллагаа

Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хөнгөвчлөхийн тулд хөгжилтэй гишүүн орнууд хөгжиж буй болон нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад ашигтай техникийн болон санхүүгийн хамтын ажиллагаагаар хүсэлтээр нь харилцан тохиролцсон нөхцөл, болзлын дагуу хангана. Уг хамтын ажиллагаа нь оюуны өмчийн эрхийг хамгаалж, хэрэгжүүлэх, түүнийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомж боловсруулахад туслах, түүнчлэн боловсон хүчнийг сургах зэрэг асуудалд холбогдолтой үндэсний, байгууллага хороог байгуулж, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**VII ХЭСЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОХИРОЛЦОО;
ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ**

68 дугаар зүйл

Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн асуудлаархи зөвлөл

ХХОӨЭА-аархи зөвлөл нь энэхүү хэлэлцээрийн үйлчлэл, тухайлбал гишүүд түүгээр хүлээсэн үүргээ биелүүлж буйд хяналт тавьж, оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах асуудлаар зөвлөлдөх боломжийг гишүүдэд олгоно. Тэрээр гишүүдээс өөрт нь хүлээлгэсэн бусад үүргийг гүйцэтгэх бөгөөд тухайлбал маргаан зохицуулах ажиллагааны хүрээнд тэднээс хүссэн аливаа туслалцааг үзүүлнэ. ХХОӨЭА-аархи зөвлөл нь үүргээ гүйцэтгэхдээ зохистой гэж үзсэн аливаа эх сурвалжтай зөвлөлдөж, мэдээлэл хүсч болно. Зөвлөл анхдугаар хуралдаанаасаа хойш нэг жилийн дотор ДООБ-тай зөвлөлдөж уг байгууллагын байгууллагуудтай хамтран ажиллах зохистой арга хэмжээг авна.

69 дүгээр зүйл

Олон улсын хамтын ажиллагаа

Гишүүд оюуны өмчийн эрх зөрчиж буй олон улсын худалдааг арилгах үүднээс бие биетэйгээ хамтран ажиллахаар тохиролцоно. Энэ зорилгоор тэд өөрсдийн захиргаанд лавлах цэгийг байгуулж, тэдэнд мэдээлэх журмаар эрх зөрчиж буй барааны худалдааны талаар мэдээлэл солилцоход бэлэн байна. Тухайлбал тэд хуурамч барааны тэмдэгтэй болон зохиогчийн эрх зөрчсөн барааны талаар гаалийн байгууллага хооронд мэдээлэл солилцож, хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжинэ.

70 дугаар зүйл

Бий болсон зүйлийг хамгаалах

1. Энэхүү хэлэлцээр нь тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдрөөс өмнө үүссэн үйлдэлтэй холбогдуулан үүрэг бий болгохгүй.
2. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол энэхүү хэлэлцээр нь тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдөр байгаа бөгөөд тухайн гишүүний нутаг

дэвсгэрт тухайн өдөр хамгаалагдаж байаа эсхүл энэхүү хэлэлцээрийн дагуу хамгаалагдах шалгуурыг хангаж байгаа буюу цаашид хангах бүх зүйлтэй холбогдуулан үүрэг бий болгоно. Энэ хэсэг болон (3), (4) дэх хэсгийн хувьд, байгаа бүтээлийн зохиогчийн эрхийн талаарх үүргийг дан гагцхүү Бернийн конвенц (1971)-ийн 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлох бөгөөд байгаа дуу авианы бичлэгийн үйлдвэрлэгч, тэдгээрийн гүйцэтгэгчийн эрхийн талаарх үүргийг энэхүү хэлэлцээрийн 14 дүгээр зүйлийн (6) дахь хэсгийн дагуу хэрэглэж болох Бернийн конвенц (1971)-ийн 18 дугаар зүйлд зааснаар гагцхүү тодорхойлно.

3. Тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх өдөр нийтийн хүртээл болсон зүйлийн хамгаалалтыг сэргээх үүрэг тухайн гишүүний хувьд үүсэхгүй.
4. Хамгаалагдсан зүйл бүхий тодорхой зүйлийн хувьд энэхүү хэлэлцээрт нийцүүлсэн хууль тогтоомжийн нөхцлийн дагуу эрх зөрчиж буй бөгөөд ДХБ-ын хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс өмнө эхэлсэн буюу ихээхэн хөрөнгө оруулалтын хувьд тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдрийн дараа үргэлжлүүлэн ийм үйлдэл хийх үед болох эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг тухайн гишүүн эрх эзэмшигчийн хувьд хязгаарлаж болно. Гэхдээ энэ тохиолдолд уг гишүүн наад зах нь зохих шан хөлс төлнө.
5. Гишүүн энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдрөөс өмнө худалдаж авсан эх бүтээл буюу хуулбарын хувьд 11 дүгээр зүйл болон 14 дүгээр зүйлийн (4) дэх хэсгийн заалтыг хэрэглэх үүрэг хүлэхгүй.
6. Гишүүд 31 дүгээр зүйлийг эсхүл технологийн салбарын хувьд патентын эрхийг ямарваа алагчилалгүйгээр эдлэх тухай 27 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн шаардлагыг зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдолд тийнхүү ашиглах зөвшөөрлийг энэхүү хэлэлцээр хүчинтэй болохоос өмнө засгийн газраас олгосон нөхцөлд хэрэглэх үүрэггүй.
7. Бүртгэлийг оюуны өмчийн эрхийг хамгаалах нөхцөл болгодог тохиолдолд тухайн Гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх өдрөөс хамааран хүлээгдэж байгаа хамгаалалт хүссэн өргөдлийг энэхүү хэлэлцээрийн заалтын дагуу илүү хамгаалалтыг хүсч өөрчлөхийг зөвшөөрнө. Уг өөрчлөлтөд ямарваа шинэ асуудал тусгахгүй.
8. Хэрэв аль нэг гишүүн ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрийн байдлаар 27 дугаар зүйлд заасан үүргийнхээ дагуу эм, хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүний патентыг хамгаалах боломжгүй нөхцөлд тухайн гишүүн нь:

(а) эдгээр шинэ бүтээлд патент олгохыг хүсч гаргасан өргөдлийг ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн VI хэсгийн заалтыг үл харгалзан бүртгэх боломжоор хангана.;

(б) энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх өдрөөс эхлэн энэхүү хэлэлцээрт заасан патент олгох шалгуурыг уг шалгуур нь тухайн гишүүн оронд мэдүүлгийн анхдагч огноо буюу давамгайлах огноо тогтоох боломжтой буюу түүнийг хүссэн бол давамгайлах огнооны өдөр хэрэглэсэн мэтээр эдгээр мэдүүлэгт тусгах ;

(с) (b) дэд хэсэгт заасан хамгаалалт авах шалгуурыг хангаж буй мэдүүлгийн хувьд патент олгосон өдрөөс эхэлж энэхүү хэлэлцээрийн 33 дугаар зүйлд заасны дагуу мэдүүлгийн анхдагч огнооноос тооцсон патентын үлдсэн хугацаанд энэхүү хэлэлцээрийн дагуу патентаар хамгаалах үүргийг тус тус хүлээнэ.

9. Бүтээгдэхүүн нь 8 дугаар зүйлийн (а) дэд хэсгийн дагуу патентын мэдүүлэг гаргах зүйл мөн VI хэсгийн заалтыг үл харгалзан тухайн гишүүн оронд зах зээлийн баталгаа олж авснаас хойш таван жилийн хугацаа эсхүл уг бүтээгдэхүүнд патент олгох буюу олгохоос татгалзах хүртэл хугацааны аль богино хугацаагаар нь түүнийг арилжаалах онцгой эрхийг олгоно, чингэхдээ ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш патент хүссэн мэдүүлэг гаргасан байх бөгөөд өөр гишүүн оронд патентыг тухайн бүтээгдэхүүнд олгож, зах зээлийн баталгаа олгосон байвал зохино.

71 дүгээр зүйл

Хянан өөрчлөх ба нэмэлт, өөрчлөлт оруулах

1. ХХОӨЭА-аархи зөвлөл 65 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан шилжилтийн хугацаа дууссаны дараа энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянан үзнэ. Зөвлөл нь хэрэгжилтийн явцад хуримтлуулсан туршлагаа харгалзан түүнээс хойш хоёр жилийн дараа хянан үзэх бөгөөд цаашид ийм хугацааны зайтайгаар хянан үзэж байх болно. Зөвлөл нь мөн энэхүү хэлэлцээрийг хянан өөрчлөх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шинэ нөхцөл байдалтай уялдуулан хянан үзэж болно.
2. Бусад олон талт хэлэлцээрт тусгасан, хүчин төгөлдөр үйлчилж буй бөгөөд тэдгээр хэлэлцээрийн дагуу ДХБ-ын бүх гишүүн хүлээн зөвшөөрсөн оюуны өмчийн эрхийг хамгаалах илүү дээд түвшинд тохируулах зорилгод зөвхөн үйлчилж буй нэмэлт, өөрчлөлтийг ХХОӨЭА-аархи зөвлөлөөс нийтийн тохиролцоогоор санал болгосныг үндэслэн ДХБ-ын хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн (б) дахь хэсгийн дагуу арга хэмжээ авахуулахаар сайд нарын бага хуралд оруулж болно.

72 дугаар зүйл

Тайлбар

Бусад гишүүний зөвшөөрөлгүйгээр энэхүү хэлэлцээрийн аль ч заалтад тайлбар хийхийг хориглоно.

73 дугаар зүйл

Аюулгүй байдалтай холбоотой онцгой тохиолдол

Энэхүү хэлэлцээрийн аль ч заалтыг дараахь байдлаар тайлбарлахгүй:

(а) аливаа гишүүнээс задруулснаар аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхолд нь харш гэж үзэж байгаа ямарваа мэдээллийг гаргахыг шаардсан,

(b) аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхлоо хамгаалахад шаардлагатай гэж үзсэн дараахь үйл ажиллагааг явуулахад гишүүнд саад болсон:

- (i) тэсэрч дэлбэрэх материал буюу тэдгээрээс гаргаж авсан материалтай холбогдсон;
- (ii) зэвсэг, сум хэрэгсэл, байлдааны хэрэгслийн хөдөлгөөн болон цэргийн байгууламжид нийлүүлэхээр шууд буюу шууд бусаар зөөж буй бусад бараа, материал зөөхтэй холбогдсон;
- (iii) дайны үед буюу олон улсын харилцааны бусад онц байдалд болсон; эсхүл

(c) Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх үйл ажиллагааг явуулахад нь аль нэг гишүүнд саад болсон.